



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэтгүүл

2019 он, Цуврал 3 (73)

Улаанбаатар хот
2019 он

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

Сэтгүүлд нийтлэсэн бүтээл нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлийн зохиогчийн эрх Сэтгүүлийн редакц болон зохиогчид хадгалагдана.

Хэвлэсэн газар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хэвлэх үйлдвэр

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ж.Амарсанаа	<i>Академич, гавьяат хуульч</i>
Ц.Сарантуяа	<i>Хууль зүйн шинжслэх ухааны доктор, гавьяат хуульч</i>
Б.Баярсайхан	<i>Хууль зүйн доктор</i>
Д.Гангабаатар	<i>Хууль зүйн доктор</i>
Д.Зүмбэрэлхам	<i>Хууль зүйн доктор</i>
Ж.Оюунтунгалаг	<i>Хууль зүйн доктор</i>
Д.Сүнжид	<i>Хууль зүйн доктор</i>
П.Амаржаргал	<i>Хууль зүйн доктор</i>
З.Сүхбаатар	<i>Бизнесийн удирдлагын доктор</i>
Ц.Цогт	<i>Хууль зүйн доктор</i>

Эрхлэгч

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захираг

С.Энхцэцэг

Нарийн бичгийн дарга

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжсилгээний ажилтан

Ж.Булгансүрэн

Хэвлэлийн эхийг

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эх бэлтгэгч, дизайнер

Д.Мөнхжаргал

Улсын бүртгэлийн дугаар: 279
ISSN:2226-9185

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс
эрхлэн гаргав. Жилд 5 дугаар гарна.

Хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Бага тойруу /15160/

Хуульчдын гудамж 1,

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр

Утас: +(976)-11-315735

Факс: 315735

Вэб хуудас: www.nli.gov.mn

Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

EDITORIAL BOARD

J.Amarsanaa	<i>Academician, Merited Lawyer of Mongolia</i>
Ts.Sarantuya	<i>(Sc.D), Merited Lawyer of Mongolia</i>
B.Bayarsaikhan	<i>(Ph.D)</i>
D.Gangabaatar	<i>(LL.D)</i>
D.Zumberellkham	<i>(Ph.D)</i>
J.Oyuntungalag	<i>(LL.D)</i>
D.Sunjid	<i>(Dr.jur)</i>
P.Amarjargal	<i>(Ph.D)</i>
Z.Sukhbaatar	<i>(Ph.D)</i>
Ts.Tsogt	<i>(LL.D)</i>

Executive Editor-in-Chief

Director, The National Legal Institute

S.Enkhtsetseg

Acting Assistant Editor

Researcher, The National Legal Institute

J.Bulgansuren

Designed by

Designer, The National Legal Institute

D.Munkhjargal

State Registration Number:279
ISSN: 2226-9185
The National Legal Institute
publishes this law review five times
per year.

Address: 4th Khoroo, Chingeltei District,
Lawyer's Street-1, Ulaanbaatar-15160, Mongolia
Phone:+(976)-11-315735
Fax: 315735
Website: www.nli.gov.mn
E-mail: lawjournal@legalinstitute.mn

АГУУЛГА

ХУУЛЬ ТӨРӨХИЙН ӨМНӨ /ОНЦЛОХ ӨГҮҮЛЭЛ, ЯРИЛЦЛАГА/

Зөвшилцлийн улс төржсөн шинж эрүүгийн бодлогод сэргэөр нөлөөлөх нь	9
<i>Хууль зүйн доктор, профессор Ж.Бямбаа</i>	
Экстремист үйл ажиллагаа явуулах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага: харьцуулсан судалгаа	14
<i>Олон улсын Улаанбаатарын их сургуулийн дэд профессор, хууль зүйн доктор Ц.Доржсям</i>	
Хүүхдэд ээлтэй шүүх тогтолцоо: Олон улсын туршлага ба Монгол Улс	20
<i>Дотоод хэргийн их сургуулийн дэд профессор, хууль зүйн доктор Ю.Бадамханд</i>	
Хууль зүйн статистикийн онол, хэрэглээний асуудал	32
<i>Дотоод хэргийн их сургуулийн Цагдаа судлалын төвийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хууль зүйн доктор Б.Мөнхдорж,</i>	
<i>МУИС-ийн ХЭС-ийн магистрант Б.Ариунтуяа</i>	
ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ	
Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийн тайлбарын тухайд	37
<i>Санхүү эдийн засгийн их сургуулийн эрх зүйн тэнхимийн багш Б.Дэлгэрмаа</i>	
Хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэх Үндсэн хуулийн хориг ба хязгаар	43
<i>Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан О.Төрболд</i>	
Тэнцвэргүй гурван эрх мэдэл ба улс төрийн бодлого, шийдвэрийн нөлөө	56
<i>Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч В.Амартувшин</i>	
Олон улсын оюуны өмчийн маргааныг альтернатив аргаар шийдвэрлэх(adr) боломжид хийсэн судалгаа	61
<i>ИЗОУИС-ийн эрх зүйн багш, докторант Б.Жаргалсайхан</i>	
Өмгөөлөгчийн ёс зүйн асуудал	71
<i>ШУА-ийн Философиийн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний дэд ажилтан М.Долгорсүрэн</i>	

Хүрээлэн буй орчны эрх зүйт ёс
Хуульч Р.Мөнхзул

79

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ

Хулгайлах гэмт хэргийн талаарх эрх зүйн зохицуулалт,
тулгамдаж буй асуудал

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал

**Хөдөлмөрийн тухай хуулийн 69.1 дэх заалтын зорилго, хэрэглээний онцлогийг
иргэний эрх зүйн харилцааны тогтолцооны хандлагаар авч үзэх нь**
Шихихутуг их сургуулийн багш, докторант Е.Болормаа

**Үр хөндөлтийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох эрх зүйн
зарим асуудал**

Хуульч А.Түвшинтөгс

102

ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ , ҮР ДҮН

**Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн хийсэн
үнэлгээний тайлан**

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төв

114

**Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэл гэмт хэргийн өсөлт,
буураатад нөлөөлсөн нь судалгааны тайлан**

*ҮЕПГ-ын Сургалтын төвийн судлаач, хяналтын прокурор Г.Оюунболд,
МУИС-ийн ХЗС-ийн магистрант Б.Ариунтуяа*

122

ХУУЛЬ ЗҮЙН НЭР ТОМЬЁОНЫ БУЛАН

Ж.Амарсанаа

CONTENT

BEFORE CREATING A LAW /UNDERLINE ARTICLE AND INTERVIEW/

- Negative Influence on a Criminal Policy of Political Characterization of Consensus 9**
Byambaa.J, Ph.D., Professor

- Criminal Liability on Crime of Extremist: Comparative Research 14**
Dorjnyam.TS, Ph.D., Professor Associate, International Ulaanbaatar University

- Child Favorable Judicial System: International Practice & Mongolia 20**
Badamkhand.YU, Ph.D., Professor Associate, Law Enforcement University

- Issue of Theory and Practice of Legal Statistics 32**
*Munkhdorj.B, Ph.D., Senior Researcher at Center for Police research,
Law Enforcement University*
Aiuntuya.B, LL.M candidate at School of Law, NUM

LEGAL THINKING: VIEWS AND REFLECTIONS

- On the Interpretation of First Constitution Mongolia 37**
*Delgermaa.B, Teacher Lecturer, Legal Department at University of
Finance and Economics*

- The Constitutional Limitation and Restrictions on Delegation of the Legislative Power 43**
Turbold.O, Researcher at the National Legal Institute

- Unbalanced Three Power and its Impacts on Politics and Political Decision Making 56**
*Amartuvshin.B, Sum (county), inter-sum and district court of First instance of Civil case
court of Dornogobi province*

- Research on the Opportunities for Resolving International Intellectual Property
Dispute by Alternative Dispute Resolution (Adr) 61**
*Jargalsaikhan.B, Ph.D candidate, Lecturer at Law Faculty, Ikh-Zasag
International University*

- Ethical Issues of Advocate 71**
Dolgorsuren.M, Sub-researcher at the Mongolian Academy of Sciences

Rules of Environmental law*Munkhzul.R, Lawyer*

79

IMPLEMENTATION OF EFFICIENCY AND LAW**Legal Regulation on Crime of Theft Crime and Urgent Issues***Ariunjargal.B, Researcher at the National Legal Institute*

85

The Purpose and Special Features of Implementation of the Article 72.3, Labor Law Explained by Approaches Within Civil Law Relation and System*Bolormaa.YO, Ph.D candidate, Lecturer of Shihihutag University*

96

Developmental Issues on Improving Legal Regulations of Abortion*Tuvshintugs.A, Lawyer*

102

LEGAL RESEARCH OVERVIEW**National Legal Institute's Research Report for Partial Evaluation on Implementation Outcomes of Law on Infringements***Legal research center at National Legal Institute*

114

Criminal Code Reform and its Impact on a Crime Rate (increase or reduction)*Oyunbold.G, Prosecutor, Researcher, State General Prosecutor's Office
Research Center Ariuntuya.B, LL.M candidate at School of Law, NUM*

122

LEGAL TERMS*J.Amarsanaa*

ЗӨВШИЛЦЛИЙН УЛС ТӨРЖСӨН ШИНЖ ЭРҮҮГИЙН БОДЛОГОД СӨРГӨӨР НӨЛӨӨЛӨХ НЬ



Хууль зүйн доктор, профессор
Ж.Бямбаа

Эрх зүйн соёлын түвшин хэр байгаагаас тухайн улс орон дахь улс төрийн нөлөөний хэр хэмжээ тодорхойлогдох учиртай. Шүүхээ хүндэтгэх, шийдвэрлийг нь даган биелүүлэх үлгэрийг их гүрний тэргүүнүүд хүртэл биечлэн харуулж буй жишээг бидний хэн ч болов хэвлэл, мэдээллийн хэрэгслээс төвөггүй мэдэх боломж бий. Харин манайд Шилжилтийн эхэн үед Монгол оронд төрийн эрх мэдэл хувиарлах онол сүрхий хэрэгжиж эхэлсэн. Гэтэл удаж төдөлгүй улс төржсөн эрх мэдлийн өвчин гажиг халдвараа тарааж амжсан. Үндсэн хуулиndaа хүч түрэн гар хүрч “дордохын долоон өөрчлөлт” хийсэн парламент, түүний бяр чадалдаа амтashсан лидерүүд хуулийн засаглалыг эс тоомсорлон Үндсэн хуулийн Цэцээ хүртэл хоёр ч удаа айхтар шоглосныг хэн хүнгүй мэнднэ.

Ардчиллын суурь зарчимд эрээ цээргүй халдсан энэхүү өөрчлөлтөө тэрхэн үед “Монгол Улс дахь төрийн эрх мэдэл хуваарилалт” сэдвээр хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан эрхмийн депутат-баланк дээр тулган бичүүлж, бусад нь гарын үсэг зурж “даацаалсан” баримт

түүх болон үлджээ. Энэхүү процессыг гардан санаачлагч нэгэн нэрт улс төрч “... хуульч эрдэмтэд гэж юу байдаг юм. Миний бичсэн хэдэн хуулийг мөлжиж амьдардаг хүмүүс...” хэмээн өгүүлсэн байдаг.

ОХУ-д эрдэм номын цэнэг авсан нөхөд маань нэрт академикаараа төлөөлүүлэн сайд асан Х.Тэмүүжинтэй Сүхбаатар дүүргийн шүүх дээр “...мэдлэг чадвараараа хоцроогүй” гэдгээ нотлох оролдлого хийж заргалдаад яаж ч чадалгүй ялагдал хүлээнээс үзэхэд дээрх хорон үг үнэний хувьтай ч юм шиг санадах юм. Ер нь бохир улс төр хууль эрх зүйн ухамсарт төдийгүй эрүүгийн бодлогод хүртэл нөлөөлдөг халдварт өвчин гарцаагүй мөн.

Ардчилсан хувьсгалыг угтаж тэр үеийн Улсын Ерөнхий Прокуророор толгойлуулсан шилдэг 10 хуульчид урьд шийдвэрлэсэн процессын алдаатай байж болох зарим дуулиант хэргүүдийг нягтлан хянаж эхлэв. Эрдэнэтийн агент Д-ийн амь насыг бүрэлгэсэн хэргийг онцлон авч өдүүлсэн гэх этгээдүүдийг илчлэхдээ процессын хуульчлагдсан журмыг ноцтой зөрчсөн хуулийн ажилтнууд шилдэг аравт юуны өмнө онилговд. Тэдний нэлээд нь эрүүдэн шүүсэн хэрэгт унаж ял авцгаасан билээ. Хөөрхий Д хээр хөдөө хариуцсан бараагаа ганцаараа тоолж 20-иод мянган төгрөг дутах нь хэмээн айж өөрийгөө буудан хороосон болохыг шилдэг 10 гарцаагүй тогтоосон гэдэг.

Түүх давтагдаг ажээ. “Хууль шаардагдахгүй хувьсгалын шинэ цаг үед” мөрдэж мөшгөх, хянан шалгах арга туршлага дутмаг эрхмүүд уянгын халил-улс төрийн хэнээрхэлтэй эрх мэдэлтнүүдэд дарамтлагдсанаас болоод ноцтой алдаа гаргаж Зориг агсны амь насыг бүрэлгэсэн цуут хэргийг юу ч биш болгох нөхцөлийг бүрдүүлж орхив бололтой.

Харин одоо “...өрөөндөө байсан бусдын малгайг гэнэт харсан талийгаач маань цочрон давчдаж өөрөө өөрийнхөө амь насыг жигшүүргэгээр бүрэлгэжээ... гэсэн” үндэслэлээр энэ ноцтой хэрэг юу ч биш болж урьдын эмгэнэл давтагдах бий гэхээс яс хавтайх юм. Дурдсан хоёр түүхийн аль аль нь эцсийн дүндээ бохир улс төрийн гаж нөлөө гэдэг нь хэнд ч болов төвөггүй ойлгогдох биз.

Үүнтэй уялдуулан дараах хоёр асуудлаар санал солилцох нь судлаач миний үүрэг хэмээн үзэж байна. Тухайлбал, манай зарим хуульчид төдийгүй нөлөө бүхий эрдэмтэд хүртэл “хууль, шүүхийн шийдвэр нь улс төрийн бодлогын түвшинд нийцсэн нийгмийн зөвшилцөл” хэмээн шуудхан өгүүлж байна. (Шүүх эрх мэдэл сэтгүүл. 2015 он №1, 8 дахь тал) Үүнийгээ янз бүрээр үнэмшигүүлэх оролдлого хийсний нэг жишээ нь” ХБГНУ-ын Бавари мужийн дээд шүүхийн шүүгч асан Ё. Каютын “Шүүхийн шийдвэрийн үндэслэл нь ялсан талд биш ялагдсан этгээдэд зориулж бичих хэрэгтэй” гэсэн ишлэлд тулгуурласан нуршуу тайлбар.

Гэтэл эрхэм шүүгчийн нутаг нэгт эрдэмтэн Б.Лихтенбергер “Үндсэн хуулийн шүүх, парламент хоорондын харилцааны эрх зүйн болон ёс суртахууны үндэс” илтгэлдээ “Улс төр эрх зүйн хэм хэмжээгээр хязгаарлагддаг. Аливаа хэрэг маргаан нь хуулийг мөрдлөг болгодог шүүх эрх мэдлийн хүрээнд шалгагдан шийдвэрлэгдэх ёстай.” хэмээн онцолсон байдаг. (Олон Улсын Симпозиум. Эмхэтгэл. Уб, 1998 он. 87 дахь тал)

Тэгвэл, 2017 онд болсон Үндсэн хуулийн цэцийн 25 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал дээр ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн гишүүн, доктор, хатагтай Зибюлле-Кессел-Вульф “улс төр эрх зүйд нийцэх учиртай, харин эрх зүй улс төрийг дагах албагүй” гэж манайд хаана хаана анхаарах ноцтой үгийг илтгэлдээ жичлэн тусгасан. Түүнтэй дуу хоолой хорших мэт БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч, доктор Ким Чинь Жунь “Улс төр өөрийн муу шинжээ эрх зүй

дээр тавих оролдлого хийдэг” гэж шуудхан хэлжээ.

Харин Монголын зарим эрдэмтэд үүний эсрэг үзэл баримтлалыг илт дэмждэг нь сонин. Тухайлбал, “эрх зүй улс төрийн нэг институци, эрх зүй нийгмийн харилцаанд зөвхөн хэм хэмжээгээр дамжуулан нөлөөлдөг бол улс төр өнөөгийн зохиц байдлыг хадгалах, маргаашийн эрх ашгийн төлөө хэвлэл мэдээллийг хүргэл ашиглан хуурмаг тоглоом хийж болно...” гэжээ. (Эрх зүйн судлал, Философийн онол. УБ. 2011 он) Чингэнээр эрх зүйн хэм хэмжээний зайлшгүй хэрэгжих, биелэгдэх мөн чанарыг эс тоосон, нийгмийн ухамрыг цогцоор бурдүүлэхэд эрх зүйн нөлөөг бууруулж, эрх зүйн хөтлөх, зохицуулах (локомотив) чанарыг үл хэрэгссэн, хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөөг хэт дөвийлгөсөн өнгөц ойлголт төрүүлэхүйц, тэгсэн атлаа хуурмаг тоглоом хүргэл хийж болдог шинжээрээ эрх зүйн тулгуур зарчим болох нийгмийн шударга ёсыг хэвлэл мэдээллийнхэн зөрчиж гүтгэж, гүйвуулж болохыг дэмжиж зөвшөөрсөн юм шиг ойлголтыг төрүүлж байна.

Одоо зөвшилцлийн тухай асуудлыг жичлэн авч үзье. Энэ чиглэлээр манайд цөөнгүй бүтээл хөрвүүлэгдэж нийгмийн салбартгажиглалт, судалгаа сүрхий идэвхтэй явагдаж байна. Улс төрийн амьдралд зөвшилцөл гэдэг нь амин чухал элементэд тооцогдож таарна. Тэнд зөвшилцлийн ардчиллыг хамгийн сонгодог хэлбэр хэмээн шүтэн номнох болов. Зөвшилцөлд хүрэхгүй бол юу ч хийх, бүтээх боломж алдагдах нь ээ. Улс төржсөн онол, арга зүйн ийм ойлголт манай хууль эрх зүйн амьдралыг ч тайван орхихгүй гэдгийг дээр цулас дурдсан.

Иргэний, арбитрын процессийн тэр ч атугай Үндсэн хуулийн цэц дээр хүргэл зөвшилцлийн хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрөх үндэслэл байгааг хэн ч угүйсгээгүй. Гэсэн хэдий ч тэдгээр ажиллагаанууд хэргийн бодит байдлыг төр, түүний байгууллагууд урьдчилан шалгаж, нотолгоо явуулж эцслэн тогтоох үүрэг хүлээдэг эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэхээс эрс ялгардаг. Манай эрдэмтэн судлаачид энэхүү онцлогийг ялан зааглах оролдлого төдийлөн хийхгүй байна. Бүр зарим нь “...хууль зүйн шинжлэх ухаанд үнэний тухай асуудал яригддаггүй, харин зөвшилцэл, зүй ёс, шударга ёс гол стандарт болдог. Тиймээс түүнийг тайлбарлан хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр нь бас харьцангуй...” хэмээн бичиж байна. (Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2015 оны №1, 7-8-р талаас дэлгэрүүлэн үзнэ үү). Мэдээж процесийн эрх зүйн бусад салбаруудад энэхүү үзэл, онолын тулгуур үндэслэл тогтсон эсэхийг тусгайлан судлах нь зүйн хэрэг. Харин Ром-Германы эрх зүйн бүл дэх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвшилцэл ноёрхох эсэх нь тун эргэлзээтэй. Учир нь Эрүүгийн процесст хэргийн бодит байдлыг тогтооно гэдэг нь зөвхөн тухайн цаг үетэйгээ амин уялдаатай ажиллагаа. Тэгэхдээ гүн ухааны “үгүйсгэлийн үгүйсгэл” гэсэн хуулийн шалгуураар биш, болж өнгөрсөн гэмт үйл явдлын баримт, мэдээллийг олж илрүүлэн буулгах нөр их хөдөлмөрөөр хэрэгжинэ. Тэрхүү эмзэг үүргийг холбогдох хуулиар мөрдөн шалгах тусгай эрх олгогдсон этгээд л биелүүлдэг.

Эрүүгийн шалган шийдвэрлэх ажиллагаа нь процесийн чиг үүргүүдийг заавалчгүй ялан зааглах чанд журмыг баримтална. Хэрэв гэмт хэргийн үнэн мөнийг тогтоо ажиллагаа харьцангуй гэж үзвэл шүүхийн шийдвэр бүхэн эцэс дүндээ хэлмэгдүүлэлтийн түүхэн баримт гарцаагүй болж хувирна.

Ер нь эрүүгийн процесс ажиллагаанд зөвшилцлийн элементүүд уламжлагдан үйлчилсээр ирсэн. Жишээлбэл, эрүүгийн хариуцлагыг (шинэ хуулиар ял шийтгэл гэж нэрлэсэн) хөнгөрүүлэх үндэслэлийн нэгэнд хохирогчтой эвлэрэх зүй ёсоор тооцогдог. Гэхдээ тэр нь зөвхөн хөнгөн хэрэг дээр, заавалчгүй төрийн хяналтын дор явагддаг байсан. Тусгай ангийн зарим хүнд зүйл ангид (жишээ нь: хүн барьцаалах, хулгайллах, худалдах хөргүүдийг тэр чатугай төрийн эсрэг зарим онц хүнд үйлдлүүдийг) хөнгөрүүлэн авч үзэх үндэслэлийг өөрт нь

жичлэн заасан байдаг. Тэр нь илүү хохирол, хор уршигт хүргэхгүйн тул жичлэн хуульчлагдсан харилцан буулт хийж буй хэлбэр. Энэ нь зөвшилцлэлтэй хэлбэр талаасаа төстэй боловч зорилго, агуулгын хувьд нэлээд ялгаатай.

Өдүүлэгдэн гарсан гэмт хэргийг илрүүлэх, хэргийн бодит байдлыг аль болох богино хугацаанд тогтоох нь эрүүгийн материаллаг болон процесийн эрх зүйн харилцаанд хамгийн амин чухал асуудал болохоос ял наймаалцах шинж бүхий зөвшилцлийг урьтал болгодоггүй онцлогтой.

ХБНГУ-ын нэрт эрдэмтэн Б.Шюнеманн гуай манай эрүүгийн процесийн хуулийн төслүүдэд санал биечлэн өгч байхдаа “АНУ-ын “ял наймаалцах” ажиллагаа танайд нөлөөлж болзошгүй байна. Ром-Германы эрх зүйн бүлийн эрүүгийн процесцд энэхүү “гаж зөвшилцэл” ихээхэн сөрөг нөлөө үзүүлнэ шүү” гэж анхааруулсан. Энэ талаар “Эрх зүйн” сэтгүүлийн 2010 оны №1-д нийтлэгдсэн “АНУ-ын эрүүгийн процес дэлхийд давамгайлж чадах уу” гэсэн монголчуудад тусгайлан зориулсан гэмээр илтгэлдээ маш тодорхой онцолсон байдал.

Өнөө үйлчилж буй эрүүгийн материаллаг болон процесийн хууль дахь нэлээгүй зохицуулалт нь чухамдаа англи-саксоны эрх зүйн бүлийн орнуудаас “нүүдэлчдийн сониучхан сэтгэлгээгээр шүүрч авсан” зөвшилцөөн нэрт ял наймаалцахад чиглэсэн алхмууд болох нь ажилгагддаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШтХууль)-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхдээ шүүгч дараах нөхцөл байдлыг анхаарахаар заажээ:

4.1.шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар нотлогдсон эсэх;

4.2.гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрсөн эсэх;

4.3.прокурорын сонсгосон ялыг хүлээн зөвшөөрсөн эсэх;

4.4.хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг зөвшөөрсөн эсэх.

Эндээс “ял наймаалцах” талруу илт тулхсэн зохицуулалт, жишээлхэд, прокурортой ямар хэмжээний ял оноогдох талаар “урьдчилан тохиролцо” шаардлага харагдаж байна.

Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шатанд урьдчилсан хэлэлцүүлэг явуулж болох тухай практик ач холбогдол бүхий зохицуулалт ЭХХШТХуульд шинээр нэмэгдсэн. Ер нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн үе шатуудын гол зорилго нь анхан шатны журмаар хар цагаанаа эцэслэн ялгуулахад л чиглэдэг юм. Тиймээс ч шүүх хуралдааны бэлтгэлийг сайтар хангах нь яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шатны /эцсийн бэлтгэл/ эрхэм зорилтын тэргүүнд зүй ёсоор тооцогдох учиртай. Гэтэл тэрхүү амин чухал үүргүүдийн эхний эгнээнд байх учиртай урьдчилсан хэлэлцүүлгийн үед яллагдагч:

- Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх;

- Учуруулсан хохирлоо нөхөн төлөх.

Хохирогчтой сайн дураар эвлэрснээ мэдэгдсэн бол хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа шууд үргэлжлүүлэн явуулж болохоор байгаа нь үндсэн зорилгоос онцгойрон “зөвшилцэлд” чиглэсэн зохицуулалт хэмээн ойлгогдож байна. Үүгээр ч зогсохгүй анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны үед (ЭХХШТХуулийн 34.1);

1. ...Хуралдаанаар... гэм буруутай эсэхийг тогтоосны дараа эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шийтгэх, цагаатгах асуудлыг шийдвэрлэх;

2. ... маргагч шүүгдэгчид... гэм буруутайд тооцсон шийдвэрийнхээ үндэслэлийг танилцуулсны дараа ... эрүүгийн хариуцлага хүлээлгэх шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулна;

3. ...Хохирлоо нөхөн төлөх ... санал хүсэлтийг үндэслэн шүүх хуралдааныг завсарлуулж болно гэсэн заалтуудын зорилго нь дахиад л “ял наймаалцаад чиглэсэн” зохицуулалт болжээ.

Тухайн ажиллагаанууд нь: шүүх хуралдааныг тасралтгүй явуулах зарчмыг зөрчиж шүүгчдийн дотоод итгэл бүрдэх,

улмаарт түүнд үндэслэн хэргийг бодитойгоор шийдвэрлэхдээ хөндлөнгийн нөлөөлөл орж болзошгүй зайд завсрыйг үүсгэж байна гэсэн уг. “Зөвшилцэлд” зориулагдсан гэмээр Эрүүгийн хуулийн заалт гэхэд “Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно. (Эрүүгийн хуулийн 6.7-р зүйл).

Түүнчлэн мөн хуулийн 6.5-д заасан хөнгөрүүлэх нөхцөл байдалд” зөвшилцэлд зориулагдсан байж болох хөнгөлөлтийг тусгаж энэ зүйлийн 1.1-т 3 жил хүртэл хорих, эсхүл түүнээс бага ял шийтгэлтэй гэмт хэрэг өдүүлсэн этгээд учруулсан хохирлоо нөхөн төлсөн, нөхөн төлөхөө илэрхийлж хохирогчтой эвлэрсэн бол ялаас чөлөөлөх, эсхүлтэнсэх, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авах, 1.3-т ... 8 жил хүртэл хорих ял шийтгэлтэй гэмт хэрэг үйлдсэн хүн хохирлоо нөхөн төлж хохирогчтой эвлэрсэн бол 8 жилийн ялын хагасаас (4) хэтрүүлэхгүй ял оноох, 1.4-т ... 12, 15 жил хүртэлх хугацаатай хорих ялтай гэмт хэрэг үйлдсэн этгээд хохирлоо нөхөн төлж хохирогчтой эвлэрсэн бол хуульд заасан ялын 2/3-с хэтрүүлэхгүй ял оноох зэргийг энд нэрлэж болно.

Манай процесс ажиллагаанд зөвшилцэл огт байж болохгүй гэж билүүгүсгээгүй. Учир нь зөвшилцэл нь:

- Процесс ажиллагааг хямд төсөр, энгийн ойлгомжтой болгодог. Чингэснээр цаг хугацаа, зардал, төсөв хөрөнгийн зарцуулалт илт багасна. (Хэмнэлт)

- Нийгэмд эерэг уур амьсгал бүрдүүлээд нааштайгаар нөлөөлне.

- Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг цаг алдалгүй нөхөж арилгах боломж нөхцөлийг бүрдүүлдэг зэргийг уүгүсгэж болохгүй биз.

Сөрөг тал ч бас нэлээдгүй бий. Энэ нь:

- Эрүүгийн процесс ажиллагаанд холбогдох зарчмуудыг “ул тоомсорлох” хандлага эрс нэмэгддэг. Ингэснээр (нийтийн) эрх зүйн хүмүүжил, ухамсарт муугаар нөлөөлөхөд хүрнэ.

- Нийгмийн шударга ёсны шалгуурыг тэр бүр хангадаггүй.

- Эрх зүйн бүлүүдийг “даяарших”, өөр хоорондоо ойртох үйлчлэл, үр нөлөө бүхий хуулийн зохицуулалт, эрх зүйн хэм хэмжээг ул суурьтай судалгаанд биш “сониу chirhan шүүрэх” арга барилд түлхэн оруулах зэргийг юуны урьд онцолж болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь маш их зардлаар явагддаг. Англид гэхэд нэг хүнд гэмт хэргийг мөрдөн шалгахад дунджаар (тухайн үеийн мөнгөн тэмдэгтээр) 250 мянган фунт стерлинг зарцуулдаг гэсэн судалгаа байдаг. Манайд энэ талаар тусгайлан судалгаа хийгдээгүй. Гэхэд Авиилгатай тэмцэх газар нэг хэргийг шалгахад 34 сая төгрөг зарцуулжээ гэсэн АТГ-ийн олон нийтийн зөвлөлийн даргын 2018 онд хэлсэн тоо баримт бий.

Жишээлбэл, Зориг агсны амь насыг бүрэлгэсэн хэргийг мөрдөн шалгахад хэчинээн хүн хүч, хөрөнгө зарцуулсныг тооцвол нүсэр тоо гарах биз. Үр дүнг нь авч үзвэл бүр ч аймшигтай санагдах байх.

Ял “наймаалцах” биш “зөвшилцөх” утгаар нь процесс ажиллагаанд ухаалгаар

хэрэгжүүлбэл болохгүй гэх газаргүй. Гэхдээ эрх зүйн аль бүлд, онол арга зүйн ямар үндэслэлээр хэрхэн, яаж хэрэгжүүлэхээ уламжлал, шинэчлэлийн үүднээс тун ухаалгаар, зөвхөн судалгаанд тулгуурлан зөвшилцлийг зохицуулах үндсийг бүрдүүлбэл ашиг тусаа өгөх байх.

Жичлэн тэмдэглэхэд: “ил тод, бүдүүлэг” гэгдэх хэргүүдэд Ром-Германы эрх зүйн бүлийн ямар ч орнуудад “зөвшилдөөн” явагдах боломж тун бага. Харин “цагаан захтан”-уудын гэгдэх далд үйлдэл, нууц ажиллагаатай өмгөөлөл, хамгаалал бүхий хэргүүдэд зөвшилцөөн өрнөж таарна. Жастин Капла мэтэд яаран сандран уччал үзүүлж зулгуйдаж байсанд орвол “олигарх” луйварчдаас зөвшилцөл нэрийдлээр хэд гурван юм салгаж албал бараг “бут ниргүүлсэн” гэмэр хуулийн байгууллагад өлзийтэй биз хэмээн бодох я юм. Эрүүгийн процесс дахь зөвшилцөлд төөрч бүдлисан эрдэмтдээс орчин цагийн “шударга” улс төрчид илүүтэй шунан дурлаж эхэлснийг хуулийнхан маань жичлэн анхаарах нь зүйтэй юм.

---00---

ЭКСТРЕМИСТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ХҮЛЭЭЛГЭХ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



*Олон улсын Улаанбаатарын их сургуулийн
дэд профессор, хууль зүйн доктор
Ц.Доржсамб*

ТҮЛХҮҮР ҮГС:

Экстремизм, экстремист үйл ажиллагаа, терроризм, экстремист чиглэлийн гэмт хэрэг, эрүүгийн хариуцлага

ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүлэл нь экстремист үйл ажиллагаа явуулах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар гадаад орнуудын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг өөрийн орныхтой харьцуулан судлахад чиглэгдсэн болно.

УДИРТГАЛ:

Экстремизм гэсэн нэр томьёог анх 20 дугаар зууны эхээр Францад тухайн үеийн хуульч М. Лерой улс төрийн хүчинчдээс улс төрийн тэмцэл явуулахаа экстремист аргыг хэрэглэж байгаа талаар¹ хөндөж тавьснаар шинжлэх ухааны судалгааны эргэлтэд оруулсан түүхтэй билээ. Орчин үед экстремизм нь гүн ухаан, социологи, улс төр судлал төдийгүй хууль зүйн шинжлэх ухааны судалгааны объект болж

¹ Дворянов В.А. Политический экстремизм в Центральной Европе //терроризм и политический экстремизм: вывозы и поиски адекватных ответов. М: Институт политического и венного анализа , 2002 с47-48

байна.

Олон улсын түвшин дэх экстремизмийн тархалт нь улс орнуудын хууль тогтоогчдоос уггэмт явдалтай тэмцэх талаар холбогдох арга хэмжээ авахыг шаардсаар ирсэн билээ. Даяарчлалын үйл явцтай уялдан үндэстний болон олон улсын, гадаад орнуудын хууль тогтоомжийг уялдуулан нийцүүлэхийн шаардлага тавигдаж байна.

НҮБ-ас экстремизмийн аливаа хэлбэр нь олон улсын хамтын нийгэмлэг, бүх нийтийн аюулгүй байдалд заналхийлэл учруулж буйг хүлээн зөвшөөрч, экстремист ажиллагаатай тэмцэх чиглэлийн олон тооны бичиг баримтууд гаргаж иржээ. Үүнд:

Экстремизмтэй тэмцэх олон улсын тулгуур баримт бичиг нь 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал билээ (ялангуяа 1-5, 7, 9-10, 13.14.16.18-20, 28 дугаар зүйлүүд). Түүнчлэн экстремизмтэй тэмцэх ажиллагааны нэг гол баримт бичиг нь Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын факт юм. Түүнд арьсны өнгө, яс үндэс, шашны шүтлэгээс үл хамааран иргэд эрх тэгш байх зарчмыг тодорхойлж өгсөн. Гэхдээ олон улсын бичиг баримтад экстремист (хэт даварсан) үйл ажиллагааны тухай тодорхойлж өгөөгүй байсан бөгөөд 1994 оны 12 дугаар сарын 9-нд НҮБ-ын ЕА-аар батлагдсан “Олон улсын терроризмыг устгах арга хэмжээны тухай” тунхаглалд анх удаа экстремизм гэсэн нэр томьёог авч хэрэглэсэн² бөгөөд экстремизм гэсэн нэр томьёог хэрэглэхдээ түүний талаар тодорхойлолт өгөхгүйгээр зөвхөн түүнийг терроризмтэй шуд холбоотой болохыг заасан байдаг.

Олон улсын шинжгүй зэвсэгт мөргөлдөөний хохирогчдыг хамгаалах

²http://www.un.org/ru/documents/decl_conv/declarations/terrdecl.shtmlДекларация о мерах по ликвидации международного терроризма

асуудлаарх 1949 оны Женевийн Конвенцийн 1977 оны нэмэлт протоколын нэгдүгээр зүйлд аливаа зэвсэгт мөргөлдөөн нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг зөрчсөн бол түүнийг олон улсын эксремизмын илрэл гэж үзэхийг зөвлөсөн билээ.

Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын “Терроризм, салан тусгаарлах үзэл, экстремизмтэй тэмцэх тухай” 2001 оны конвенцид³ “Экстремизм гэж төрийн эрх мэдлийг хүчээр булаан авах, эсвэл хүчээр тогтоон барих, түүнчлэн үндсэн хуульт байгууллагын хүчээр өөрчлөхөд чиглэсэн аливаа үйлдэл, нийгмийн (олон нийтийн) аюулгүй байдалд хүч хэрэглэн халдсан үйлдэл, түүний дотор дээрх зорилгоор хууль бус зэвсэгт бүлэглэл байгуулах, эсвэл түүний үйл ажиллагаанд оролцох үйлдлийг хэлнэ”⁴(орч.зохиогч) гэж тодорхойлсон.

Дэлхийн улс орнууд олон улсын гэрээ, конвенцуудын хүрээнд экстремист үйл ажиллагаатай тэмцэх асуудлыг хамтын ажиллагааны янз бүрийн түвшинд зохицуулахын хамт, дотоодын хууль тогтоомжоо улам боловсронгуй болгож байна. Ялангуяа эрүүгийн хууль тогтоомждоо экстремист үйл ажиллагаа үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.

Харин Монгол Улсын Эрүүгийн хуулинд “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, саатуулах”, “Төрийн өндөр албан тушаалтны амь насанд халдах”, “Үндэсний эв нэгдлийг бусниулах”, “Зэвсэгт үймээн дэгдээх” болон терроризмын гэмт хэрэг зэрэг экстремист чиглэлийн гэмт хэргүүдэд эрүүгийн хариуцлагахүлээлгэх зохицуулалт үйлчилж ирсэн бөгөөд 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хуулиар терроризм, терроризмын санхүүжүүлэх, терроризмыг сурталчлах зэрэг гэмт хэргийг өөрчлөн, 19.8 дугаар зүйлд Экстремист үйл ажиллагаа явуулах, 20.1-20.2 дугаар зүйлд “Террор үйлдэх талаар зориуд

³<http://kremlin.ru/supplement/3405>

⁴ Шанхайская Конвенция о борьбе с терроризмом, сепаратизмом и экстремизмом, Шанхай, 15 июня 2001 г.

худал мэдээлэх”, “Террор ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх” зэрэг гэмт хэргийг шинээр оруулсан нь мөрдөгдөж эхлээд хоёр жил болох гэж байна. Эрүүгийн хуульд Экстремист үйл ажиллагаа явуулах гэмт хэргийн объектив талын шинжийг “Үндсэн хуульт тогтолцоо, төрийн байгууламжийг хууль бусаар, хүч хэрэглэн өөрчлөх, устгах зорилгоор улс төр, шашны үйл ажиллагаа явуулсан, энэхүү үйл ажиллагаа явуулахаар тодорхой бүлэг байгуулсан, бусдыг элсүүлсэн бол...” гэж тодорхойлсон. Иймээс экстремист гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын эрх зүйн зохицуулалтыг бусад улсуудынхтай харьцуулан судлах зорилго тавилаа.

Гадаад зарим орнуудын эрүүгийн хууль тогтоомж

ХБНГУ-ын Эрүүгийн хууль⁵ экстремистчиглэлийнгэмхэрэгтэйтээмцэхэд гэмт хэргийн нэлээд хэдэн бүрэлдэхүүнийг тодорхойлж өгсөн байdag. Уг хуулийн тусгай ангийн “Арчилсан эрх зүйн төрд заналхийлэх гэсэн З дугаар бүлгийн 86 дугаар зүйлд Үндсэн хуульт байгууллагын эсрэг ухуулга сурталчилгааны материал тараах үйлдэлд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тодорхойлсон. Хуулийн энэ хэм хэмжээ нь ухуулга сурталчилгааны материалыг хэвлэн нийтлэх, тараах гэмт үйлдлээр хязгаарлахгүй, түүнийг тус улсын нутаг дэвсгэрт нэвтрүүлж оруулах үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор заасан онцлогтой. Мөн хуулийн 86а зүйлд үндсэн хуульт байгуулалт нийцээгүй (харшилсан) тэмдэглэгээ ашигласан үйлдэлд хариуцлага хүлээлгэх хэм хэмжээг тогтоосон байdag. Гэхдээ ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлийн З дахь хэсэг, 86а дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хэрвээ эдгэрэж материал, тэмдэглэгээ нь Үндсэн хууль, урлаг, шинжлэх ухаан, түүхтэй зөрчилдөөгүй иргэдийн ухуулга сурталчилгааны хэрэгсэл болсон бол гэмт хэргийн бүрэлдэхүүнгүйд тооцох талаар тусгасан нь онцлог юм. Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн “Төрийн засаглалын эсрэг үйл ажиллагаа” гэсэн 6 дугаар

⁵<https://constitutions.ru/?p=5854> Уголовный кодекс ФРГ

хэсэгт экстремизмийн шинжтэй зарим гэмт хэргийг оруулсны дотор, 111 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрийн эсрэг хууль бус үйлдэлд олон нийтийн өмнө уриалсан баримт материал тараасан үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор заасан. Түүнчлэн хуулийн 7 дугаар хэсэгт нийтийн амгалан тайван байдлын эсрэг үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Тухайлбал уг эрүүгийн хуулийн 129а зүйлийн “с” хэсэгт террорист байгууллагыг байгуулсан үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

Францын Эрүүгийн хуулийн⁶ 1 дүгээр бүлэгт террорист үйлдлийн тухай, 2 дугаар бүлэгт терроризмын тухай хуульчлан тогтоосон. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 421-1 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт нийгмийн дэг журмыг алдагдуулах зорилгоор айлан сурдуулж, эсхүл террор үйлдэл хийж, хүний ам нас, хувийн халдашгүй байдалд санаатайгаар халдах, хулгайлах, эсхүл эрх чөлөөг нь хууль бусаар хязгаарлах, агаарын хөлөг, бусад нисэх хэрэгслийг хулгайлах гэмт үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

Францын Эрүүгийн хуульд террор үйлдэл гэдгийг нилээд өргөн утгаар авч үздэг. Тухайлбал, террор үйлдэлд дээрх зорилгоор үйлдсэн нийгэмд аюултай бусад үйлдлийг ч хамааруулдаг⁷. Францын Эрүүгийн хуулийн 421-3, 421-4, 421-5 зүйлд заасан террор үйлдэлд хорих ялыг торгох ялтай хамт хэрэглэдэг.

Мөн Эрүүгийн хуулийн R-625-7 дугаар зүйлд үндэс угсаа, арьс өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхах, үзэн ядалт, эсхүл хүчирхийлэлд олон нийтийн өмнө өдөөн турхирсан үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор заасан. Францын Эрүүгийн хуулийн R-40-3 дугаар зүйлд олон улсын цэргийн шүүхийн дүрмийн 9 дүгээр зүйлээр, эсхүл Франц Улсын болон олон улсын шүүхээр хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутгагдсан байгууллагын билэг тэмдэг, тэмдэглэгээг зүүсэн, олон

нийтэд сурталчилсан үйлдэлд хариуцлага хүлээхээр заасан.

Франц, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан экстремист чиглэлийн гэмт хэрэгт хүлэх хариуцлагын талаарх эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг харьцуулан шинжлэхэд дараах онцлог байна үзэж байна. Үүнд: нэгдүгээрт, францад энэ төрлийн гэмт хэрэгт хувь хүн, хуулийн этгээдэд аль алинд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Хоёрдугаарт, эрүүгийн хуульд энэ төрлийн гэмт хэрэгт зөвхөн ялын уламжлалт төрлийг (хорих ял) хэрэглэхээс гадна торгох, эрх чөлөөг түр хугацаагаар хязгаарлах ялыг хэрэглэж байна.

Их Британи Улсад экстремизмийн онцгой хэлбэр болсон терроризмтэй хийх тэмцлийг хүчтэй болгоход анхаарч, 1974 онд Терроризмээс урьдчилан сэргийлэх тухай хууль гарган, улмаар 2000 оны Терроризмын тухай хуулиар Их Британы нутаг дэвсгэрт болон өөр улсад үйлдсэн террор ажиллагаанд хариуцлага хүлээлгэхээр болсон, Энэ хуулиндаа терроризмын үндсэн шинж, ойлголтыг тодорхойлж өгсөн. Үүнд: хүч хэрэглэх эсхүл хүч хэрэглэхээр заналхийлэх, өмч хөрөнгөнд хор хохирол учруулах, учруулахаар заналхийлэх, нийгмийн аюулгүй байдал, эрүүл мэндэд заналхийлж, ялангуяа цахим мэдээллийн тогтолцоог хорлон сүйтгэх зэрэг үйлдлийг энэ гэмт хэрэгт хамааруулан үзэхээр хуульчилсан. Гэхдээ дээрх гэмт үйлдлийг улс төр, шашны болон үзэл суртлын сэдэлтээр Засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаа, нийгмийг сурдуулэхэд нөлөөлех зорилгоор үйлдсэн нөхцөлд терроризм гэж тооцохоор заасан. Мөн 2001 оны 10 дугаар сарын 21-нд “хуурамч терроризмын” тухай хууль баталж, террор үйлдэхээр хуурамч дуудлага өгөх жагсаалтыг гоц халдварт өвчин, химийн эсхүл цөмийн зэвсэг хэрэглэхээр сурдуулэх үйлдээр өргөжүүлж, эдгээр үйлдэлд 7 жил хүртэл хорих ял хүлээхээр болжээ⁸.

Их Британид 2001 онд “Терроризм, гэмт явдалтай хийх тэмцэл ба аюулгүй

⁶ См.: Власов И.С. Зарубежное законодательство в борьбе с терроризмом. М., 2002. С. 54.

⁷ <https://constitutions.ru/?p=5859> Уголовный кодекс Франции

⁸ Узэх. Никитин А.Г. Экстремизм как объект общественно-политического и общеправового анализа: дис....канд. юрид.наук. Казань, 2010.с.115)

байдлын тухай” хууль баталсан нь экстремист үйл ажиллагаатай тэмцэхэд чухал эх сурвалж болсон бөгөөд энэ нь үй олноор хөнөөх зэвсгийн хууль бус эрглэлтэд хүлээлгэх хариуцлагыг тогтоож өгсөн ач холбогдолтой⁹.

Дээрх судалгаанаас үзүүлэлт, Их Британи Улс нь экстремизмийн янз бүрийн илрэлтэй тэмцэх зорилгоор хууль тогтоомж шинээр гарган хэрэгжүүлж иржээ. Ялангуяа экстремизмийн хамгийн радикал илрэл болох улс төр, шашны болон үзэл суртлын сэдэлтээр үйлдэгддэг терроризмтэй тэмцэхэд түлхүү анхаарал хандуулдаг онцлогтой байна:

АНУ-д экстремист чиглэлийн гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг зохицуулсан хууль тогтоомжийн системчлэл байхгүй. Харин тухайн гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг зохицуулсан хэд хэдэн хуулиуд үйлчилдэг. АНУ-ын Хуулиудын эмхтгэлийн 2383 хэсэгт АНУ-ын төрийн эсрэг бослого, зэвсэгт үймээн өдөөн турхирах, зохион байгуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх эсхүл оролцоход эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Хуулиудын эмхтгэлийн 1136 бүлэгт дотоодын терроризмыг хүний амь насанд заналхийлсэн, энгийн иргэдийг айлан сурдуулэх, эсхүл хүчинчийлэх, засгийн газраар шийдвэр гаргуулахад чиглэгдсэн, төр, засгийн төлөөлөгчдийг алах, эсхүл хулгайлсан хууль бус ажиллагаа гэж тодорхойлсон байdag.

АНУ-ын Хуулиудын эмхтгэлийн 2332в дэвтэрийн 5 дахь хэсэгт зааснаар террорист чиглэлийн гэмт хэрэгт нийгэмд аюултай 48 төрлийн үйлдлийг хамруулсан¹⁰. Тухайлбал, төрийн албан хаагчийг алах, алахыг завдах, тээвэр, харилцаа холбооны хэрэгслийг устгах, гэмтээх, экстремист байгууллагын үйл ажиллагаанд эд материалын дэмжлэг үзүүлэх гэх мэт. Дээрх зохицуулaltaас үзэл, АНУ-ын экстремизмтэй тэмцэх

эрүүгийн хууль тогтоомжийн онцлог нь экстремизмтэй хийх тэмцлийг түүний онцгой хэлбэр болох терроризмтэй явуулах тэмцлээр дамжуулан хэрэгжүүлдэг байна.

БНХАУ нь 2015 онд анх удаа Терроризмтэй тэмцэх тухай хууль гарган, террорист ажиллагаатай тэмцэх эрх зүйн үндсийг тодорхойлсны дотор террорист гэмт хэрэгт холбогдсон этгээдийг өөрийн улсын болон бусад улсын нутаг дэвсгэрт байхаас үл хамааран мөрдөн шалгах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн онцлогтой. 2001 онд Хятадын Эрүүгийн хуулийн 120 дугаар зүйлд заасан террорист байгууллагыг байгуулах, удирдах, үйл ажиллагаанд нь оролцсон этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатган 10 жилээс дээш хугацаагаар хорих ял, эсхүл бүх насаар нь хорих ял оногдуулах, терроризмыг саңхүүжүүлэхийг тухайн гэмт хэргийн бүрэлдүүний шинж болгон нэмэлт өөрчлөлт оруулсан¹¹.

Тус улсын Эрүүгийн хуульд¹² 294 дүгээр зүйлд экстремизмийн шинжтэй хэд хэдэн гэмт үйлдлийг экстремист чиглэлийн гэмт хэрэгт хамааруулсан. Тухайлбал, төрийн эрх мэдлийг булаах, ард түмнийг дарангуйлах зорилгоор нууц байгуулага байгуулах, удирдах эсхүл түүний үйл ажиллагаанд оролцох гэмт үйлдлийг хамааруулжээ. Гэхдээ эдгээр үйлдэл нь зөвхөн хятадын нийгмийн байгуулал, эдийн засагт ноцтой хор хохирол учруулбал гэмт хэрэгт тооцогдохоор заасан онцлогтой. Эрүүгийн хуулийн эдгээр хэм хэмжээ нь тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний объектыг нийгмийн аюулгүй байдал, үндсэн хуульт байгууллаар хязгаарлахгүйгээр хятадын эдийн засгийн аюулгүй байдал, иргэний ашиг сонирхол байхаар хуульчлан тогтоожээ.

Мөн БНХАУ-ын Эрүүгийн хуульд 2015 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр 120 дугаар зүйлд террорист ажиллагаатай холбоотой 5 төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг шинээр нэмж оруулсан¹³.

⁹ Anti-Terrorism, Crime and Security Act 14th December 2001 (UK Public General). [Электронный ресурс]. URL: <http://www.opsi.gov.uk>

¹⁰ United States Code [Электронный ресурс]. // Office of the Law Revision Counsel United States Code. –Режим доступа: <http://www.uscode.house.gov>

¹¹ Цан Цээмэй. Обзор к уголовного законодательства о борьбе с терроризмом и «Закона о борьбе с терроризмом» Китая. Евразийский Научный Журнал №5 2016

¹² Зууннасан. Э.Батзориг. БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль. Уб., 2006 он.

¹³ Цан Цээмэй. Дурдсан бүтээл.

Үүнд: 120 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт террорист ажиллагаанд бэлтгэх, мөн зүйлийн 3 дахь хэсэгт террорист болон экстремист ажиллагааг дэлгэрүүлэх, эсхүл террорист ажиллагаа үйлдэхэд өдөөн турхирах, мөн зүйлийн 4 дэх хэсэгт экстремизмын зорилгоор хуулийг буруу хэрэглэх, мөн зүйлийн 5 дахь хэсэгт террорист болон экстремист ажиллагааг сурталчлах зорилгоор гоёлын зүйл, тэмдэг хэрэглэхийг албадах, мөн зүйлийн 6 дахь хэсэгт терроризм болон экстремизмийг дэлгэрүүлэх зорилгоор эд зүйлийг хууль бусаар эзэмших гэмт хэргүүдийг нэмж оруулсан байdag. Түүнчлэн уг хуулийн 322 дугаар зүйлд террорист ажиллагаанд бэлтгэх, зохион байгуулахад оролцох, эсхүл террорист ажиллагаа үйлдэх зорилгоор улсын хилээр хууль бусаар нэвтрэх үйлдлийг улсын хил хууль бусаар нэвтрэх гэмт хэргийн хүндүүлэх бүрэлдэхүүн болгон нэмэлт оруулж, энэ хэрэгт торгох, 1-3 жил хүртэл хугацаагаар хорих ял, эсхүл 1 жил хүртэл хугацаагаар баривчлах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ба торгох ял оногдуулахаар тогтоож өгчээ.

2017 оны 3 дугаар сарын 30-нд БНХАУ-ын хууль тогтоох байгууллага Шинжаан Уйгурын Өөртөө Засах Орон дахь экстремизмтэй тэмцэх хууль батлан¹⁴ гаргаж хэрэгжүүлж байна.

Австрийн Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэг (нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг гэмт хэрэг) 283 дугаар хэсэгт “Хэн нэг нь Австрийн нутаг дэвсгэрт байдаг сүм хийдийн эсвэл шашны нийгэмлэгийн эсрэг, сүм хийдийн эсвэл шашны нийгэмлэгт хамаарах хүн амын тодорхой бүлгийн эсрэг, эсвэл үндэс угсаа арьсны өнгөөр нь тодорхой бүлгийг ялгаварлан гадуурхаяг олон нийтэд уриалсан эсвэл энэ үйлдлийг хийхийг өдөөн турхирсан нь нийгмийн дэг журамд аюул учруулахаар бол 2 жил хүртэл хугацаагаар хорих ял хүлээлгэхээр заасан байдаг¹⁵.

¹⁴ <https://tass.ru/mezhdunarodnaya-panorama/4140853>

¹⁵ Уголовный кодекс Австрии / науч. ред. и вст. ст. д.ю.н., проф. С.В. Милюкова; предисл. Ген. прокурора Австрии, докт. Эриста Ойгена Фабриции; пер. с немец. Л.С. Вихровой. – СПб., 2004.

ОХУ-ын хууль тогтоомжид экстремизмын тухай ойлголтыг анх 2002 оны Экстремист үйл ажиллагаатай тэмцэх тухай хуульд тодорхойлж өгч, улмаар 2006 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр экстремист үйл ажиллагаанд хамаарах гэмт үйлдлийн каталогийг оруулж өгсөн¹⁶.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэг (“Үндсэн хуульт байгуулалт, үндсэний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг”), болон 29 дүгээр бүлэгт (“нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг”) экстремист чиглэлийн гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тодорхойлсон. Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэгт төр нийгмийн зүтгэлтний амь насанд халдах (277 дугаар зүйл), төрийн эрх мэдлийг булаан авах, хүчээр тогтоон барих (278 дугаар зүйл), экстремист үйл ажиллагаа явуулахыг олон нийтэд уриалах (280 дугаар зүйл), үзэн ядалт, дайсагналцал, хүний нэр төрийг гутаан доромжлол өдүүлэх (282 дугаар зүйл), экстремист байгууллага байгуулах (282.1 дүгээр зүйл), экстремист байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах (282.2 дугаар зүйл) экстремист үйл ажиллагаа явуулсны улмаас үйл ажиллагааг нь шүүхийн шийдвэрээр зогсоосон төрийн бус байгууллага, шашны болон бусад байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулсан бол эрүүгийн хариуцлага хүлээхээр заажээ¹⁷. Экстремист байгууллага байгуулах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжийг:

а) Экстремист чиглэлийн гэмт хэрэг үйлдэх, түүнд бэлтгэх зорилгоор экстремист байгууллага байгуулах, уг байгууллагыг удирдах түүнчлэн экстремист чиглэлийн гэмт хэрэг үйлдэх төлөвлөгөө, нөхцөлийг боловсруулах зорилгоор дээрх байгууллагын удирдагчид, зохион байгуулагчид, бусад төлөөлөгчдийг нэгтгэсэн байгууллагыг байгуулах;

б) Экстремист байгууллагын үйл ажиллагаанд бусдыг элсүүлэх, бусад аргаар

¹⁶ <http://base.garant.ru/12127578/> Федеральный закон от 25 июля 2002 г. N 114-ФЗ “О противодействии экстремистской деятельности” (с изменениями и дополнениями)

¹⁷ Уголовный кодекс Российской Федерации. 1996

татан оролцуулах;

с) Экстремист байгууллагын үйл ажиллагаанд оролцох гэж тодорхойлсон байдаг.

Үг зүйлийн тайлбарт, экстремист чиглэлийн гэмт хэрэгт нийгмийн ямар нэгэн бүлгийг улс төр, үзэл суртал, арьсны өнгөөр ялгаварлах сэдэлтээр эсхүл үзэн ядах, дайсагналцах сэдэлтээр үйлдэгдсэн гэмт хэргийг хамааруулан ойлгоно гэж тайлбарласан онцлогтой. Түүнээс гадна ОХУ-д Терроризмтэй тэмцэх тухай 2006 оны хуулиар терроризмтэй тэмцэх ажлыг зохицуулж ирсний зэрэгшээ Эрүүгийн хуулийн 205-205.2 дугаар зүйлд Террор үйлдэл хийх, Террор ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Террор ажиллагаа явуулахыг нийтэд уриалах, терроризмыг нийтийн өмнө зөвтөх, эсхүл түүнийг сургалчлах зэрэг гэмт хэргүүдийн бүрэлдэхүүнийг тодорхойлж өгсөн.

Польш Улсын 1997 оны Эрүүгийн хуулийн “Энхтайван хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг” гэсэн 16 дугаар бүлэг, 119 дүгээр зүйлд “хэн нэгэн нь үндэстний болон арьсны өнгө, улс төр, шашны бүлэгт хамаарах, эсхүл ямар нэг шашны бүлэгт хамаарахгүй байдлаар бүлэг хүмүүс, тодорхой этгээдийн эсрэг хүч хэрэглэсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан (3 сараас 5жил хүртэл). Мөн олон нийтийг уг үйлдэл хийхийг уриалсан бол хариуцлага хүлээлгэхээр заажээ¹⁸.

Дүгнэлт:

Экстремист үйл ажиллагаатай тэмцэх эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг

¹⁸ <http://law.edu.ru/norm/norm.asp?normID=1246817> Уголовный кодекс Польша

харьцуулан судалсны үндсэн дээр дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Судалгаанд хамрагдсан улс орнуудын хувьд экстремист чиглэлийн гэмт хэргүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг эрүүгийн хуулиндаа тусгахдаа тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг өөр өөрийн онцлогтой тодорхойлсны дотор экстремист үйл ажиллагаа явуулах гэсэн гэмт хэргийн бие даасан бүрэлдэхүүн байхгүй байна.

2. БНХАУ, ОХУ-д экстремист болон террорист ажиллагаатай аль алинтай нь тэмцэхэд түлхүү анхаарч Экстремист үйл ажиллагаатай тэмцэх тухай хууль, Терроризмтэй тэмцэх тухай хууль, эрүүгийн хуулиар зохицуулан, экстремист чиглэлийн гэмт хэргийн каталогийг нилээд өргөн хүрээнд авч үзсэн, АНУ, Их Британи, Франц зэрэг улсад экстремизмын онцгой хэлбэр болох терроризмтэй хийх тэмцэлд түлхүү анхаарч эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлж өгчээ.

3. Манай улсын Эрүүгийн хуульд экстремист чиглэлийн гэмт хэргэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын тогтолцоо байсаар байтал экстремист үйл ажиллагаа явуулах гэсэн бие даасан гэмт хэргийн бүрэлдэхүүн болгон хуульчилсан, гэхдээ экстремист үйл ажиллагаа явуулах, экстремист байгууллага байгуулах гэсэн хоёр өөр гэмт хэргийн бүрэлдэхүүнийг нэг гэмт хэрэг болгон заасан байгааг эргэж харах шаардлагатай.

4. Гадаад орнууд дахь экстремист болон террорист чиглэлийн гэмт хэргийн эрүүгийн хариуцлагын тогтолцооны хөгжлийн үйл явцыг гүнзгийрүүлэх судлах нь үндэсний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ач холбогдолтой.

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ШҮҮХ ТОГТОЛЦОО: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА БА МОНГОЛ УЛС



*Дотоод хэргийн их сургуулийн
дэд профессор, хууль зүйн доктор
Ю.Бадамчанд*

ТҮЛХҮҮР ҮГС:

Хүүхдэд ээлтэй шүүх тогтолцоо (Англи. Juvenile justice, орос. ювенальная юстиция), хүүхэд, өсвөр үеийн шүүх, шүүхийн бус загвар, сонголтод (альтернатив), шүүхийн бус байгууллага (англ. quasi-judicial organs, quasi-judicial tribunal, орос. квазисудебные органы), эвлэрүүлэн зуучлал (англ. Mediation, орос. медиация), хорихоос өөр төрлийн ялыг хэрэгжүүлэх (Англи. Probation, орос. пробыация) байгууллага, нөхөн сэргээх технологиуд (англ. Restorative justice, орос. восстановительные технологии).

ТОВЧЛОЛ:

Энэ өгүүлэлд олон нийтийн анхаарлын төвд байдаг хүүхдэд ээлтэй шүүх тогтолцооны талаар судлан авч үзэж, манай улсад хэрэгжүүлж болохуйц арга технологийн талаар тодорхой санал дэвшүүллээ.

УДИРТГАЛ:

Өнөөдөр дэлхийн улс орнууд хүүхдэд ээлтэй орчин, түүний дотор нийгмийн хамгийн эмзэг хэсэг хүүхэд, өсвөр үеийнхний нас, бие маход, сэтгэлзүй,

хөгжлийн түвшингийн онцлог байдлыг харгалзсан шүүх тогтолцоог бий болгохыг зорьж, насанд хүрээгүй хүмүүсийг хууль зөрчсөн тохиолдолд шийтгэх гэхээс илүүтэйгээр хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг чухалчлан авч үздэг болсон.

Эрүүтийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцонд насанд хүрээгүй хүмүүстэй холбоотой хэргийг шалган шийдвэрлэх асуудал чухал байр суурь эзэлдгийн учир нь хүүхэд нас, бие, сэтгэхүйн хувьд томчуудаас ялгадах онцлогтой¹, тэдэнд онцгой халамж, анхаарал хандуулах ёстойд оршиж байгаа билээ².

Монгол Улс хүүхэд хамгааллын чиглэлээрх олон улсын гол гол гэрээ, конвенцод нэгдэн орж (соёрхон баталж), хүүхдийн эрхийг энэ тэргүүнд ханган хамгаалах үүрэг хүлээсний учир хүүхдийн асуудлыг тусгайлан авч үзэх, шүүхийн болон цагдаагийн байгууллагад хүүхдийн асуудлаар тусгайлан бэлтгэгдсэн, дагнасан нэгж (мэргэшсэн ажилтан, алба хаагч) ажиллуулах шаардлага байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан шүүх тогтолцооны тухай ойлголт анх XVIII зууны сүүлээр яригдаж, XIX зууны эхээс зарим улс оронд зохион байгуулагдаж эхэлжээ.

Хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан шүүх тогтолцоо (англ. Juvenile justice, орос. ювенальная юстиция) нь тодорхой

¹ "Хүүхдийн онцлогт токирсон" гэж хүүхдийн хамгаалгадах эрхийг эн тэргүүнд авч үзэг бэгээд тухайн хүүхдийн хэргизээ, болд санааг харгалзан үзэг арга ажиллагааг хэлнэ. Гэмт хэргийн хохирогч, гэрч болсон хүүхдэд холбогдох байсан шийтгэх ажиллагааны тухай загвар хууль ба холбогдох тайлбар. //Монгол Улсад насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдээн гэмт хэргийн шалтгаан нөхцөл" сэдэвт судалгааны ажлын тайлан. ЦЕГ, ХСИС. Уб., 2018 он, 214 дэх тал.

² НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц. Удиртгал хэсэг.

байгууллага (институт)-д бүхий эсхүл тогтолцоожсон байх гэсэн хоёр үндсэн шалгууртай. Тодорхой байгууллагууд бүхий байх гэдэг нь гадаад бүтэц тогтолцоог илэрхийлэх буюу тодорхой зохион байгуулалт, чиг үүргээ бүхий зохих байгууллага, алба/нэгжтэй байхыг ойлгодог бол, тогтолцоожсон - тухайн улсын эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурь, үйл ажиллагааны зориулалтыг илтгэдэг.

Тэрхүү шүүхийн институтчилэгдсэн байгууллагуудыг шүүхийн ба шүүхийн бус загварын гэж хоёр ангилдаг. Хүүхэд, өсвөр үеийн шүүхийн загвар хоёр хэлбэртэй байна: 1) насанд хүрээгүй хүмүүсийн асуудал эрхэлсэн бие даасан тусгайлсан шүүх, 2) бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр томилогдсон энэ асуудлаар мэргшсэн шүүхийн бүлэг, шүүгчдийн бүрэлдэхүүн, тодорхой шүүгч ажиллуулж байна.

Харин шүүхийн бус загвар нь сонголтод (альтернатив) ба шүүхийн бус байгууллага³ (англ. quasi-judicial organs, quasi-judicial tribunal, орос. квазисудебные органы) гэсэн хоёр хэлбэртэй:

- Сонголтод (альтернатив) хэлбэр нь 2 янзын хувилбаргаар зохион байгуулгаждаж болно. 1.Шүүхийн өмнөх шатанд шүүхийн харьяаллын байгууллагуудын оронд шүүхийн бус байгууллагуудыг сонгох боломжтой байх; 2.насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг шүүн таслах ажиллагааны явцад хэрэг маргааныг шүүн хэлэлцэх бүрэн эрхтэй шүүхийн бус байгууллагыг сонгон ашиглах боломжтой байх.

³ Шүүхтэй төстэй буюу аливаа гомдол, маргааныг хүлээн авч зохих (жинтэй) шийдвэр гаргах эрхтэй. Тэдгээр шүүх эрх мэдлийг орлосон олон байгууллагуудыг олон улсын, үндэсний, улсын, олон нийтийн, холимог г.м. ангилдаг. Ж: Үндсэн хуулийн зөвлөл, Тангарагатний шүүх, Олон улсын худалдааны байгууллага, Дүрвэгдийн асуудал хариуцсан комисс, Олон улсын хар тамхины эргэлтэд хяналт тавих хороог т.м.

<https://translate.academic.ru/%D0%BA%D0%B2%D0%B0%D0%80%D7%D0%8B%D1%81%D1%83%D0%84%D0%85%D0%80%D1%81%D0%BD%D1%8B%D0%80%D9%20%D0%BE%D1%80%D0%B3%D0%80%D0%BD/xr/ru/>
Квазисудебные органы.
https://studref.com/379525/pravo/kvazisudebnye_organy_integrasionnogo_pravosudiya

Шүүхийн бус байгууллага гэдэгт “Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс”, Эвлэрүүлэн зуучлал зэрэг аливаа маргааныг шүүх эрхтэй, гаргасан шийдвэр нь биелэгдэх боломжтой (эрх зүйн хэм хэмжээний эх сурвалж болдог), ямар нэг шүүхийн болон бусад хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахыг зорьсон байгууллагуудыг хамааруулдаг. Эдгээр нь захиргааны, олон нийтийн, холимог байгууллагын загвартай байж болно. Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс нь төрийн-нийгмийн хяналтын байгууллага бөгөөд хэрэг маргааныг шүүх, уялдуулах, хяналт тавих эрх эдэлдэг, комиссын бүх гишүүд хууль эрх зүйн мэдлэг эзэмшсэн байдаггүй, нийгмийн идэвх дээр үйл ажиллагаа нь үндэслэдэг гэж хэлж болно.

Хүүхдэд зориулсан тусгайлсан шүүх нь “Хүүхдэд ээлтэй шүүх тогтолцоо”-ны гол цөм бүрэлдэхүүн хэсэг бөгөөд “Насанд хүрээгүй хүний тухайн процесс ажиллагаа нь түүний нас, хүмүүжих хүсэл эрмэлзлийг тооцон авч үзсэн байх” гэсэн үзэл баримтлалд үндэслэдэг, шийтгэх бус хүүхдэд сайн сайхныг авчрах, хамгаалахад чиглэгддэг, хүүхэд бүрийн онцлогт тохирсон нэгбүрчилсэн хандлагаар харьцах, энэ бүхэн нь хууль тогтоомж, бүтэц орон тооноос илүүтэйгээр хүмүүнлэг байхыг шаардана. Гол зорилго нь нөхөн сэргээх буюу хууль эрх зүйн гэхээс илүүтэйгээр, төрөөс тогтоосон, тухайн зөрчигдсөн дэг журмыг нөхөн сэргээх, өргөн утгаар нийгэм-хүн судлал (антропологи)-ын талаас хохирогчийг “эдгээх”, учирсан хохирлыг нь төлж барагдуулах, хохироосон хүн гэмээ хүлээх, түүнд хариуцлагыг нь үүрүүлэх, зөрчигдсөн тухайн нийгмийн харилцааг сэргээх ба шийтгэл бус эвлэрлийг үндэс болгодог.

⁴ Насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүд нь өөрсдөө хохирогчид бөгөөд тэднийг шийтгэх бус нөхөн сэргээх хэрэгтэй гэсэн үзэл санаагаар 1899 онд АНУ-ын “Хаягдсан, хараа хяналтгүй, гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүд, тэдгээрт хяналт тавих тухай хууль”-ийн дагуу Чикаго хотод ийм төрийн шүүх анх байгуулгасан байна. Гэр бүлийн шүүх, Залуучуудын шүүх, Хүүхэд залуучуудын шүүх, Хүүхэд, өсвөр үеийн шүүх гэх эзргээр нэрлэгддэг.

Хүүхдэд ээлтэй шүүх тогтолцоонд тусгайлсан шүүх, эсхүл шүүгчдийн бүрэлдхүүн, дагнасан шүүгч голлох үүргийг гүйцэтгэн ажиллаж, хүүхдийн төлөө, тэдний эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан төрийн байгууллагууд, нийгмийн бусад албад, цагдаагийн байгууллагын харилцан хамтын ажиллагааны механизмууд, түүн дотроо шүүхийг орлосон эвлэрүүлэн зуучлал (англ. Mediation, орос. медиация)-ын; хориоос өөр төрлийн ялыг хэрэгжүүлэх (англ. Probation, орос. пробация) тусгайлсан байгууллага/нэгж ажиллуулах зэрэг нөхөн сэргээх янз бүрийн технологиудыг багтааж ойлгодог.

Нөхөн сэргээх⁵ технологиуд (англ. Restorative justice, орос. восстановительные технологии) гэж юу вэ, ач холбогдол нь юунд оршдог вэ?

Нөхөн сэргээх технологи гэдэг нь нөхөрсөг, ойлголцсон, үр ашигтай, эв нэгдэлт хоёр талын харилцааг тогтооход чиглэсэн байх ба:

тухайн зөрчилдөөнт нөхцөл байдлыг зерэгээр шийдвэрлэх хариуцлагыг оролцогч нарт өөрсдөд нь олгох

- бүх оролцогч нарт учирсан хохирлыг арилгахад анхаарал хандуулах;
- зөрчил гаргасан этгээдийн хувийн хариуцлагыг ухамсарлуулах;
- оролцогчдыг өөрийн амьдрал, хийсэн үйлдэлдээ хариуцлагатайгаар хандуулахыг зорих;
- зөрчилдөөнт харилцаа, нийгмийн холбоосыг нөхөн сэргээх зарчмуудыг баримталдаг.

⁵ Нөхөн сэргээх ажиллагааг гэж тэрхүү гэмт хэрэгээс үзсэн асуудлыг шийдвэрлэхэд хохирогч, гэмт хэрэгтэн, мөн зохиомжтой бол гэмт хэргийн хор уршигийг амссан бусад хувь хүн (гэр бүлийн гишүүд), этгээдүүд идэвхтийн хамтран оролцоогоы шардах бегоед зохицуулагчийн туслаамжийг авч байгаа үйл явцыг хэлнэ. Нөхөн сэргээх ажиллагаа нь хохирогчид учирсан хор уршигийг арилгах, гэмт этгээдэд хийсэн үйлдлийн нь төлөө хариуцлагыг хүлээгж, үүссэн зөрчилдөөнийг шийдвэрлэхэд хамтын нийтгэмжлэгийг оролцуулах асуудлыг онцгойлон үзэх замавар гэмт хэргийг шийдвэрлэх үйл явцыг хэлнэ. Гэмт хэргийн хохирогч, гарч болсон хүүхэд холбогдох байцаан шийтгэх ажиллагааны тухай загвар хууль ба холбогдох тайбар. 30 дугаар үзүүл. // "Монгол Улсад насандаа хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн зэрэг үйлдэгдээн гэмт хэргийн шалтгаан нөхцөл" сэдэвт судалгаанаас ажлын тайлан. ЦЕГ, ХСИС. Уб., 2018 он, 262 дахь тал.

Нөхөн сэргээх технологи нь "хуультай зөрчилдсөн" насандаа хүрээгүй хүмүүсийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хэрэгжүүлэх, хамгаалах, тэднийг нийгмийн дунд чөлөөтэй хөгжих хувь хүний чадвараа нээн гаргах, нийгмийн эсрэг сөрөг зан үйлээсээ сайн дураараа татгалзахад нь тус дэмжлэгт үзүүлэхэд чиглэгдсэн цогц арга хэмжээ ба яз нүүрийн хандлага, арга хэлбэрийт ашигладаг. Тухайлбал:

Эвлэрүүлэн зуучлалын алба (хөтөлбөр) нь шийтгэлийг бус цагдаа, шүүх гэхгүйгээр хэрэгт (тухайн асуудал эрүүгийн шинжтэй ч байж болно. Ж нь: хулгайлах, зодох) хамааралгүй гуравдагч этгээдийн оролцоотой оролцогч талуудыг сайн дураар эвлэрүүлэх, хохирогчийн хөндөгдсөн эрхийт нөхөн сэргээх, гэм буруутай этгээд гэмээ хүлээх, өөрийн хүслээр хохирлоо төлж барагдуулах, нийгмийн зөрчигдсөн харилцааг сэргээх зэргийг гол болгон ажилладаг.

Харин хориоос өөр төрлийн ялыг хэрэгжүүлэх бие даасан нэгж/ алба (хөтөлбөр) буюу ял хойшшуулахыг хариуцах газар нь тухайн насандаа хүрээгүй этгээдэд шүүхээс оногдуулсан хориоос бусад ялын хэрэгжилтийг хангахдаа боловсрол олгох, амьдралын нөхцөлийг өөрчлөх, нийгмийн хяналт тавих г.м. аргаар уг этгээдэд нийгмээс тусгаарлахгүйгээр гэр бүл, хамт олны дунд хүмүүжих/нийгэмших, засрах боломжийг олгодог.

Гадаадын зарим орны туршлага

Хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан тусгайлсан шүүх тогтолцоог хөгжүүлэх ажил гадаадын зарим улс оронд ямаршуу онцлогоор явагдаж ирснийг тодруулбал:

1824 онд АНУ-ын насандаа хүрээгүй хүмүүсийг засан хүмүүжүүлэх нийгэмлэгээс бага насын хүүхдийн асрах газар байгуулж, 1899 онд Нигүүлсэхүйн зөвлөл ба Чикагогийн эх орончдын нийгэмлэгээс хүүхдийн шүүх байгуулах тухай хууль батлах санаачлагыг анх гаргаж, гол үзэл санаагаа насандаа хүрээгүй хүний өөрийнх нь эрх ашгийн төлөө түүний болон гэр бүлийнх нь амьдралд оролцож

шаардлага буйг, ялангуяа насанд хүрээгүй хууль зөрчигч, хүмүүжлийн доголдолтой хүүхэд, эцэг эхийн асран хамгаалалтгүй үлдсэн хүүхдийн хувьд бөгөөд хүүхэд өсвөр үеийнхэнд зориулсан шүүх байгуулснаар тэдний хэргийг тусгайлан авч үзэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх, гэмт үйлдлийн нь шалтгааныг тогтоох, засуулах буюу тэднийг “эмчлэх” хандлагаар асран хамгаалах, дахин хүмүүжүүлэх, засан сайжруулахыг зорих гэсэн.

Английн хүүхдэд ээлтэй шүүх тогтолцоо байгуулах асуудал насанд хүрээгүй хүнд “халамж, хамгаалал, хяналт” хэрэгтэй гэсэн сургаалд үндэслэсэн. Уг сургаалийн ялгагдах онцлог нь насанд хүрээгүй хүний хэргийг “баг” (2 медиатор ажилладаг, нэг нь сэтгэл зүйн чиглэлээр, нөгөөх нь гэр бүлийн харилцааны хуулиар мэргэшсэн)-аар шийдвэрлэх, шүүх хуралдааны үеэр хүүхэд эцэг, эхтэйгээ харилцахыг сайшаах, хүүхдэд ойлгомжтой үг хэллэг хэрэглэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг аль болох богиносгож асран халамжахад тулхүү анхаарахыг эрмэлзэх юм.

Франц Улсад халамжийн зөвлөл, тусгай хүмүүжүүлэх газраас эхлэн хүүхэд хамгааллын зөвлөл, холбоод байгуулах зэргээр захирагааны, эрүүгийн альтернатив ял шийтгэлийг эрэлхийлэн хөгжиж ирсэн.

ОХУ-д 1910 онд анх Санкт-Петербург хотод насанд хүрээгүй хүмүүсийн шүүх байгуулагдаж, хүүхдийн асуудлыг хаалттай шийдвэрлэдэг байсан⁶, тусгайлан шүүх (Ювенальная юстиция) байгуулах асуудал 1995 оноос идэвхтэй яригдаж хуулийн төсөл боловсруулагдсан хэдий ч олон нийтийн дэмжлэгийг авч батлагдаагүй, одоог хүртэл маргаан дагуулсаар, гэхдээ Москва, Санкт-Петербург, Хакас, Карели болон хэдэн мужид⁷ зарим технологиудыг нэвтрүүлжээ.

⁶ Э.Б.Мельникова хүүхэд өсвөр үеийн шүүхийн оросын загвар амжилттай хэрэгжжих байсан, эрх зүйн зөрчил гаргагч насанд хүрээгүй этгээдүүдийн 70 хүртэл хувь нь хорхын газар луу бус асран хамгаалагчдынхаа хяналтанд очдог байсан гэж бичижээ. /Мельникова Э.Б. Ювенальная юстиция. Проблемы уголовного права, уголовного процесса и криминологии. М. 2000. 48 дахь тал.

⁷ Ростов, Липецк, Эрхүү, Брянск, Ивановск зэрэг.

Тухайлбал:

- тусгайлан шүүх⁸ эсхүл дагнасан шүүх бүрэлдэхүүн⁹ ажиллуулах
- шүүгчдийг чадавхжуулж, туршлагатай шүүгч наарт хэргийг хуваарилах
- шүүхүүдэд насанд хүрээгүй хүний хувийн байдал, сэтгэл зүйн хөгжил, томчуудын зүгээс уруу татах буй эсэх, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нөхцөл, гэр бүлийн амьдралын талаар судлан танилцуулга бэлтгэх үүрэг бүхий тусгайлан нийгмийн ажилтнуудыг бэлтгэн¹⁰ томилох¹¹ (зарим бус нутагт шүүгчийн туслахууд нийгмийн ажилтны энэхүү үүргийг хариуцан гүйцэтгэдэг байна)
- сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйчдийг оролцуулах;
- шүүхээс насанд хүрээгүй этгээдийг нөхөн сэргээх ганцаарчилсан төлөвлөгөө гарган ажиллах шийдвэр гаргах, хариуцуулах;
- насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг бүр дээр Насанд хүрээгүй хүмүүсийн асуудал эрхлэх комиссын болон цагдаагийн хүүхдийн байцаагч нарыг оролцуулах;
- хичээлийн болон хичээлийн бус цагаар суралцагчдад эрх зүйн ухамсар суулгах ажил (хичээл, сонгон суралцах хичээл), шүүх, цагдаа, хуулийн байгууллагууд, хуулийн сургуулиудын оролцоотой нөхөрсөг харилцааны төсөл хэрэгжүүлэх, хуулийн олимпиад, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, секц дугуйлан ажиллуулах, эрх зүйн боловсрол олгодог багш нарыг мэргэшүүлэх зэрэг болно.

Хүүхдэд ээлтэй шүүх тогтолцооны нөхөн сэргээх альтернатив¹² технологи болох маргаан зохицуулах “Эвлэрүүлэн зуучлал” нь 1970-аад оны дундуур Канад Улсад анх бий болсон гэж үздэг ба

⁸ Правосудие в современном мире: монография /под. ред. В.М.Лебедева, Т.Я.Хабриева /Гарант эрх зүйн цахим сан/

⁹ Буриад Улс.

¹⁰ Жишээ нь Буриадын Улсын их сургуулийн хуулийн факультетад бэлтгэдэг.

¹¹ 2010-2012 онд хэрэгжүүлсэн “Знай, ты не один” (Чи ганцаараа биш) хөтөлбөрийн дунд бүх дүүргийн шүүхүүд нийтмийн ажилтантай болжээ.

¹² Англи. alternative dispute resolution, ADR.

өдгөө нилээд хэдэн улсад нэвтрүүлжээ. Тухайлбал: 1981 онд Австри, Норвегид, 2 жилийн дараа Финляндад. Норвеги Улсад санхүүгийн бэрхшээлийн улмаас хангалттай хөгжихгүй байж байгаад 1991 онд хуульчилснаас хойш бүх хүн амд хүрэлцсэн үйлчилгээ бий болсон, Финляндад орон нутгийн байгууллагын гуравны хоёрыг эдгээр албад эзэлдэг, Австри Улсад насанд хүрээгүй хүмүүст зориулсан эвлэрүүлэн зуучлалын албадын зохион байгуулттай сүлжээтэй, тэдгээр албад нь эвлэрүүлэн зуучлалаас гадна нийгмийн ажуудыг явуулдаг аж. Харин Герман Улсад 400 гаран албадтай, дийлэнх нь гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, эхэн үедээ хохирогч хамгааллын болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх асуудал хариуцсан байгууллагуудын зүгээс эвлэрүүлэн зуучлалын эсрэг байр суурийг илэрхийлж, ийм төрлийн төсөл хөтөлбөрт хамрагдсанаар хохирогч нь гэмт хэрэгтний ашиг сонирхолд нийцүүлсэн, түүнд ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхэд “ашиглагдана” гэж эмээж байсан. Гэхдээ энэ технологийн практик хэрэгжилтийн дунд хохирогчийн хэрэгцээ шаардлагыг хангасан зэрэг үр дүн гарсан тул дээрх шүүмжлэл үгүйсгэгджээ. Франц Улсад хохирогч хамгааллын байгууллагууд зуучлалын үйл ажиллагаанд идэвх гарган оролцдог, Бельги Улсад хүнд ангиллын гэмт хэргийн хохирогчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлалын загвар ажиллуулдаг байна¹³.

Харин ОХУ-ын боловсролын

байгууллагад¹⁴ эвлэрүүлэх уулзарт, харилцан хүндэтгэлтэй хандах ярилцлага хэлбэрээр зохион байгуулгажд ирсэн, насанд хүрээгүй хохирогч, гэмт хэрэгтэн 2-оос гадна тэдний хууль ёсны төлөөлгч, тусгай мэргэжлийн албад, шүүхийн, цагдаагийн албан тушаалтан, эцэг, эхийг оролцуулах, хэлбэрийн хувьд эвлэрүүлэх хуралдаан, гэр бүлийн хурал, шүүхийн хөтөлбөрүүд зэргээр өргөжиж, ЕБС ба орон нутгийн байгууллагад эвлэрүүлэн зуучлалын албад бий болжээ.

Дээрх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх явцад учирдаг хүндрэл бэрхшээлүүдийг судлан авч узвэл: Зарим оронд (Герман) эрх мэдэл хуваарилалт (төвийн, холбооны, мужийн засаглал), дүрэм журам боловсруулах, төсөв санхүү, төсөл хэрэгжүүлэх зэрэгт хүндрэл тулгарч байсан; нийгмийн ажилтны үүргийг шүүгчийн туслах гүйцэтгэхэд сурган хүмүүжүүлэх болон сэтгэл зүйн мэлдэг дутагдах; шүүгчийн туслах шүүхэд хэрэг нь шилжин ирсэн цагаас ажилладгаас урьдчилсан мөрдөн байцаалтын шатанд “нийгмийн ажилтны үүрэг” эзэнгүйдэх; зарим байгууллагын зүгээс хохирогчид нөлөөлне гэж үзэж шүүмжлэлтэй ханддаг; нийгмийн бусад албад, сурган хүмүүжүүлэх байгууллагын хамтын ажиллагаа сулаас гэр бүл, нийгэм, хамт

¹⁴ Школьная медиация (сургууль дахь эвлэрүүлэн зуучлал) - хэрэг/зөрчилд хамааралгүй, хувийн сонирхолгүй, шударга гуравдагч этгээд (медиатор)-ийн оролцоотгоор маргааныг шийдвэрлэх альтернатив зохицуулалт (англ. alternative dispute resolution, ADR) технологиудын нэг. ЕБС-ийн “том” хамт олны янз бүрийн түвшний маргааныг үр ашигтай шийдвэрлэх шинэ хандлага нь ОХУ-ын боловсролын байгууллагад өргөн нэвтрэсэн. Талуудад бие биенээс ойлгох, тодорхой тохиролцоонд хүрэх шийдвэр гаргахад нь тусалж, уг үйл явц, зөвшүүлийн нөхцөлийн өөрсдөө бурзнуулж ханзуулж талууд тус бүрийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргугуудаг. Медиатороор багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сургачид өөрсдөө ч тусгай сургалтанд хамрагдан ажиллах болох бөгөөд хүүхэд, эсвэр үсийнхэнд гомдолоо тайлах, бие биенээс үзэн ядах, бусад серөг хандлага (дайсагнах, ирээдүйдээ үл итгэх г.м.), бие дааж асуудлыг шийдвэрлэх (хохирлыг барагдуулах), дахин тийм алдаа гаргахгүй байхаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. /Митичева Е. Восстановительные технологии как средство профилактической работы педагога-психолога по разрешению конфликтных ситуаций на примере школьной службы примирения. <https://pandia.ru/text/79/065/20912.php>

Школьная конференция (сургуулийн бага хурал) – эврэргүүлэн зуучлалын арай өргөн оршогчдын оролцоотой хөтөлбөр хэрэгжүүлэх технологи. Олон оролцогчид (ангийн хооронд, суралцагч ба антийн хооронд, багш ба эцэг эхчүүдийн хооронд г.м.)-ыг хамарсан тохиолдод хэрэглэгддэг.

¹³ Түүнчилэн Болгар, Дани, Испани, Итали, Нидерланд, Люксембург, Польш, Румын, Унгар, Швед зэрэг улсад байдаг, Албани, ОХУ, Чех зэрэг улсад бий болж байна.

олны дунд засан хүмүүжүүлэх ажил үр дүн муутай, дийлэнх тохиолдолд хорих ял оногдуулах, зарим газарт (ОХУ) засан хүмүүжүүлэх байгууллага дутагдалтайгаас хүүхдийн эрх зөрчигдөх зэрэг байна.

Мөн зарим оронд эцэг эхийн аль нэг сэтгэл зүйн ямар нэг гэмтлийн улмаас нас бараг, хүүхдээ хөнгөн шийтгэх, буланд зогсоох зэрэг тохиолдолд хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлан улсын асрамжинд авдаг, өөр нэг улс (Финлянд)-д гэр бүл голлох үүрэгтэй гэж үздэггүй, хүүхэд төрөхэд эцэг эхийг нь асран хамгаалагчаар нь томилдог, эрхийг нь зөрчвэл эцэг эхийн эрхийг хасдаг, эцэг эх ба хүүхдийн хооронд тэгш эрхийг эрхэмлэдэг зэрэг тухайн улс орны ёс заншил, уламжлал, үндэстний хэв маяг, нийгмийн дүр төрхтэй нь холбоотой болов уу гэмээр онцлог зохицуулалтууд харагдана.

Хүүхдэд ээлтэй шүүх тогтолцоо нь нэг талаас насанд хүрээгүй хүмүүсийн эрх, ашиг сонирхлыг хамгаадах, нөгөө талаас хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжилтнүүдэд насанд хүрээгүй хууль зөрчигчидтэй томчуудыг бодвол хамгийн боломжит таатай байдлаар харилцахыг санал болгодог; шүүх, цагдаа, ял эдлүүлэх болон тэднийг хамгаалах, нийгэм-сэтгэл зүйн, асрамж халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн ба төрийн бус байгууллагын нэгдсэн тогтолцоо, цогц механизм юм.

Энэ бүхнээс хараад гадаад орнуудад хүүхэдтэй холбоотой шүүн таслах ажиллагаанд хууль эрх зүйн гэхээс илүүтгэй хүмүүжлийн, боловсролын нөлөөллийн механизмууд, нөхөн сэргээх технологийг илүү өргөн ашиглахыг урьтал болгож, “хүүхдийн сайн сайхны төлөө” зөвхөн гэмт хэрэгт холбогдсон/үйлдсэн насанд хүрээгүй хүмүүсээс гадна өртөж хохирсон хохирогч, гэрч хүүхдийн асуудлыг шалган шийдвэрлэхэд тэдгээрийн хувийн онцлогоос гадна уруу татагчдын сөрөг нөлөөлөл, амьдралын тааламжгүй нөхцөл байдал г.м. түүний эргэн тойрны бүх асуудалд зэрэг анхаарал хандуулж, сэтгэл рүү нь өнгийн харж байж, хүүхдэд тохирсон

арга зүйгээр, сэтгэл судлал, сурган, хууль эрх зүйн зохих мэдлэг, туршлагаар хандах шаардлагатайг тэмдэглэдэг байна.

Хүүхдэд зориулсан шүүх тогтолцоо (англ. juvenile justice, орос. ювенальная юстиция) гэдэг нэр томьёог ойролцоо “juvenile policy¹⁵” (орос. ювенальная политика), “juvenile proceedings¹⁶” (орос. ювенальное судопроизводство), “juvenile law¹⁷” (орос. ювенальное право) гэсэн ойлголтуудаас ялган салгаж ойлгох нь чухал.

Монгол Улсад хөгжиж буй өнөөгийн байдал

Манай улсын хувьд НҮБ-ын хүүхэд хамгааллын талаарх гол гол гэрээ

¹⁵ Juvenile policy - залуу үеийг дээмжих (30 хүртэл насны), хөгжүүлэх, хамгаалах, түүчинчлэн насанд хүрээгүй хууль зөрчигчдэд хуулзүйн зүйн хамгаалалт үзүүлэхэд чиглэгдсэн нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүй, зохион байгуулалт, мэдээллийн шинжээтий төрөөс хэрэгжүүлж буй цогц арга хэмжээ бөгөөд төрийн нийгэм - эдийн засгийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг юм.

Зорилго нь залуу үе, гэр бүлийн амьдралын таатай орчныг бий болгох; амьдралын чанарыг дээшлүүлж; олон хүүхдэдтэй, бүтээгдсэн зүйн хамгаалалт үзүүлэх, залуу гэр бүлийг дээмжих эрх зүй, эдийн засаг, улс төр, зохион байгуулалт, санхүүгийн болон бусад нөхцөлийг бүрдүүлэх, тэдгээрийг хангах тогтолцоог цогцлоо.

¹⁶ Juvenile proceedings - Насанд хүрээгүй хүмүүсийн эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэх хуулиар тогтоосон онцлогийн журам бөгөөд тусгайлсан шүүх нь олон улсын, үндэсний хуулиар тогтоомжийн зарчмын, хэм хэмжээнд үндэслэн бусад туслах нийгмийн үйлчилгээний байгууллагуудтай харилцан хамтран ажиллах насанд хүрээгүй хүмүүсийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаа (Насанд хүрээгүй этгээдийн хэргийг хэлэлцэн шийдвэрлэх шүүхийн үйл ажиллагаагаар илэрнэ).

¹⁷ Juvenile law - насанд хүрээгүй хүмүүсийн эрх зүйн байдлыг тодорхойлсон, янз бүрийн салбарын алз нэг талын орцлогч нь насанд хүрээгүй хүн байх тухайн харилцааг зохицуулдаг хэм хэмжээнүүдийг судалдаг салбар шинжлэх ухаан (англ. орос. ювенальное право) юм. //https://yandex.ru

конвенцод¹⁸ удаа нэгдэн орсон, тэдгээрт заасан үүрэг, уриалгыг биелүүлэхийг чармайж, эрх зүй, зохион байгуулалтын олон арга хэмжээ авч, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүх орчинд хуулиар хориглосон дэлхийн 49 дэх орон болсон, хүүхдийг гэр бүлийн хүрээнд нь хүмүүжүүлэхийг чухалчилдаг, төрийн болдого нь гэр бүлийн ая тухтай байдлыг хөгжүүлэх, амьдралынх нь чанарыг сайжруулах, гэр бүлийн нийгэмд хүргэх тус нэмэр үүргийг хангуулах, төрөлтийг дэмжихэд чиглэгддэг билээ. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2017 онд Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинэчлэн өөрчилж, Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулиуд болгон нарийвчлан баталсан, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд тусгайлсан бүлэг оруулсан, “Хамтарсанбаг”, Хүүхдийн эрхийн ажилтан (ombudsman¹⁹), Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо (өмнө нь байсан, албан ёсоор хуульчлагдсан) гэх институтуудыг хуульчилсан, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, байгууллагуудад холбон зуучлах зэрэг хүүхдэд ээлтэй зарим технологиудыг нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаа, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах талаар Эрүү, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай

¹⁸ Тухайблын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, түүний нэмэлт протокол, Хүүхдийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протокол болох Хүүхдийн худалдах, биеz үнэлэх, садар самуунд уруу татагдахаас сэргийлэх тухай болон Хүүхдийн зэвсэгт мөргөлдөөнд оролцохос сэргийлэх тухай нэмэлт протокол, Эмзэтгүүчүүдийн алагчлах бүх хэлбэрийн устгах тухай конвенц, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай 182 дугаар конвенц, Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБын 138 дугаар конвенц, “Сайн дүрүн үндсэн дээр гэрэлж, гэрэлж насны доод хязгаар болон гэрэлтийг бүртгэх тухай” конвенц, Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үргчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гагийн Конвенц, Ажилд авах насны доод хязгаарыг шинэчлэн тогтоох тухай 192 дугаар Конвенцид нэгэндээн орсноос гадна “Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт явдлаас урьдчилсан сэргийлэх талаар НҮБ-ын үндсэн зарчим буюу “Эр-Риадын үндсэн зарчим” зэрэг олон улсын эрх зүйн баримт бичгийн дагуу хүүхдийн эрхийг хамгаалахаас хүлээн зөвшөөрсэн билээ.

¹⁹ Омбудсмен гэх институт анх Швед Улсад 1809 оны Үндсэн хуулийн дагуу бий болсон гэх уздэг.

[/https://ru.wikipedia.org/wiki/%D0%9E%D0%BC%D0%B1%D1%83%D0%BA%D1%81%D0%BC%D0%BD](https://ru.wikipedia.org/wiki/%D0%9E%D0%BC%D0%B1%D1%83%D0%BA%D1%81%D0%BC%D0%BD)

зэрэг хуулиуд, холбогдох журмуудад нарийвчилсан зохицуулалтуудыг тусгасан, хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр²⁰ батлан хэрэгжүүлж байгаа, энэ асуудлаар үйл ажиллагаа явуулах тусгай байгууллагууд²¹ бий болж, хүүхэд хамгааллын тогтолцоо боломжийн тувшинд бүрэлдсэн. Түүнчлэн дэлхийн улс орнуудад шүүхээс хараат бусаар хэрэгжүүлдэг эрх зүйн маргааныг гуравдагч этгээдийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлалын процедур манай улсад хэрэгжээд долоон жил болж байна. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар²² эрүүгийн шинжтэй маргааныг шийдвэрлэхгүй, эвлэрүүлэн зуучлалын албыг анхан шатны шүүхээс гадна төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод дээр ажиллуулж болно. Түүнчилэн цагдаагийн байгууллагад Хүүхдийн алба ажиллаж, нийслэл, орон нутаг бүрт 2-4 хүүхдийн байцаагч ажиллуулж байсныг үгүй болгож, хэсэг хугацааны дараа гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг хүүхдийн гэмт хэргийн асуудалтай хавсран хариуцан ажиллах байцаагчдыг томилон ажиллуулсан, одоо Хүүхдийн тасаг, хэлтэс байгуулагдан хэдий ч энэ асуудлыг дагнан хариуцах “хөлгүй” хэвээр байгаа²³, шүүх, прокурор, цагдаагийн байгууллагад дагнасан шүүхч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч ажиллуулж ирсэн туршлага бий. Гэсэн хэдий ч, “хүүхдэд ээлтэй шүүх тогтолцоо”-г албан тушаалтан (ажилтан), иргэд олон нийт бүхэл тогтолцоогоор нь харахгүй байгаа,

²⁰ Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоол. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр батлах тухай

²¹ Хамтарсан багууд, Түр хамгаалах байр /18/, Нэг цэгийн үйлчилгээний төв /10/, Хүүхдийн туслаамжийн 108 утасны үйлчилгээ, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх түр байр, Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаарх сургалт, судалгаа, мэдээллийн бие даасан төв зэрэг.

²² Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль. Төрийн мэдээлэл. Уб., 2012 он, № 25.

²³ 2012 онд цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр энэ орон тоог байхгүй болгосон.

насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдалтай²⁴ тэмцэх, тэдэнд зохих халамж хамгааллыг үзүүлэх, холбогдох байгууллагад холбон зуучлах зэрэг бүх ажлыг нэг хүн дангаар гүйцэтгэх боломжгүй, цаг хугацаа, ур чадвар, бусад олон зүйлс дутагдах, насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдлын асуудал, тэдний эрх, ашиг сонирхлыг ханган хамгаалах, нийгмийн хамгааллын, бусад үйлчилгээний чанар, хүртээмж чамлалттай зэрэг нь улсын хэмжээнд харилсан уялдаатай тасралтгүй үйл ажиллагааг зохицуулах, хүний болон санхүүгийн нөөц бүхий үр нөлөөтэй цогц зөв тогтолцоо, чиг үүрэг, хяналт үгүйлэгдсээр буйг харуулж байна.

Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгч субъектуудын гол зорилго бол хүүхэд хараа хяналтгүй болох, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирох, бусад нийгмийн серөг үзэгдэл, үйл явдалд автхааас урьдчилан сэргийлэх (илрүүлэх, таслан зогсох), эрх ашиг сонирхлыг нь хамгаалах, бусдад уруу татагдахаас сэргийлэх бөгөөд энэ бүхний үр дүн тэдний нэгдмэл, цогц идэвхтэй үйл ажиллагаа, хүүхдийн араас тавих анхаарал, нийгмийн хяналт тасралтгүй байхаас шууд хамаарна. Гол зарчим, үйл ажиллагаа нь нээлттэй байх, хүүхдийн нас, хөгжилд нийцсэн байх, цаг алдалгүй арга хэмжээ авах, хүүхдийн хэрэгцээг эн тэргүүнд хангах, эрх, ашиг сонирхолд нь чиглэсэн байх, хүүхдийн хувийн байдал, эрхэм чанар, хувийн ба гэр бүлийн амьдралыг хүндэтгэх, уг асуудлыг даван туулах, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад гэр бүл гол үүрэгтэй

боловыг чухалчлах, шүүхийн шатанд хүүхдийн талаарх албан ёсны баримт материал, амьдралын нөхцөл, хүмүүжлийн мэдээллийг сайн цуглуулах, ашиглах, хүүхдэд үзүүлэх аюулгүй байдлын хамгаалалтыг чангатгах, дэвшилтэй технологиудыг ашиглах, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг урьталь болгох, насанд хүрээгүй хүмүүсийн асуудлаар тусгайлан бэлтгэгдсэн хүний нөөцтэй байх, туслах зэргийн тусгай албад/нэгж (хүн)-ээс бүрэлдсэн тогтолцоо бүхий байх, хүүхдийн эрхийг хангаж буй эсэхд хяналт тавих журам, хэм хэмжээг бий болгосон байх явдал юм.

Монголчууд бил хүүхэд хүмүүжлийн баялаг уламжлал, ёс заншилтай, өвөрмөц сэтгэлгээтэй, гэр булийн асуудалд төрийн зүгээс хөндлөнгөөс оролцох нь буруу, ялангуяа эцэг эхчүүдэд хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэхийг зааж зааварлах нь буруу гэж үздэг, учир нь эцэг эхээс илүү өөр хэн ч тухайн хүүхдийг сайн мэдэхгүй, тэд л хүүхддээ зөв замыг зааж сургана, хэрэв хүүхэд дураараа аашилбал, буруу үйлдэл гаргахад нь зэмлэн буруушаахгүй бол замаа алдах магадлалтай, гэр бүл бол хүүхдийн хамгийн амгалан орчин гэж бодож ирсэн. Харамсалтай нь өнөө цагт гэр бүл болгон хүүхдийн хүмүүжил, боловсролд ээлтэй “тохирсон” байж чадахгүй байна: эцэг эхийн аль нэг байхгүй ганцаар хүүхдээ өсгөж байгаа, архи согтууруулах мансууруулах бодисын хамааралтай болсон, гажуудсан зан суртахуунтай (шоронгоос суллагдсан, багадаа хүчирхийлэл дунд өсч, түүнд “дассан”) гэр бүлийн гишүүнтэй, хүнд, аюултай нөхцөлд амьдарч байгаа гэр бүл зэрэг “асуудалтай” өрхийн хүүхдийн эрх ашиг зөрчигдөх, хохирох, гэмт хэргийн замд орвол төрийн зүгээс хөндлөнгөөс оролцох нь зайлшгүй.

Хүүхдэд ээлтэй шүүх тогтолцоо гэдгийг цоо шинэ зүйл мэтээр хүлээн авах бус, харин насанд хүрээгүй хүмүүсийн ашиг сонирхлыг хамгаалах эрх зүй-хамгаалалтын арга хэмжээг улам боловсронгуй болгох үйл явц гэж

²⁴ Насанд хүрээгүй этгээдээс тодорхой газар нутаг, тодорхой цаг хугацаанд үйлдсэн гэмт хэргүүдийн нийблээрийг насанд хүрээгүйчүүдийн гэмт явдал гэж тусгайлан авч үзэж судалдаг тогтолц нийтлэг хандлагыг байдал бол ОХУ-ын эрдэмтэн Ю.Е.Пудовочкин: “насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг гэмт явдал гэж насанд хүрээгүй хүмүүсийн бие бядлын, оюун санааны, зан суртахууны хүмүүжлийг төлөвшүүлж байгаа тэр нийгмийн харилцааг шууд зөрчиж байгаа нийтээд аюултай гэмт хандлагыг юн” гэж дүгнээд “Насанд хүрээгүй хүмүүсээс үйлэж байгаа болон тэдний эсрэг үйлдэгдэж байгаа гэмт явдлын хооронд нөхцөл байдлын тодорхой холбоos байна гэж тэмдэглэсэн. Ю.Бадамханд. Насанд хүрээгүй этгээдийн эсрэг гэмт явдлын талаарх онол, практикийн зарил асуудал. “Гэмт явдалтай тэмцэх төрийн боллогын хэрэгжилт, чиг хандлага” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтэгэл. ХСИС. Уб., 2013 он.

ойлгон, тусгайлсан шүүх байгуулах эсэх, хуулийн байгууллагуудад мэргэшсэн/дагнасан ажилтнуудыг бий болгох, тусгай өрөөнүүдийг ашиглах, хүүхдийн асуудлаар үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд нэгдмэл зохион байгуулалтаар ажиллаж, эцсийн үр дүнгээ тооцдог байх зэрэг асуудлуудыг судлан, холбогдох хууль, журам, зааврыг боловсруулан хэрэгжүүлэх дорвитой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Анхаарах зарим асуудлууд

➤ Хүүхдийг гэр бүлээс нь шууд тусгаарлах нь түр зуурын асуудал болдог, гэр бүлийн маргаантай асуудал хэвээр засагдахгүй үлдээгийг анхаарах ёстой. Гэр бүлийн “хэцүү” асуудлыг шийдвэрлэхийн оронд сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах, түр хамгаалалтад авах, гэр бүл салгах, эцэг, эх байх эрхийг хасах зэргээр хүүхдийг тусгаарлах арга хэмжээг уртал болгох нь бидний эрхэм зорилгод нийцэхгүй. Гэр бүл бол хүүхдэд хамгийн ээлтэй орчин байх учиртай. Нөгөөтээгүүр гадаадын зарим орны туршлагаар цагдаагийн болон нийгмийн ажилтан, шүүхийн туслах ажилтан зэрэг тусгайлсан албан тушаалтанд дангаар даалган тухайн гэр бүлийн асуудлыг судлах, санал/танилцуулгыг сонсон шийдвэр гаргах нь гэр бүлийн болон хүүхдийн хувь заяаг нэг хүний үзэмжээр шийдвэрлэх, яваандаа эцэг эхийн хүүхдэдээ үзүүлэх нөлөөллийг баагасгах²⁵, нийгмийн зүгээс гэр бүлийн асуудалд хэт оролцох болохыг үгүйсгэхгүй юм.

➤ Нийгмийн ёс суртахууны түвшин буурсан²⁶, өсвөр үсийнхэн дунд найз нөхөд, хамт олны зүгээс үерхэл нөхөрлөл,

үүрэг, ухамсар, эр зоригийн талаар худал буруу ойлголт, эмзэглэл авсны улмаас гэмт хэрэг үйлдэх магадлал²⁷ харьцангуй өндөр²⁸, энэ цаг үед хууль эрх зүйн сургалт, сурталчилгаа явуулж, амьдралын зөв хэв маяг, соёл, шударга байдал, эх оронч үзлийн талаар чихэнд нь байнга сонсгож эртнээс урьдчилан сэргийлэх ажил чухал (энэ талаар цагдаагийн байгууллагаас чамгүй ажлуудыг²⁹ санаачлан хэрэгжүүлж байгаа ч хүч дутагдалтай хэвээр) байна. Мөн БСШУЯ энэ асуудалд ихээхэн анхаарч, холбогдох байгууллагуудтай ойр нээлттэй ажиллаж, дорвитой алхмуудыг хийх хэрэгтэй.

➤ Насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг нь нийгмийн тодорхой харилцаанд хохирол учруулаад зогсохгүй түүний өөрийнх нь ухамсарт серег зан үйлийг бий болгож, хөгжих явцад нь хохирол учруулдаг, тэд өөрсдөө хохирогчид байдаг тул энэ талаас нь “харж”, хохирогчоор тогтоох нь бараг үтгүй байна³⁰.

➤ Эвлэрүүлэн зуучлагчийн гол зорилго нь эвлэрүүлэх бус, харин талуудад тэд өөрсдөө сайн дураар эвлэрэх замыг сонгох, зөвшилцэлд хүрэхд нь туслах, бие биетэйгээ харилцах тэр нөхцөлийг бий болгох явдал бөгөөд “гэмт хэрэгтэн болох”-оос сэргийлэх явдал юм. Энэ технологийг шүүхийн өмнөх шатнаас

²⁵ Тэдэнд амьдралын зорилго байхгүй болох, түр зуурын таашаал авах, хэрэгцээгээ хангах мөнгө олох, сэтгэл зүйн түр зуурын таатай байдлыг зөв үйлээг гэж харах, зарим тохиолдолд гэмт үйлдэлгүй буруушаахгүй, хууль зөрчсөн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ гэдээ ойлгохгүй байх тохиолдом хамаарна.

²⁶ 2013-2017 онд бусдыг амиа хорлоход хүргэх 104 гэмт хэрэгт насанд хүрээгүй хүмүүс хохирсон. Насанд хүрээгүй хохирогчид 40% нь бага насны хүүхдүүдийн байна. //“Монгол Улсад насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” сэдэвт судалгааны ажлын тайлан. ЦЕГ, ХСИС. УБ. 2018. 44 дэх тал.

²⁷ Ухаалаг цагдаа, School police хөтөлбөр, UNFRIEND, Нэг хором, Зөв хандлага хөдөлгөөн, “Сэргийлэгч хүү, охин”-ы хүүхэлдийн дур бүтээх, Хүүхд хамгаалалгч төслийд, “Цахим орчинг зөв болгоё” аян гм.

²⁸ Насанд хүрээгүй хүнийг уруу татан гэмт хэрэг үйлдүүлснээр түүний бие бэлдэр, оюун санаа, хөгжих эрхэд нь хохирол учруулдаг болохыг эрдэмтэн судлаачид нотлон харуулдаг. [Харах. Пудовочкин Ю.Е., Уголовно-правовые и криминологические проблемы предупреждения преступлений против несовершеннолетних: Дисс. ... докт. юрид. наук. М. 2005.

гадна ЕБС, орон нутгийн байгууллага, халамж асрамжийн газарт ч хэрэгжүүлэх боломжтой, үүний тулд холбогдох эрх зүйн баримт бичгийг батлах, хууль зүйн дээд боловсролтойгоос гадна сэтгэл судлал, эрүүл мэнд, зөрчилдөөнийг шийдвэрлэх (түүнчлэн бизнес, менежмент, хөдөө аж ажуй, банк санхүүгийн) зэрэг мэдлэгтэй зохион байгуулагч мэргэжилтэн (медиатор), бусад хүний нөөц (сэтгэл судлаач, нийгмийн асуудлаар мэргшсэн сурган хүмүүжүүлэгч)-ийг бэлтгэх, холбогдох нэгж, албадыг бий болгох, уг технологийн үндсэн арга хэлбэрийг сайтар судлах, шүүхийн болон бусад байгууллагад хэн хэрхэн хэрэжүүлэх онцгой журмыг бий болгох зэрэг эрх зүй, зохион байгуулалтын дэс дараатай арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй.

➤ Хүүхэд, өсвөр үеийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тэдэнтэй ажиллах, өртөж хохирсон (гэрч) хүүхдийг хамгаалах үүрэг хариуцлага хүлээж байгаа бүх төрлийн мэргэжилтэн (хуульч, нийгэм судлаач, сэтгэл судлаач, эмч зэрэг)-ийг ойлголтыг нэг мөр чадваржуулах үр ашигтай арга зам бол сургалтыг нэг байгууллага дээр төвлөрүүлж, нэгдсэн байдлаар сургалтыг хүргэх явдал байж болох юм. Энэ үргийг Египет Улсад Хууль зүйн яамны бүтцэд харьялагддаг Хүүхдийн хууль зүйн хамгааллын ерөнхий газар гүйцэтгэдэг туршлага байна.

➤ Зарим гадаадын оронд ял эдлүүлэх (ял хойшлогдсон, тэнссэн, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан), засрал хүмүүжилд хяналт тавих асуудлыг хариуцсан тусгай байгууллага (Probation) ажиллуулдаг туршлагыг судлах нь зүйтэй. Ж: Шүүх байгууллагын тогтолцоонд хэлтэс/алба байгуулах (Англи, Бельги, Польш, Чех, Швед, Эстон), Хууль зүйн яамны харьяа бие даасан хэлтэс/тасаг (Грузин, Латв, Молдав, Япон) ажилладаг.

➤ Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд (ялангуяа шүүхийн өмнөх шатанд) насанд хүрээгүй

хохирогчийн хамгаалалт сул байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хамгаалалтад авах, хохирогчоор тогтоох, хууль ёсны төлөөлөгчийг томилох зэрэг асуудалд цаг хугацаа алдах нь хүүхэд давхар хохирох³¹ эрсдэл дагуулдаг. Мөн гэмт хэрэгтэнтэй харьцахаас сэргийлэх, хувийн нууцыг хамгаалах, хохирол барагдуулах асуудал болон эрүүл мэндийг хамгаалах, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, шүүхийн дараа зөвлөгөө өгөх, эмчилгээ сувилгаа хийлгүүлэх зорилгоор мэргэжлийн, төрийн бус байгууллагатай гэрээлэн ажиллах ажиллагаа шаардлага хангахгүй байна.

➤ Цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаан дахь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдийн хүмүүжлийн нөлөөллийг дээшлүүлэх, хүүхэд нэг бүр дээр уг гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг бодитойгоор тогтоох ажил учир дутагдалтай хэвээр байна. Цагдаагийн байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан алба хаагчдыг үгүй болгож, хүүхдийг гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлыг хэсгийн байцаагч нар давхар хариуцан ажиллах нь хүндрэл дагуулдаг (мэргшээгүй, ажлын ачаалал их). Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудтай хийсэн ярилцлагаар “Прокурорын ажилтан ирж яриа хийхдээ гэмт хэрэгт холбогдсон хүүхдээ мэдэхгүй байгаа нь та нарын буруу гэсэн, цагдаа нь хувь хүний нууцтай холбоотой гээд зарим мэдээллийг бидэнд өгдөггүй. Цагдаагийн байгууллагатай хамтарч ажилламаар байна, бараг ирдэггүй, хааяа нэг ирэхээрээ хичээлийн дундуур яриа хийх гэдэг нь заал чөлөөгүй байх, хичээл завсардах, бөөнөөр нь нэг зааланд оруулж ярих нь үр дүн муутай байдаг, голдуу эцэг эхийн эргүүлийн тайлангаа өг

³¹ “Давхар хохирох” гэж гэмт үйлдлийн шууд үр дагаварын улаас бүс байгууллага, хувь этгээдээс хохирогчийг талаар авсан арга хэмжээний улмаас хохирохыг хэлнэ. Гэмт хэргийн хохирогч, гэр болсон хүүхэддэх холбогдох байцан шийтгэх ажиллагааны тухай загвар хууль ба холбогдох тайлбар. //“Монгол Улсад насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” сэдэвт судалгааны ажлын тайлан. ЦЕГ, ХСИС. УБ., 2018 он, 214 дэх тал.

гэж л нэхэж утасддаг” гэсэн нь цагдаагийн байгууллага сургуулийн хамтын ажиллагаа бараг байхгүй болсныг илтгэж байна.

➤ Манай улсад өмнө нь Хүүхэд, өсвөр үеийн шүүх тогтолцооны зарим технологиуд хэрэгжиж байсан туршлагыг судлах. Заримыг дурдвал: Шүүх байгууллагад энэ асуудлаар мэргэшсэн, туршлагатай тодорхой шүүгч; мөн дагнасан прокурор, дагнасан мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч (хүүхдийн байцаагч нараас гадна) нарыг томилон ажиллуулж, НҮБ, бусад олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр сурган чадваржуулж, ном, гарын авлага хэрэглэгдэхүүнийг боловсруулан гаргаж байсан. Тэдгээрийн нэг нь парламентын гишүүдэд зориулсан ном байсан. Шүүхийн бус загвар болох “Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс” (Одоогийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо³²) 1964 оноос нийслэл, дүүргийн ЗДТГ-ын (даргаар нь Боловсролын хэлтсийн дарга) дэргэд, дараа нь 2000-д оноос хойш ХЗДХЯ, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр загвар хэлбэрээр зарим дүүрэг, орон нутагт дахин байгуулагдан³³ ажиллаж байсан. Хүүхдийн хүмүүжлийн тусгай сургалтай сургууль (Ерөөгийн тусгай ТМС, Шувуун фабрик дахь Хөдөлмөр хүмүүжлийн сургууль)-иуд байгуулагдан ажиллаж байгаад татан буутгсан, Цагдаагийн бүх байгууллагад хүүхдийн гэмт явдалтай тэмцэх “Хүүхдийн алба” (хүүхдийн байцаагч) мэргэшин

ажиллаж³⁴, “хэцүү хүүхэд”-тэй ажиллах Хүүхдийн кабинетууд (Хүүхдийн хүмүүжлийн тасалгаа)-ыг хүүхдийн байцаагчид хариуцан ажиллуулдаг байсан зэрэг болно.

➤ Θөөдөр насанд хүрээгүй этгээдийг гэмт халдлагаас хамгаалах цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь зөвхөн хүүхдийн тасаг/нэгж³⁵ гэлтгүй цагдаагийн байгууллагын бүхий л төрөл мэргэжлийн албатуудын хамтын үйл ажиллагааны нийлбэрээс бүрдэж зохих түвшинд явагдаж байгаа хэдий ч хүний нөөцийн дутмаг байдал, ажлын ачаалал, мэргэшсэн мэдлэг, ур чадвар зэргээс шалтгаалан хүүхдийн эрх ашиг хохирох, гэмт хэрэг, зөрчлийн асуудлыг дутуу дулимаг шийдвэрлэх, гэмт этгээдүүд “ял завших”, хуулийн хэрэгжилт сурлах хандлага буй нь ажиглагдаа³⁶.

Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдалтай тэмцэх эрх зүй, зохион байгуулалтын үндэснэгээр тэдний хэрэгтэй тэмцэх төрийн бодлогоос шууд хамаарлтай, сүүлийн жилүүдэд гарч буй гэмт хэрэг, түүн дотроо насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн байдал нь хүүхэд, өсвөр үеийнхийг гэмт халдлагаас хамгаалах асуудалд онцгой анхаарал хандуулахыг шаардах боллоо. “Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын

³⁴ Цагдаагийн байгууллагад гэмт хэрэгт холбогдсон тэнэмэг хүүхдүүд, тэдний хүмүүжлийн асуудлыг хариуцан ажиллах үргэлжийг анх 1946 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Хүүхдийн алба үүсэн байгуулгадж, 2012 оны дунд хүртэл ажиллах хугацаанд хүүхдийн байцаагч, хүүхдийн төлөөлгөчийн орон тоотой, НАХЯ, ЦЕГ-ын харьяалалд, Эрүүгийн, Хэв журмын албаны бүтцэд эзлэхэн харьялагдаж, хүүхэд, насанд хүрээгүй хүмүүстэй ажиллах, тэднийг гэмт хэрэг зөрчил үйлдээ, гэмт хэрэгт өртөж хохирохос урьдчилан сэргийлэх, эрх ашигийн хамгаалах, энэ талаарх хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, сахиуулан сурталчилах, бусад албад, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах асуудлудыг хариуцан ажиллаж байжээ. ЦЕГ-ын даргын 2012 оны “НЦГ-ын бүтэц, орон тоог батлах” тухай 700 тоот тушаалаар уг албыг татан буулгасан.

³⁵ ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/234 тоот тушаалаар Үрьдчилан сэргийлэх хэлтэст Хүүхдийн гэмт хэрэгээ үрьдчилан сэргийлэх тасаг, Нийслэлийн цагдаагийн газарт Хүүхдийн гэмт хэрээс үрьдчилсан сэргийлэх хэлтэс, дүүргэ, орон нутагт гэр булийн хүчирхийлэл, хүүхдийн асуудлудыг хамтгаттан хариуцсан тус бүр нэг алба хаагч томилон ажилшуулж байна.

³⁶ “Монгол Улсад насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” сэдэвт судалгааны ажлын тайлан. ЦЕГ, ХСИС. Уб., 2018 он.

³² Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Хууль зүй, дотоод хэргийн яамны сайдын хамтарсан 2017 оны А/51, А/69 тоот хамтарсан тушаалаар ажиллах журмыг баталсан.

³³ ХЗДХЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг хариуцан ажиллаж байсан.

2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 60 дугаар зарлигаар 2019 оныг “Хүүхдийн хөгжил, хамгааллын жил” болгосон. Энэ хүрээнд хүүхдийн эрхийг хүндэтгэх, эрдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд туслах, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлд идэвх санаачилга гаргаж ажиллахыг ард иргэддээс уриалсан билээ.

ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Хүүхдэд ээлтэй шүүх тогтолцоо нь зөвхөн гэмт хэрэгт холбогдсон бус тэдгээрт өртөж хохирсон насанд хүрээгүй хохирогч, гэрч, эцэг эхийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг шийдвэрлэх шүүх (Тусгайлсан шүүх, Шүүхийн баг, Тангаргатний шүүх)-ийн ба шүүхийн бус байгууллагаас гадна энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүх төрийн ба төрийн бус байгууллага, хувь хүн (хуулийн, эрүүл мэнд, соёл, боловсрол, асрамж халамж, нийгмийн үйлчилгээ, сургалт, судалгааны, Хүүхдийн хууль зүйн хороо, Хүүхдийн эрхийн ажилтан, Хүүхэд хамгаалагч нар г.м.) зэрэг өргөн хүрээний байгууллагуудыг хамарсан, эрх зүйн тогтолцоонд тодорхой байр суурь эзэлсэн тогтолцоожсон бүтэц юм.

2. Монгол Улсад хүүхдийн эрүүгийн боллогыг эрчимжүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүх байгууллагуудыг уялдуулан зохицуулах нэгдмэл хандлага чухал юм. Хууль тогтоомжийг өөрчилснөөр тэр бүр шинэчлэлт болдоггүй удаширдаг тал байна, энэ талын бүх байгууллагуудыг хамарсан тогтолцоонд нь, цогц шинэчлэл хийх, хуулийн их, дээд сургуулиудыг ч хамтад нь шинэчлэх шаардлага байна.

3. Олон Улсын стандарт, шаардлага, хүүхдийн эрхийг эн тэргүүнд ханган хамгаалахын тулд юуны түрүүнд цагдаагийн байгууллагад хүүхдийн

асуудлаар дагнан ажиллах нэгж/албыг байгуулах (судалгаанд суурилж орон тоог тогтоох) нь тулгамдсан асуудал болжээ.

4. Дэлхийн улс орнууд насанд хүрээгүй этгээдийн хэргийг хянан шийдвэрлэхдээ аль болох шийтгэх бус, өөрийнх нь эрх ашгийн төлөө албан бус хэлбэрээр шийдвэрлэх янз бүрийн технологиудыг нэвтрүүлжээ. Тухайлбал: Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэгт эвлэрүүлэн зуучлал явуулдаг загвар нь тэднээс үйлдсэн эрх зүйн зөрчлийг шүүхийн бус аргаар шийдвэрлэх, давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зан үйлийн улам эвдрэлд орохоос сэргийлэх, хэвийн амьдралдаа эргэн орох, хохирогч хүүхдийн асуудлыг таатайгаар шийдвэрлэхд чухал ач холбогдолтой тул эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх сургалтын газартай болох, одоогийн “Хүүхдийн хууль зүйн хороо”-ны ажилтнуудаас зохион байгуулагч (медиатор)-ийг мэргэшүүлэн томилох, улмаар ЕБС-дад бий болгох боломжтой.

5. Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэд (эсхүл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтцэд) өсвөр насны хүнд оногдуулах ял, хүмүүжлийн чанартай арга хэмжээний³⁷ хэрэгжилтэд хяналт тавих тусгайлсан газар³⁸ байгуулах асуудлыг судлах. Бие даасан статустай тусгай газар/алба хаагчид байх нь хууль сахиулах байгууллагуудын дэг журам сахиулах зэрэг тэдний хувьд үндсэн бус үүргээс чөлөөлөгдөж, хяналтанд байгаа хүүхэдтэйгээ байнга харилцаатай байж, үйл ажиллагаа нь тодорхой этгээдэд ойртсон, цагаа олсон, үр дүнтэй байх, нөгөө талаас олон нийтийн итгэл, идэвхийг нэмэгдүүлэх давуу талтай байж болох юм.

³⁷ Одоогийн хуулиар Хүүхдийн асуудал хариуцсан захиргааны байгууллага хэрэгжүүлж байгаа.

³⁸ Probation

ХУУЛЬ ЗҮЙН СТАТИСТИКИЙН ОНОЛ, ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛ



*Дотоод хэргийн их сургууль,
Цагдаа судлалын төвийн
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан,
хууль зүйн доктор Б.Мөнхдорж,*



*МУИС-ийн ХЗС-ийн магистрант
Б.Ариунтуяа*

ТҮЛХҮҮР ҮГС:

Ёс зүйн статистик, хууль зүйн статистик, эрүүгийн эрх зүйн статистик, иргэний эрх зүйн статистик, захирагааны эрх зүйн статистик, криминологи, математик, статистик, гэмт хэргийн статистик.

ТОВЧЛОЛ:

Энэ өгүүллээр “Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал” шинжлэх ухаан, технологийн төслийн¹ үр дүн, дүгнэлт, санал, зөвлөмжид үндэслэн хууль зүйн статистикийн онол, арга зүйн үндэслэлийг судлах, хууль зүйн төдийгүй, статистикийн салбарт шинэ мэдлэгийг бий болгох, академик эргэлтэд оруулах, түүний хэрэглээг үндсэн хуулийн эрх зүй, эрүүгийн эрх зүй, иргэний эрх зүй, захирагааны эрх зүй, өмгөөлөл, нотариатын үйлчилгээ зэрэгээр төрөлжүүлэн, практик байгууллагын үйл ажиллагаанд тулгуурлан хөгжүүлэх асуудлыг дэвшүүлэн гаргасан болно.

Гэмт хэргэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй, үр ашигтай зохион байгуулахын тулд үйлдэгдсэн гэмт хэрэг бүрийг шинжлэх ухааны арга зүйгээр зөв бүртгэж, бодитой хэмжих, шалтгаан, нөхцөлийг нарийн тогтооход статистикийн шинжлэх ухаан чухал үүрэгтэй. Төрийн эрүүгийн бодлого, гэмт хэргэгтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэмжих үзүүлэлтийн нэг нь гэмт хэргийн статистикийн тоон мэдээлэл мөн. Тодруулбал, нийгмд оршин буй гэмт явдлын дүр зураг, нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр төрөөс гэмт хэргэгтэй тэмцэх бодлого, арга замаа хэрхэн тодорхойлохоос үйл ажиллагааны үр ашиг, үр дүн шалтгаалдаг².

Иймд хууль зүйн салбарын мэдээллийн нэгдмэл, гэмт хэргийн статистикийн бодит байдлыг хангах үүднээс Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар “Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал” шинжлэх ухаан, технологийн төслийг Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр Дотоод хэргийн их сургуулиас 2016 оны

¹ Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр Хууль сахиулахын их сургуулиас 2016 оны 11 дүгээр сараас 2018 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн. <http://www.leu.gov.mn/content/19522.shtml?sel=1>. 2019.05.28

² Б.Мөнхдорж. Гэмт хэргийн статистикийн онол, хэрэглээний асуудал, Докторын диссертаци. Уб., 2018 он.

11 дүгээр сараас 2018 оны 12 дугаар сар хүргэлих хугацаанд хэрэгжүүлсэн.

Төслийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, “Хууль зүйн цахим нэгтгэл” төслийн баг, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, МУИС, МУБИС, ДХИС, ХААИС, СЭЗИС, Монголын Криминологичдын холбоо, Нээлттэй нийгэм форум болон бусад байгууллагын 40 гаруй эрдэмтэн, судлаач ажилласан юм.

Тус ажлын хүрээнд гэмт хэргийн статистикийн эрх зүйн зохицуулалтыг судалж, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Статистикийн тухай хуулиудын шинэчилсэн наиргуулгын төсөлд тусгах тодорхой саналууд өгсөн, нэг судлаач докторын зэрэг, 7 судлаач магистрын зэрэг хамгаалсан, “Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн өнөөгийн байдал: SWOT шинжилгээ”, шүүх, прокурор, цагдаа, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээ зэрэг практик байгууллагад тулгамдсан асуудлаар 25 судалгааны ажлыг гүйцэтгэж, тайлланг эмхэтгэл болгон хэвлүүлж, практик байгууллагад зөвлөмж хэлбэрээр хүргүүлсэн байна.

Анх удаа олон улсын жишигт ойртуулсан “Монгол Улс дахь 2017 оны гэмт хэргийн цагаан ном”³-ыг судалгааны төсөл хэлбэрээр эрхлэн гаргасан, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын статистикийн үйл ажиллагаанд мөрдөгдөх “Гэмт хэрэг, шүүх таслах ажиллагааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-ыг Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлөөр 2018 онд хэлэлцүүлэн батлуулсан зэрэг гол үр дүнг дурдаж болно.

³ Б.Мөнхдорж (Судалгааны багийн ахлагч), Г.Эрдэнэбат (Судалгааны багийн зөвлөх). МКХ-ны судалгааны баг. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016. Суурь судалгааны тайлан. Уб., 2017 он.

Мөн цагдаа, авлигатай тэмцэх, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурорын байгууллага, шүүхийн статистикийн үйл ажиллагаа хариуцсан ажилтнуудад зориулсан “Гэмт хэргийн статистикийн мэргэжилтэн, судлаачдыг чадавхжуулах нь” сэдэвт онлайн сургалт-хэлэлцүүлгийг Цагдаагийн ерөнхий газрын онлайн сургалтын баазад түшиглэн ХЭДХЯ, ГХУСАЗЗ, УСХ, ЦЕГ-тай хамтран 2018 онд зохион байгуулсан.

“Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал” шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг тоймлон авч үзвэл⁴:

Төслийн хүрээнд 25 судалгааны ажил гүйцэтгэж, 26 орчим тооны эрдэм шинжилгээний өгүүлэл сэтгүүлд нийтлүүлж, мөн 30 гаруй илтгэл эрдэм шинжилгээний хурлуудад хэлэлцүүлж, анх удаа энэ сэдвээр дагнан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөх үндэсний аргачлал боловсруулан батлуулсан байна.

Дээрх төслийн хүрээнд хийсэн судалгааны үр дүн холбогдох байгууллагад зөвлөмж хэлбэрээр хүрч байгаагаас гадна эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, тогтолцоо, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, энэ чиглэлийн эрдэм шинжилгээний бүтээлийн тоо, чанарыг нэмэгдүүлэх, олон нийт, салбарын анхаарлыг үүнд хандуулах, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр тодорхой ажил хийж, практикт үр дүнгээ өгч байна.

Төсөл үр дүнтэй хэрэгжсэнээр гэмт хэргийн статистик зүйн онол, арга зүй судлагдахуунаар баяжигдаж, практик байгууллагуудын төдийгүй үндэсний хэмжээнд гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаа боловсронгуй болж, мэдээлэл үнэн зөв, бодитой гарах нөхцөл сайжирч, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал түлхэц болсон.

Мөн гэмт хэргийн статистик зүйн онол, арга зүйн үндэслэлийг анх удаа

⁴ ХЭДХЯ, ХСИС, ШУТС. “Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал” сэдэвт шинжлэх ухаан, технологийн төслийн үндсэн тайлан. Уб., 2019 он.

докторын судалгааны түвшинд суурь судалгааны хэлбэр, арга зүйгээр судалж, эрдэм шинжилгээ, сургалтын эргэлтэд орсон. Гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал, хуулийн төсөл боловсруулж, одоогоор хуулийн төслүүгэд тусгагдаад байна. Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааны тогтолцооны загварыг боловсруулж, холбогдо түвшинд санал болгосноор зарим тогтолцоо, бүтэц, зохион байгуулалттай холбоотой асуудал шийдэгдээд байна.

ЦЕГ, АТГ, ШШГЕГ, ШЕЗ зэрэг байгууллага гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаанд баримтлах заавар, эрх зүйн акт, маягт, аргачлалаа ҮСХ-оор шинэчлэн батлуулсан ба ҮЕПГ, ШШҮХ батгуулахаар боловсруулж байна. Өөрөөр хэлбэл, төсөл хэрэгжих явцад практик байгууллагуудын гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаа боловсронгуй болон хөгжсөн.

Гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг эрхлэх хүний нөөцийг бэлтгэх, тэднийг сургах, мэргэшүүлэх, чадавхжуулах талаар бодитой үр дүн гарсан төдийгүй практикийн 9 ажилтан хууль зүйн магистрын зэрэг хамгааллаа. Эрх зүйч-статистикийн мэргэжилтэн, судлаачийг бэлтгэх боломжийг нээлээ.

Хууль зүйн шинжлэх ухааны судалгаанд, ялангуяа гэмт хэрэг, гэмт явдлыг судлахад математик, статистикийн арга, арга зүйг хэрэглэх талаар академик хэрэглээ, хандлагыг салбарын эрдэмтэн, судлаачдын хэмжээнд нөлөөлж, хэвшиүүлсэн. Нөгөө талаас, математик, статистик, эдийн засгийн эрдэмтэн, судлаачдын анхаарлыг хууль зүй, гэмт явдлыг судлахад чиглүүлсэн нь энэ салбарын судалгааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан нь чухал үр дүнг юм.

Эцэст нь Монгол Улсын статистик, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн, түүнчлэн хууль зүйн салбарын байгууллагын удирдлага, асуудал хариуцсан нэгжийн удирдлага, мэргэжилтэн, ажилтнуудын болон хууль

зүй, статистик, математик, эдийн засгийн салбарын эрдэмтэн, судлаачдын анхаарлыг гэмт хэргийн статистикийн мэдээлэл, судалгаа бодитой, боловсронгуй байх ёстой гэсэн үзэл санаанд чиглүүлсэн болно.

Дээрх судалгааны үр дүн, тайланд туссан, эрдэм шинжилгээний хурал, семинар, уулзалтаас гарсан санал, зөвлөмжид хууль зүйн статистикийн онол, арга зүйн үндэслэлийг судлах, хууль зүйн төдийгүй, статистикийн салбарт шинэ мэдлэг, мэдээллийг бий болгон, академик эргэлтэнд оруулах, түүний хэрэглээг төрөлжүүлэн, практик байгууллагуудад тулгуурлан хөгжүүлэх санал, зөвлөмж гарсан. Тухайлбал, үндсэн хуулийн цэцийн маргааны статистикийг хөгжүүлэх, Монгол Улсад хэдэн хүн хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ авч эрх ашигаа хамгаалуулсан талаар статистикийн үзүүлэлтийг бий болгох, түүний бодлогын түвшинд ашиглах боломжийг бий болгох хэрэгцээ байна гэж үзлээ.

Аливаа улс, салбарын хөгжлийг хэмжих шалгуур үзүүлэлт бол статистикийн судалгаа, мэдээллийн үнэн бодит болж байна. Олон улсын болон үндэсний хэмжээнд хөгжлийн өнөөгийн түвшинг үнэлж, цаашдын чиг хандлага, бодлогыг тодорхойлоход статистикийн бодитой мэдээлэлд тулгуурлаж байна. Тухайлбал, НҮБ-аас дэлхийн улс орнуудын Тогтвортой хөгжлийг 2030 хүртэл хэмжих үзүүлэлт бүрт статистикийн мэдээлэл ашиглаж байна.

Дэлхий нийтээрээ “Энхтайван, шударга ёсыг цогцлоо зорилт” дэвшүүлж буй энэ цаг үед “тухайн улсын шударга байдлын түвшин, хууль хэрэгжилтийн үнэлгээ, аюулгүй байдлын түвшин, авлигын индекс, гэмт хэрэг, зөрчил, маргааны статистик мэдээлэл” чухал хэмжүүр болж байна.

Монгол Улсад шударга байдал, хууль хэрэгжилт, аюулгүй байдал, авлигын түвшин, шударга бусын илрэл болсон гэмт хэрэг, зөрчил, маргаан, түүний шийдвэрлэлт хэрхэн гарч буй нь онолын үндэслэлгүй, хоорондоо уялдаа холбоо муутай, бодлого,

үйл ажиллагааны хэрэгжилтийг хэмжихэд “Хууль зүйн салбарын статистикийн үзүүлэлт” хангалттай түвшинд хэрэглэгдэхгүй байна.

Иймд “хууль зүйн статистик”-ийн онол, арга зүйн үндэслэлийг судлах, хууль зүйн төдийгүй статистикийн салбарт шинэ мэдлэг, мэдээллийг бий болгон, академик эргэлтэнд оруулах, улмаар түүний хэрэглээг эрүүгийн эрх зүй, иргэний эрх зүй, захиргааны эрх зүй, үндсэн хуулийн эрх зүй, өмгөөлөл, хууль зүйн туслалцаа, нотариатын үйлчилгээ зэргээр төрөлжүүлэн, практик байгууллагуудад тулгуурлан хөгжүүлэх санал, зөвлөмж боловсруулах зайлшгүй шаардлага байна.

Гадаад орны, ялангуяа ОХУ-ын туршлагаас үзэхэд хууль зүйн статистикийг нэгдүгээрт: эрүүгийн эрх зүйн статистик, хоёрдугаарт: иргэний эрх зүйн статистик, гуравдугаарт: захиргааны эрх зүйн статистик гэж ангилж иржээ⁵.

Хууль зүйн статистикийг ОХУ-д ёс зүйн статистик, эрх зүйн статистик, Англи улсад шүүхийн статистик, Америкт гэмт хэргийн статистик, эрүүгийн хариуцлагын статистик, түүний дотор цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэрийн статистик гэх байдлаар ангилан авч үзэж байна.

Харин Монгол Улсын хувьд эрүүгийн тоо бүртгэл, гэмт хэргийн тоо бүртгэл, шүүхийн статистик, эрүүгийн хэргийн статистик, гэмт хэргийн статистик гэх зэргээр нэрлэж иржээ. Өнөөгийн практик, туршлагаас үзэхэд байгууллагаар нь цагдаагийн статистик, авлигатай тэмцэх байгууллагын статистик, прокурорын статистик, шүүхийн статистик, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистик, шүүхийн шинжилгээний статистик гэх мэтчилэн ангилж байна.

Нийгмийн статистикийн нэг төрөл болох хууль зүйн статистикийг эрүүгийн эрх зүйн, захиргааны эрх зүйн, иргэний эрх зүйн статистик гэж ангилж, хууль зүйн статистик нь нөгөө талаас хууль зүйн шинжлэх ухааны нэг төрөл судлагдахуун гэж үзэж болно.

⁵ Б.Мөнхдорж. Гэмт хэргийн статистикийн онол, хэрэглээний асуудал. Докторын диссертаци. Уб., 2018 он.

Эрүүгийн эрх зүйн статистикийн нэг хэсэг нь гэмт хэргийн статистик юм. Иймд “шүүхийн статистик” гэсэн бүлгийг “хууль зүйн статистик” гэж онолын үндсэн дээр өөрчлөн, хууль зүйн статистикийн ангилаал, төрлийг шинэчлэх шаардлага байна гэж үзсэн.

Хууль зүйн статистик гэх ангиллаас гадна гэмт хэргийн статистикийн олон улсын ангиллыг НҮБ-аас гарган, гишүүн орнуудад мөрдүүлж байна. Энэ ангиллыг үндэсний хэмжээнд хэрхэн нийцүүлэх хувилбарыг манай улс боловсруулж, мөрдүүлэх шаардлага бий болж байна.

ДҮГНЭЛТ

Хууль зүйн статистикийн онол, арга зүйн үндэслэл, түүний хэрэглээг төрөлжүүлэн хөгжүүлсэнэр дараах үр дүн гарна гэж үзэж байна.

- НҮБ-аас баталсан Тогтвортой хөгжлийн “Энхтайван, шударга ёсыг цогцлоо зорилт”-ыг хэмжих үзүүлэлт сайжирч, тухайн улсын шударга байдлын түвшин, хууль хэрэгжилтийн үнэлгээ, аюулгүй байдлын түвшин, авлигын индекс, гэмт хэрэг, зөрчил, маргааны статистик мэдээлэл бодитой гарах онол, арга зүйн үндэс бүрдэн хөгжине.

- Гадаад болон дотоодын эх сурвалжид үндэслэн эрдэмтэн, судлаачдын санал санаачилгаар “Хууль зүйн статистик зүй” хэмээх мэдлэгийн шинэ салбар, судлагдахууны онол, арга зүйн үндэслэл бий болж боловсруулагдаж, академик эргэлтэд орно.

- Хууль зүйн статистикийн хэрэглээг эрүүгийн эрх зүй, иргэний эрх зүй, захиргааны эрх зүй, үндсэн хуулийн эрх зүй, өмгөөлөл, хууль зүйн туслалцаа, нотариатын үйлчилгээ зэргээр төрөлжүүлэн, практик байгууллагын “хууль зүйн статистикийн үйл ажиллагаа” боловсронгуй болж, хөгжих нөхцөл бүрдэнэ.

Хууль зүйн статистикийн онол, арга зүйн үндэслэл, түүний хэрэглээг төрөлжүүлэн хөгжүүлсэнэр эдийн засаг, нийгмийн болон шинжлэх ухааны ач

холбогдлын талаар дараах үр дүн гарна гэж төсөөлж байна.

- Хууль зүйн статистикийг боловсронгуй болгосноор хууль зүйн салбарт зарцуулж буй төсвөөс эдийн засгийн хэмнэлт гарна.

- Мөн улс орны хэмжээнд шударга ёс, дэг журмыг тогтоох, хуулийг биелүүлэх, хэрэгжүүлэх, сахиулах үйл ажиллагаанд ахиц гарч, эдийн засаг, төсөвт хэмнэлт хийгдэхээс гадна нийгэм, олон нийтэд учрах хор хохирол буурна.

- Шударга ёс алдагдаж, хууль хэрэгжихгүй байгаа алдаа доголдлыг зөв арга зүйгээр хэмжиж чадсанаар “алдааг засах, дутагдлыг арилгах, зөвийг дэмжих” замаар манай орны хөгжилд чухал ач холбогдолтой.

САНАЛ

Хууль зүйн статистикийн онол, арга зүйн үндэслэлийг гүнзгийрүүлэн судлах, хууль зүйн төдийгүй, статистикийн салбарт шинэ мэдлэг, мэдээллийг бий

болгон, академик эргэлтэд оруулах, түүний хэрэглээг эрүүгийн эрх зүй, иргэний эрх зүй, захиргааны эрх зүй, үндсэн хуулийн эрх зүй, өмгөөлөл, хууль зүйн туслалцаа, нотариатын үйлчилгээ зэрэгээр төрөлжүүлэн, практик байгууллагад тулгуурлан хөгжүүлэх нь зүйтэй.

Энэ ажлыг салбарын эрдэмтэн, судлаачдаас Үндсэн хуулийн цэц, Хууль зүй, дотоод хэргийн яам Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төв зэрэг эрдэм шинжилгээний байгууллага, Монголын Хуульчдын холбоо, Монголын Нотариатчдын танхим, Монголын Өмгөөлөгчдийн холбоотой хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

---000---

МОНГОЛ УЛСЫН АНХДУГААР ҮНДСЭН ХУУЛИЙН ТАЙЛБАРЫН ТУХАЙД



Санхүү эдийн засгийн их сургуулийн
Эрх зүйн тэнхимийн багши Б.Дэлгэрмаа

ТҮЛХҮҮР ҮГС:

Үндсэн хууль, Үндсэн хуулийн тайлбар, Монгол Улс, Улсын Их Хурал, Улсын Бага Хурал.

ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүллээр Монгол Улсын Анхдугаар Үндсэн хуулийн тайлбарыг хэрхэн, хэзээ, хэн тайлбарласан тухай түүхэн талаас хөндсөн төдийгүй хууль, эрх зүйн үүднээс хуулийг тайлбарлах арга, хэлбэр талаас нь мөн судалсан болно. Төрийн тулхтай зүтгэлтэн Б.Цэрэндорж нь Улсын анхдугаар Их хурлаас баталсан Үндсэн хуулийн бүх зүйлийг нэг бүрчлэн тайлбарлаж 1926 оны 6-р сард тусгай товхимол болгон хэвлүүлсэн юм. Энэ нь Монгол Улсад Үндсэн хуулийн эрх зүйн судалгааны эхлэл болсон билээ.

Манай улсын анхдугаар Их Хурал 1924 онд хуралдаж, тус орны түүхэнд анх ардчилсан Үндсэн хууль бүхий БНМАУ-ыг тунхаглахад нам, төрийн бусад зүтгэлтийн хамт Б.Цэрэндорж чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Б.Цэрэндорж Улсын анхдугаар Их Хуралд Засгийн газрын гүйцэтгэн явуулсан ажлын тухай дэлгэрэнгүй тайлан илтгэл хийж, бас манай Улсын анхдугаар Үндсэн хуулийг боловсруулан

зохиох ажилд хувь нэмэр оруулж, улмаар тус их хуралд зүйл дараалан уншин хэлэлцүүлж, төлөөлөгчдийн асуултанд хариу тайлбарлаж байв.¹ Төрийн тулхтай зүтгэлтэн Б.Цэрэндорж нь 1926 онд Үндсэн хуулийг зүйл, анги дараалан албан ёсны тайлбар хийсэн төдийгүй бусад улстай харилцах олон талт гэрээ, хэлэлцээрт оролцож, уг гэрээнд мөн тайлбар хийсэн байdag. Тухайлбал, Цэрэндорж бээр Гурван этгээдийн гэрээ бичгийн утга учрыг нарийвчлан судлаад “өөрийн мэдсэний хирээр зүйл дараалан” (Тайлбарласан дэвтэр (онгуй) т.бА) тайлбарлаж нийтийн хүртэл болговол олонд тустай хэмээн Богд хаанд айлтгасанд 1915 оны 10-р сарын 13-нд “Зарлиг гүйсан ёсоор болгогтун” хэмээн зөвшөөрчээ. Цэрэндорж бээр тэрхүү тайлбараа Гурван этгээдийн гэрээний бараг бүх (22) зүйлийг 21 анги болгож ямарч хүн уншаад ойлгохоор бичжээ. Тус тайлбaryн нэгдүгээр ангид нь Хиагтын гэрээний эхний хэсэгт Гадаад монголын Богд Жавзандамба хутагт “повелитель” хэмээн бичсэн байна. Энэ уг бол Өрнө умард зүгийн өөртөө эзэрхсэн бага улсын хаадыг өргөмжилсөн цол бөгөөд монголоор орчуулбал улсын эзэн хэмээх уг лавтайяа мөн гэж тайлбарлажээ.²

Ийнхүү 1924 онд Үндсэн хуулиа баталсан нь манай улсын түүхэнд онцгой чухал бөгөөд ихээхэн ач холбогдолтой үйл явдал болсон юм. Монголчууд Чингийн эрхшээлд байх үед болон 1911-1919 онд, ер нь оршин тогтонох бүхий л хугацаанд Монголын бүх нийгмийн харилцааг нарийн зохицуулсан нэгдмэл Үндсэн хууль байсангүй. Гэхдээ монголчууд төрийн хууль ямар үүрэгтэйг буюу хүн бүхэн төрийн хуулинд захирагдах ёстойг сайн

¹ М.Ядамсүрэн. Ардын төрийн ахмад зүтгэлтэн Балингийн Цэрэндорж, Хоёр дахь хэвлэл, Уб., 1967 он, 6-7 дахь тал.

² З.Лонжид. Б.Цэрэндоржийн тухай эргэцүүлэл, Монгол Улсын Ерөнхий сайд Балингийн Цэрэндорж-150, Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, Уб., 2018 он, 108 дахь тал.

мэддэг байсан билээ. 1924 онд Анхдугаар Үндсэн хууль баталснаар Монгол Улсын харьяат иргэд улс төрийн хувьд эрхээ баталгаажуулж чадсан боловч Үндсэн хуулийн тухайд тодорхой ойлголтгүй байсан учраас түүнийг зүйл дараалуулан тайлбарлах зайлшгүй шаардлага урган гарч ирсэн юм. Үндсэн хуулийн эрх зүйд “хууль тайлбарлах”, “эрх зүйг тайлбарлах”, “Үндсэн хууль тайлбарлах”-ыг тусгай нэр томьёо болгон хэрэглэдэг. Хуулийн заалт (бичвэр), томьёоллын утга агуулгыг задлан шинжилж, хэрхэн ойлгож хэрэглэхийг нээн харуулахыг хууль тайлбарлах гэнэ³. Сурвалжаас хараахад Үндсэн хууль тайлбарлах үргийг УБХ-ын тэргүүлэгчдэд олгожээ. Тэргүүлэгчид тухайн үргийг Засгийн газрын зөвлөх Э.Д.Ринчиною буюу Элбэгдоржид даалгасан бололтой.

БНМАУ-ын Анхдугаар Бага Хурлын хоёрдугаар хуралдааны наймдугаар өдөр буюу Монгол Улсын 15 дугаар он гурван сарын 28-ны өдрийн хуралдаанд (1925.03.28.) Үндсэн хуулийг тайлбарласан дэвтэр гаргах эсэх асуудал яригдav. Гишүүн Элбэгдоржоос, Үндсэн хуулийг тайлбарласан дэвтэр гаргах хэргийг тусгай даалгавраас ямар хэмээхүйд, мөн гишүүн Тардадаас, Үндсэн хуулийг тайлбарлуулах тухайг тогтоол гаргаваас зохих болов уу⁴ гэх мэт санал, асуултууд өрнөсөн байна. Улмаар Улсын хоёрдугаар Бага Хурлын наймдугаар тогтоолын дөрөвдүгээр зүйлд, “Аливаа хэлэлцэн тогтоосон ба баталсан олон зүйлийн чухал хэргүүдийн учир утгыг олон нийтэд сэнхүүлэн ухуулан, танилцуулах ба басхүү Үндсэн хуулийг тайлбарлан гаргаваас зохих тул энэхүү ухуулан гаргах ба тайлбарлах явдлыг харьяат хурлын Тэргүүлэгчдэд эрхлүүлэн гүйцэтгүүлэхээр тогтгов”⁵ хэмээн Улсын Анхдугаар Үндсэн хуулийн гол утга асуулгыг нийтэд түгээн дэлгэрүүлэх явдлыг УБХ-ын Тэргүүлэгчдэд үүрэг

болгон тогтоол гаргасан байна.

БНМАУ-ын Хоёрдугаар Их хурлын 1925 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдааны хэлэлцэх асуудлын тавдугаар зүйлд, “Хоёрдугаар Бага хурлын тогтоолын ёсоор Тэргүүлэгчдээс ухуулах гаргаж нийтээр зарласан ба Үндсэн хуулийг тайлбарлуулахаар тусгай хүнийг томилсон нь энэ завсар хараахан багтальцуулан нийтэлж завдаагүй ба бас ард түмнийг удирдан боловсруулж шинэ боловсролын байдалд урагш дэвшүүлэхийг эрхэмлэж, Үндсэн хуулийн зэрэг олон зүйл дүрэм заавар сэтгүүл зэргийг Засгийн газраар уламжлан үлэмж тоогоор тус тус хэвлүүлэн тараан гүйцэтгэсээр буй”⁶ хэмээжээ.

Тус өдрийн хуралдаанд төлөөлөгч Гэндэнгээс, “Үндсэн хуулийг тайлбарлах хэргийг завдаагүй хэмээсэнд ямар учраас завдаагүй бол гэсэнд Гэндэнгээс, Үндсэн хуулийг тайлбарлах хэргийг н.Элбэгдоржид даалгасан нь тэрхүү хүн өөр газар явчхаад хараахан гүйцэтгэж чадаагүй” гэсэн хариултыг өгсөн байdag.

Б.Цэрэндорж зөвхөн бичгийн үлэмж боловсролтой хүн байсан төдийгүй бас хууль цааз, түүх, эдийн засгийн талаар нилээд их зүйлийг мэддэг хүн байлаа.⁷

Иймээс УБХ-ын тэргүүлэгчид хууль, эрх зүйн гүнзгийг мэдлэгтэй Ерөнхий сайд Б.Цэрэндоржид хариуцуулж Үндсэн хуулийн тайлбар бичихийг үүрэг болгосон аж. Энэ дагуу тэрбээр уул тайлбарыг бичих бэлтгэл болгон “Бүгд Найрамдах Улс болсон ба Үндсэн хууль”⁸ хэмээх өгүүлэл бичжээ. Уг өгүүллийг ажихад Үндсэн хуулийг зүйл дараалан тайлбарлах хураангуйгаа бэлдэж байсан нь мэдэгдэж байна. Тус өгүүлэлд “... харьяат олон түмэн ардууд энэхүү Үндсэн хуулийн утга чанарыг нийтээр гүнээ ухамсарлан мэдэж зүйл анги дараалан журамлан дагаж яваас аваас бидний БНМАУ-ын засаг ба олон түмэн

³ Хуулийн тайлбарыг албан ба албан бус хэмээн хоёр хуваана. Эрх бүхий байгууллагын тайлбарыг албан ёсны хэмээдэг.

⁴ Ч.Болдбаатар. БНМАУ-ын Анхдугаар Бага Хурлын хуралдаан (1924-1925). баримт, судалгаа. Уб., 2009 он, 117-118 дахь тал.

⁵ Монгол Улсын үндэсний төв архив. (хойшид МУУТА гэж товчилно) МУУТА, х-11, д-1, хн-19.

⁶ Ж.Амарсанаа,, О.Батсайхан,, Монгол Улсын гадаад бодлого:

хичээнгүй сайд Балингийн Цэрэндорж. Уб.. 2011 он., 218-219 дэх тал., х-26, д-1, хн-56.

ардын эрх чөлөөт гадаад, дотоодын эзэрхэг харгис этгээдэд дахин алдагдаж урьдын адил гашуун зовлонг эдлэхэд хэрхэвч хүргүүлэхгүйгээр үүрд батлан хамгаалж чадах бөгөөд гагцхүү зүйл ангийн дотор хааяа хэтэрхий товчидсон ба битүүлэгдсэн газар бий агаад олон түмэн ардуудын зарим нь эндүү ташаагаар ухаж болуужин хэмээн болгоомжлох учир арван тавдугаар он гурван сарын хорин наймын өдөр (1925.03.28.) хуралсан Улсын хоёрдугаар Бага Хурлын наймдугаар тогтоолын дөрөвдүгээр зүйлийн дотор улсын Үндсэн хуулийг тайлбарлан гаргаваас зохих тул харьяат хурлын тэргүүлэгчдэд эрхлүүлэн гүйцэтгүүлэхээр тогтов хэмээснийг журамлан дагаж одоо Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газраас зүйл анги дараалан товчлон тайлбарлаж тусгай дэвтэрт хэвлүүлэн нийтээр зарлан тараахыг завдан буй⁹ хэмээжээ. Энэхүү өгүүллээс үзэхэд тухайн үеийн нийгэмд эрх зүйг, хуулийг тайлбарлах зайлшгүй шаардлага буй болж эрх зүйт төр бүрэлдэн тогтоож эхэлсний илрэл харагдаж байна. Тус хуулийн зүйл ангийн доторх заалт нь хэт товч, битүү утгатай буйг, түүнчлэн хувь хүн, иргэн бүр нэгэн утгаар ухаж ойлгох, төсөөлөх боломжгүй учраас Үндсэн хуулийг тайлбарлах шаардлага буйг илэрхийлсэн байна.

Ийнхүү Монгол Улсын Анхдугаар Үндсэн хуульд тайлбар хийх эрх УБХ-ын тэргүүлэгч гишүүддэд¹⁰ олгогдсон байна. Ерөнхий сайд Б.Цэрэндорж энэ товч агуулгыг дэлгэрүүлж Үндсэн хуулийн 50 зүйлийг нэг бүрчлэн энгийн, ойлгомжтой хэллэгээр тайлбарыг хийж дууссаны дараа тус тайлбарыг хэвлэх тогтоол гаргасан байна.

Үндсэн хуулийн тайлбарыг хэвлүүлэх тухай Засгийн газрын хорин тавдугаар хурлын тогтоолын арван нэгдүгээр зүйлд, “... УБХ-ын тогтоолын ёсоор Үндсэн Хуулийн утга чанарыг харьяат олон түмэн

⁹ Монгол Улсын гадаад бодлого: Хичээнгүй сайд Балингийн Цэрэндорж. Уб., 2011 он, 219 дэх тал.

¹⁰ БНМАУ-ын Бага Хурлын Анхдугаар хурлын тогтоолоор, Бага Хурлын Тэргүүлэгчдэд Цэрэндорж, Дамбадорж, Ламжав, Гэндэн, Дангаа нарыг сонгосон байна.

ардууд ухамсарлан мэдэхэд хялбар болгон тайлбарласан дэвтэр үйлдэж, элбэг хүрэлцэхийг бодож эдүгээгээс даруй бүгд гурван түмэн хувийг хэвлүүлэн тараах, хэвлүүлэх цаасны үнэ ба хэрэгсэх зүйлүүд энэ жилийн төсөвлөсөн данснаа оролцсонгүй тул тусгай төсөвлөсөн данс үйлдэж нэмэн батлуулж гүйцэтгүүлэхээр тогтсон учир, ... Хянан байцаах яамнаас болон Сангийн явдлын яамнаас, Үндсэн хуулийн утга чанарыг зүйл анги дараалан тайлбарлаж ард түмнээ үзэж мэдэхэд хялбар болгох нь үнэхээрийн эрхэм тул бүх зарлагын янчaaан нэгэн тум нэг мянган долоон зуун гучийг нэмэн батлахад манай яам үл татгалзана хэмээжээ¹¹. Ийнхүү “БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газраас Үндсэн хуулийг тайлбарлуулах хэргийг оролдож, 1926 оны 6 дугаар сард БНМАУ-ын Үндсэн хуулийг зүйл анги дараалан товчконоор тайлбарласан дэвтэр”-ийг гучин мянган хувиар хэвлэн тараажээ.

Ерөнхий сайд Б.Цэрэндоржийн нэрээр хэвлэгдсэн “БНМАУ-ын Үндсэн хуулийг зүйл анги дараалан товчконоор тайлбарласан дэвтэр”-ийг “хууль тайлбарлах” эрх зүйн судлагдахууны талаас нь авч үзвэл гол төлөв түүхчилсэн, харьцуулсан (учир шалтгааны) аргаар хийгдсэн байх бөгөөд тухайн зүйл, ангийг дэлгэрүүлж, өргөжүүлсэн төдийгүй зарим тохиолдолд хэмжээнд нь үгчлэн тайлбарласан байна. Түүнчлэн энэхүү Анхдугаар Үндсэн хуулийн тайлбар бол тайлбарлагч субъектийн хувьд албан ёсны тайлбар юм.

1924 оны Үндсэн хуулийн хувьсгалт ардчилсан агуулга, утга чанарыг 1926 онд зүйл анги дараалан тодорхойлж тайлбарласан нь түүний хууль цаазны өргөн боловсролтой, мэргэжилтэн байсныг гэрчилж байна.¹²

Анхдугаар Үндсэн хууль нь оршил болон “Монголын жинхэнэ ардын эрх чөлөөг илтгэн тунхаглах нь”, “Улсын дээд эрхийг барих газрын тухай”, “Нутгийн

¹¹ МУУТА.Х-1.Д-2.ХН-143, хуудас 351-352 дахь тал.

¹² Б.Ширэндэв. Хичээнгүй сайд Цэрэндорж, Уб., 1965 он, 26 дахь тал.

захиргааны тухай”, “Сонгох, сонгогдох эрхийн тухай”, “Улсын орлого зарлагын тухай” ба “Улсын тамга ба сүлд тэмдэг, туг далбаа гурвины тухай” хэмээх бүлэг 50 зүйлээс бүрдэж байна. Дээрхээс агуулгыг багцлан тайлбарыг үзвээс, Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн гуравдугаар зүйлийн дөрөвдүгээр заалтын тайлбарт, улсын аж ахуй ба эдийн засаг хэмээх ойлголтыг дэлгэрэнгүйгээр, өргөжүүлж, ойлгомжтойгоор тайлбарласан байна. Тухайлбал, “Улсын аж ахуй ба эдийн засаг хэмээгч улс төрийн дэгжих буурах, тогтоно мөхөхөд холбогдох чухал зүйл болох бөгөөд бидний монголын олон түмэн ардууд язгуураас дан ганц дөрвөн зүйлийн малд итгэж амьдрах бөгөөд цагийн гачигт үхэж хорогдон хохирч хоосрох нь маш үлэмж, түүнээс өөр тариалан, үйлдвэрийн зэрэг боловсон аж ахуй төсөөлөгчид нэн ховор ба бас ч эдийн засгийн бодлогыг огт үл хэрэглэх зэрэг учраас амьдарлага хөрөнгө нь улам доройтон, заримууд нь даруй өлсөх өлбөрөх зэргийн зовлон зүдгүүрийг харсаар хүлээхэд хүрч бүхий учир тийнхүү улсын аж ахуй ба эдийн засгийн бодлогыг чухал болгон тус улсаас эрхлэн удирдахаар тогтоосон¹³⁾ хэмээжээ. Мөн түүнчлэн гуравдугаар зүйлийн тавдугаар заалтыг дэлгэрүүлэн, учир шалтгааны болон түүхчилсэн тайлбар хийсэн байна. Үүнд, “Бидний монгол болбоос эдүгээ нэгэнт жинхэнэ ардын хувьсгал ба ардын хувьсгалт цэргийн хүчээр гадаад дотоодын эзэрхэг харгис этгээдийг устгаад харьяат олон түмэн ардуудад бүрэн эрх чөлөө олгож бүгд найрамдах ард улсын засгийг явуулсны тул тийнхүү жинхэнэ ард түмний эрх чөлөөг бүрэн бүтнээр хамгаалах ба басхүү гадаад дотоодын харгис шунахай нарын эрх мэдэл дахин хөгжих замыг таслан сэргийлэхийн тул ардын хувьсгалт цэргийг байгуулахаар тодорхойлон тогтоосноос гадна, урьдын эзэрхэг харгисын үед бидний монголын ван, гүн, тайж, түшмэд ба баялаг хөрөнгөтөн хэмээгчид нь цөм эрхтэн дархтан хэмээн ардын цэргийн

албыг дан ганц үгээгүй ядуу ардуудад тулган хаалгасаар ирсэн бөгөөд одоо энэ мэтийн шударга бус муу суртлыг бүрмөсөн устгасан тул тийнхүү бүх улсын идэр залуу ардыг цэргийн эрдэмд боловсруулбаас зохино хэмээн тодорхойлон заасан нь болой¹⁴⁾ гэжээ. Харин гуравдугаар зүйлийн аравдугаар заалт буюу сурч боловсрох эрхийг тайлбарлахдаа, “Бидний монгол эдүгээ нэгэнт эзэрхэг харгисыг устгаж, улс төрийн ба орон нутгийн захиргааны хамгийн жинхэнэ ард түмэн нь гартаа шилжүүлэн авсан бөгөөд гагцхүү харьяат олон түмэн ардууд хэдэн зуун онд гадаад дотоодын эзэрхэг харгис этгээдүүдэд эрдэм соёлгүй бүдүүлэг харанхуйгаар боолчлогдон захирагдсаар ирсэн нь энэ хэр зарим нэгэн орон нутгийн захиргааны газраа элдэв хэргийг хөдөлгөн явуулах бичиг эрдэмд боловсорсон хүн хүрэлцэхгүй боогдох гачигдах явдал гарч буйгаар үл барам гол Засгийн газраа боловч мөн эрдэмтнээр дутагдах зүйл гэгээрүүлэх явдлыг нэн чухал болгон үзэхийн дээр Европ зэргийн боловсронгуй улсууд эрдэм соёлын явдлыг чухал болгох боловч аливаа сурагчдаас үнэ төлбөр хэмээн үлэмжхэн мөнгө хураан авах учир угээгүй ядуу ард түмний эрдэм соёлд гэгээрч боловсрох зам нь ихэд боогдоор бүхийн тул тийнхүү жинхэнэ олон ардын аливаа эрдэм соёлд гэгээрүүлэх замыг нээгдүүлэн тус улсаас элдэв ухааны эрдэмд бүрнээ төлбөргүйгээр боловсруулах явдлыг гүйцэтгэвээс зохино хэмээн тодорхойлон тогтоосон нь болой¹⁵⁾ хэмээжээ. Дээрх тайлбар нь дэлгэрэнгүй, харьцуулсан, түүхчилсэн тайлбар болсон төдийгүй хэл зүйн хувьд, агуулга, найруулга, өгүүлбэрийн бүтцийн хувьд ихээхэн онцлогтой болсон байна. Тухайлбал, Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн зургадугаар зүйлийн тайлбар, “Энэхүү улсын Үндсэн хууль хэмээгч бидний бүгд найрамдах ард улсын засаг ба харьяат олон түмэн ардын эрх чөлөөг үүрд батлан хамгаалахад үндэс баримт болох туйлын чухал зүйл мөн. Гагцхүү

¹³⁾ Ж.Амарсанаа, О.Батсайхан, Х.Магсаржав, А.Төмөр, Монгол Улсын гадаад бодлого: Хичээнгүй сайд Балингийн Цэрэндорж. Уб., 2011 он, 223 дахь тал.

¹⁴⁾ Мөн тэнд, 224 дахь тал.

¹⁵⁾ Мөн тэнд, 226 дахь тал.

анх тулгар хянан тогтооход хааяа санаа бодлого эс хүрэлцсэн газар буй бөгөөд дараа эрхбиш нэмэх хасах засах запруулах зүйл гарч ирэхийг болзохуйяа бэрхтэй. Тийн хэмээвч хялбараар хөдөлгөж болох нь бус учир тийнхүү өөрчлөх, батлах явдлыг гагцхүү Улсын Их Хурлаас эрхлэн шийтгэвээс зохино хэмээн тодорхойлон тогтоосон нь болой¹⁶. Хэдийгээр, Үндсэн хууль боловсруулах комисс төслийг боловсруулахдаа 1918 онд батлагдсан ЗОУ-ын үндсэн хуулийг гол жишгээ болгосон гэдэг хэдий ч, дээрх тайлбарын агуулгаас харахад Үндсэн хуулийн зүйл, заалтыг өөрчлөх, нэмэх, хасах эрх гагцхүү Улсын Их Хуралд буйг илтгэн тайлбарлажээ. Түүнчлэн хоёрдугаар бүлгийн хорин есдүгээр зүйлд, эдийн засгийн зөвлөлийн тухай заахдаа Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн дөрөвдүгээр ангийг ишилсэн байdag.

Дөрөвдүгээр бүлгийн “Сонгох, сонгогдох эрхийн тухай” гучин тавдугаар зүйлд заасан сонгогдох эрхгүй хүмүүсийг ийнхүү тайлбарлажээ. Үүнд, “Европ зэргийн боловсронгуй улсуудын баялаг хөрөнгөтөн нь аливаа хатуу зөвлөн эд таваар боловсруулах фабрик, завод хэмээх ихээхэн үйлдвэрийн газрууд байгуулж хэд хэдэн зуу мянган үйлдвэрийн хүмүүсийг очижүүхэн бага хөлсөөр зарж тэд нарын хүчээр онц их ашиг хонжвор олж ямагт хувьд ашиглан завших ба бас ямагт бусдыг хөлслөн зарж худалдаа үйлдвэр буюу мөн бусдад мөнгө хүүлж түүний ашиг үржлээр амьдрагчид маш үлзэмж¹⁷” гэсэн харьцуулсан тайлбарыг хийжээ.

Тавдугаар бүлгийн дөчин долдугаар зүйлд улсын тамгыг тайлбарласан байна. Тухайлбал, “Европ зэргийн олон улсууд аливаа албаны газруудын тамганд их төлөв улсын сүлд тэмдгийг оруулан дугараг үйлдэх боловч хааяа зарим нэгэн нь дөрвөлжин үйлдэхийн дээр бидний монгол хэдийнээс дөрвөлжин тамга хэрэглэсээр ирсэн ба бас ч бидний урьдын автономит засгийн үед тамганы дунд

дор соёмбо хэмээх эрхэм үсгийг оруулан дөрвөлжнөөр үйлдэн хэрэглэж байсан ба ардын засгийг байгуулнаас нааш мөн нэгэн адил үйлдүүлэн хэрэглэсээр буй нь түүнийг хэвээр оруулан үйлдэж хэрэглэхэд үл зохицдох зүйлгүй учир тийнхүү Улсын Их Хурлаас дараалан Засгийн газар, олон явдлын яам, албаны газруудын тамгыг цөм дөрвөлжин бөгөөд нүүрийн дундад дор соёмбо хэмээх эрхэм үсэг, түүний хоёр этгээдэд уул газрын нэр сэлтийг үйлдүүлэн гүйцэтгүүлбээс зохино хэмээн тодорхойлон тогтоосон нь болой¹⁸. Дээрх тайлбар нь харьцуулан, түүхчилж, дэлгэрэнгүй бичигдсэн нь олон нийтэд түгээхэд ойлгомжтой байх зарчмыг барьсан мэт байна.


Монголын төр, нийгмийн зүтгэлтэн Б.Цэрэндорж бол хууль, эрх зүйн гүнзгий мэдлэгтэй аливаа асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэх ёстой гэж хатуу чанд байр суурь баримталдаг байсан нь сурвалжаас мэдэгддэг. Тухайлбал, 1914-1915 онд Хиагтад хуралдсан Орос, Хятад, Монгол турван улсын бага хурлын эцэст баталсан дэвтэр бэлтгэж Богд хааны зарлигаар зөвшөөрүүлэн хэвлэн тараасан 22 зүйлт гэрээний 21 зүйлийг бүрэн тайлбарлаж, Хятад Улс (ДИУ) Монголын дотоод хэрэгт ёрийн дураар оролцож учиргүй зөвхөн гэрээнд заасны дагуу Монголын бүх асуудалд хандах ёстойг ойлгуулсан байдал¹⁹. Нэмж эрэгцүүлэхэд Ерөнхий сайд Б.Цэрэндорж тус тайлбарыг бичихдээ Үндсэн хуулийн эрх зүй болон бусад сэдэв асуудлаар өргөн мэдлэгтэй, бичиг номын хүмүүстэй ярилцаж, зөвлөж, асууж лавлан энэхүү тайлбарыг бичсэн гэдэгт эргэлзэх зүйлгүй юм.

1924 оны Анхдугаар Үндсэн хуулиас хойш 1940, 1960 онуудад Монгол Улсын хоёр Үндсэн хууль баталсан боловч тэдгээрийг нийт иргээдэд ойлгомжтой, дөхөм болгон тайлбарласан ямар ч бутгээл

¹⁶ Мөн тэнд, 229 дахь тал.

¹⁷ Мөн тэнд, 238 дахь тал.


одоог хүртэл гараагүй байна²⁰. Харин 1992 оны Үндсэн хуулиар бүхэлд нь болон хэсэгчилсэн тайлбарууд хийгджээ. Ингэхлээр Монгол Улс дөрвөн Үндсэн хууль баталсны эхний эхийг Монгол Улсын Ерөнхий сайд олноо "Хичээнгүй сайд" хэмээн алдарсан төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Б.Цэрэндорж албан ёсоор тайлбарлаж, монголын ард түмний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан гэж үзэж болох юм.



Зураг №1. “БНМАУ-ын Үндсэн хуулийг зүйл анги дараалан товчхоноор тайлбарласан дэвтэр” (1926)

----oo----

²⁰ 1960 оны БНМАУ-ын Үндсэн хуулийг сурх бичгийн чанартайгаар улс төр, эрх зүйн тайлбарыг ЗСБНХУ-ын 1977 оны Үндсэн хуулийг тайлбарласан улс төр-эрх зүйн дэлгэрэнгүй тайлбарын үлгэр жишээгзэр МУИС-ийн эрдэмтэн багш нар бэлтгэсэн байдал. Зохиогч.



Зураг №2. “Дундад, Орос, Монголын гэрээ бичгийн утга чанарыг тайлбарлах дэвтэр” (онгуй болно)

“ХУУЛЬ ТОГТООХ ЭРХ МЭДЛИЙГ ШИЛЖҮҮЛЭХ ҮНДСЭН ХУУЛИЙН ХОРИГ БА ХЯЗГААР”



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан
O.Tөrbolg

ТҮЛХҮҮР ҮГС:

Төрийн эрх мэдэл хуваарилах онол, Хууль тогтоох эрх мэдэл, эрх мэдлийг үл шилжүүлэх /non-delegation/, эрх шилжүүлэх /delegation of power/

УДИРТГАЛ

Үндсэн хуулиар зурсан тойрог дотор нь байлгахын тулд харилцан тэнцвэртэй хяналт бүхий төрийн тогтолцоог бүрдүүлж, нэгээр нь нөгөөг хянуулж, мануулж, тэдгээрийг ард түмэн иргэний нийгмийн байгууллагуудаараа дамжуулан эсвэл өөрсдөө шууд давхар харж, хянаж байхгүй бол тэр тойргоосоо гарах магадлал хөгжсөн төвшингөөсөө хамаараад байсаар байдаг¹ учраас энэ тойрогт нь байлгах нь Үндсэн хуульт ёсны гол зорилго юм. Үндсэн хуульт ёс нь эрх зүйт төрийн үзэл санааг хэрэгжүүлэх хамгийн шилдэг, зохицтой хэрэгсэл гэдэг нь нэгэнт хүлээн зөвшөөрөгджээ.² Тийм ч учраас Үндсэн хуулийг дээдлэх зарчим нь хууль тогтоогчдод шууд хамааралтай.

¹ Paul W.Kahn, “Comparative Constitutionalism in a New Key,” Michigan law review (2004): 2677.

² Н.Лүндэндорж, Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага, Уб., 2004 он, 13 дахь тал.

1945 оноос хойш баруун Европод өрнөсөн Үндсэн хуулийн гол ололт, амжилтын нэг нь хүний эрхийн шүүхийн тогтолцоогоор хамгаалахаас гадна, парламентат ёсны уламжлал болон хууль тогтоох эрх мэдлийг гүйцэтгэх засаглалд шилжүүлэх тухай тэнцвэрийг баталгаажуулах явдал гэж үздэг³ бөгөөд Монгол Улс 1992 оны Үндсэн хуулиар парламентад засаг бариулж, баас дээр нь мөн хуулийн Хорьдугаар зүйлээр⁴ “төрийн эрх барих дээд байгууллага” гэгч дээд эрхийг эдлүүлэхээр заасан. Төрийн эрх барих дээд байгууллага гэхийн учир нь УИХ ард түмний чөлөөт сонгуулиар мандатаа авч тэдгээрийг төлөөлөн үйл ажиллагаагаа явуулдаг учраас хэмээн тайлбарлаж болно⁵. УИХ нь төрийн эрх барих дээд байгууллага болохынхоо хувьд хууль тогтоох, хууль хүчингүй болгох, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх мэдлийг гагцхүү УИХ хэрэгжүүлэхээр Үндсэн хуульд зааж өгсөн ба энэ нь УИХ-д хадгалагдах онцгой бүрэн эрхийн нэг юм. Гэсэн хэдий ч УИХ-аас гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болон Ерөнхийлөгчид хууль тогтоох эрх мэдлээ шилжүүлэх тохиолдол тогтмол гарж байгаа бөгөөд энэ талаар Үндсэн хуулийн дээрх зүйл заалттай холбоотойгоор өөр өөр агуулга бүхий Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарч⁶ шийдвэрлэсэн байна.

³ П.Амаржаргал, “Parliamentary review хууль тогтоох эрх мэдлийн онол үзлэл, баримтлац”, Эрх зүй сэргүүл, <https://numlawreview.mn/wp-content/uploads/2017/10/3.pdf>, 35.

⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дахь заалтад “Монгол Улсын Их Хурал бол Төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №1, 1992 он.

⁵ Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Уб., 2000 он 136 дахь тал.

⁶ Энэ талаар цаашид дэлгэрэнгүй авч үзнэ.

Нэг. Төрийн эрх мэдэл хуваарилах онолын үүднээс хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэх нь боломжтой эсэх

1215 оны Английн эрх чөлөөний их харти /Великая хартия вольностей/ 1222 оны Унгарын “Алтан булла” /Золотая булла/, Францын 1357 оны “Гуравдугаар сарын аугаа их хууль” /Великий мартовский ордонанс/ зэрэг эх сурвалжуудаас дараах нийтлэг зүйлүүд ажиглагддаг байна. Үүнд хааны хүсэл зоригийг хязгаарлах, хууль ёсны хязгаар тогтоох, нийгмийн давхаргуудад тодорхой эрх олгож тэдний төлөөлөлгчдийн байгууллагыг байгуулсан.⁷ Дээрх хууль тогтоомжуудыг залгамжлан дараа дараагийн эрх зүйн шинэ үзэл баримтлалууд гарч ирсээр байсан бөгөөд уг үзэл сургаалийг гүнзгийрүүлж орчин үеийн үзэл баримтлалыг бий болгоход Английн улс төрийн гүн ухаантан Жон Локк /1632-1704/, Францын нэрт сэтгэгч, хуульч Ш.Л.Монтескье /1681-1755/ нар жинтэй хувь нэмэр оруулж, төрийг хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагааг нь хязгаарлах тухай саналыг дэвшиүүлж, түүнийгээ эрх мэдэл хуваарилах замаар зохион байгуулахыг номлож байв.⁸ Тухайлбал: Жон Локк “Төрийн тухай хоёр шастир” хэмээх бүтээлдээ төрийн тухай үзэл бодлоо гаргаж тавьжээ. Тэрээр төрийн эрх мэдлийг:

- хууль тогтоох;
- гүйцэтгэх /шүүхийг хамруулсан/;
- холбооны /гадаадад хэрэгжүүлэх

гүйцэтгэх эрх мэдэл/ гэж ангилж байв. Мөн өмч хөрөнгөтэй иргэдээс сонгогдон байгуулгадж улс төрийн бодлогыг тодорхойлох парламентыг илүү чухалд тооцож, гүйцэтгэх засаглал нь түүнд захирагдан шийдвэрийг нь хэрэгжүүлж ажлаа түүнд тайлгахаа бөгөөд парламентын хүсэл зоригийн дагуу солигдож, өөрчлөгдж болно⁹ гэж үзэж байв. Төрийн эрх мэдэл хуваарилалтын тухай Ж.Локкийн үзэл

санааг цааш нь үргэлжлүүлэн хөгжүүлсэн хүн бол Ш.Монтескье бөгөөд “Хуулийн амин сүнс”-ийнхээ арван нэгдүгээр дэвтэр “Английн төрийн байгууламжийн тухай” гэсэн бүлэг хэсэгтээ: “төрд гурван төрлийн эрх мэдэл орших /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх/ ба эхнийх нь хууль тогтоох эрх мэдэл бөгөөд түүний гол субъект төрийн тэргүүн болон байгууллага байж болно. Энэ субъект /төрийн тэргүүн эсвэл байгууллага/ цаг үеийн болон байнтын хууль тогтоож, оршин буй хуулиудыг засаж, өөрчилж, хүчингүй болгож байх ёстой хэмээн авч үзэж байв.”¹⁰ Уг төрийн гурван салаа эрх мэдлийн нэг болох Хууль тогтоох эрх мэдэл нь Үндсэн хууль хийгээд нийтээр дагаж мөрдөх хуулийг тогтоох, улсын төсөв батлах, түүнчлэн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч ЗГ-ын үйл ажиллагаанд хяналт тавих эрхийн цогц¹¹ бөгөөд энэ ч утгаараа хууль тогтоох үйл ажиллагааны цөм бөгөөд Үндсэн хуулийн утга санаагаар эрх мэдлийн хуваарилалтад нэг институт болон байршидаг.¹²

Парламент хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч болохын хувьд нийтлэг эрх ашгийг тэгш хийгээд шударга хамгаалж, ард түмний эрх чөлөөний хэмжүүр болсон хуулийг тогтооно. Хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү парламент хадгалах үзэл санаа өнө эртний түүхтэй бөгөөд энэ талаар дээр дурдсанчлан Монтескьеийн “Хуулийн амин сүнс” бүтээлд тусгалаа олсон байна. Тэрбээр төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд хуваарилж тэнцвэржүүлэх нь хууль засаглах, хүмүүний эрх, эрх чөлөөг бодитой хангах болон хамгаалах гол нөхцөл хэмээн үзэж байжээ. Энэхүү үзэл санаа “хууль тогтоох эрх мэдлийг ард түмнээс сонгогдсон төлөөлөгчид хэрэгжүүлэх ёстой” гэсэн парламентат ёсны үзэл

⁷ С.Төмөр, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй/онол үзэл баримтлалын тойм, Уб., 2002 он, 6 дахь тал.

⁸ Д.Тегэлдөрсүрэн, “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт, тулгамдаж буй зарим асуудал,” Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2015 он, №4 97 дахь тал.

⁹ Д.Лүндээжанцан, Аюулгүй байдал, хөгжил, төр эрх зүй/ тэргүүн дэвтэр/, Уб., 2002 он, 142 дахь тал.

баримтлалд хүргэсэн.¹³

Хууль нь хэлбэрийн болоод агуулгын талаасаа тодорхойлогддог бөгөөд хэлбэрийн хувьд ард түмнээс төлөөллийн дагуу сонгогдсон бүрэн эрх бүхий субъект хуулийг албан ёсоор батлах ёстой бол агуулгын хувьд нийтлэг ашиг сонирхлыг тусгаж, цөөнхийг хамгаалах механизмыг орхигдуулаагүй, эрх зүйн мөн чанар илэрхийлсэн оршихуй буюу байх ёстой зүйлийг¹⁴ агуулсан байх ёстой. Тэрхүү байх ёстой зүйл нь хуулийн амин сүнс буюу Монголын хэлснээр хамгийн өргөн утга санаагаар тодорхойлогдох, юмны цаад мөн чанараасаа урган гардаг шаардлага бүхий харилцаа, ард олны мөн чанарт уялдах зүйл юм. Тиймээс хуулийг хүлээн зөвшөөрхөүцээр зохиох¹⁵ буюу хүмүүсийн хүсэл зоригийг тусгах юм. Тодотговол, нэг хэсэг судлаачид ард түмний нэрийн өмнөөс хууль тогтоох онцгой бүрэн эрхтэй нийгмийн институттээс батлан гаргасан аливаа шийдвэр акт нь хууль болно гэж формаль талаас нь тайлбарладаг бол нөгөө хэсэг судлаачид нь мөн чанараараа хууль болж байгаа аливаа акт төрийн байгууллага гаргаснаас хамааралгүйгээр хууль болно гэж материал талаас нь тайлбарлаж байна.¹⁶

Хууль тогтоох эрх мэдлийн мөн чанараас хоёр үндсэн асуудал урган гардаг бөгөөд нэгт Хууль тогтоох эрх мэдэлд тавигдах хөндлөнгийн буюу институцийн хяналт, нөгөөн “хууль тогтоох” эрх мэдлийг бусад шилжүүлж /legislative delegation¹⁷/ болох эсэх асуудал¹⁸ бөгөөд хууль тогтоох эрх мэдэл хэмээн парламентыг төлөөлүүлэн тодорхойлбол хэт явцуу, хөдөлгөөнгүй хөшингө мэт үзэгдэл болон хувирч тэр хэрээрээ хязгаарлагдмал орчинг үүсгэж эрх

¹³ Д.Лүндээжанцан, Монгол Улс дахь төрийн эрх мэдэл хуваарилалт, онол практикийн асуудал, Уб., 2001 он, 123 дахь тал.

¹⁴ Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан, Парламент ёс, Уб., 2002 он, 181 дахь тал.

¹⁵ Ф.Бастиа, орч: Н.Баярбаатар, Хууль, Уб., 2001 он, 11 дахь тал.

¹⁶ Д.Лүндээжанцан, Монгол Улс дахь Төрийн эрх мэдлийн хуваарилалт, Уб., 2014 он, 155 дахь тал.

¹⁷ С.Нарангэрэл, Хууль зүй судалалын Англи-Монгол толь, Уб., 2005 он, 297 дахь тал.

¹⁸ П.Амаржаргал, “Парламентын хууль тогтоох эрх мэдлийн онол үзэл, баримтал,” Эрх зүй сэргүүл, <https://numlawreview.mn/wp-content/uploads/2017/10/3.pdf>, 35.

мэдэл хуваарилалтын онолын томьёоллоо гээж болзошгүй юм.¹⁹ Дэлхийн практикт парламент нь төрийн тэргүүн, эсхүл засгийн газарт өөрийн бүрэн эрхийн зарим хэсгийг шилжүүлэн өгсөн үед төлөөллийн хууль тогтоомжийн /делегированное законодательство/ институт үйлчилдэг. Өөрөөр хэлбэл ерөнхийлгч буюу ерөнхий сайд эрх зүйгээр зохицуулагдаагүй буюу эсхүл хойшлуулшгүй асуудлаар хуультай адил хүчинтэй акт. Төлөөллийн хууль тогтоомж гаргах явдлыг ихэвчлэн үндсэн хуулиараа зөвшөөрсөн байdag. Учир нь зарим асуудлыг /жишээлбэл: эдийн засаг/ нэг талаар нэн даруй шийдвэрлэх, нөгөө талаар хуулиар тодорхойлох шаардлагатай байdag.²⁰ Холбооны улсад муж улс болон бус нутагт тодорхой асуудлаар хууль тогтоох эрх мэдлийг олгодог. Түүнчлэн, засгийн газар парламентаас баталсан хуулийг хэрэгжүүлэхийн тулд нарийвчилсан, дэлгэрүүлсэн зохицуулалт хийх үүднээс эрх зүйн акт гаргадаг. Үндсэн хууль хаант улсад хууль тогтоогч гэдгийг тодорхойлоходоо хаан ба түүний засгийн газар, парламентын нийлбэр гэж үздэг. Жишээ нь: Нидерланд, Бельги, Их Британи Европын холбооны хууль, тогтоомж нь гишүүн улсын дотоодын хууль тогтоомжоос илүү хүчинтэй байdag болон олон улсын гэрээ нь нэгдэн орсон болон соёрхон баталсан улсын дотоодын хууль тогтоомжоос илүү хүчинтэй байdag зэрэг нь парламент цорын ганц хууль тогтоогч биш гэдгийг нотолдог.²¹

Хууль тогтоох эрх мэдэл ямар хүрээнд өрнөж байх тухай ерөнхийдөө хандлага өдгөө бий болжээ.

Нэгдүгээрт: тодорхой хүрээ буюу парламентын хууль тогтоох хүрээг яв цав тогтоон түүнийгээ үндсэн хуулийн түвшинд тусгасан байх. Өөрөөр хэлбэл, хуулийг ямар төвшинд, ямар асуудлаар

¹⁹ Ж.Наранпүрэв, “Төрийн эрх мэдэл хуваарилалтыг ойлгохуу,” Шилжүүлэх хууль зүйн шинээлжэх ухааны онол, арга зүй, мэдээлэл 1 2004 он , 87 дахь тал.

²⁰ Ч.Энхбаатар, Монгол улсын төрийн байгуулалтыг төгөлдөржүүлэх боломж арга зам /судалганы тайлан/, Уб., 2010 он, 109 дахь тал.

²¹ Д.Гангабатар, Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал, Уб., 2012 он, 150 дахь тал.

гаргаж байх, ард түмнээс хууль тогтоох эрх мэдэлд олгогдсон эрхийн хүрээнд шийдвэрлэгдэхээргүй асуудлыг ард нийтийн санал асуулгаар шийдвэрлэх тухай заалтыг нарийн тусгасан байх явдал юм. Үүний сонгодог жишээ бол ХБНГУ гэж хэлж болно.

Хоёрдугаарт: тодорхой бус хүрээ буюу хууль тогтоогчид эрх мэдлээ төлөөлүүлэн шилжүүлэгч ард түмэн нь хууль тогтоогч парламентад хууль тогтоох хүрээ хязгаарыг нарийвчлан зааж өгдөггүй бөгөөд энэ үест ард нийтийн санал асуулгыг үндсэн хуулийн хэмжээнд тусгасан байх боловч тэд уг эрхээ хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байдаг. Түүнчлэн парламент нь энэ орчин дахь хууль тогтоох ажиллагаанд дахь хязгааргүй эрхийн хүрээнд хууль тогтоох өргөн эрх мэдэлтэй парламентад тооцогдох учиртай.²²

Олон улс орны ардчилсан хувьсгалын үеэр “хууль тогтоох бүтээх эрх”, “хууль тогтоох эрх”, “хууль хэвлэх эрх”, “хууль тогтоох бүрэн эрх” гэх мэт ойлголтыг буй болгосон юм. Эдгээрийг Үндсэн хуульдаа хуульчилан баталгаажуулжээ.

Хуулийг тодорхойлох тухайд энэхүү онолын ангилал нь төлөөлөн шилжүүлсэн хууль тогтоох эрх мэдлийн үзэл баримтлалын үндэс болдог байна.²³

Өдгөө эрдэмтэн судлаачдын дунд парламентын хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэхтэй холбоотойгоор эрх үл шилжүүлэх /non-delegation/, эрх шилжүүлэх /delegation of power/ хэмээх хоёр агуулгад хуваагдан маргадаг.

Эрх үл шилжүүлэх /non-delegation/: Жорж Вашингтоны хууль зүйн их сургуулийн Профессор Николос Ж.Забо, Чикагогийн хууль зүйн их сургуулийн профессор Касс Р.Санстейн, Нью Иоркийн хууль зүйн сургуулийн профессор Дэвид Шоенброд болон Францын эрдэмтэн Н.Эйнсмэн тэргүүтгэй эрдэмтэд үзэхдээ Үндсэн хууль дахь эрх мэдэл нь угаас ард

²² Ж.Наранпүрэв, “Төрийн эрх мэдэл хуваарилалтыг ойлгохуй,” Шихижутг хууль зүйн шинжлэх ухааны онол, арга зүй, мэдээлэл 1, 2004 он, 87 дахь тал.

²³ Л.Дюги, Конституционное право, 1908, 201. Д.Лүндээжанцан, Монгол Улс дахь Төрийн эрх мэдлийн хуваарилалт, Уб., 2001 он, 67 дахь тал.

түмнээс улбаатай учир тэдний нэрийн өмнөөс хэрэгжиж тухайн эрх хэмжээг парламент нь гүйцэтгэх эрх мэдэл тодорхой хугацаанд ч хэсэгчилсэн байдлаар хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлж болохгүй. Үндсэн хуулиараа олон төрлийн институцийн оршин тогтоно болон тэдгээрийн эрх хэмжээг тогтоох бөгөөд парламентаас тогтоосон хуулийн хэмжээ хязгаар, түүнд тохирсон нөхцөлд үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрнө.²⁴

Б.Чимид “Үндсэн хуулийн мэдлэг” бүтээлдээ “УИХ-н онцгой бүрэн эрх гэдэг бол хууль тогтоох эрх мэдлийн ерөнхий хүрээнд ямар ч асуудлыг үзэмжээр шийдэх биш, харин “үг дуугүй” эдэлж биелүүлэхээр тулгаж заасан /императив шинжтэй/ эрх, үүрэг юм. Өөр ямар ч байгууллагаын эрх хэмжээнд “хамаарахгүйгээр” заагласан гэсэн үг²⁵” гэжээ.

Г.Совд “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар” бүтээлдээ “УИХ-д хадгалагдах онцгой бүрэн эрхийн нэг нь түүний хууль тогтоох эрх мэдэл бөгөөд энэ эрхийг өөр бусад ямар ч байгууллага, албан тушаалтан төлөөлөхгүй²⁶” гэжээ.

Ж.Амарсанаа “Хууль бүтээх урлаг: Орчин цагийн чухаг асуудал” хэмээх нийтлэлдээ “Эрх мэдэл хуваарилах зарчмын шаардлага бол түүнийг эрх мэдлийн өөр салаа мөчирт төдийгүй, тухайн салбарын дотор бүр ч шилжүүлж болохгүй юм... Монгол Улсын өдгөөгийн эрх зүйн тогтолцооны уг гарвал суурь нь Ромын эрх зүйтэй холбоотой. Өмнө дурдсанaan 4000 жилийн өмнө эх үндэс нь бий болсон Ромын эрх зүйн нэг тулгуур ойлголт, аксиом бол “Potestas delegate non potest delegari” /төлөөлсөн эрх мэдлийг

²⁴ С.Амартувшин, “Хуулиар тусгайлан эрх шилжүүлэх эрх зүйн зохицуулалтын тухайд”, Эрх зүй сэргүүл 2, 2013 он, 20 дахь тал.

²⁵ Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, Уб., 2008 он, 201 дахь тал.

²⁶ Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Уб., 2000 он, 136 дахь тал.

шилжүүлэн төлөөлөхгүй²⁷. Эрх зүйн тогтолцооныхоо уугуул үзэл баримтлалыг өнөө хир ойлгоогүй, бидний мэдлэгийн санд сууж төлөвшөөгүй л байна шүү дээ.” Гэжээ.

П.Одгэрэл “Захиргааны эрх зүйн ерөнхий анги” бүтээлд “...Захиргааны үйл ажиллагаа хуульд үндэслэх зарчим байдаг хэдий ч хуулийн зохицуулалтын хийдэл болон цаашид дэлгэрүүлж нарийвчлах шаардлагаас үүдэн захиргаанаас өөрөөс нь эрх зүйн хэм хэмжээ гаргах шаардлага гардаг. Өөрөөр хэлбэл иргэний эрх, эрх чөлөөг зөвхөн хуулиар хязгаарлах Үндсэн хуулийн зохицуулалт байдаг ч УИХ-аас хэм хэмжээ тогтоох эрхээ шилжүүлснээр захиргаа иргэний эрх, эрх чөлөөг хязгаарласан шийдвэр гаргах боломжтой болдог²⁸” гэж үзсэн байна.

Н.Лүндэндорж “Шилжилтийн үе: “Улс төр, эрх зүйн асуудал” бүтээлдээ “Засгийн газар-Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар төрийн хуулийг биелүүлэх эрх мэдлийн нэг салаа мөчир юм. Гэтэл үе үеийн Засгийн газар төрийн хууль тогтоох бодлогыг хэрэг дээрээ атгаж, парламент Засгийн газрын захиалгыг хэрэгжүүлж ирсэн нь зохиистой бус төдийгүй нарийн ярьвал хууль бус үйлдэл мөн... төрийн хууль тогтоох бодлого ард түмний төлөөлөгчдийн дээд байгууллага болох парламентад хадгалагдаж байх тухай Үндсэн хуулийн үзэл санаа алдагдахад хүргэж болзошгүй²⁹” гэж үзжээ.

Ж.Ж.Руссо “Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд” бүтээлд “Хуулийг гаргаж байгаа этгээд уг хуулийг хэрхэн хэрэгжүүлэх, хэрхэн тайлбарлахыг хэнээс ч илүү сайн мэддэг. Энэ утгаараа гүйцэтгэх засгийг хууль тогтоох засагт нэгтгэх нь илүү чухал мэт санагдж болох. Гэвч энэ нь засаг төрийн чадавхийг бууруулдаг

²⁷ “Үүнтэй холбоотойгоор АНУ-ын Дээд шүүх хоёр ч удаа шилжүүлсэн эрх мэдэл Үндсэн хуулийт нийцэгүй талаар шийдвэр гаргаж байсан ба шилжүүлсэн бүрэн эрх “хэтэрхий их, хязгааргүй” байна хэмээн үзжээ. Гэвч цөнөнгүй удаа шилжүүлсэн эрх мэдлийг Үндсэн хуульд нийцэж байна гэж дүгнэсэн байдал.

²⁸ П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, Уб, 2016 он, 55 дахь тал.

²⁹ Н.Лүндэндорж, Шилжилтийн үе: Улс төр, эрх зүйн асуудал, Уб., 2010 он, 204 дахь тал.

төдийгүй, өөр эрх мэдлүүд үгүй болсноор төрийн тэргүүн болон бүрэн эрхт хоёр нэг гарын төвлөрч, бодит байдал дээр засгийн газар үгүй засаг төрийг бий болгоно³⁰” гэж үзсэн байна.

John Locke “Second Treatise of Government”/төрийн тухай хоёр шастир/ бүтээлд “хууль тогтоох эрх мэдэл нь ард түмнээс сайн дураараа олгогдсон бүрэн эрх учраас зөвхөн хуулийг бүтээх эрхтэй болохоос харин хууль тогтоогчийн бүтээхгүй гэж тайлбарлан хууль тогтоогч нь өөрийн хууль бүтээх эрхээ бусдад шилжүүлэх эрхгүй гэж тодорхойлсон³¹”

Peter Lindseth “The Paradox of Parliamentary Supremacy: Delegation, Democracy and Dictatorship in Germany and France, 1920s-1950s” бүтээлд “Хууль тогтоох эрх мэдэл нь ардчиллыг хэрэгжүүлэх нэг гол хэрэгсэл байдаг тул үүнийг гүйцэтгэх засаглалд шилжүүлснээр ардчилалд аюул нүүрлэх болно³²” гэжээ.

Эрх шилжүүлэх /delegation of power/: Профессор Ричард Стюарт тэргүүтэй эрдэмтэд Үндсэн хуульдаа “эрх шилжүүлэх” талаар тусгаж, парламентаас захиргааны байгууллагуудад эрх шилжүүлэх бөгөөд парламентаас бүхий л хууль тогтоомжийг батлах нь “супер парламент” бий болгох үндсийг бүрдүүлнэ. Эрх шилжүүлэн авч гаргасан хэм хэмжээний актуудыг ягаад гаргах шаардлагатайг мөн түүний давуу талуудыг судалсан үр дүнгээс харвал.³³

- Парламентаас хууль гаргах процедурын хугацааг багасгана.

- Нарийн мэргэжлийн болон техник технологийн асуудлууд нь парламентын түвшинд хэлэлцэх нь “үр ашигтай” байдлын хувьд хэтэцдээн байдаг /парламент ард түмний шууд төлөөлөл учир нарийн мэргэжлийн асуудлыг сайн мэднэ гэх баталгаа байхгүй/

³⁰ Ж.Ж.Руссо, орч: Р.Янжмаа, Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд, Уб., 2015 он, 94 дж тал.

³¹ John Locke, Second Treatise of government, 1690, C.B Macpherson, 1980, 45 pp.

³² Peter Lindseth, The Paradox of Parliamentary Supremacy: Delegation, Democracy and Dictatorship in Germany and France, 1920s-1950s, (2004), 1341.

³³ С.Амаргүвшин, “Хуулиар тусгайлан эрх шилжүүлэх эрх зүйн зохицуулалтын тухайд”, Эрх зүй сэтгүүл 2, 2013 он, 19 дэх тал.

- Гүйцэтгэх засаглалын удирдлага нь хамрах хүрээний хувьд маш өргөн тул бүхий л асуудалд арга хэмжээ авдаг. Парламентын үйл ажиллагаа тэр болгон хүрч чадахгүй учир эрх шилжүүлэх нь зүйд нийцнэ.

- Эрх шилжүүлж хууль “бүтээх” нь өөртөө уян хатан чанарыг агуулж байдаг.

- Эрх шилжүүлж хууль “бүтээх” нь хараат бус хяналтын боломжийт бүрдүүлдэг.

- Онц аюултай нөхцөл байдал гарсан тохиолдолд шаардагдах шуурхай болон үр дүнтэй чанарыг өөртөө агуулдаг.³⁴

Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар нар “Үндсэн хуулийн эрх зүй” бүтээлдээ “төрийн эрх мэдэл түүнийг хэрэгжүүлдэг байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааг нийтлэг зорилтын хүрээнд шаардлагатай нөхцөлд хамтран ажиллах, төр ард түмний нэгдэл, язгуур эрх ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн хөгжлийн баталгаат нөхцөлийг хангах зэрэг үйл хэрэгт нэгдмэл хүчээр ажиллах явдлыг үүгүйсгэдэггүй бөгөөд энэ нь төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмын нэг гол баримтлал болдог”³⁵.

Ц.Сарантуяа “Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал” бүтээлдээ “нийгмийн харилцааг бүхэлд нь дан формаль хуулиар зохицуулах боломжгүй учир хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудыг батлан гаргадаг ба тэдгээр нь нийгмийн харилцааг мөн л зохицуулдаг тул “материаллаг хууль” хэмээн нэрлэх нь ч бий”³⁶ хэмээн үзсэн байна.

Э.Уэйд, Дж.Г.Филипс “Конституционное право” бүтээлдээ “Хууль тогтоох үүрэг нь ерөнхий хэм хэмжээг бүтээхэд оршино. Парламентын олон хууль, ялангуяа хувийн юм уу, орон нутгийн шинж чанартай хуулиуд нийгмийн асуудлыг шийдвэрээд, ерөнхий хэм хэмжээг бий болгодоггүй. Энэ тохиолдолд парламент

нь хууль тогтоох хэлбэрийг ашиглан, удирдах үүргийг хэрэгжүүлж байна. Ийм төрлийн шийдвэрийг гаргах эрхийг эрх мэдлийг хуваах зарчмын ямар нэг зөрчил гаргахгүйгээр захирагааны эрх мэдэлд өгч болох юм³⁷” гэжээ.

А.Шайо “Самоограничение власти” бүтээлд “ямар шалтгаан, зорилгоор эрх шилжүүлж байгаа талаар, Гадаад улс орнуудын хоорондын нийцэмжгүй хамтын ажиллагаа, харилцаа, эсхүл улс орныг бүхэлд нь хамарсан онцгой тохиолдолд /эдийн засаг, улс төрийн, нийгмийн социал бүлгүүдийн, үзэл бодлын, газар зүйн г.м/ түргэн маневиrlах зорилгоор хууль тогтоох эрхийг Засгийн газар түүний харьяа байгууллагад шилжүүлдэг”³⁸ гэжээ.

Дээрхээс дүгнэн үзвэл “эрх үл шилжүүлэх” онолыг дэмжигчид “эрх шилжүүлэх” онолыг хууль тогтоох эрх мэдлийг зөвхөн парламент эдлэх ёстойг үндсэн хуулиараа зааж өгсөн бөгөөд парламент үүнийгээ өөр ямар ч субъектэд шилжүүлж үл болох бөгөөд гагцхүү хуулиар олгогдсон хэмжээндээ эдлэх ёстой юм гэж шуумжилдэг. Хэрэв эрх шилжүүлэх юм бол эрх хуваарилах бүх эрх мэдэл ард түмнээс эхтэй зэрэг суурь зарчмууд алдагдаад хүрч, оршин буй Үндсэн хуулийн оронд шинэ Үндсэн хуулийг бий болгож байгаатай утга нэг болно гэж тодотгосон байна. Гэвч эрх шилжүүлэх онолыг дэмжигчид парламент нь бүхий л шийдвэрийг гаргах боломжгүйн дээр эрх шилжүүлж өгснөөр супер парламент буюу хэт төвлөрсөн шийдвэр гаргалтыг хязгаарлах үндэс болдог хэмээн үзэж хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэх боломжтой хэмээн үзсэн байна.

Хоёр. Хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэхэд тавигдах хязгаарлалт

Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хууль тогтоох үйл ажиллагааг хүлээн

³⁷ Э.Уэйд, Дж.Г.Филипс, Конституционное право, (М: 1950)

³⁸ Э.Эрдэнэбат, Б.Батцэнгэл, “Хууль тогтоох эрх мэдлийг Үндсэн хуулийн хүрээнд шилжүүлэх нь,” Үндсэн хууль ба эрх зүйт ёс сэргүүл, 2009 он, 113 дахь тал.

³⁹ А.Шайо, Самоограничение власти, (М: 1999)163-173. Б.Гантемер, М.Цэнд-очир, “Хууль тогтоох эрх мэдлийг засгийн газарт шилжүүлэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал,” Үндсэн хууль ба эрх зүйт ёс сэргүүл, 2014 он, 106 дахь тал.

³⁴ Мөн тэнд, 19.

³⁵ Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар, Үндсэн хуулийн эрх зүй, Уб., 2000 он, 139 дахь тал.

³⁶ Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал, Уб., 2005 он, 116 дахь тал.

зөвшөөрч буй дэлхий нийтийн хандлага нь:

1. Түргэн шуурхай байх буюу маниверлах, бүхий л харилцааг хууль баталж шийдвэрлэх нь удаашралтай байдаг.

2. Хууль тогтоомжийг биелүүлэх зохион байгуулалтыг хангах

3. Тухай харилцаанд нарийвчлалтай харилцаанд орж буй Засгийн газрын харьяа байгууллагууд нь мэргэшсэн байдаг гэсэн учир шалтгааныг урталь болгосонтой холбоотойгоор³⁹

шилжүүлж байгаа бөгөөд хууль тогтоох үед дараах нийтлэг хязгаарлалтууд тавигдаж байна. Үүнд:

a/ Хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэн авсан (delegation legislative power) болон хууль тогтоох эрх хэмжээ нь өргөтгөгдсөн (extend legislative power) субъект (институц)-ын хувьд аливаа хэлбэрээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон түүний үйлчлэлийг хэсэгчлэн болон бүхэлд нь зогсоох, хүчингүй болгох хууль батлахгүй байх;

b/ Иргэний Үндсэн эрх, хүний эрхэм чанарыг хязгаарласан шинжтэй хууль батлан гаргахгүй байх;

г/ Шинээр улсын хил тогтоох, өөрчлөх тухай хууль тогтоохгүй байх;

д/ Өөртөө засан тогтонох эрх олгох байдлаар улсын бүрэн бүтэн байдалд халдсан шинж бүхий хууль тогтоохгүй байх зэрэг нь нийтлэг хязгаарлалт байх бөгөөд улс орон бүр өөрийн онцлогоос хамааран Үндсэн хуулийн үл өөрчлөгдөх хэсгийг хөндөхгүй байх зэрэг тусгай хязгаарлалт тогтоож байна.⁴⁰

Гурав. Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжинд хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэх асуудлыг хэрхэн тусгасан эсэх, өнөөгийн нөхцөл байдал:

“Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож,

³⁹ Б.Гантөмөр, М.Цэнд-очир. “Хууль тогтоох эрх мэдлийг засгийн газарт шилжүүлэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал,” Үндсэн хууль ба эрх зүйт ёс сэтгүүл, 2014 он, 107 дахь тал.

⁴⁰ Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2017 оны 108 дугаар тогтооюн дагуу томилогдсон доктор, профессор А.Бямбажаргалт дүгнэлт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, 2018 оны 1-р сарын 31, дугаар 01, <http://legalinfo.mn/law/details/13132?lawid=13132>

мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ өдэлнэ” гэсэн нь төр нь ард түмнээс үндэстэй, ард түмнээс байгуулагдахаар тусгаж өгсөн байх бөгөөд Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална⁴¹”, мөн Үндсэн хуулийн Гучинтаймдугаар зүйлийн 38.1-д “Монгол улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн”, Үндсэн хуулийн Дөчиндолдугаар зүйлд “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэсэн заалтуудаас харахад ард түмнээс эх сурвалжтай төр нь ардчилсан, шударга ёсны зарчмыг агуулсан байх хувьдаа түүнээс салгаж болшгүйгээр сэтгэгдэг төрийн эрх мэдэл үндсэн хуулийн түвшинд хуваарилагдсан байна.

Үгчлэх тайлбарын үүднээс авч үзвэл Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл хэсэг нь хоёр том санааг агуулдаг. Нэгдүгээрт нь Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн, Хоёр дахь нь “...хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хадгална” гэсэн. Нэг дэх санаа нь төрийн эрх мэдлийг хуваарилах онолын харилцан тэнцвэртэй байх, харилцан хяналттай байх, төрийн эрх барих үйл хэрэгт хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн оролцоог тэнцвэртэй байлагах хамтын зарчмыг Үндсэн хуулийн үзэл баримтлал болсон.⁴²

Хоёр дахь санаа УИХ-д хадгалагдах онцгой бүрэн эрхийн нэг нь түүний хууль тогтоох эрх мэдэл бөгөөд энэ эрхийг өөр бусад ямар ч байгууллага, албан тушаалтан төлөөлөхгүй. Хууль тогтоох, хууль хүчингүй болгох, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хэрэгжүүлэх талаар тусгаж өгсөн байна.⁴³ Үүнээс үзвэл Монгол улсын Үндсэн хуульд эрх шилжүүлэх асуудлыг шууд заагаагүй

⁴¹ Монгол Улсын Үндсэн хууль, төрийн мэдээлэл эмхтгэл №1, (1992) Хорьдугаар зүйлийн 1 хэсэгт.

⁴² П.Очирагт, Монгол Улсын Үндсэн хууль хэрэгжилт, хяналт, судалгаа, Уб., 2017 он, 127 дахь тал.

⁴³ Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Уб..2000 он, 136 дахь тал.

байгаа нь харагдаж байна. Үүнээс гадна Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт, оруулах нь” Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэн⁴⁴ гэж заасан бөгөөд хууль тогтоох, хууль хүчингүй болгох, хуульд нэмэлт, өөрчлөлт, оруулах эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хэрэгжүүлэхээр байгаа нь харагдаж байна. Үгчлэх тайлбарын үүднээс авч үзвэл Монгол Улсын Үндсэн хуульд хууль тогтоох эрх шилжүүлэх агуулга бүхий зохицуулалт байхгүй байгаа нь харагдаж байна.

Гэсэн хэдий ч Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчинтавдугаар зүйлийн 45.1-д “Засгийн газар хууль тогтоомжинд нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна” мөн зүйлийн 2-т “Засгийн газрын тогтоол захирамж нь хууль тогтоомжинд нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалтаас үүдэн органик хуулиар Засгийн газар⁴⁵ болон парламентад ажлаа тайлагнадаг бие даасан байгууллагуудад зориулж тусгай хууль батлан эрх зүйн байдлыг нь тогтоон⁴⁶ хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлж байна. Эдгээр асуудлыг тус бүрд нь авч үзвэл:

1. Засгийн газарт хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлж байгаа тухайд: Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30.2-т “Засгийн газар нь Улсын Их Хурлаас хуулиар тусгайлан эрх олгосон нехцөлд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрхийн акт гаргаж болно. Засгийн газар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ

тогтоосон тогтоол гаргахдаа тусгайлан эрх олгосон хуулийг эш үндэс болгоно⁴⁷ хэмээн баталгаажуулж өгсөн. Уг заалт нь парламент нь Засгийн газарт хууль тогтоох эрх мэдлийг холбогдох хуулиудаар эрх шилжүүлэх боломжийг бүрдүүлсэн байгааг тодотгож байна. Ингэхдээ Засгийн газарт эрх олгох тухай тусдаа бие даасан хууль гаргах болон тухайн нийгмийн харилцаатай холбоотой хуулиудад засгийн газарт эрх олгох тухай зохицуулалтыг тусгах байдлаар хэрэгжүүлж байна. Жишээлбэл: Монгол Улсын хувьд 2001, 2003 онуудад “Засгийн газарт эрх олгох тухай” гэх хуулийг батлан гаргаж байсан байна. Эдгээр хуулиудаар чухам ямар төрлийн харилцааг зохицуулж байсанг тус бурд нь авч үзвэл: 2001 оны “Засгийн газарт эрх олгох тухай хууль”-ийн 1 зүйлд “2001 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2002 оны 6 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд хаврын тариалалтад зориулж импортлох үрийн буудай болон хүнсний буудайн гаалийн татварын хувь, хэмжээг өөрчлөн зохицуулах эрхийг Засгийн газарт олгосугай”⁴⁸, 2003 оны “Засгийн газарт эрх олгох тухай” хуулийн 1 зүйлд “2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2004 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд импортлох улаан буудайн болон гурилын гаалийн тарифын хувь хэмжээг өөрчлөн тогтоох эрхийг Засгийн газарт олгосугай”⁴⁹ гэх зэрэгээр 1-2 хүртэлх зүйл заалттай хуулиар зохицуулсан байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 17.1-д “Монгол улсын иргэн шударга, хүнлэг ёсиг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ” хэмээн 17.1.3-д “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” хэмээн зааж өгснөөс үзвэл дээрх тохиолдолд албан татварын хувь хэмжээг өөрчлөх эрхийг хуулиар Засгийн газарт шилжүүлсэн байгаа нь УИХ хууль тогтоох эрх мэдлээ шилжүүлсэн гэж үзэж болохоор байна. Энэ нь Засгийн газар түүний байгууллагууд өөрсдөө дур

⁴⁷ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №3, 1993 он.

⁴⁸ Засгийн газарт эрх олгох тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №18, 2001 он.

⁴⁹ Засгийн газарт эрх олгох тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №2, 2004 он.

⁴⁴ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1, 1992 он.

⁴⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчинтавдугаар зүйлийн 45.1-д “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн, бүрэн эрхийнхээ дотор тогтоол захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна”, Төрийн мэдээлэл эмхэтгэл №1, 1992 он.

⁴⁶ Төв банк /Монгол банк/-ны тухай хууль /1996 он, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль /2005/, Банкны тухай хууль 2010 он.

мэдэн эрхээ тогтоох, хуульд заагагаагүй үндэслэлээр иргэдээс татвар, хураамж авах, асуудал үүссэн тохиолдолд хэн хариуцлага хүлээх нь тодорхойгүй учир, хариуцлагаас мултардаг зэрэг сөрөг үр дагавырг бий болгож байна. Энэ асуудал нь нөгөө талдаа, иргэдийг эрх, эрх чөлөөг зөрчих, хууль тогтоох эрх мэдэлд халдаа эрсдэлтэй юм.

2. Парламентад ажлаа тайлагнадаг бие даасан байгууллагад ажлаа шилжүүлж байгаа тухайд: Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 зүйлийн 6.1-д “Хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” хэмээн 6.1.2-т “Бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэнд нь хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох”⁵⁰ хэмээн зааж өгсөн байна. Мөн Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.“холбогдох этгээд” гэж дор дурдсан иргэн, хуулийн этгээдийг: хэлнэ хэмээн 3.1.2.ж-д “Монгол банк холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.”⁵¹ Эдгээр байгууллагууд нийтийн эрх ашгийн төлөө ажил үүргийн хувьд улс төрийн төвийг сахисан, тусгай мэргэжлийн үндсэн дээр нийгмийн харилцаа зохицуулдаг засгийн газрын шатлан захирах тогтолцоонд хамаарахгүйгээр үйл ажиллагаа явуулдаг захиргааны байгууллага юм. Уг байгууллагуудын нэг онцлог нь гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлсний төлөө засгийн газар парламентдаа ямар нэг хариуцлага хүлээдэггүй бөгөөд хэм хэмжээ тогтоох, шүүх, хянан шалгах эрхийг олгож өгдөг⁵² бөгөөд энэ ч утгаараа УИХ-аас хэм хэмжээ тогтоох эрхийг шилжүүлэх асуудал гарсаар байна. Ийнхүү Засгийн газар болон бие даасан байгууллагад шилжүүлж байгаа нь бусад улсад ч гэсэн түгээмэл байдаг байна. Тухайлбал: Герман Улсын хуулиар хууль тогтоох эрх мэдлийг гүйцэтгэх засаглал,

⁵⁰ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №46, 2005 он.

⁵¹ Банкны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №7, 2010 он.

⁵² С.Амартувшин, “Хуулиар тусгайлан эрх шилжүүлэх эрх зүйн зохицуулалтын тухайд”, Эрх зүй сэтгүүл 2, 2013 он, 21 дэх тал.

Засгийн газрын байгууллага, эсхүл бие даасан байгууллагад шилжүүлэхийг хооронд нь ялгаатай авч үздэг⁵³ бөгөөд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад шилжүүлсэн эрхийн дагуу гаргах эрх зүйн актыг “statutory order”, бие даасан шинжтэй байгууллагаас гаргасан актыг “by law” гэж ялгаатай нэрлэхээс гадна батглах журам, шүүхийн хяналт зэрэг нь ялгаатай байдаг ажээ.

Мөн үүнээс гадна Монгол Улсад Ерөнхийлөгчид хууль тогтоох эрхийг шилжүүлэх асуудал гарч байна. Жишиэлбэл: Дайны байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Дайны байдлын үеийн онцгой нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын Их Хурал шаардлагатай гэж узвэл зарим бүрэн эрхээ Монгол Улсын Ерөнхийлөгчид шилжүүлж болно”, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 12 зүйлийн 1-д⁵⁴ “Монгол улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээс гадна дараах тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” хэмээн мөн хуулийн 12.1.5-д “дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох”⁵⁵ гэх зэргээр УИХ-аас хууль тогтоох эрхийг бусад хуулиар шилжүүлсэн байгаа нь харагдаж байгаа бөгөөд уг асуудал нь өдгөө нэгдсэн ойлголтонд хүрээгүй байгааг харуулж байна.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр

Үндсэн хуулийн цэц нь 1992 оноос хойш хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэхтэй холбоотойгоор 4-н дүгнэлт гаргасан бөгөөд эдгээр дүгнэлтүүд тус бүр дээр өөр, өөр үндэслэлээр маргааныг шийдвэрлэсэн байдаг. Эдгээрийг тус бүрд

⁵³ Mahendra P.Singh. German Administrative Law in Common Law Perspective. (2001). 42, Д.Баттулга, “Хэм хэмжээний актаар зохицуулах харилцааны хүрээ, хязгаар, болон хяналтын зарим асуудлыг боловсруулж болгох нь,” Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан / <http://www.legaldata.mn/buteel/pdf?id=338/>, 36.

⁵⁴ Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль /Шинэчилсэн нарийруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл №36, 2016 он.

⁵⁵ Энэ заалтыг Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгнэлтээр түдгэлзүүлсэн.

нь авч үзвэл:

1.Үндсэн хуулийн цэц 1993 оны 03-р сарын 13-ны өдрийн 02 дүгнэлтээрээ.⁵⁶

Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалтад “Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно.”; 18 дугаар зүйлийн 2 дахь заалтад “Засгийн газар нь энэ хуулийн 17 дугаар зүйлийн 13-15-д заасан татварын хувь, хэмжээг Улсын Их Хурлаас баталсан хязгаарт багтаан тогтооно.”; 28 дугаар зүйлийн 1 дэх заалтад “Татварын байцаагчийн бие хамгаалах тусгай хэрэгслийг хэрэглэх журмыг Улсын Ерөнхий прокурорын зөвшөөрснөөр Татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тогтооно”,⁵⁷ Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь заалтад “Засгийн газар үнийн өсөлтийн түвшинг харгалзан албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг өөрчилнө”⁵⁸ гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн 20 дугаар зүйл, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 13 дахь заалт, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтуудыг зөрчсон тухай маргааныг хянан хэлэлцээд Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийн заалт нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн заалтыг, Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь «Монгол Улсын иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх», «Улсын Их Хурал ... хуульд өөрчлөлт оруулах ... асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэн» гэсэн Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 25 дугаар

зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна хэмээн шийдсэн хэдий ч Үндсэн хуулийн цэц дүгнэлтийнхээ тогтоох хэсгийн 2-т “Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтыг үндэслэн нэмэлт шалгalt хийсний эцэст Цэц дахин хянан хэлэлцэж эцэслэн шийдвэрлэхээр хойшлуулсугай.” хэмээн шийдвэрлэсэн байна.

Дүгнэн үзвээс: Одоогийн үйлчилж буй хуулийн хүрээнд Үндсэн хуулийн цэц дахин хянан хэлэлцэхээр хойшлуулах эрх зүйн үндэслэл байхгүй хэдий ч “Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь зохицуулалт Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг шийдэгүй байгаа нь эрх мэдэл шилжүүлэх асуудал тухайн үед ч гэсэн эргэлзээтэй байсан нь харагдаж байгаа бөгөөд Үндсэн хуулийн Хорьдугаарзүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” хэмээх зохицуулалтыг үгийн шууд утгыг харан тайлбарлалгүйгээр асуудлыг илүү нууцтай авч үзэхээр болсон байгаа нь харагдаж байна.

2.Үндсэн хуулийн цэц 2016 оны 05-р сарын 04-ны өдрийн 06 дүгнэлтээрээ.⁵⁹

Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.ж дэх заалтад “Монгол банк холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.”; Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30.е дэх заалтад “Санхүүгийн зохицуулах хорооноос “холбогдох этгээд” гэж тодорхойлсон бусад этгээд.” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.”, Хоринтавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “хууль батлах,

⁵⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 03-р сарын 13-ны өдрийн 02 дугаартай дүгнэлт, <http://www.legalinfo.mn/law/details/1057?lawid=1057>.

⁵⁷ Монгол Улсын Татварын ерөнхий хууль, 1992. /2008 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсон тооцсон.

⁵⁸ Монгол Улсын Хүн амын орлогын албан татварын хууль, 1992. /2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар хүчингүй болсон тооцсон.

нэмэлт, өөрчлөлт оруулах;” гэх заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцээд Банк, санхүү, үнэт цаасны зах зээл нь төрөөс мэргэжлийн онцгой хяналт, зохицуулалт шаардлаг учраас тухайн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, үнэт цаасны зах зээлийн хурдацтай хөгжил, өөрчлөлт, онцлогийг харгалзан үнэт цаасны зах зээлийн оролцогч, банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээгт цаг алдалгүй шуурхай авах зорилгоор хянан зохицуулагч байгууллагад тодорхой эрх олгож болохоор олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн банк, санхүүгийн салбарын хяналт, шалгалтын үндсэн зарчмуудад тусгасан байдаг бөгөөд дээрх зарчим болон олон улсын стандартуудыг манай улсын банк, санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаандaaа удирдлага болгохоор холбогдох хууль тогтоомжид тусгасан гэж үзэн Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчөөгүй байна гэж үзсэн байна.

Дүгнэн үзвээс: Үндсэн хуулийн шүүхийн эрхэлж буй цорын ганц үндсэн ажил бол гаргаж буй шийдвэрээрээ маргаж буй асуудалд хамааруулан Үндсэн хуулийг тайлбарлах улмаар цогцлоон хөгжүүлэх явдал⁶⁰ бөгөөд өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн заалтыг хэрхэн ойлгох тухай тайлбар хийдэг.⁶¹ Гэтэл дээрх Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээс харахад Үндсэн хуулийн холбогдох зүйл хэсэгт тайлбар хийлгүйгээр олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн банк, санхүүгийн салбарын хяналт, шалгалтын үндсэн зарчмуудад тусгасан учраас тодорхой эрх олгох боломжтой хэмээн дүгнэсэн байгаа нь ямар тохиолдолд хууль тогтоох эрх мэдлийг хэрхэн шилжүүлэх нь эсэх талаар тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэн Үндсэн хуулийн дээр дурьдсан зүйл заалтыг хэрхэн ойлговол зохилтойг тусгаагүй байгаа нь уг асуудал одоо хир

⁶⁰ Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр үндсэн хуулийн хөгжүүлэх нь,” Монгол улсын Үндсэн хуулийн цэц: өгүүзэл, илтгэлийн эмхэтгэл, 2007 он, 377 дахь тал.

⁶¹ Ж.Амарсанцаа, Г.Баясгалан, Хууль зүйн тайлбар толь, Уб., 2003 он, 347 дахь тал.

эргэлзээтэй байгааг харуулж байна.

3. Үндсэн хуулийн цэц 2006 оны 10-р сарын 11-ны өдрийн 04 дүгнэлтээрээ:⁶²

Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т “Зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран тухайн даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээ гэнэ хуулийн 22.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаарзүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, мөн Хоринтавдугаарзүйлийн 1 дэх хэсгийн 1/ “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах” гэсэн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцээд УИХ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах өөрийн бүрэн эрхээ Санхүүгийн зохицуулах хороонд олгосон байна. Ингэснээрээ Улсын Их Хурлын хууль тогтоох эрх мэдлийг бусдад шилжүүлсэн болох нь тогтоогдж байна хэмээн дээрх хуулийн зүйл хэсгийг хүчингүй болгосон байна.

Дүгнэн үзвээс: Үндсэн хуулийн цэц тухайн үед “Үндсэн хуулийн Хорьдугаарзүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, мөн Хоринтавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1/ “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах” гэсэн заалтыг үндэслэн УИХ өөрийн бүрэн эрхээ Санхүүгийн зохицуулах хороонд олгосон байна. Ингэснээрээ УИХ хууль тогтоох эрх мэдлийг бусдад шилжүүлсэн болох нь тогтоогдж байна.” Хэмээн уг хуулийн зүйл заалтыг хүчингүй болгосон байна.

4. Үндсэн хуулийн цэц 2018 оны 1-р сарын 31-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтээрээ:⁶³

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх

⁶² Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 10-р сарын 11-ны өдрийн 04 дугаартай дүгнэлт, <http://legalinfo.mn/law/details/985?lawid=985>

⁶³ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 1-р сарын 31-ны өдрийн 01 дугаартай дүгнэлт, <http://legalinfo.mn/law/details/13132?lawid=13132>

хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командаагчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээс гадна дараах тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;” гээд 12.1.5 дахь заалтад “дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командаагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох;” гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн Хорьдугаарзүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” Гэж заасныг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцээд Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт нь хэл зүйн хувьд хууль тогтоогчийн хүсэл зоригос өөр өөр ойлгогдохоор хуульчлагдсан нь хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална гэсэн Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийг зөрчсөн гэж үзэхд хүргэж байна хэмээн шийдвэрлэсэн байна.

Дүгнэн үзвээс: Үг заалт нь Монгол Улсын Ерөнхийлөгч дайн бүхий байдал, дайны байдал зарласан үед зэвсэгт хүчний ерөнхий командаагчийнхаа хувьд хэрэгжүүлэх өөрийн бүрэн эрхийн талаар хууль тогтоох эрхийг эдлэх агуулгыг илэрхийлж байна хэмээн Үндсэн хуулийн цэцээс үзсэн бөгөөд дээрх тохиолдолд хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэх боломжгүй байдлаар Үндсэн хуулийн Хорьдугараар зүйлийг тайлбарласан байна.

ДҮГНЭЛТ

Ш.Л.Монтескье-гийн Төрийн эрх мэдэл хуваарилах онол нь өдгөө тэр үеийнхээ агуулгаар хэрэгжих боломжгүй болсон бөгөөд нийгмийн хурдацтай хөгжил, олон төрлийн харилцаанаас үүдэн дийлэнх улсад Засгийн газар тодорхой хэмжээний хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлж байгаа нь тулгарсан чухал асуудлыг нэн даруй хугацаа алдалгүй шийдвэрлэж, эдийн засаг болоод бусад нарийн мэргэжил шаардах зүйлийг илүү олон улсын түвшинд судалгаа Үндэслэгээтэй шийдвэрлэх

боловижийг бүрдүүлэг байна. Хууль тогтоох эрхийг шилжүүлэх түүний эрх зүйн зохицуулалтын асуудлыг Монгол Улсын эрх зүйн орчны хүрээнд судлан үзэхэд Үндсэн хуулинд хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэх агуулга бүхий зохицуулалт байхгүй байх бөгөөд Үндсэн хуулийн цэц тодорхой хэрэг маргаан шийдвэрлэхээс эрх шилжүүлэх боломжтой, боломжгүй хэмээн дүгнэлт гаргаж өөр өөр байр суурьтай дүгнэлт гаргасан байна. Мөн бусад органик хуулиудад хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлсэн байгаа нь дээрх асуудал нь нэг мөр тодорхой болоогүй байгаа нь харагдаж байгаа бөгөөд уг ойлголтыг тодорхой болгох шаардлагатай гэж үзэх байна.

Үндсэн хуульд уг асуудлыг тусгаж өгөөгүй байгаагаас үүдэн Үндсэн хуулийн бус аргаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоож байгаа нь хүний эрхийн зөрчил улмаар эрх зүйт төрийн суурь зарчим хүртэл хөндөгдөх боломжтой юм.

НОМ ЗҮЙ

ХУУЛЬ, ТОГТООМЖ

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
- Монгол Улсын Татварын ерөнхий хууль, 1992 он.
- Монгол Улсын Хүн амын орлогын албан татварын хууль, 1992он.
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993 он.
- Төв банк /Монгол банк/-ны тухай хууль, 1996 он.
- Дайны байдлын тухай хууль, 1998 он.
- Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль, 2001 он.
- Монгол улсын Засийн газарт эрх олгох тухай хууль, 2003 он.
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2005 он.
- Банкны тухай хууль, 2010 он.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2013 он.

- Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2016 он.

МОНГОЛ ХЭЛ ДЭЭР

- Амарсанаа.Ж. Баясталан.Г. Хууль зүйн тайлбар толь. УБ: Митита принтинг, 2003 он.

- Амаржаргал.П. Парламентын хууль тогтоох эрх мэдлийн онол үзэл, баримтлал. Эрх зүй сэтгүүл. 2017 он

- Амартүвшин.С. Хуулиар тусгайлан эрх шилжүүлэх эрх зүйн зохицуулалтын тухайд. Эрх зүй сэтгүүл № 2 2013 он.

- Бастиа.Ф. орч: Н.Баярбаатар, Хууль, УБ., 2001 он.

- Гангабаатар.Д. Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал. УБ., 2012 он.

- Гантөмөр.Б. Цэнд-очир.М. Хууль тогтоох эрх мэдлийг засгийн газарт шилжүүлэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. Үндсэн хууль ба эрх зүйт ёс сэтгүүл. 2014 он.

- Лүндээжанцан.Д. Энхбаатар.Ч. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2000 он.

- Лүндээжанцан.Д. Монгол улс дахь төрийн эрх мэдэл хуваарилалт, онол практикийн асуудал. УБ., 2001

- Лүндээжанцан.Д. Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2014 он.

- Лүндэндорж.Н. Төрийн онол. УБ., 2008 он.

- Лүндэндорж.Н. Шилжилтийн үе: Улс төр, эрх зүйн асуудал. УБ., 2010 он.

- Лүндээжанцан.Д. Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник. УБ., 2016 он.

- Лүндээжанцан.Д. Өлзийсайхан.Л. Парламентат ёс. УБ., 2002 он.

- Лүндээжанцан.Д. Аюулгүй байдал, хөгжил, төр эрх зүй /тэргүүн дэвтэр/. УБ., 2002 он.

- Наранпүрэв.Ж. Төрийн эрх мэдэл хуваарилалтыг ойлгохуй. Шихихутаг хууль зүйн шинжлэх ухааны онол, арга зүй мэдээлэл. УБ., 2004 он.

- Нарангэрэл.С. Хууль зүй судлалын Англи-Монгол толь. УБ., 2005 он,

- Одгэрэл.П. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. УБ., 2016 он.

- Руссо.Ж.Ж. орч: Янжмаа.Р.Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд. УБ., 2015 он.

- Сарантuya.Ц. Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал. УБ., 2005 он.

- Совд.Г. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000 он.

- Төгөлдөрсүрэн.Д. Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт, тулгамдаж буй зарим асуудал. Хууль дээдлэх ёс сэтгүүл №4 УБ., 2015 он.

- Чимид.Б. Үндсэн хууцийн мэдлэг. УБ., 2008 он.

- Энхбаатар.Ч. Монгол улсын төрийн байгуулалтыг төгөлдөржүүлэх боломж арга зам /судалгааны тайлан/. УБ., 2010 он.

- Эрдэнэбат.Э. Батцэнгэл.Б. Хууль тогтоох эрх мэдлийг Үндсэн хуулийн хүрээнд шилжүүлэх нь. Үндсэн хууль ба эрх зүйт ёс сэтгүүл, УБ., 2009 он.

ГАДААД ХЭЛ ДЭЭР

- Mahendra P.Singh. German administrative law in common law respective, (2001),

- Paul W.Kahn. Comparative Constitutionalism in a New Key. Michigan law review. (2004): 2677.

- John Locke. Second Treatise of government, 1690, C.B Macherson, 1980,

- Peter Lindseth. The Paradox of Parliamentary Supremacy: Delegation, Democracy and Dictatorship in Germany and France, 1920s-1950s, 2004

ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 03-р сарын 13-ны өдрийн 02 дугаар дүгнэлт

- Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05-р сарын 04-ны өдрийн 06 дугаар дүгнэлт

- Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 10-р сарын 11-ны өдрийн 04 дугаар дүгнэлт

- Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 1-р сарын 31-ны өдрийн 01 дугаар дүгнэлт

ТЭНЦВЭРГҮЙ ГУРВАН ЭРХ МЭДЭЛ БА УЛС ТӨРИЙН БОДЛОГО, ШИЙДВЭРИЙН НӨЛӨӨ



*Дорноговь аймаг дахь сум дундын
Иргэний хэргийн анхан шатны шүүхийн
шүүгч В.Амартувшин*

ТҮЛХҮҮР ҮГС:

Тэнцвэргүй гурван эрх мэдэл

ТОВЧЛОЛ:

Судлаачийн зүгээс эрдэм шинжилгээний ажлаа дэмжих, төрийн 3-н эрх мэдлийн тэнцвэргүй байдал, улс төрийн тогтвортгүй бодлого, судалгаа тооцоогүй шийдвэр нь эрх мэдлийн тэнцвэрийг алдагдуулж байна гэж үзж, өөрийн эрхийнхээ дагуу шүүх эрх мэдлийг төлөөлөн шүүгч болон түүний нийгмийн баталгааг хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагаас гаргасан алдаатай бодлого, шийдвэрээс болж шүүх, шүүх эрх мэдэлд хэрхэн нөлөөлж буйг нотолгоон дээр үндэслэн өгүүлэхийг зорив.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж буй энэ цагт хуулийн санал, төсөл боловсруулж буй этгээдүүд хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг түлхүү оруулж. Шүүх эрх мэдлийн талаар дурдахгүй байгаад судлаач миний зүгээс туйлын их эмзэглэл төрүүлж байгааг нуух аргагүй гэхдээ төрийн бодлого шийдвэрт анхаарал хандуулах нь миний үүрэг хэмээн ойлгож хувь нэмрээ оруулах нь чухал тул мэргэжил нэгтийнүүддээ өөрийн

санаа бодлоо илэрхийлэв.

УДИРТГАЛ

Шүүхийн шинэтгэл, багц хуулиудын шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд гарч буй бэрхшээл тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах. Мөн шүүгчийн эрхийн баталгааг дахин боловсруулж одоо хэрэгжик байгаа хуулийг илүү боловсронгуй болгох, түүнчлэн шүүх эрх мэдлийн байгууллагыг хэнээс ч хараат бус болгох нь зүй ёсных хэмээн үзж. Өөрийн судалгаан дээр дүгнэж шүүхийн багц хуульд ямар нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтойг та бүхэнд хүргэхийг хүсэв.

Оmnө нь уг бүтээлтэй төстэй бүтээлүүд байсан. Тухайлбал: “Шүүхийн хараат бус байдлын харьцуулсан судалгаа” сэдвээр Ч.Энхбаатар 2001 онд¹, Монгол Улсын гавьяат хуульч Л.Бямбаа “Шүүхийн хараат бус бие даасан байдлын эрх зүйн зохицуулалт” сэдвээр 2006 онд тус тус судалгааны ажил хийж докторын зэрэг горилсон томоохон эрдэм шинжилгээний бүтээл гаргаж шүүхийн байгууллагад өөрийн хувь нэмрийг оруулсан байна². Тухайн бүтээлүүдээс ялгарах нь зөвхөн шүүгчийн хараат бус байдал, эдийн засгийн болон нийгмийн баталгаанд хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс нөлөөлж хэрхэн гурван эрх мэдлийг тэнцвэргүй болгож байгааг судлахад оршино.

Энэ сэдвээр судалгаа дүгнэлт хийх, илтгэл хэлэлцүүлэгт оролцохыг зорьж өөрийн зүгээс энэ цаг үед улс төрийн байдал, бодлого, шийдвэр нь шүүхийн бие даасан болон шүүгчийн хараат бус байдалд хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудаас шүүх эрх мэдлийн байгууллагын бүтэц, орон тоо, эдийн

¹ Ч.Энхбаатар. “Шүүхийн хараат бус байдлын харьцуулсан судалгаа”. Уб., 2001 он.

² Монгол Улсын гавьяат хуульч Л.Бямбаа. “Шүүхийн хараат бус бие даасан байдлын эрх зүйн зохицуулалт” Уб., 2006 он.

засаг, нийгмийн хамгаалал зэрэгт хэрхэн нөлөөлж байгааг судлахыг зорьсон юм.

1.1 Хууль тогтоох эрх мэдлийн шүүхийн бие даасан байдал болон хараат бус байдалд нөлөөлөх нь

Монгол Улсын Үндсэн хууль:

Хорьдугаар зүйл: Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.

Гучин наймдугаар зүйл: Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.

Дөчин долдугаар, дөчин есдүгээр зүйлүүдэд: “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ, Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана³”, гэж тус тус хуульчилжээ.

Шүүгч гэж хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдон, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг сахиулан хамгаалахаар тангараг өргөн шүүх эрх мэдлийн хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэнийг⁴ ойлгоно.

2013 оноос 2019 он хүртэл Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд их олон өөрчлөлтөрсон ба уг өөрчлөлтөөс шүүгчийн эдийн засгийн баталгаа, шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөхтэй холбоотой 5 зүйл 46 заалтаас 2 заалтад нэмэлт, өөрчлөлт, 4 заалтыг шинээр нэмж, 9 заалтыг хүчингүй болгосон тухайн заалтууд нь өөрчлөгдөөгүй мэт харагдах боловч үнэн хэрэгтэй маш их хэмжээний зөрчлийг дагуулсан.

Судалгаа Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар бүлэг, 20-24 дүгээр зүйлийн 46 заалтад хийв.

Нэр/№	Хуулийн зүйл, нэр	Заалт Өөрчлөлт	Үүнээс:		
			Нэмэлт	Хүчингүй	
1	20-р Шүүгч хараат бус байж зарчим, баталгаа	12	1	0	0
2	21-р Шүүгчийн үйл ажиллагаанд хонидлангиж оролцохыг хориглох	4	1	0	0
3	22-р Нөлөөллийн мэдүүлэг хотиж	8	0	0	0
4	23-р Шүүгчийн эдийн засгийн баталгаа	12	0	0	8
5	24-р Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний нийгмийн хамгаалал	10	0	4	1
Нийт дүн		46	2	4	9
		5	15		

Уг зүйл заалтуудаас хамгийн ноцтой нэг заалт бол 23.5 Шүүгчийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээт бууруулж болохгүй; 23.8.Хуульдзаасаннаас, болзлын дагуу ондер насны тэтгэвэрт гарсан шүүгчид сүүлийн нэг жилийн цалингийн дунджаар тооцон 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг олгоно. Гэх зохицуулалтыг хүчингүй болгосон нь нэн тэргүүнд зах зээлийн чөлөөт нийгэмд, түүнд чөлөөтэй болон аливаа гачигдал бэрхшээлгүй амьдрах үндсэн эх үүсвэрийг нь халж байгаа нь түүгээр дамжуулан хараат бус байх боломжид нөлөөлж болох аливаа шийдвэр, тогтоол гаргах нөхцөлийг улс төрийн нам болон түүнээс улбаатай эрх баригчид бэлтгэн гүйцэлдүүлсэн нь илт харагдаж байна. Үүнийг их олон талаас нь тайлбарлаж болно.

Тэгвэл хуулийн 24 дүгээр зүйлийн шүүгч, түүний гэр бүлийн гишүүний нийгмийн хамгаалал болсон 10 заалтын 4-н заалт нэмж, 1 заалтыг хүчингүй болгосон нь хэдийгээр дээрх хүчингүй болгосон найман заалтаас 4-г нэмсэн боловч 1 заалтыг дахин хүчингүй болгосон нь шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх боломжтой заалт байна гэж үзэж байна .

³ “Төрийн мэдээлэл” эмхтгэл, Монгол Улсын Үндсэн хууль, 1992 оны 1-р дугаарт.

⁴ “Төрийн мэдээлэл” эмхтгэл, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2013 он.

- Ихэнх барууны хөгжилтэй оронд шүүгчийн эдийн засгийн болон түүний гэр бүлийн гишүүдийн нийгмийн хамгааллыг Улсын маш нууц төвшний буюу улс төр, эрх баригчдаас огт хамааралгүй байгууллагаар дамжуулан хамгаалдаг байна. Тиймээс гурван эрх мэдэл тэнцвэртэйгээр нэг нэгнийгээ хянаж байдаг. Харин Монгол Улсын хувьд хууль тогтоох эрх мэдлийн зүгээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох болох нэрийдлээр өөрчилж буй үйлдэл нь шүүх эрх мэдэлд маш хүчтэй нөлөөлөл үзүүлж байна.

Үг судалгаанаас хархад нийт 5 зүйл 46 заалтаас 2 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, 4 заалтыг шинээр нэмж, 9 заалтыг хүчингүй болгосон ба тухайн заалтууд нь өөрчлөгдөөгүй мэт харгадах боловч шүүгчийн эдийн засгийн баталгаа хамгийн их хөндөгдөж байна. Шүүгчийн хараат бус байдлын үндсэн 2 нөхцөл болох нийгмийн болон эдийн засгийн баталгааг түүнийг хэрэгжүүлэгч Шүүгчийн ерөнхий зөвлөлийн санал, дүгнэлтийг огт харгалзахгүй бүрэн эрхийн хүрээнд гэх нэрийн дор шууд хасах, өөрчлөх, хүчингүй болгох замаар шийдвэрлэж буй нь шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх асар том сонирхол нуугдаж байна гэж үзэж байна.

Иймд шүүгчийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах үндсэн тулгуур болох 2 баганыг нэн тэргүүн эгүүлэн сэргээж, түүний боловсронгуй болгон нууцлалын өндөр зэрэглэлд багтааж, бодлого шийдвэр гаргахаас өмнө байнгын хороо, ажлын хэсэгт дийлэнх олонхыг шүүгчдийн хорооноос шүүгчдийг хамруулж, дотроос нь асуудлын санал, бодлыг авч тусгасны үндсэн дээр шийдвэр төсөл боловсруулж байх нь нэн тэргүүний ажил юм.

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд Шүүгчийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, эрх зүйн зохицуулалтыг тааламжтай болгож, шүүхэд итгэх олон нийтийн итгэл дээшлэх, хуулийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл бэрхшээлийг олж илрүүлэх, илтгэл хэлэлцүүлэгт бэлтгэх, төрийн эрх

мэдэл харилцан тэнцвэртэй болгох ба харилцан тэнцвэртэй болсноор бие даасан, хараат бус байдал хамгаалагдах практик ач холбогдолтой гэж үзэв.

Энэ ... бие даасан, хараат бус байдал бусад эрх мэдлийн тэнцвэр, улсын төрийн судалгаа тооцоотой зөв бодлого, шийдвэр эцсийн дүндээ шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг шийдвэрлэх эхэл байх болно. Шүүгчийн шинэтгэлийг эсэргүүцэх хүч, зогсох сонирхол их бий. Гэвч Монголын ард түмний заяа түшиж, «галт тэрэг» явааар байгаа...5

Шүүгч нь өөрийн мэргэжлийн ур чадварыг шүүн таслах ажиллагаанд бүрэн зориулах бөгөөд үүндшүүн таслах, шийдвэр гаргах төдийгүй шүүгчийн байгууллагатай холбоотой бүхий л үйл ажиллагаа хамаарна /үүргээ зохих ёсоор, бүрэн гүйцэтгэх чадамжтай байх-competence and diligence/ гэжээ.

Ер нь аливаа улс орны улс төрийн бодлого шийдвэр нь судалгаатай, ур нөлөөтэй, зөв зохицуулалт, удирдлагын арга барилуудыг хайж, бутгээмж өндөртэй хэрэгжүүлснээр тухайн улс орны хөгжил, эдийн засаг, нийгмийн баталгаа болдог. Энэ нь эргээд гурван эрх мэдлийг тэнцвэртэй болгодог байна.

1.2 Гүйцэтгэх эрх мэдлээс шүүх эрх мэдэлд нөлөөлөх нөлөөлөл

220-230 жилийн өмнө А.Смит “Үндэстний баялаг” зохиолдоо “Аливаа улс орон ардчиллын замаар явах гэж байвал хараат бус шүүх, чөлөөт эдийн засгийг бүрдүүлэх ёстой” гэсэн байдаг. Энэ нь манай өнөөдрийн эрх зүйн орчин, эдийн засагт тод харагдаж байна. ... Шүүгчийн төсвийг ШЕЗ боловсруулж, УИХ-д өргөн барина гэж хуулиараа эрх олгогдсон боловч Сангийн яам төслийг хэлэлцээд явчихсан, 2014 онд шүүгчийн хөрөнгө оруулалт тэг дүнтэй байгаа. Mash олон шүүх түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулж байна. Шинэтгэлд сайн тал байвч нөгөө талд тулгамдсан хүндрэл нь хуулияа дагаж гарах эдийн засгийн тооцоог хийдэггүйтэй холбоотой. Шүүгчийн цалин, шүүгчийн төсвийг өмнөх жилээс бууруулж болохгүй

гэсэн зарчим цаашдаа мөрдөгдөх байх” хэмээн ярьсан юм.⁵ Шүүхийн бие даасан байдлын эсрэг, улс төрийн дотоод зөрчил ихсэх тусам хараат бус байдалд нөлөөлнө. гэсэн дүгнэлтийг гаргах боломжтой.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Шүүх хараат бус байдлын суурь зарчмууд”-ын 7-л “Гишүүн Улсын үүрэг нь шүүх эрх мэдлийг чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино”⁶ гэж зөвлөсний дагуу Монгол Улсын Засгийн газар шүүхийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд хангалттай төсөв, санхүүгийн нөөцөөр хангах үргийг хүлээдгээ байгууллага боловч энэ үргийг хэрэгжүүлэхдээ хойрго ханддаг.

Тэр бүү хэл бодлого шийдвэр нь эзрэгээр харгадахгүй буюу харин ч эзрэгээрээ хууль тогтоогч эрх баригчдын хүсэл зоригийн илэрхийллийг ханган гүйцэлдүүлэгч байгууллага мэт тодоос тод гэрэлтэх болжээ. Эцсийн дунд бидний үйл хэргийн үр дүнг эрх баригчид биши ард түмэн шүүж шүүмжлэн үнэлдэгт оршдогт байгаа юм.

Түүнчлэн шүүгч орон нутагт томилогдоод ажиллах орчин нь төрийн бус түрээсийн байх, орон байрны түрээс, хөлс зардал нь өөрийн орон сууцны зардаас З дахин илүү үнээр, ар гэр үр хүүхдээсээ хол бөгөөд тангарарт үүрэгтээ чин үнэнчээр ажиллаж, харин гэр бүлийн гишүүд нь амьдралын эрхээр дасан зохицсон орон байраа орхин орон нутагт ажил хайсаар өнгөрүүлж байна. Энэ бол ард түмний нүднээс далд орших үнэн юм.

ДҮГНЭЛТ

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж буй өнөө цагт шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэхдээ эрх мэдлийн бүтэц, тогтолцоо, нийгэм, эдийн засгийн хувьд Шүүх эрх мэдлийг харилцан адил, тэнцүү

байлгахаар тусгах, хэрэгжүүлэх боломжийг олгох хэрэгтэй.

Үндсэн хуулийн тулгуур зарчмуудын нэг болох Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх гэсэн зарчим байх болов ч улс төрийн бодлого, шийдвэрээр нөлөөлбөл шүүх эрх мэдлийн байгууллага хүн бүрд тэгш үйлчлэх зарчим алдагдах цаг нэгэнт ойрхон байна хэмээн эмзэглэж байна. Үүнийг засахгүй бол одоогийн нөхцөлд засаг барьж байгаа Парламентад олонх болсон улс төрчдөөс хамаарсан, тэдний ааш араншин, хайр хишигээс горьдсон маягтайгаар сайн шүүх засагдалтай, сайн хуулийн байгууллагын тогтолцоотой болох боломжгүй.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан шүүгчийн хараат бус байх зарчим, баталгаа, эдийн засаг, цалин хангамж, нийгмийн хамгааллын хуулийн зохицуулалтыг хүчингүй болгосноор шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх эх үндэс тавигдсан. Үүнээс үүдэж шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн бүтэц, орон тоо, шүүгчийн эдийн засаг болон нийгмийн баталгаа тэр чигтээ хөндөгдсөн гэж хэлэхэд буруутахгүй.

Эх нь булингартай бол адаг нь булингартай гэдгийн адилаар гурван эрх мэдэл зөв хуваарилалттай байхгүй бол түүнээс үүсэх үр дүн нь хэмжээлшгүй их гай дагуулах боломжтой. Тиймээс засах цаг байгаа дээр нь засаж өөрсдийн ирээдүй хойчдоо муу үр дагаврыг үлдээхгүй байхыг зорж ажиллах хэрэгтэй байна.

Хэдий одоогийн нөхцөл байдал ийм байгаач шүүгч бид, Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн тамгын газар энэ нөхцөл байдалтай эвлэрхгүй, хүлээхгүйгээр хүчингүй болгосон хуулийн зохицуулалтыг дахин боловсруулж хуулийн төсөлд оруулж, батлуулахыг зөв зүйтэй гэж үзэж байна.

⁵ Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба бизнес хэлэлциүүлэг. 2014. <http://www.judcouncil.mn/main/125--.html> Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндоржийн хэлсэн үт.

⁶ Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт, 2015 он.

НОМ ЗҮЙ:

Монгол Улсын Үндсэн хууль 1992 он.

Төрийн мэдээлэл эмхтгэл, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль 2013 он.

“Шүүгчийн хараат бус байдлын харьцуулсан судалгаа” Ч.Энхбаатар 2001 он.

“Шүүгчийн хараат бус бие даасан байдлын эрх зүйн зохицуулалт” 2006 он.

ШЕЗ, Шүүгчийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн-Судалгааны тайлан эмхтгэл 2015 он.

Үндэстний баялаг, А.Смит 1792 он.

Шүүгчийн хараат бус байдлын харьцуулсан судалгаа” Ч.Энхбаатар 2001 он.

Шүүгчийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт 2015 он.

---00o---

“АЗИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СУЛЖЭЭ”-НИЙ /ALIN/ 15 ДАХЬ УДААГИЙН УДИРДЛАГУУДЫН ЭЭЛЖИТ УУЛЗАЛТ, ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



2019 оны 8 дугаар сарын 27-29 өдрүүдэд “Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ” (ALIN) олон улсын байгууллагын 2019 оны эзлжит удирдлагуудын уулзалт, олон улсын эрдэм шинжилгээний хурал Тайлан улсад зохион байгуулагдлаа. Удирдлагуудын эзлжит уулзалт, олон улсын эрдэм шинжилгээний хурлыг жилд нэг удаа, өмнөх хурлаар тухайлан сонгогдсон гишүүн оронд зохион байгуулдаг уламжлалтай 2018 онд Монгол Улсад зохион байгуулсан бол энэ удаад Тайланд Улсад зохион байгууллаа.

Энэ удаагийн ALIN 15 дахь удаагийн удирдлагуудын эзлжит хуралд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал С.Энхцэцэг оролцож, олон улсын эрдэм шинжилгээний хуралд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа “Монгол улс дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хэрэгжилт” сэдвээр илтгэл хэлэлцүүллээ.

ОЛОН УЛСЫН ОЮУНЫ ӨМЧИЙН МАРГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТҮҮНИЙГ АЛЬТЕРНАТИВ АРГААР ШИЙДВЭРЛЭХ(ADR) БОЛОМЖИД ХИЙСЭН СУДАЛГАА



ИЗОУИС-ийн Эрх зүйн багши, докторант
Б. Жаргалсайхан

ТҮЛХҮҮР ҮГС:

Арбитр, Оюуны өмч, Олон улсын оюуны өмчийн маргаан, маргаан шийдвэрлэх хувилбарууд

ТОВЧЛОЛ:

Оюуны өмч эрх зүй нь хүн төрөлхтний шинээр олж нээж буй санаануудын илүү хэрэгцээтэй хэсгийг хамгаалах эрх зүйн нэг салбар юм. Оюуны өмчийн эрх нь нутаг дэвсгэрийн шинжтэй буюу тодорхой улсын нутаг дэвсгэрээр хязгаарлагддаг. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн эрх нь улсуудын хувийн хуулиар зохицуулагддаг. Гэвч, улс дамнасан маргаан гарсан үед ихэнх шүүх мухардалд ордог. Зарим тохиолдолд оюуны өмчийн маргаан нь энгийн маргаан шийдвэрлэхтэй адил шийдэх боломжгүй асуудлууд урган гардаг. Тиймээс олон улсын оюуны өмчийн маргааныг шийдэх өөр шинэ гарц хайх шаардлага тулгарч байна. Уг шаардлагад нийцсэн арга бол альтернатив арга хэмээн үзэж уг аргыг хэрэглэж олон улсын оюуны өмчийн маргааныг шийдвэрлэх нь зохимжтой гэдгийг батлахыг зорьсноос гадна, БНСУ-

ын Патентын Ерөнхий Газар болон Оюуны Өмчийг Хамгаалах Зөвлөлөөс “улс орнуудын дотоодын болон гадаадын аж ахуйн нэгж хоорондын олон улсын патентын маргаан цаашид ч нэмэгднэ” хэмээн таамагласан таамаглалыг батлахыг зорьж уг судалгааг хийлээ.

I. УДИРТГАЛ

Олон улсын оюуны өмчийн эрхийн маргааныг шийдвэрлэхэд шаардагдах онцлог өөрөөр хэлбэл, мэргэжлийн чанар, ил тод бус чанар, шуурхай чанар зэрэг асуудлын улмаас шүүхэд хандахад хүндрэл гардаг. Ялангуяа олон улсын оюуны өмчийн маргаанд холбогдогч аль нэг талын харьяа улсын хууль эрх зүйн тогтолцооны дор шүүх хуралд ороход сул тал, сэтгэл зүйн түгшүүр, далд эрсдэл зэрэг гардаг тул шүүхийн нэхэмжлэлийн үндсэн дээр шийдвэрлүүлэхээс өөр арга хайх хэрэгцээ нэмэгдэж байна. Иймээс маргаан шийдвэрлэх алтернатив арга (Alternative Dispute Resolution /цаашид ADR гэх/) ын талаар тодорхой анализ, дүгнэлт хийх шаардлага урган гарсан. Тиймээс ADR-ын онолын ухагдахуун ба шүүхийн нэхэмжлэл хоёрыг нарийвчлан харьцуулж, тус бүрийн давуу тал, сул талыг судалж, олон улсын оюуны өмчийн эрхийн маргааныг шийдвэрэд ADR ашиглах боломжийн талаар БНСУ-ын хууль, сурх бичгүүд болон бусад гадаадын ном сурх бичгүүдэд үндэслэн судлахыг хичээлээ.

II. ОНОЛЫН СУДАЛГАА

1. ADR-ЫН ХӨГЖЛИЙН ҮЙЛ ЯВЦ

Шүүхийн нэхэмжлэлийг орлох маргаан шийдвэрлэх хэрэгсэл (Alternative

Dispute Resolution) гэдэг нь шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлэхээс өөр арга юм. Гэхдээ тусгай арга юм уу? шат дамжлага биш холбогдогч талуудын хооронд гарсан маргааныг шийдвэрлэх зорилготой олон төрлийн бодит аргуудыг хэлдэг.¹ ADR нь дэлхийн өнцөг булан бүрт олон хэлбэрээр ашиглагдах, хөгжиж ирсэн түүхтэй. АНУ-д хэдэн зуун жилийн өмнө Индиан овгийнхны хооронд сүүлийн үеийн зохицуулах хэлбэртэй төстэй маргаан шийдвэрлэх хэрэгслийг ашиглаж ирсэн бөгөөд ийм уламжлалт хэлбэрийн ADR нь өнөөг хүртэл АНУ-д хөгжиж иржээ. Европ дахь ADR-ын үүсэл нь XIII зуунаас дундад зууныг дамнан Францын нэгдлүүдийн маргааныг ADR-тай төстэй аргаар шийдвэрлэж байсан гэж үздэг. Хятад гэх мэт Номхон далайн улс орнууд, Азийн улс орнуудад хувь хүмүүсийн хоорондох маргааныг шийдвэрлэхдээ ойролцоогоор 2000 гаруй жилийн өмнөөс ADR-ыг ашиглаж байсан гэсэн эх сурвалж бий.² ADR аргыг ерөнхийд нь хоёр хэлбэрээр ангилж болно. Үүнд, “Заавал биелүүлэх хэлбэр”-ийн ADR(binding method) болон “Тохиролцоонд хүрэх хэлбэр”-ийн ADR(consensual method) юм. “Заавал биелүүлэх хэлбэр”-ийн ADR нь үйл ажиллагаа явагдсаны дараа гарсан шийдвэрийг талууд автоматаар, хүчээр хэрэгжүүлэх үр нөлөөтэй байдаг. Арбитр, албан ёсны бус шүүх хурал(private judging) зэрэг нь үүнд хамаарах хэлбэр бөгөөд шүүхэд гаргах нэхэмжлэлтэй гадаад хэлбэрийн хувьд ижил төстэй байдаг. “Тохиролцоонд хүрэх хэлбэр” нь холбогдогч талууд хэлэлцээр хийж эцсийн тохиролцоонд хүрэх хэлбэр бөгөөд харилцан зөвшөөрч байж үр дүн хүрнэ. Хэлэлцээр, зохицуулалт (mediation), төвийг сахигчийн урьдчилсан үнэлгээ (early neutral evaluation), заавал биелүүлэх хэлбэрийг агуулсан туршилтын шүүх хурал (non-binding mock-trials), зөвлөгөөний

санал дүгнэлт (advisory opinions) зэрэг аргууд үүнд багтана. Мөн ADR-ыг ялгахдаа шүүхийн нэхэмжлэлийн тусгай шат дамжлагын хөтөлбөртэй хамааралтай эсэхээр нь шүүхтэй холбоотой юм уу албан үүргийн (court-annexed or mandatory) ADR хэлбэр болон албан бус хувийн шинжтэй (private) ADR хэлбэр гэж ангилах нь ч бий.³ ADR-ын үндсэн арга нь арбитр, зуучлал боловч бүх маргааныг сайтар хянаж шалгаснаар тухайн маргаанд тохирох шийдлийн стратегийг олж болох тул түүнд тохирох ADR арыг хэрэглэх боломжтой болно.⁴ ADR-ын төрөл тус бүрийн ерөнхий онцлогуудыг дор тайлбарлав.

2. ADR-ЫН ТӨРӨЛ

Хувь хүмүүсийн хоорондын эсвэл аж ахуйн нэгжүүдийн хоорондын маргааныг шийдвэрлэх аргын хэлбэрүүд нь улс орон бүрийн уламжлалт арга болох шүүхийн нэхэмжлэлээс гадна ярилцлага, зөвлөлдөөн, хэлэлцээ, зуучлал, арбитр, албан бус шүүх хурал (private judging) зэрэг олон янз байдаг.⁵ Маргаан гарах тохиолдолд холбогдогч талууд хамгийн түрүүнд ашигладаг нийтлэг шийдэл нь маргааны холбогдогч талууд өөрсдөө шийдвэр гаргадаг хэлэлцээ боловч энэхүү хэлэлцээ амжилтгүй байх тохиолдолд гуравдагч этгээдийг оролцуулан тусlamж авах юм уу шийдвэр гаргуулдаг арга байдаг. Тиймээс ADR-ын төрлийг ангилахдаа гуравдагч этгээдийн тусlamж авсан тохиолдол, мөн гуравдагч этгээдийн тусlamж авсан байсан ч ADR-ын үр дүн холбогдогч талуудад цагдан саатуулах эрхтэй байх тохиолдол эсвэл ийм эрхгүй тохиолдол гэж олон хэлбэрт хувааж болох бөгөөд эдгээрээс тодорхой тогтсон хэлбэр нь арбитр, зуучлал бөгөөд энэ аргыг түгээмэл хэрэглэдэг тул төлөөлөх арга гэж болно. Үүнээс гадна ADR-ын төрлүүдийг

¹ See Center for Pub. Resources and the Int'l Trademark Assoc., ADR in Trademark And Unfair Competition Disputes: A Practitioner's Guide II-1, II-2 (William A. Finkelstein ed., 1994).

² See Frank E.A. Sander & Stephen B. Goldberg, Fitting the Forum to the eFuss: A User-Friendly Guide to Selecting an ADR Procedure, 10 Negotiation J. 49 (1994).

³ Пак Гуан Со, “Дотоодын ADR (орлуулан маргаан шийдвэрлэх) байгууллагын судалгаа”, БНСУ-ын гадаад худалдаа, арилжааны холбоо, 2014 он.

хольж ашиглах зэргээр өөрчлөгдсөн хэлбэр (hybrid dispute resolution processes)-тэй байж болох бөгөөд ADR-ын чухал аргуудыг танилцуулах болно.

А. АРБИТРЫН АЖИЛЛАГАА

Арбитр нь арбитрын шийдвэрийн дагуу хохирогч талд зохицой үр дүн авчрах зорилготой маргаан шийдвэрлэх үйл явц, хэрэгсэл юм.⁶ Арбитр нь нэг ба түүнээс дээш хүмүүсийн дунд төвийг сахих гуравдагч этгээдийг сонгож үйл ажиллагааны явц болон асуудалд дүгнэлт хийлгүүлдэг ADR-ын хэвшмэл арга бөгөөд шүүх хурлыг хялбаршуулсан шинжтэй байдаг. Ихэвчлэн маргааны талууд асуудлын талаар мэргэжлийн мэдлэгтэй нэг эсхүл гурван хүнийг арбитраар сонгох юм уу сонголтонд оролцож тэдгээр хүмүүсээр шийдвэр гаргуулдаг.⁷ Арбитрын үйл явц нь ихэнхдээ маргааны холбогдогч талуудын сонгосон арбитрын байгууллагаас тогтоосон тодорхой дүрэм, журмын дагуу явагдах бөгөөд талуудын хэрэгцээ шаардлага, тохиролцооны дагуу асуудлын онцлогт тааруулан өөрчлөх боломжтой байдаг.⁸ Тиймээс АНУ-ын хувьд урьдчилан шалгах үе шат болох баримт нотолгоог дэлгэх (discovery) цар хүрээг хязгаарлах, баримт нотолгоо, гэрчийг батлах болон эсрэг мэдүүлэг, баримт материал, аман судалгаа олж авах зэргийг холбогдогч талууд тохиролцож нийт арбитрын үйл явцыг урьдчилан тогтоож болно.⁹ Ялангуяа арбитрын бүрэлдэхүүний шийдвэртэй холбогдуулан талууд хохирлын нөхөн төлбөрийн хамгийн дээд, доод түвшинг урьдчилан тогтоож, арбитрын үйл ажиллагаага эхлүүлж болно.¹⁰ Тиймээс арбитр нь хэдийгээр хоёр талын сергэлдэөн дунд явагддаг шүүх хуралтай

⁶ Шим Сан Рёл нар, “Арбитрын шийдвэр гаргах бүрэлдэхүүний түр шийтгэл болон олон улсын арбитрын байгууллагуудын яаралтай арбитрын тогтолцооны харьцуулсан судалгаа”, Арбирт судлал, 22-р боть, дугаар 3, 2012, 216 дахь тал.

⁷ Endispute Inc., ADR Processes, 1994, at 4-15.

⁸ Холбогдогч талууд өөрсдөө үйл явцын тодорхойлох дүрын арбитр(Ad hoc)-ын талаар дор тайлбарлав; American Arbitration Association, Patent Arbitration Rules 6 1993.

⁹ Paradise, supra note 3, at 270-78.

¹⁰ Endispute Inc., supra note 177, at 4-17.

маш төстэй хэлбэртэй боловч бодит байдал дээр бүхий л үйл явцад холбогдогч талуудын бие даасан байдлыг хүндэтгэдэг ADR-ын хэлбэр гэж хэлж болно.

Маргааны холбогдогч талуудын сонгосон арбитрын аргаас хамаарч Байгууллагын арбитр (Administered Arbitration) болон Дүрын арбитр (Ad hoc Arbitration) гэж хувааж болох бөгөөд тус тусын онцлогтой. Үүнд Байгууллагын арбитр нь холбогдогч талууд тодорхой нэг байгууллагад хэргийг даатгаж, байгууллагаас томилсон арбитрын төлөөлөгч, дүрэм, журам, цагийн хуваарь зэргийг дагана.¹¹ Байгууллагын арбитрыг сонгож байгаа холбогдогч талууд ихэнхдээ байгууллагаас тогтоосон шатлалын дүрмийг сонгоно.¹² Тиймээс байгууллагын зааврын дагуу арбитрын үйл ажиллагаа явагдах тул аль нэг талаас арбитрийг сонгоход санаатайгаар, заль мэхээр саад учруулахаас сэргийлж болно.¹³ Арбитрийн хараат бус, найдвартай байдал болон шийдвэрийн хэрэгжүүлэх боломж зэргийг байгууллагаас нягтлан шалгах боловч гүйцэтгэлийн дүрмийн дагуу арбитрын үйл ажиллагаа явагдах ёстой тул нэхэмжлэлийн төлбөрийн тодорхой хувийг хураамж болгон төлөх болдог учир зардал гарах сул талтай.¹⁴

Дүрын арбитр нь албан ёсны хяналт, гадны байгууллагын хараат байдалд оролгүй холбогдогч талууд хүссэн үе шатлалаар арбитрын үйл ажиллагаа явуулахыг хэлнэ.¹⁵ Тиймээс арбитрын тодорхой байгууллага сонгох шаардлагагүй бөгөөд Байгууллагын арбитртай харьцуулахад зардал хэмнэх

¹¹ See Commission on Arbitration and ADR, International Chamber of Commerce, <http://www.iccwbo.org/policies/arbitration/id2882/index.html> (last visited March 1, 2016); Kenneth R. Adamo, Overview of International Arbitration in the Intellectual Property Context, 2 Global Bus. L. Rev. 7, 11 (2011).

¹² Doak Bishop, Drafting Arbitration Agreements in the International Arena, 25 The Advocate 32, 34 (2003).

¹³ John W. Hinchee, Troy L. Harries, International Construction Arbitration Handbook (2015).

¹⁴ Adamo, supra note 182, at 11.

¹⁵ Thomas H. Oechmke & Joan M. Brovins, 2 Commercial Arbitration § 41:29 (2015).

боломжтой гэсэн давуу талтай юм.¹⁶ Гэвч талуудын үйл явцын талаарх саналууд харилцан тохиролцохгүй байх тохиолдолд шүүх хөндлөнгөөс оролцох боломжтой байдаг сүл талтай.¹⁷

Тиймээс дурын арбитрыг сонгох бол арбитрын үйл явцын талаар урьдчилан тодорхой тохиролцоонд хүрснийхээ дараа явуулах хэрэгтэй бөгөөд шүүхийн оролцоог аль болох хааж, арбитрын үйл ажиллагаа саатахаас сэргийлэх шаардлагатай.¹⁸ Үүний тулд холбогдогч талуудын байнгын хамтын ажиллагаа¹⁹ болон арбитрын журмаа боловсруулах шаардлага үүсдэг бөгөөд тохирсон Арбитрчийг олох хэрэгтэй.²⁰ Дурын арбитрыг сонгосон холбогдогч талууд ерөнхийдөө НҮБ-ийн Олон Улсын Гадаад Худалдааны Хуулийн Комисс (United Nations Commission on International Trade Law, цаашид “UNCITRAL” гэх)²¹-ын арбитрын шүүх хурлын дүрмийг сонгож байна.²² Энэхүү дүрэм нь арбитрын байгууллагын арбитрын хэргийг зохицуулах ерөнхий дүрэм бус арбитрчийг томилох төвийг сахисан байгууллага, шүүхийг тогтоох дүрэм юм.²³ Дурын арбитрын тухайд уг арбитрын үйл явцад ямар ч байгууллага оролцохгүй тул арбитрчдын гаргасан шийдвэрийн зарим нэг хэсэг дутуу дулимаг байж болох²⁴ бөгөөд үүний улмаас арбитрын шийдвэрийн хэрэгжүүлэлтийг энгийн шүүхээс харгалзан үздэггүй гэдгийг

анхаарах хэрэгтэй.²⁵ Тиймээс дурын арбитрын үйл ажиллагаанд UNCITRAL дүрмийн ашиглалтыг тодорхой зааж өгч, нэр алдартай арбитрчийг сонгон түүгээр хэргийн шийдвэр ба арбитрын дүгнэлтийг гаргуулах нь үр дүнтэй юм.²⁶

В. ЗУУЧЛАЛ

Зуучлал нь маргааныг шийдвэрлэхийн тулд төвийг сахисан гуравдагч этгээд нь маргааны холбогдогч талуудын хэлэлцээ, тохиролцооны талаар санал гаргаж, боловсруулахад нь туслах бөгөөд маргаан шийдвэрлэхэд үр ашигтай ADR арга юм. Арбитрт арбитрч асуудлын талаарх дүгнэлт, цагдан саатуулах эрхтэй шийдвэр гаргадаг бол зуучлагч нь маргааны шийдвэрийг илүү саадгүй гаргуулах үүрэгтэй байдаг тул маргааны холбогдогч талуудаар өөрсдөөр нь тохиролцоонд хүргэх гэж хичээдгээрээ онцлогтой.²⁷ Мөн шүүх хурал шиг нүүрэлдүүлсэн хэлбэрээр явагддаг арбитртай харьцуулахад харилцан найрсаг, хамтарсан уур амьсгалтайгаар явагддаг тул урьд өмнөх бизнесийн харилцаа алдагдахаас урьдчилан сэргийлэхэд илүү үр дүнтэй байна.²⁸ Зуучлал явагдахын тулд үндсэндээ холбогдогч талуудын маргааныг зохистой шийдвэрлэх гэсэн үзэл санаа хамгийн чухал юм.

С. ХЭЛЭЛЦЭЭР

Хэлэлцээр нь тогтсон шинжгүй бөгөөд бусад ADR-ын маргаан шийдвэрлэх тогтолцоог ашиглахаас өмнө талууд тохиролцоонд хүрэхийн тулд хэзээд ч сонгож болох арга юм.²⁹ Энэ аргыг ихэвчлэн талууд өөрсдөө хэрэглэх нь элбэгт байдаг. Мөн энэхүү арга хэрэг шийдвэрлэлтийн ач

¹⁶ See Mackay & Bryan, Ad Hoc Arbitration Keeps Costs Down, A Special Report, The National Law Journal, November 19, 2009; Samuel T. Reaves, Self-Administered Arbitration: Something Worth Considering, Under Construction, Mar. 2007, at 4-5.

¹⁷ Bishop, supra note 183.

¹⁸ Thomas L. Gravelle et al., International Arbitration, 84 Mich. Pl. & Pr. § 62C:136 (2016).

¹⁹ Joyce J. George, The Advantage of Administered Arbitration When Going it Alone Just Won't Do, 57 Disp. Resol. J. 66 (2002).

²⁰ James M. Klotz, Drafting Dispute Resolution Clauses in International Sales Agreements, 241 N.J. Law. 16 (2006).

²¹ See Uncitral, Uncitral Arbitration Rules, http://www.uncitral.org/uncitral/en/uncitral_texts/arbitration/2010_Arbitration_rules.html.

²² Bishop, supra note 183.

²³ See Robert L. Brown & Alan S. Guterman, Dispute Resolution in International Business Transactions, Use of Arbitration, 1 Cal Bus. Trans. § 7:50 (2016).

²⁴ Bishop, supra note 183.

²⁵ Stephen Bond, How to Draft an Arbitration Clause, 1 ICC Int'l Ct. Arb. Bull. 14, 16 (1990); Nicholas Ulmer, Drafting the International Arbitration Clause, 20 Int'l Law 1335, 1337 (1986); William W. Park, Arbitration of International Contract Disputes, 39 Bus. Law. 1783, 1785 (1984).

²⁶ See Terrence F. MacLaren, Comparing Institutional and Ad Hoc Arbitration (2016)

²⁷ International Institute for Conflict Prevention and Resolution, Mediation Procedure, <http://www.cpradr.org/CaseServices/CPRRules/MediationProcedure.aspx> (last visited March 2, 2016).

²⁸ Id.

²⁹ Jesse S. Bennett, Saving Time and Money by Using Alternative Dispute Resolution for Intellectual Property Disputes- Wipo to the Rescue, 79 Rev. Jur. U.P.R. 389, 393 (2010)

холбогдол болон хүрэхийг хүссэн зорилгыг тодорхойлоход нь туслах бөгөөд харилцагч талуудад дараагийн шийдлийг нийцүүлэх боломжтой юм.

Дээр дурдсан арбитр, зуучлал, хэлэлцээр нь БНСҮ-д одоогоор хийгдэж байгаа ADR-ын хамгийн түгээмэл хэлбэрүүд юм. Дор тайлбарлах бусад ADR-ийн төрөл нь БНСҮ-д одоогоор мэдэгдээгүй, ашиглагддагтүй аргууд болно.

D. ТӨВИЙГ САХИГЧИЙН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ (EARLY NEUTRAL EVALUATION)

Төвийг сахигчийн урьдчилсан үнэлгээ нь төвийг сахисан мэргэжилтэн уулзалт товлосон өдрөөс өмнө хоёр талын төлөөлөгчдөөс хэргийн бүх үйл явцыг цаасан хэлбэрээр хүлээн авч, урьдчилан үнэлгээ өгөх юмуу? Тохиролцоонд хүргэх арга юм. Хэрэв хоёр тал тохиролцоыг хүсэхгүй эсвэл тохиролцоо саадгүй явагдахгүй тохиолдолд төвийг сахисан мэргэжилтэн хэргийн гол асуудлыг нарийвчлах юмуу? АНУ-ын шүүхийн нэхэмжлэлд тус болох зорилгоор нотлох баримтыг ил болгох явц (*discovery*), хууль эрх зүйн хүсэлтийн (*motion*) цар хүрээ, хугацааг системчлэхэд туслах үүрэг гүйцэтгэн.³⁰ Төвийг сахигчийн урьдчилсан үнэлгээнд хоёр тал шууд ярилцах боломжтой бөгөөд мэргэжилтнээс нууц хадгалах боломжтой үнэлгээ гаргуулан авч болно. Мөн энэхүү үнэлгээ нь хэргийн асуудлыг нарийвчлан илүү чухал асуудлуудад анхаарах боломж олгодог бөгөөд энэхүү үйл явцаар дамжуулан цагдан saatуулах эрхгүй³¹ санал гаргуулах бөгөөд маргааны холбогдогч талуудад тохиролцох боломж олгодог гэдгээрээ давуу талтай.³²

³⁰ David T. Lopez, Feature: Year in Review 2007, Alternative Dispute Resolution, 71 Tex. B. J. 36 (2008). See also David I. Levine, Northern District of California Adopts Early Neutral Evaluation to Expedite Dispute Resolution, 72 Judicature 235, 238 (1988).

³¹ Richard A. Rosen & Stephen P. Younger, Use of Non-Binding Alternative Dispute Resolution Mechanisms to Foster Settlement § 25.03 (2016).

³² Joshua D. Rosenberg & H. Jay Folberg, Alternative Dispute Resolution: An Empirical Analysis, 46 Stan. L. Rev. 1487, 1510 (1994).

E. ТУРШИЛТЫН ШҮҮХ ХУРАЛ (MOCK TRIAL) БА АЛБАН БУС ШҮҮХ ХУРАЛ (PRIVATE JUDGING)

Туршилтын ба албан бус шүүх хурал нь уламжлалт шүүх ажиллагаа мэт аман өмгөөлөл болон гэрчийн мэдүүлгээр явагддаг. Туршилтын шүүх хурал нь оюуны өмчийн эрхийн маргаан шиг мэргэжлийн мэдлэг шаардах тохиолдолд шүүх бүрэлдэхүүнийг маргаантай холбоотой чиглэлийн мэргэжилтнүүдээр бүрдүүлж болно. Туршилтын шүүх хурал нь цагдан saatuullaah эрхгүй бөгөөд аж ахуйн нэгжийн эрх бүхий төлөөлөгчид шүүхийн нэхэмжлэлийн бүхий л үйл явц болон гэрчийн мэдүүлгийг ажигласнаар илүү объектив байдлаар дүгнэлт гаргах боломжтой бөгөөд түүгээр дамжуулан тохиролцох боломж нэмэгдэнэ.³³ Албан бус шүүх хурал нь илүү хурдан шуурхай явуулахын тулд холбогдогч талууд хэргийг шүүх хамгийн тохиромжтой шүүгчийг сонгон явуулах боломжтой бөгөөд шүүх хурлын үйл явц болон дүрмийгэнгийн шүүх хурлаас ялгаатай байдлаар тохиролцож болно. Аль нэг шүүхээс энэхүү үйл ажиллагааг хянах бөгөөд албан бус шүүх хуралд ажиллаж байгаа шүүгч нь ихэвчлэн урьд нь шүүгч байсан хүмүүс байдаг бөгөөд шүүх бүрэлдэхүүнгүй явагддаг. Туршилтын шүүх хурлаас ялгагдах онцлог нь албан бус шүүх хурлын үр дүн нь холбогдогч талуудыг цагдан saatuullaah эрхтэй байдаг юм.

F. ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ АЛБАН БУС ШҮҮХ ХУРАЛ (SUMMARY JURY TRIAL)

Шүүх бүрэлдэхүүний албан бус шүүх хурал нь энгийн шүүх хуралтай төстэй харагдах боловч хоёр талын төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд хэргийн талаар тайлбарлах боломж олгодгоороо онцлогтой.³⁴ Төлөөлөгчдийн нөхөн

³³ See Center for Public Resources Institute for Dispute Resolution, CPR Model ADR Procedures and Practices: Technology Disputes I-9, I-10 (1994); See also Stenograph Corp. v. Fulkerson, 972 F.2d. 726 (7th Cir. 1992).

³⁴ Glenn Newman, The Summary Jury Trial As A Method of Dispute Resolution in the Federal Courts, 1990 U. Ill. L. Rev. 177, 182 (1990).

төлбөрийн хэмжээний талаарх санал их зөрүүтэй байх юмуу жинхэнэ шүүх хуралд дуудагдсан тохиолдолд, шүүх бүрэлдэхүүн хуульзүйн ухагдахууны ойлголт дутмаг гэж санаа зовж байгаа тохиолдолд, мөн сэтгэл хөдлөлийн хүчин зүйлийн улмаас тохиролцоонд хүрэхэд хүндрэлтэй байх тохиолдолд ихэвчлэн энэ аргыг ашиглана. Шүүх бүрэлдэхүүний албан бус шүүх хурлын ажиллагаагаар дамжуулан холбогдогч талууд туршилтын шүүх бүрэлдэхүүний цагдан saatuulaах эрхгүй³⁵ дүгнэлтийг сонсох бөгөөд тохиролцоонд хүрэх боломжтой нөхцөл байдлыг бүрдүүлэхийн зэрэгцээ хэрэв тохиролцо амжилтгүй болох тохиолдолд энэ нь талуудад маргаанд урьдчилан бэлтгэх сэдэл өгдгөөрөө давуу талтай.³⁶

G. ЗУУЧЛАЛЫН АРБИТР (MED-ARB)

Зуучлалын арбитр нь зуучлалыг явуулсан ч талууд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд зуучлагч дахин арбитрчаар ажиллан шийдвэр гаргах эсвэл гуравдагч арбитрчаар эрх үүргийнх нь дагуу шийдвэр гаргуулах тогтолцоюм.³⁷ Зуучлал нь арбитр эхлэхээс өмнөх шатанд явагдах боломжтой бөгөөд маргаан шийдвэрлэх олон төлөвлөгөөний нэг юм. Мөн маргаан гарсан даруй зуучлал явуулж цаашид арбитр явагдах боломжтой гэх мэтээр холбогдогч талууд өөрсдөө ажил үүргийн хуваария тохируулж болно.³⁸ Хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь нэг төвийг сахигч зуучлагч ба арбитрчийн үүрэгтэй байх бөгөөд ийм хэлбэрээр явагдвал холбогдогч талууд гуравдагч арбитрчийг сонгох шаардлагагүй төдийгүй зуучлагч урьдаар хэргийн бүх үйл явцыг ойлгож болох тул ихээхэн хугацаа хэмнэх

сайн талтай байдаг учиртай.³⁹ Мөн зуучлалаар дамжуулан маргааны асуудлыг нарийвчилсан байж болох тул цаашид арбитрт шилжсэн ч арбитрын хугацаа богиносож болно.⁴⁰ Гэхдээ нөгөө талаар нэг төвийг сахигч зуучлал, арбитрыг явуулах тохиолдолд зуучлалын шатанд талууд цаашид арбитр явагдана гэж үзээд мэдээллээ хэлэлгүй үлдээх магадлалтай байна.⁴¹ Зуучлал арбитрт зуучлал, арбитр хоёуланд нь хэрэгждэг нууц хадгалах дүрэм үйлчлэх⁴² бөгөөд зуучлал амжилтгүй болсны дараа арбитрын үр дүнд гарах арбитрын шийдвэрийг шүүхийн шийдвэр гэж хүлээн зөвшөөрнө.⁴³

H. АРБИТРЫН ЗУУЧЛАЛ (ARB-MED)

Арбитрын зуучлал нь арбитр явагдсаны дараа арбитрын шийдвэрийг танилцуулахаас өмнө зуучлал явуулж тохиролцоонд хүргэх тогтолцоо юм.⁴⁴ Хэрэв зуучлалын үед тохиролцоонд хүрвэл тухайн шатанд маргааны шийдвэрлэлт зохицтойгоор дуусгавар болох боловч тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд арбитрчийн арбитрын шийдвэрээр маргааныг дуусгавар болгоно.⁴⁵ Зуучлал болон арбитрын давуу талыг сайтар ашиглаж цагдан saatuulaах эрхтэй арбитрчын шийдвэр ба зуучлалын чөлөөт үйл ажиллагааны аргыг нэгтгэсэн шийдвэрийн тогтолцоо юм. Мөн зуучлалын шатанд танилцуулсан агуулга арбитрын шийдвэрт нөлөөлдөггүй нь давуу тал болдог.⁴⁶ Арбитрын ажиллагааг явуулсны дараа зуучлалыг эхлүүлэх нь Зуучлалын

³⁵ Ellen E. Deason, Combinations of Mediation and Arbitration with the Same Neutral: A Framework for Judicial Review, 5 Y.B. On Arb. & Mediation 219, 219 (2013).

³⁶ Thomas J. Brewer & Lawrence R. Mills, Combining Mediation & Arbitration, 54 Disp. Resol. J. 32, 34 (1999).

³⁷ Deason, *supra* note 213, at 224.

³⁸ Kristen M. Blankley, Keeping A Secret from Yourself? Confidentiality When the Same Neutral Serves Both As Mediator and As Arbitrator in the Same Case, 63 Baylor L. Rev. 317, 319 (2011).

³⁹ Brewer & Mills, *supra* note 214, at 34.

⁴⁰ Alan S. Guterman, Business Transactions Solutions § 101:29 (2016).

⁴¹ Stephen K. Huber, The Role of Arbitrator: Conflicts of Interest, Fordham Urb. L.J. 915, 929 (2001).

⁴² Brian A. Pappas, Med-Arb and the Legalization of Alternative Dispute Resolution, 20 Harv. Negot. L. Rev. 157, 178 (2015).

³⁵ Jay E. Grenig, Alternative Dispute Resolution, 1 Alt. Disp. Resol. § 2:61 (

³⁶ Thomas D. Lambros, The Summary Jury Trial – An Alternative Method of Resolving Disputes, 69 Judicature 286, 288 (1986).

³⁷ Construction Disputes: Practice Guide With Forms § 14.06 (2015).

³⁸ Christian Buhring-Uhle et al., Arbitration and Mediation in International Business 251 (2006).

арбитраас илүү их хугацаа, зардал зарцуулах сул талтай.⁴⁷ Гэхдээ зуучлал амжилтгүй болсны дараа танилцуулагддаг арбитрын шийдвэр нь цагдан саатуулах эрхтэй эцсийн шийдвэр болдог⁴⁸ тул талуудад маргаан шийдвэрлэгдэнэ гэсэн итгэл өгдөг байна.⁴⁹

I. ШҮҮХТЭЙ ХОЛБООТОЙ БУСАД ADR

Үнээс гадна улсын шүүхийн тогтолцооны хүрээнд ADR-ыг ашиглах боломжтой юм. Тухайлбал, шүүхийн нэхэмжлэлд хэрэглэгддэг ADR-д шүүхийн арбитр, шүүхийн зуучлал, шүүхийн эвлэрүүлэл орно. Дотоодын ADR байгууллага нь шүүхийн маргаан шийдвэрлэх нэхэмжлэлийг орлох хуульзүйд суурисан хүсэлт гаргах, бие даасан зуучлал, эвлэрэл, зохицуулалт, арбитр, зөвлөгөө зэрэг үүрэг гүйцэтгэнэ.

II. ADR ХЭРЭГЖИХ БОЛОМЖ

ADR- шийдвэрийн талаарх хууль эрх зүйн хүчин төгөлдөр байдлын талаарх асуудал нь ADR төрлийг сонгож маш чухал хүчин зүйл болно. БНСУ -ын хувьд арбитрын шийдвэр нь талуудын хооронд шүүхийн шийдвэртэй адил хүчин төгөлдөр байх⁵⁰ бөгөөд шүүхтэй холбоотой иргэний хэргийн зуучлал нь талуудын хооронд тохиролцсон асуудлыг протоколд тэмдэглэснээр бүрэлдэх ба⁵¹ энэхүү протоколд тэмдэглэсэн иргэний хэргийн зуучлал нь шүүхийн шийдвэртэй адил хүчин төгөлдөр байна.⁵² Эвлэрлийг шүүх хурлын, шүүхийн гэж хуваагдах бөгөөд шүүх хурлын эвлэрлийг нэхэмжлэлээс өмнөх эвлэрэл, нэхэмжлэлийн үеийн эвлэрэл гэж ангилах ба эвлэрлийн протокол

⁴⁷ Sam Kagel & Bette J. Roth, 1 Alternative Dispute Resolution Practice Guide § 37.9 (2015).

⁴⁸ Arnold M. Zack, The Quest for Finality in Airline Disputes: A Case for Arb-Med, 58-JAN. Disp. Resol. J. 34, 37 (Nov. 2003/Jan. 2004).

⁴⁹ Elizabeth A. Hunt, Arb-Med: Adr in the New Millennium, Orange County Law, January 2000, at 29.

⁵⁰ БНСУ-ын Арбитрын тухай хуулийн 35-р зүйл.

⁵¹ БНСУ-ын Иргэний хэргийн зуучлалын тухай хууль 28-р зүйл.

⁵² БНСУ-ын Иргэний хэргийн зуучлалын тухай хууль 220, 231-р зүйл.

гаргасан тохиолдолд бүгд шүүхийн шийдвэртэй адил хүчин төгөлдөр байна.⁵³ Гэхдээ энэхүү шүүх хурлын эвлэрлийг бодит талаас нь авч үзвэл нэхэмжлэлтэй маш төстэй шинжтэй тул хатуу стандарт баримтлан авч үзвэл ADR-ын төрөлд хамруулах боломжгүй юм. Харин Шүүхийн эвлэрэл бол шүүх хурлаас бусад үед талгууд харилцан буулт хийж маргааныг дуусгавар болгох тохиролцоо бөгөөд хэлэлцэр, зуучлал эсвэл нэхэмжлэлээс бусад зуучлал зэрэгт явагддаг талуудын тохиролцоо юм. Өөрөөр хэлбэл, дебиторын гэрээнд хамаарна гэж ойлгож болно. АНУ гэх мэт гадаадын улс орнуудад явагддаг Төвийг сахигчийн урьдчилсан үнэлгээ (Early Neutral Evaluation), Туршилтын шүүх хурал (Mock Trial), Шүүх бүрэлдэхүүний албан бус шүүх хурал (Summary Jury Trial), Жижиг шүүх хурал (Mini-trial) эсвэл зуучлалын үр дүнд гардаг тохиролцооны бичгийг ийм дебиторын гэрээнд хамааруулан үздэг. Албан бус шүүх хурал (Private Judging)-ын хувийн шүүгч (private judge) нь талуудыг аль болох тохиролцоонд хүргэх гэж хичээх бөгөөд харин талууд хэзээд харилцан тохиролцсоны үндсэн дээр маргааныг дуусгавар болгож болно. Гэхдээ хувийн шүүгч хэргийг эцслэн шийдвэрлэх эрхтэй байdag. Албан бус шүүх хурлын шийдвэрийн талаарх шүүхийн тогтоол бол бусад шүүх хурлаас гарсан шийдвэртэй адилхан хүчин төгөлдөр бөгөөд (хяналтын шүүхийн дурмийн дагуу ялгаатай байж болно) давж заалдах эрхтэй байна.⁵⁴ Хэрэв албан бус шүүх хурлын явцад шүүхэд эсвэл хувийн шүүгчтэйгээ талууд тохиролцоонд хүрсэн тохиолдолд энэ тохиролцоо шүүхээс гаргасан тогтоолтой ижил хүчин төгөлдөр байна. Арбитрын шийдвэрийг гадаадын улс орнууд шүүхийн шийдвэртэй нэгэн адил хүчин төгөлдөр гэж хүлээн зөвшөөрдөг байна. Харин Арбитрын зуучлал (Arb-Med)-д арбитрын ажиллагааны үеэр маргааныг дуусгавар болгосон тохиолдолд

⁵³ БНСУ-ын Иргэний хэргийн зуучлалын тухай хууль 220, 221, 386-р зүйл.

⁵⁴ See Center For Public Resources Institute For Dispute Resolution, CPR Model ADR Procedures and Practices: Technology Disputes I-25 (1994).

анхаарлаа хандуулах шаардлагатай. Энэ тохиолдолд зуучлалын үр дүн нь зарчмын хувьд албан бус тохиролцооны хэлбэрээр бичигдэг тул дебитор шиг хүчин төгөлдөр байх боловч холбогдогч талуудын хүсэлтээр үүнийг арбитрын шийдвэрийн хэлбэр болох консент авард (consent award) хэлбэрээр бичиж шүүхийн шийдвэр шиг хүчин төгөлдөр болгож болдог учиртай.

III.ОЛОН УЛСЫН ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН МАРГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БАЙДАЛ

2000 оноос хойш БНСҮ болон дэлхий нийтийн аж ахуйн нэгжүүдийн хоорондын оюуны өмчийн маргаан ихээхэн нэмэгдсэн бөгөөд 2004 оноос 2011 он хүргэлх 7 жилийн хугацаанд оюуны өмчийн маргаан 4.3 дахин нэмэгдсэн байна.⁵⁵ БНСҮ-ын Патентын Ерөнхий Газар болон Оюуны Өмчийг Хамгаалах Зөвлөлөөс дотоодын ба гадаадын аж ахуйн нэгж хоорондын олон улсын патентын маргаан цаашид ч нэмэгдэн гэж таамаглаж байна.⁵⁶ Уг таамаглалын дагуу БНСҮ-ын Оюуны Өмчийг Хамгаалах Зөвлөлийн олон улсын оюуны өмчийн маргааны тайлангаас үзвэл 2012-2014 оны олон улсын оюуны өмчийн маргааны тоо 2012 онд 6746, 2013 онд 9377, 2014 онд 7585 гэсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд ерөнхийдөө өсөлттэй гарчээ. 2013 оноос хойш 2014 онд олон улсын оюуны өмчийн маргааны тоо бага зэрэг буурсан үзүүлэлттэй гарсан нь хийсвэр патентыг хүчингүй гэж тооцсон АНУ-ын Дээд шүүхийн шийдвэр⁵⁷ болон АНУ-ын Засгийн Газрын патентын маргаантай

⁵⁵ Гүон Хёг Жэ, “Oюуны өмчийн маргааны хандлага, хариу агаар хэмжээ», SERI эдийн засгийн фокус, 2012, 1х. (권혁재, “지식재산권 분쟁의 추세와 대응방향”, SERI 경제포커스, 2012, 1면)

⁵⁶ Патентын ерөнхий газар болон БНСҮ-ын Оюуны өмчийг хамгаалах нийгмэлэг, “2012 оны олон улсын оюуны өмчийн маргааны чиг хандлага, жилийн тайлан”. 2012 он, 49-53 дахь тал. (특허청·한국지식재산보호협회, “2012년 국제지재권 분쟁동향 연차보고서”, 2012 он, 49-53 дахь тал. 면 참조)

⁵⁷ БНСҮ-ын Оюуны өмчийг хамгаалах нийгмэлэг, “2014 оны олон улсын оюуны өмчийн маргааны чиг хандлага, жилийн тайлан”, 2015, 16x ашиглав. See Alice Corp. v. CLS Bank International, 134 S. Ct. 2347 (2014). (한국지식재산보호협회, “2014년 국제지재권 분쟁동향 연차보고서”, 2015, 16면 참조; See Alice Corp. v. CLS Bank International, 134 S. Ct. 2347 (2014))

холбоотой үүссэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогын үр дүн гэж тайлбарлах нь ч бий.⁵⁸ Гэхдээ 2016 онд Lex Machina сэтгүүлээс гаргасан 2015 оны АНУ-ын патент, зохиогчийн эрх, барааны тэмдэгтийн эрхийн тайлангаас үзвэл 2015 онд шинэ патентын нэхэмжлэл 5830 /гэхдээ зөвхөн патент, зохиогчийн эрх, барааны тэмдэгтийн олон улсын маргааныг дурдсан тоо гэдгийг анхаарна уу! Θөр бусад оюуны өмчийн олон улсын маргааныг дурдвал харьцангуй их тоо гарна./ гэж гарсан нь 2014, 2013 оноос бусад онтой харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт юм.⁵⁹ Оюуны өмчийн маргааны тоо нь үндэсний болон олон улсын менежмент, хууль, тогтолцооны өөрчлөлтөөс шалтгаалан жил бүр ялгаатай гарч болох боловч оюуны өмчийн эрхийг аж ахуйн нэгж болон улсын эдийн засгийн өсөлтийн стратеги, хөрөнгө болгон ашиглаж байгааг харуулж байна. Θөрөөр хэлбэл, олон улсын оюуны өмчийн маргаан нэмэгдэхээс урьдчилан сэргийлэхэд хэцүү байх болно.

Оюуны өмчийн эрх олон улсын бизнесийн гол объект болон идэвхжиж байгаа тул БНСҮ, АНУ, ЕХ, Япон, Хятад зэрэг томоохон улсууд оюуны өмч бол үндэсний өрсөлдөх чадварыг бэхжүүлэх гол хүчин зүйлийн нэг гэдгийг хүлээн зөвшөөрч, холбогдох тогтолцоог шинэчлэн сайжруулах гэх мэтээр үндэсний стратеги боловсруулан хэрэгжүүлж байна.⁶⁰ Оюуны өмчид төвлөрч үйл ажиллагаа явуулдаг салбарын эдийн засгийн оролцоо нь БНСҮ, АНУ, Европ зэрэг эдийн засгийн агентуудад тодорхой харагдаж байгаа юм. Θөрөөр хэлбэл эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжил бий болгохын тулд оюуны өмчийг хамгаалах, идэвхжүүлэхэд хамаг хүчээ

⁵⁸ БНСҮ-ын Оюуны өмчийг хамгаалах нийгмэлэг (вшлэл 6), 17 х ашиглав. (Обамагийн засгийн газар патентаас болж үүсж нийгмийн зардлыг багасгахын тулд программ хангамж, бизнесийн загварын патентын талаар АНУ-ын патент ерөнхий газрын хяналтыг сайжруулахыг даалгасан”).

⁵⁹ Review of Intellectual Property Trends over 2015, Lexology, February 4 2016, <http://www.lexology.com/Library/detail.aspx?g=2525227f-1d1f-4161-be71-79f803734151> (last visited February 1, 2016).

⁶⁰ Патентийн ерөнхий газар, “2014 оны Оюуны өмчийг цагаан ном”, 2015, 62x ашиглав. (특허청, “2014 지식재산 백서”, 2015, 62면 참조.)

зориулахаас өөр аргагүй болжээ. Ялангуяа Солонгосын дайнаас хойш эрчимтэй хөгжиж ирсэн БНСУ-ын эдийн засгийн өсөлтийн хөдөлгөгч хүч нь экспортод чиглэсэн худалдааны бодлого байсан бөгөөд эдийн засгийн цар хүрээнээс давсан гадаад худалдааны хамаарал⁶¹ болон оюуны өмчийн эрчимжсэн үйлдвэрлэл нь гадаад худалдаанд томоохон тэнхлэг болж байна. Эдгээр баримтаас үзвэл оюуны өмчийн эрхийг хамгаалах, маргааныг шийдвэрлэх үр дүнтэй, үр нөлөөтэй хэрэгсэл бий болгох нь МҮ-ын эдийн засгийн тогтвортой байдал, өсөлтийг хангахад юу юунаас илүү чухал билээ. Улс орнуудын хамтын ажиллагаа ба ашиг сонирхлын хооронд үүсэх олон улсын оюуны өмчийн маргаан нь маш төвөгтэй, бэрхшээлтэй асуудал бөгөөд үүнийг шийдвэрлэх арга замыг олох нь бидний даалгавар билээ.

IV. ДҮГНЭЛТ

Дээрхээс дүгнэхэд, Олон улсын оюуны өмчийн маргаанд ашигладаг арбитр, зуучлал зэрэг ADR аргууд нь төвийг сахисан бөгөөд бизнесийн харилцааг хамгаалж, холбогдогч талуудын оролцоо, үүргийг нэмэгдүүлэх, нууцыг хадгалах, шүүхийн ачааллыг багасгах давуу талтай байна. Оюуны өмчийн эрхийн маргаантай холбоотой шүүхийн зардал ба хохирлын нөхөн төлбөрийн эрсдэл, зарцуулах цаг хугацаа, олон улсын маргааныг шүүхээр шийдвэрлэсэн тохиолдолд шүүхийн шийдвэр гадаадын улс оронд хэрэгжих боломж зэргийг харгалzan үзвэл холбогдогч талууд шүүхээр шийдвэрлүүлэхээс өөр арга зам хайх, сонгохос аргагүй байдалд ордог. Энэхүү арга нь дээр дурдсан олон төрлтэй алтернатив буюу ADR арга хэмээн үзэж байна. Жил ирэх тутамд олон улсын оюуны өмчийн маргаан өсөн нэмэгдэж байгаа өнөө үед маргалдагч талууд дээрх алтернатив аргын олон төрлүүдээс өөрт тохиромжтойг⁶² 2000 оны эжн үед гадаад худалдааны түвшин 60-70% байсан бол дэлхийн санхүүгийн хямраас хойш огном нэмэгдэж, 2011 оноос хойш 100% болж өссөн байна. Ким Юу Жон, "Гадаад бүтээгдхүүний хамаарал нийтгэж байгаа БНСУ-ын эдийн засгийн гадаад худалдааны хамаарал ендер", Yonhap News, 2013.10.12, <http://www.yonhapnews.co.kr/stock/2014/10/10/1309000000AKR2014101007680002.HTML?template=7239> (2016. 2. 11-нд үзсэн).

сонгон хэрэглэгдээрээ мөн давуу талтай юм.

НОМ ЗҮЙ

I. Ном

Bae, Kim&Lee LLC. Arbitration Law of Korea: Practice and Procedure. 115

Deborah E. Bouchoux. Intellectual Property. The Law of Trademarks, Copyrights, Patents, and Trade Secrets.

Loukas A. Mistelis. Concise International Arbitration. Kluwer Law International.

MICHAEL SPENCE. "Intellectual Property". CLARENDRON LAW SERIES.

Trevor Cook& Alejandro I. Garcia. International Intellectual Property Arbitration. ARBITRATION IN CONTEXT SERIES. Wolters Kluwer Law Business.

박광서, “국내 ADR(대체적 분쟁해결)기관 조사 연구”, 한국무역상무학회, 2014.

II. Хууль

Korean Commercial Arbitration Act

Patent Act of Korea

The New York Convention on the Recognition and Enforcement of Foreign

Arbitral Awards

UNCITRAL Model Law

III. Кейс

Lasercomb America, Inc. v. Reynolds, 911 F.2d 970, 974-975 (4th Cir. 1990)

Seoul District Court Judgment 94gahap59931, 15 Spetember 1995. Supreme Court Judgment 2001Da77840, 26 February 2003.

IV. Бусад

2015 Investment Climate Statement-Cambodia. Bureau of Economic and Business Affairs. 2015. <https://www.state.gov/e/eb/rls/othr/ics/2015/241508.htm>

Albert Jan van den Berg. New York Convention of 1958- Consolidated Commentary. Yearbook Commercial Arbitration. 2003.

Albert Jan Van Den Berg. The New York Convention 1958 and Panama Convention 1975: Redundancy or Compatibility? 2014

Ana Gerdau de Borja. Intellectual Property Mandatory Rules and Arbitrability in the U.S and in Brazil.

Appeals& Trials. Korean Intellectual Property Office. <http://www.kipo.go.kr/kpo/user.tdf?a=user.english.html.HtmlApp&c=30300&catmenu=ek30300>

Arbitrability of Intellectual Property Disputes. Marc Blessing. Arbitration International. 1996

Arbital Award Law and Legal Definition. <https://definitions.uslegal.com/a/arbitral-award/>

Arbitration Guide IBA Arbitration Committee: United States. 2012

Arbitration Guide. IBA Arbitration Committee. South Korea. 2012

Arbitration of Disputes Over Intellectual Property Rights in Hong Kong. Legal News & Analysis. Angela Wang & Co. <http://www.conventuslaw.com/report/arbitration-of-disputes-overintellectual-property/>

Arbitration procedures and practice in South Korea: overview. www.us.practicallaw.com

Arpad Bogsch. Opening Address. WORLDEIDE FORUM ON THE ARBITRATION OF INTELLECTUAL PROPERTY DISPUTES. 1994

ASEAN Intellectual Property Portal. Cambodia. <https://www.aseanip.org/Statistics-Resources/ASEAN-IP-Offices-Details/Cambodia>

---000---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА П.АМАРЖАРГАЛ ХБНГУ-ЫН ТӨРИЙН ЗАХИРГАА СУДЛАЛЫН ИНСТИТУТАД ЗОЧИН СУДЛААЧААР АЖИЛЛАЛАА



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, дэд профессор П.Амаржартгал ХБНГУ-ын Төрийн захиргаа судлалын институтад 2019 оны 8 дугаар сарын 6-ны өдрөөс 28-ны өдрүүдэд зочин судлаачаар ажиллаж захиргааны эрх зүй, нийтийн удирдлагын чиглэлээр судалгаа хийж, тус байгууллагад ажиллаж байх хугацаандaa цаашид хоёр байгууллага хамтран ажиллах талаар санамж бичиг байгуулахаар харилцан санал солилцлоо.

ӨМГӨӨЛӨГЧИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛ



ШУА-ийн Философиийн хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний дэд ажилтан
М.Долгорсүрэн

ТҮЛХҮҮР ҮГС:

Өмгөөлөгчийн үнэт зүйл, өмгөөлөгч мэргэшлийн ёс зүй, харилцааны соёл, найрсаг харилаа

ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүллээр өмгөөлөгч мэргэшлийн тухай, өмгөөлөгчийн ёс зүйн өнөөгийн төлөв байдал, өмгөөлөгчийн ёс зүйн олон улсын туршлагыг судалж, өмгөөлөгчийн үйлчилгээний стандартыг бий болгож, мөрдүүлж, нэвтрүүлэн ажиллах, өмгөөлөгчийн ёс зүйн болон мэргэжлийн хариуцлагыг өндөржүүлж, хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчинг сайжруулах талаар санал дэвшүүлэхийг зорьсон.

ҮДИРТГАЛ:

I. Өмгөөлөгч мэргэшлийн тухай

Өмгөөлөгч (латин.advocatus; англи. lawyer; advocate; орос.адвокат) нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлдэг хуульч юм. Хуульд заасан журмын дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан

хүнийг өмгөөлөгч гэнэ. Өмгөөлөгчөөс үйлчлүүлэгчдээ үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцааг өмгөөллийн үйл ажиллагаа гэдэг. Хууль зүйн мэргэжлийн туслалцаа нь зөвлөгөө өгөх, шүүхэд төлөөлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох буюу өмгөөлөл гэсэн төрлтэй. Монгол Улсад “өмгөөлөгч” гэсэн нэр томьёог 1924 оны “Шүүх таслах ба прокурорын газруудын дагаж явах дүрэм”-д анх хэрэглэсэн байдаг¹. Түүнчлэн 1928 оны 4 дүгээр сард хэвлэгдсэн “Монгол Ард Улсын Цааз хууль, шүүх таслах газруудын байдлыг товчилсон дэвтэр” хэмээх бүтээлд төлөөнөө заалдагч (өмгөөлөгч)-ийн тухай авч үзсэн байдаг². Үүнээс хойш удалгүй 1928 оны 5 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан “Шүүх таслах тухай олонд тусламж үзүүлэх бүлгэмийн дүрэм”-д төлөөнөө заалдагч (өмгөөлөгч)-ийн талаар зохицуулсан³.

Монгол Улсын Үндсэн хуульд “...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах”, “шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй. Шүүгдэгч энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ” гэж өмгөөллийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлсон бөгөөд өмгөөлөгчийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны, цар хүрээ, эрэлт, хэрэгцээ өдгөө улам бүр өсөн нэмэгдсээр байна.

Өмгөөллийн үйл ажиллагааны хүний эрх, эрх чөлөөг хамгаалах эрхэм зорилго бүхий өмгөөлөгчийн мэргэжлийн ажил хэрэг мөн бөгөөд түүний эзэд нь өмгөөлөгчид байдаг. Мөн “үйлчлүүлэгч нарынхаа эрх, эрх чөлөө болон шударга ёсыг бүхэлд нь хамгаалдгаараа өмгөөлөгчид

¹ З.Сүхбаатар, П.Оюундэлгэр. Монгол Улсын өмгөөллийн хууль, дүрэм /1924-2013/, Уб., 2014 он, 6 дахь тал.

² Ц.Гүрсэд. Монгол Ард Улсын Цааз хууль, шүүх таслах газруудын байдлыг товчилсон дэвтэр. Уб., 1928 он, 24-25 дахь тал.

³ З.Сүхбаатар, П.Оюундэлгэр, Монгол Улсын өмгөөллийн хууль, дүрэм /1924-2013/Уб., 2014 он, 8-11 дэх тал.

нь ардчилсан нийгмийг оршин тогтоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг байна”.

Өмгөөлөгч бол үйлчлүүлэгчийнхээ итгэл найдварт нь байдаг. Тийм ч учраас өмгөөлөгчийн мэргэжил бол нэн хүндтэй дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хуульч мэргэжлийн нэгэн төрөл юм. “Өмгөөлөгч нь зөвхөн нэг орны төдийгүй, дэлхий дахинд түгээмэл ач холбогдолтой, өндөр нэр хүндтэй, хуульч мэргэжлийн нэгэн тулгуур багана нь болдог онцгой мэргэжил мөн” ажээ⁴. Энэ мэргэжил нь “Шүүгч шиг эртний, буянтан шиг өгөөмөр, хууль зүй шиг чухал”⁵ бөгөөд нийгмийн ариун нандин үнэт зүйлийг хамгаалахын төлөө үргэлж бодол оюунаа чилээдэг. “Өмгөөлөгч бол хууль зүйн мэргэжил анх үүсэхэд буй болсон, эмчтэй ямагт жишин үздэг, хүмүүнлэг мэргэжлийн нэгэн төрөл мөн”⁶.

“Өмгөөлөгч нь шүүхэд төлөөлөх, шүүн таслах ажиллагаанд оролцох эрхтэй; чөлөөт, бие даасан мэргэжилтэн”⁷ бөгөөд хууль, мэргэжлийн дүрэмд захирагдана. Түүнчлэн өмгөөлөгчийн мэргэжлийн ажил буюу өмгөөлөл, хууль зүйн туслалцаа нь хүний эрх, мэргэжлийн ёс зүйд сууриссан, “шударга ёс ба хууль”-иас эх авсан байдаг. Америкт өмгөөлөгчөөс өөр ямар ч мэргэжил тийм олон ерөнхийлөгчийг төрүүлээгүй. Линкольн, Франклин, Рузвельт нар өмгөөлөгч байв⁸.

Ардчилал, хүний эрх, Үндсэн хуульт ёс гэх зэрэг нийгмийн үнэт зүйлийг болон үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрх бүхий байгууллага болон шүүхэд төлөөлөн хамгаалж байдаг хүн бол өмгөөлөгч юм. Тийм ч учраас Францын хуульч Андре Мари Жак Дюпен “Улс орон эр цэргүүдээрээ төдийгүй өмгөөлөгчдөөрөө хамгаалагдаж байдал”

гэж хэлжээ. Энэ утгаараа “Өмгөөлөгчийн ажил мэргэжил нь хууль зүйн мэргэжлийн асар их ур чадварыг шаарддаг, хүний төлөө чин санаа тавьдаг, үйлчлүүлэгчийнхээ хууль ёсны эрх ашгийн төлөө өөрийгөө ч золиосолдог ажил мэргэжил юм”⁹

“Улс төрийн өндөр боловсролтой байх, ёс суртахууны эрхэм чанарыг дээдэлдэг байх, ажил хэргийн гүнзгий мэдлэг, мэргэжлийн өндөр ур чадварыг эзэмшиж байх, хүний сэтгэл зүйн онцлогийг сайн мэддэг байх, асуудалд бодитой хандаж, зөв үнэлэлт, дүгнэлт өгдөг байх, ажил амьдралын туршлага, практик ажлын дадлагатай байх”¹⁰ зэрэг нийтлэг шаардлага өмгөөлөгч хүнд тавигдана. Өмгөөлөгчийн мэргэжил нь “эрх зүйн өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, өдөр тутамд яз бүрийн асуудалтай тулгарч байдаг мэргэжил, ёс суртахууны болон сэтгэл зүйн их дарамттай байдаг”¹¹ ажээ. Тиймээс энэ бүгдийг өмгөөлөгч харгалzan үзэж ажил хэргээ зөв зохион байгуулах шаардлагатай болдог.

Өмгөөлөгчийн мэргэжлийн ажил бол хууль зүйн мэргэжлийн зөвлөгөө өгөх, өмгөөлөл хийх явдал юм. Уугуул чанараараа хүний сайн сайхны төлөө зориулагдсан байдаг тул зөвхөн дээр дурдсанaar хязгаарлагддаггүй заримдаа “хүний итгэл, хүндэтгэл хүлээж, хувийн амьдралд нөлөөлөх хууль зүйн болон ёс суртахууны үүрэг хүлээж ажилладаг, бүр хувийн амьдралд нь хутгалдан мэргэжлийн туслалцаа үзүүлдэг”¹² байна.

Өмгөөлөгчийн ажил хэрэг буюу өмгөөлөл бол үнэ цэнэ, утга учир бүхий эрхэм зүйл, үнэний төлөөх үйл явц байдаг. Тиймээс өмгөөллийг хүний эрхийг хамгаалахад чиглэсэн бодол ухаан, сэтгэл хөдлөл, хүнлэг ёс, шударга ёс, хууль дээдлэх үзэл санааг агуулсан үйл явц гэж тодорхойлж болох юм. Хууль нь бүх нийтийн хүсэл эрмэлзлийн илрэл

⁴ Т.Сэнгэдорж, С.Энхмэнд, С.Энхсаруул. Дэлхийн ба Монголын хуульч эрх зүй, ёс зүй. Уб., 2014 он, 8-9 дах тал.

⁵ Произведения Г-на, Рассуждения о независимости адвоката, I, стр 3

⁶ С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. Уб., 2001 он, 146 дахь тал.

⁷ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.б дахь хэсэг

⁸ Лоуренс Фридмэн. Введение в Американское право.М.,1993.“Универс”,“Прогресс”.С.203

⁹ Д.Тогтоожаргал. Төрийн хүн /намтар, дурсамж/Уб., 2011 он, 90 дахь тал.

¹⁰ Т.Сэнгэдорж. Хуульч мэргэжил.Уб., 2003 он, 56-57 дахь тал.

¹¹ Д.Тогтоожаргал. Төрийн хүн /намтар, дурсамж/Уб., 2011 он, 90 дахь тал.

¹² Мөн тэнд. Уб.. 2011 он,187 дахь тал.

байх бөгөөд өмгөөлөгч үүнд захирагдаж өмгөөлөл хийнэ. Өмгөөлөл нь хүний эрх, эрх чөлөөгөө баталгаатай эдлэх туйлын хүслэнгээс эхлэлтэй. “Өмгөөлөл нь хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөгдөж бас түүгээр хязгаарлагдаж байдаг бөгөөд энэ нь өмгөөлөгчийн үг, үйл хөдлөлөөр илрэн гардаг”¹³

Өмгөөллийн үр дүн үйлчлүүлэгчийнх нь амь, амьдралаа цэгнэгдэх нь бий гэдгийг дурдах нь зүйтэй болов уу. Өмгөөлөл бол тоглоом наадгай биш, урлаг уран сайхны арга хэмжээ биш, худалдаа биш¹⁴, үйлдвэрлэл биш¹⁵, дэлгэцээр шуугиан дэгдэх ч бас л биш юм. Харин үүрэг, хариуцлага, үр дүн, цуцалтгүй хичээл, зүтгэл бол мөнөөсөө мөн. Өмгөөлөл бол өмгөөлөгчөө процесстой нь багтаасан суурь ухагдахуун билээ. Өмгөөлөл нь цагийн аяс, улс төрийн уур амьсгалыг дагах учиргүй. Хэрэв ийм байдал руу өмгөөлөгч халтирвал хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгүй, хуульд заасан арга хэрэгслийг бүрэн ашиглаж чадаагүй, өмгөөлөгчийн байр суурин дээр бат зогсоогүй болж хувирах болно.

Нийгэмд гүйцэтгэх үүрэг, засаглалд хамаарах шинжээр нь шүүхэд төлөөлөх эрхийн хуульчид болох өмгөөлөгч бол үйлчлүүлэгчийн төлөөлөгч. Өмгөөлөгч хүн хууль тогтоомжийг зөв ойлгож, тайлбарлаж хэрэглэх, мэргэжлийн мэдлэг, чадвар, дадлыг бүрэн эзэмшсэн, нийгэмд ямагт эерэгээр үнэлэгддэг мэргэжилтэн байх ёстай. Үүний тулд өмгөөлөгч хүн туйлын ажил хэрэгч, хичээл, зүтгэл гаргадаг, аливаа асуудалд хандахдаа хууль зүйн онол, зарчмыг удирдлага болгож, эрх зүйн болон процессын журмыг ямагт баримталж хүндэтгэн хэрэгжүүлдэг чадвартай байх хэрэгтэй. Өмгөөлөгч хүн шударга зан чанартай, хүний эрхийг ямагт хүндлэн үздэг мэдрэмжтэй байх ёстай.

II. Өмгөөлөгчийн ёс зүйн өнөөгийн төлөв байдал

Өмгөөлөгчийн ёс зүй нь хуульчийн ёс зүйн салшгүй нэг хэсэг төдийгүй өмгөөллийн үйл ажиллагааны онцлогийг илэрхийлсэн “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ээр тогтоосон тусгай шаардлагууд байдаг. Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн хангахад чиглэгдсэн баталгааг урьдчилан гаргах ёсгүй бөгөөд хууль тогтоомж хэрэглэх, тайлбарлах асуудлаар өөрийнх нь мэдлэг, хүч бололцоо хүрэхгүй байгааг мэдэрсэн нөхцөлд, биеийн эрүүл мэндийн байдал болон бусад хүндэтгэн үзэх шалтгаан гарсан үед үйлчлүүлэгчээс өмгөөллийн тавьсан хүсэлтийг хүлээн авахаас татгалзах, хэргийн материалд үндэслэн өөрийнх нь ашиг сонирхлыг хөндсөн шийдвэр гарч болзошгүй талаар үйлчлүүлэгчдээ урьдчилан мэдээллэх эрхтэй.

Өмгөөлөгч бол өндөр ёс зүйтэй мэргэжилтэн, иргэн байх ёстой. Үйлчлүүлэгчтэйгээ болон үйлчилгээ авахаар ирсэн иргэдтэй маргалддаг, тэдэнд хоосон итгэл төрүүлдэг, бодит байдлыг буруу ойлгуулдаг, хуульч гэдэг нэрээр түрий барьдаг, үйлчлүүлэгчийг өөрийн эрх ашигт ашигладаг, бусдын эрх ашиг сонирхлыг үл тоодог зэрэг ёс зүйгүй үйлдэл хуульчдад / ялангуяа сонгон шалгаруулалтгүй эрх авсан өмгөөлөгч/ цөөнгүй ажиглагддаг. “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм” эрх зүйн сайн баримт бичиг болсон боловч үүнийг мэддэг, үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог хуульч цөөхөн байна. Өмгөөлөгчийн үүргийн талаарх НҮБ-ийн 1990 оны Гавана хотын сайшаасан зарчимд өмгөөлөгчийн мэргэшил, боловсрол, хариуцлага, үйл ажиллагааны баталгааг заасан байх бөгөөд үүнээс авч үндэсний хууль тогтоомжид тусгах шаардлагатай байна. Монгол Улсад шүүгчийн, прокурорын, өмгөөлөгчийн, нотариатчийн зэрэг ёс зүйн дүрмүүд олонтаа гарч мөрдөгдөж байсан ч тэр нь ихэнхдээ өөр өөрийн системийн хуульчдаа

¹³ 3. Сүхбаатар. Хуульчдын холбооны үйл ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоо. Хуульч сэтгүүл. 2014 оны 12 дугаар сар №01 /101/.28 дахь тал.

¹⁴ ХБНГУ-ын өмгөөлөгчийн тухай хуулийн 2 дугаар зүйл.

¹⁵ ОХУ-ын өмгөөллийн үйл ажиллагаа, өмгөөллийн байгууллагын тухай хуулийн 1 дүгээр зүйл.

хамгаалахад чиглэж, хуульчдаа ёс зүйн хувьд өөрчлөх үүргээ гүйцэтгэж чадаагүй.

Шүүх эрх мэдлийн хүрээнд хамгийн олон тоотой өмгөөлөгчид “бүхнийг мэдэгч”, “чадагч”, “залилангийн өмгөөлөгч” мэтээр ямар ч ялгаа, зэргэмжгүй байдал шүүх эрх мэдлийн хэрэгжилтэд ч хуульчийн нэр хүнд, үнүү цэнэд сөргөөр нөлөөлж байгааг зөвшөөрөхөд буруудах зүйл байхгүй.

Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүй бол өөрөө эрхэм дээд үнэт зүйл юм. Учир нь хуульч иргэний харилцаанд оролцож байгаа бол ёс суртахуны нийтлэг хэм хэмжээг сахих ёстай. Өмгөөлөгчийн хувьд ажиллаа гүйцэтгэж байгаа бол мэргэжлийн ёс зүйн шаардлагыг баримтлах учиртай. Хамгийн өндөр соёл, ёс суртахуун, зан суртахуун, төлөвшил, хандлага, харилцааг эзэмшсэн хүн өмгөөлөгч байх ёстай билээ. Ийм болохын тулд бид хэн бэ? гэдэг дээр өмгөөлөгчид өөртөө дүгнэлт өгч, бусдын шүүмжлэлийг найрсаар хүлээн авч, цаг тухайд засаж, алдаан дээрээ суралцаж, хөгжих нийгмийн шаардлага буй болжээ. Энэ нь хуульч мэргэжлийн нэр хүндийг өндөрт өргөж явах, тэрхүү мэргэжлээр иргэд бахархах, тийм мэргэжилтэй болохыг залуус хүсэн тэмүүлдэг болтол нь уг салбарынхан үлгэр жишигчээр ажиллах хэрэгтэй. Энд хүн ганцхан харилцаан дээрээ алддаг гэдгийг өмгөөлөгчид мэдрч ажиллах нь чухал байна.

Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд өмгөөлөгчийн мэргэжлийн үүрэг, хүлээх харилцааг дээшлүүлэх, нийгмийн хэрэгцээ, шаардлага, өмгөөлөл, хууль зүйн туслалцааны үр нөлөө, үйлчилгээний чанар, Монголын Өмгөөлөгчдийн үйл ажиллагаанд тавигдах шалгуур үзүүлэлтийг тогтоож, өмгөөлөгч, үйлчлүүлэгчийн зохистой харилцааг хангах нь тус улсын Үндсэн хуульд заасан “... хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хууль дээдлэх, өмгөөлөл, хууль зүйн мэргэжлийн туслалцаа хүсэгч хэн бүхэн өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох” баталгааг бэхжүүлэх үндэс болохынх нь хувьд тус улсад өрнөсөн ардчилал, хүний эрхийг хамгаалах, төрөөс хэрэгжүүлж буй эрх

зүйн шинэтгэлийн бодлого, хүний эрхийн олон улсын шинэ ололт, чиг хандлага, хууль зүйн шинжлэх ухаан, эрх зүйн орчин цагийн хөгжилтэй уялдуулан мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах стандартыг тогтоон мөрдүүлэх шаардлагатай байна. Өмгөөлөгчөөс аливаа этгээдэд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхдээ Монгол Улсын хууль, олон улсын гэрээ, хууль тогтоомжийн бусад акт, өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахин биелүүлж, үйлчилгээний чанар, харилцааны соёлыг дээдлэн өмгөөлөгчийн нийгмийн өмнө хүлээх мэргэжлийн хариуцлагыг дээшлүүлэх нэн чухал байна.

Өмгөөлөгчид тавигдах мэргэжлийн болон ёс зүйн, ажил хэргийн шалгууруудын хувьд өнөөдөр мөрдөгдөх буй хууль тогтоомжийг авч үзэхэд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өмгөөлөгчдийн үйл ажиллагааны зарчим, үүрэг, үйл ажиллагаанд нь хориглох зүйлийг тусгасан боловч мэргэжил, ёс зүйн шалгуурыг тусгагүй байна. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5, 6 дугаар зүйлд заасан өрөнхий үүрэг, зарчмыг хадгалахын зэрэгцээ дээр дурдсан төрөл, тавигдах мэргэжил, чадвар, ёс зүйн шалгуур шаардлагыг хуулиар тогтоо шаардлагатай.

Хүснэгт 1: Өмгөөллийн ёс зүйн асуудлыг зохицуулж буй хууль, дүрслийг хүснэгтээр харуулахад:

Байгууллага	Анхны дүрэм батлагдан он	Одоо үйлчилж буй хууль, дүрэм
Өмгөөллийн байгууллага	1994 оны Өмгөөллийн тухай хуулийн 13.1.1. 2002 оны Өмгөөллийн тухай хуулийн 12.3.1-д өмгөөлөгч хуульчийн ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдхийг үүрэг болгосон байх ба залгэр хуулиудад өмгөөлөгчийн болон хуульчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд сахилгын арга хэмжээ оногдуулахад заасан 1994, 2002 онд Өмгөөлөгчийн ёс зүйн дүрэм батлагдан хэрэгжиж байсан.	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль боловч холбогдох бусад хууль. Олон улсын гэрээ. Хуульчийн мэргэжлийн дүрэм

Хүснэгтээс хараад Өмгөөлөгчдийн ёс зүйн дүрэм нь 1994, 2002 оны Өмгөөллийн хуулийн дагуу батлагдан хэрэгжиж байснаас гадна Монголын

Өмгөөлөгчдийн Холбоо байгуулагдсан үеэс Өмгөөлөгчдийн мэргэжлийн ёс зүйн дүрэм батлагдан хэрэгжиж байжээ. Харин одоогийн байдлаар хуульчдын ёс зүйн нь Монгол Улсын “Хуульчийн эрх зүйн байдлын тухай” хууль, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмээр зохицуулагдаж байна.

Өмгөөлөгчийн мэргэжлийн мөн чанар, хэрэгцээ шаардлагын талаар академич С.Нарангэрэл “…би энэ мэргэжлийг эмчийн мэргэжилтэй жиших их дуртай. Яагаад гэвэл эмч хүн бол өвчтөнд мэргэжлийн туслалцаа үзүүлэх ёстай. Эмч өөрөө л хэвтэргт орчихоогүйгээс бусад тохиолдолд мэргэжлийн яаралтай тусламж үзүүлж байх ёстай. Тэрүүгээрээ эмч бол их энэрэнгүй, хүний төлөө гэсэн мэргэжил. Яг түүнтэй адил өмгөөлөгчийн мэргэжил бол яг хоолойн дээр хутга тулгасан юм шиг хууль зүйн маш нарийн асуудал тохиолдолд учраа олохгүй хүнд байдалд орсон хүмүүст мэргэжлийн туслалцаа үзүүлдэг ажил үйлс. Өмгөөлөгч хүн гэрээт тал буюу үйлчлүүлэгчийнхээ хууль ёсны төлөөлөгч байж итгэлцлийн үндсэн дээр эрх ашгийг нь хамгаалж байгаа гэдгийг ямагт санаж, энэ зорилгоо биелүүлэхийн тулд үнэн сэтгэл гарган уйгагүй хөөцөлдөх, туштай ажиллах шаардлагатай. Хэдийгээр нэг талын эрх ашгийг өмгөөлдөг ч гэсэн 2 талын аль алинд хүндэтгэлтэй хандах ёстай. Өмгөөлүүлж, төлөөлүүлж байгаа талынхаа эрх ашгийг хамгаалж, түүний хууль ёсыг илэрхий зөрчиж, нэгэнт тодорхой болсон хэргийг зөвтгөх гэж учир утгагүй маргалдаж, улайран тэмцэх нь зохисгүй. Айхан шатны шүүхээр хэрэг шийдвэрлэгдсэний дараа ч өмгөөллийн үүрэг дуусгавар болдоггүйг санах хэрэгтэй.

Өмгөөлөгч хүмүүст маш өндөр ёс зүйн стандарт тавьдаг. Өмгөөлөгч хэрвээ ёс зүйн стандарттаа зөрчвөл тохирох хариуцлагыг зайлшгүй хүлээлгэдэг, хараат бус хөндлөнгийн тогтолцоо Хуульчдын холбоонд ажиллаж эхлэсэн. Монголын хуульч нар өндөр хариуцлагатай байх механизмын суурь тавигдсан. 2013 онд Хуульчдын холбооны анхдугаар их хурал

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм (“Хуульчийн мэргэжлийн дүрэм”) гэдэг нэртгий дүрмийг баталж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, хэм хэмжээг олон улсын жишигт хүргэж тогтоосон юм. Мэргэжлийн үйл ажиллагааны стандарт нь хуульчийн мэргэжлийн ажил хийж байхад төдийгүй хувийн амьдралд нь үйлчилнэ, мөн энэ хоёроос бусад хүрээнд хүрч үйлчилнэ. Жишээлбэл, өмгөөлөгч хүн үйлчилгээ үзүүлнэ гэж мөнгө авчихаад шүүх хуралд нь очихгүй, хэргийг нь ч уншихгүй, ямар ч үйлчилгээ үзүүлэхгүй байвал мэргэжлийн хүрээнд гарсан зөрчил болно.

Одоогийн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн өмгөөлөгчид хаалттай эсхүл нээлттэй сануулах, шүүхэд төлөөлөх эрхийг хугацаатай эсхүл хугацаагүй түдгэлзүүлэх, хуульчийн зөвшөөрлийг хугацаатай эсхүл хугацаагүй хүчинтгүй болгох гэсэн найман төрлийн шийтгэлээс ногдуулдаг. Өмгөөлөгчийн гаргасан зөрчлөөс нь хөнгөрүүлэх болон хүндруүлэх нөхцөлийг нь харгалzan тохирсон шийтгэл ногдуулдаг. Жишээлбэл, шинээр өмгөөлөгч болсон хүн анх удаа мэдлэг, туршлага дутсанаасаа болоод хөнгөн хэлбэрийн зөрчил гаргасан байвал хаалттай сануулах шийтгэл ногдуулж болно. Хаалттай сануулах нь тухайн хүнд өөрт нь “дахин ийм зөрчил гаргуузай” гэж өгсөн анхааруулга юм.

Өмгөөлөгчдийг хэлмэгдүүлж, буруугүй байхад нь хариуцлага хүлээлгэж болохгүй боловч ёс зүйн зөрчил гаргасан хуульчид заавал хариуцлага хүлээлгэдэг байх ёстай. 2014-2017 онд хуульчидтай холбоотой маргааныг шийдсэн статистикийг харахад, 791 гомдол хүлээж авснаас 751 өмгөөлөгчтэй холбоотой гомдол иржээ. Үнээс 52 өмгөөлөгчид сахилгын шийтгэл ногдуулжээ. Тодруулбал, 31 өмгөөлөгчид хаалттай сануулах, 12 өмгөөлөгчид нээлттэй сануулах, хоёр өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг

хугацаагүйгээр, 4 өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг хугацаатай түдгэлзүүлэх, нэг хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, нэг хуульчийн зөвшөөрлийг хугацаатай, нэг хуульчийн зөвшөөрлийг хугацаагүй хүчингүй болгох шийтгэл ногдуулжээ. Энэ тооноос харахад Мэргэжлийн хариуцлагын хороо өмгөөлөгчид хариуцлага тооцож байна. Тухайлбал, мөнгө авчхаад ямар ч хууль зүйн туслалцаа үзүүлээгүй, үйлчлүүлэгчээ хэл амаар доромжилсон өмгөөлөгчийг шийтгэснийг хараат бус байдалд нь халдсан гэх боломжгүй юм.

Мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд хуульчдын ёс зүйн асуудлаар гомдол гарч, ёс зүйн хариуцлага хүлээсэн өмгөөлөгчид барагүй байгаа нь анхаарал татаж байна. Монгол Улсын Дээд Шүүхийн Эруүгийн хэргийн хяналтын шатнаас анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр хүчингүй болох, зарим хэрэг нь хэрэгсэхгүй болох явдал ганц нэгээр тогтохгүй байгаа нь хуульчдын мэргэжлийн болон ёс зүйн мэдлэг, чадвар их дорой байгаагийн илрэл бөгөөд өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завшуулах, хэт мөнгөний төлөө хөөцөлдөх, мэдлэг, чадвар муутай байх гэх мэт хуульчийн ёс зүйн зөрчил гаргадаг, хуульчийн мэргэжлийн ур чадвар муутай өмгөөлөгч нэлээдгүй байгаа билээ.

Хүснэгт 2: Өмгөөлөгчид ногдуулсан сахилгын шийтгэлийн тоо, төрөл (2014-2018)¹⁶

Он	Бүгд хуулийн тоо	Хүлээн авсан гомдол	Маргаан, хэрэгүүсээн	Сахилгын шийтгэлийн ногдуулсан тоо													
				Хариуцлагын сангуулсан		Нээлтийг сангуулсан		Шүүгч төвлөвөх эрхийн хувьтайг түдгэлзүүлэх		Шүүгч төвлөвөх эрхийн 3 сарын түдгэлзүүлэх		Шүүгч төвлөвөх эрхийн 6 сарын түдгэлзүүлэх		Худалдааны эөнөхөрний 2 жилийн түхтээр		Худалдааны эөнөхөрний хувьтайг түдгэлзүүлэх	
2014	205	326	170	31	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
2015	229	284	199	95	10	2	-	-	-	1	1	1	1	1	1	16	
2016	250	376	216	97	14	7	1	-	-	-	-	-	-	-	-	23	
2017	249	378	206	94	5	3	1	1	-	-	-	-	-	-	-	11	
2018	182	342	179	103	8	5	-	1	-	-	-	-	-	-	-	15	
Дун	1115	909	970	420	37	17	2	2	4	1	1	1	1	1	1	65	

¹⁶ Мэргэжлийн хариуцлагын хорооны тайлан, 2014-2019 оны 1 дүгээр улирлын байдлаар.

Мэргэжлийн хариуцлагын хорооны 2014-2018 онд хуульчидтай холбоотой маргааныг шийдсэн статистик (Хүснэгт 2)-ийг харахад, 1115 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 909 нь өмгөөлөгчид гомдол, мэдээлэлд марган үүсгэжээ. Үүнээс 65 өмгөөлөгчид сахилгын шийтгэл ногдуулжээ. Тодруулбал, 37 өмгөөлөгчид хаалттай сануулах, 17 өмгөөлөгчид нээлттэй сануулах, 2 өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг хугацаагүйгээр, б өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг хугацаатай түдгэлзүүлэх, нэг өмгөөлөгчийн зөвшөөрлийг 6 сараар түдгэлзүүлэх, нэг өмгөөлөгчийн зөвшөөрлийг 2 жилийн хугацаатай, нэг өмгөөлөгчийн зөвшөөрлийг хугацаагүй хүчингүй болгох шийтгэл тус тус ногдуулжээ. Энэ тооноос харахад Мэргэжлийн хариуцлагын хороо өмгөөлөгчид хариуцлага тооцож чадаж байна.

Орчин үеийн нийгэм бол үйлчилгээний технологитой нийгэм болсон тул өмгөөлөгчид иргэдэд үйлчилхэд ёс суртахууны онолын мэдлэг, практик, мэдрэмж, харилцаа, хандлагaa шинэчлэх, нийгмийн шинэ хэрэгцээ шаардлагаа тавигдаж байна. EQ буюу харилцааны өндөр мэдрэмжтэй өмгөөлөгчид байх нэн шаардлагатай ур чадварын нэг болood байна. Технологийн дэвшил хичнээн их нэвтэрсэн ч IQ болон EQ өндөртэй тэрүүлэх зэргийн өмгөөлөгчид хэээд эрэлттэй хэвээр байх юм. Ирээдүйн өмгөөлөгчид өгөгдөл, мэдээллийг харилцагчид тайлбарлан ойлгуулах, түүнд тулгарсан асуудлыг мэргэжлийн зүгээс үнэлэн шийдэл гаргагч «итгэл даах зөвлөх»-ийн чиг үүрэгтэй болж байна.

ХБНГУ-д өмгөөлөгч нь дадлагажигч өмгөөлөгч, өмгөөлөгч, муж улсын шүүхэд оролцох өмгөөлөгч, Холбооны дээд шүүхэд оролцох өмгөөлөгч гэсэн 4 зэрэмжтэй байдаг. Англи улсад анхан шатанд оролцдог барристууд, давах, хяналтын шатны шүүх хуралдаанд оролцдог солиструуд, Францад өмгөөлөгчид 3 зэрэмжтэй байдаг зэргийг судлах шаардлагатай байна. Өмгөөлөгч нэртэй бүхэн давах, хяналтын шүүхэд очоод

хуульч бүр ойлгох, хаана ямар асуудлаар орж ирснийг нь тааварлахад ойлогомжгүй яриад зогсож байдаг явдал түгээмэл болж байгааг цэглэх, Өмгөөллийн хуулийг шинэчлэх, МӨХ нь зөвхөн өмгөөлөгчдөө тэдний давтан сургалтад дэмжлэг үзүүлдэг, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах зэргээр үйлчилдэг, тэдний эрх ашигийг хамгаалдаг ТББ-ын статустай субъект байх, МХХ-д Өмгөөллийн хороо идэвхтэй ажилладаг байх, хариуцлага нь Мэргэжлийн хариуцлагын хороондоо хамаарах, өмгөөлөгчийн төлөөлөх эрхийг хэт задгай тавьсныг эргэж харж цэглэх нь хүртээмжтэй өмгөөлөгч болох өмгөөлөгчийн үнэ цэнийг өстөхөд эерэгээр нөлөөлнө.

III. Олон улсын туршлага

Гадаад орнуудад тухайн мэргэжлийн хүний буюу өмгөөлөгчийн хийдэг ажлын нэгээхэн хэлбэрээр хуулиа нэрлээгүй байдаг. Тухайлбал: БНХАУ-д Хуульчийн тухай хууль, Япон улсад өмгөөлөгчийн тухай хууль, Тайваньд хуульчийн тухай хууль, Европын Холбооны улсад Европын өмгөөлөгчийн тухай хууль, ХБНГУ-д өмгөөлөгчийн тухай хууль, ОХУ-д өмгөөллийн үйл ажиллагаа, өмгөөллийн байгууллагын тухай хууль, БНСУ-д өмгөөлөгчийн тухай хууль, Сингапур Улсад хуульчийн мэргэжлийн тухай хууль гэх зэрэгээр томьёолсон байна.

Олон улсад өмгөөлөгчийн хариуцлагын асуудлыг зөвхөн өмгөөлөгчид нь хариуцуулахаас татгалзаж байгаа. Жишээлбэл, Германд өмгөөлөгчийн ёс зүйн асуудлыг шийддэг тусдаа сахилгын шүүх ажилладаг. Түүнээс биш дан өмгөөлөгчөөс бүрдсэн холбоонд өмгөөлөгчийн хариуцлагын асуудлыг өгдөггүй. Өмгөөлөгч нь олонх биш бүрэлдэхүүнээр шийддэг газрууд ч бий. Америкийн Флорида мужид өмгөөлөгчийн хариуцлагын асуудлыг ердийн шүүх шийддэг. Калифорни, Колорадод сахилгын шүүх шийддэг. Дани Улсад гурван шүүгч, 9 өмгөөлөгч, б иргэн орсон бүрэлдэхүүн шийдэг. Эстон, Шведэд ч гэсэн хуулийн

профессор, иргэдийг оролцуулсан холимог бүрэлдэхүүн өмгөөлөгчийн асуудлыг шийдээд байгаа юм.

АНУ-ын хувьд Барын холбооныхоо дэргэд хуульчдын мэргэшлийн чиглэлийг тогтоох, мэргэшсэн хуульчийн гэрчилгээ олгох үндсэн үүрэг бүхий Мэргэшлийн асуудал эрхэлсэн байнгын хороо (Standing Committee on Specialization) байгуулсан байна. Тус мэргэшлийн хороо нь хууль зүйн мэргэшлийн үндсэн зорилгыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд: 1. Олон нийтэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх /Хүртээмжтэй байх/ 2. Хууль зүйн үйлчилгээний чанарыг сайжруулах /Чадвартай байх/ 3. Үйлчлүүлэгчид үзүүлж буй хууль зүйн үйлчилгээний өргтийг бууруулах /Үнэ, өртөг/

IV. ДҮГНЭЛТ

Өмгөөлөгч нь иргэний нийгмийг хамгаалдаг, олон нийтийн итгэлийг хүлээдэг мэргэжилтэн тул үйл ажиллагаа нь шударга байх шаардлага эртнээс тавигдсаар ирсэн байна. Өмгөөлөгчийн мэргэжлийн ажил буюу өмгөөллийн үйл ажиллагааны хүний эрх, эрх чөлөөг хамгаалах эрхэм зорилго бүхий, хууль болон ёс суртахуунд сууриссан, хүн чанар, мэдрэмж, зохион байгуулалт, цуцалтгүй хөдөлмөрийг шаардах либерал мэргэжлийн үйл ажиллагаа юм. Иймд өмгөөллийн үйл ажиллагаа нь нийтийн байх бөгөөд ашиг орлого олохын төлөөх гагцхүү зорилго чиглэлтэй үйл ажиллагаа биш бөгөөд өмгөөллийн чанар, үр нөлөөг дээшлүүлэх, мэргэшсэн өмгөөлөгчийг төрүүлэх, тухайн салбарыг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулдаг болохыг анхаарах нь зүйтэй. Өмгөөлөгчийн ёс зүй, түүний үнэт зүйл нь хууль зүйн практикт зөрчигдэх явдал нь хэвийн үзэгдэл болж, өдөр тутмын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдэх байгаа нь өмгөөлөгчийн үйлчилгээний соёл дутмаг, өмгөөлөгчийн ёс зүйн тулгамдаж буй асуудал болсон байна. Өмгөөлөгчийн ёс зүйн болон мэргэжлийн хариуцлагыг өндөржүүлж, хариуцлага

хүлээлгэх эрх зүйн орчинг сайжруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

V. САНАЛ

- Өмгөөлөгчид тавигдах мэргэжлийн болон ёс зүйн ажил хэргийн шалгуур үзүүлэлтийг зохих хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хуульч сонгон шалгаруулах шалгалтын босго, шалгуур үнэлэмжийг өндөр болгох

- Өмгөөлөгчөөр ажиллах эрх олгох, сонгон шалгаруулалтын арга хэлбэр, шалгуур босго, үнэлгээг нарийвчлах, өмгөөлөгчдийг дахин сонгон шалгаруулж эрх олгох

- Өмгөөлөгчийн үйлчилгээний стандартыг баталж мөрдүүлэх

1. Монгол эх сурвалж

1. Моригива Ясугомо.Хуульчийн ёс зүй. Уб., 2006 он.

2. УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, ТАЗ, Шихихутг хууль зүйн дээд сургууль. Төрийн албаны соёл: шударга ёс, ил тод байдал, ёс зүй, Уб., 2010 он.

3. Хууль зүйн яам. Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл. Хуульчийн ёс зүй. Уб., 2013 он.

4. С.Нарангэрэл. Зохиомол гэмт хэрэг буюу Н.Энхбаярын өмгөөлөгчийн тэмдэглэл.Уб.,2012 он.

5. Вибеке Норгард, Мартин болон Маттев Фредрих. Хуулийн сургуульд сурсан 101 зүйл.Уб., 2019 он.

6. “Монгол өмгөөлөгч хууль зүйн фирм. Өмгөөлөл судлалын академи. Гадаад орнуудын өмгөөлөгчийн тухай хууль I.Уб., 2017 он.

7. Кейт Эванс. Өмгөөллийн алтан дүрэм.Уб., 2017 он.

8. Т.Сэнгэдорж. Хуульч мэргэжил ёс зүйн асуудал.Уб., 2010 он.

9. З.Сүхбаатар, П.Оюундэлгэр. Монгол Улсын өмгөөллийн хууль, дүрэм (1924-2013).Уб., 2014 он.

10.Ц.Гүрсэд. Монгол Ард Улсын Цааз хууль, шүүх таслах газруудын байдлыг товчилсон дэвтэр.Уб., 1928 он.

11.Т.Сэнгэдорж, С.Энхмэнд, С.Энхсаруул. Дэлхийн ба Монголын хуульчид эрх зүй ёс зүй. Уб., 2014 он.

12.С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. Уб.,2001 он.

13. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэг

14.С.Нарангэрэл, Н.Лүндэндорж. Эрх зүй судлалын удиртгал.Уб., 2002 он.

15. Т.Сэнгэдорж. Хуульч мэргэжил. Уб., 2003 он.

16.Д.Тогтохжаргал. Төрийн хүн / намтар, дурсамж/. Уб., 2011 он.

17.З.Сүхбаатар. Хуульчдын холбооны үйл ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоо. Хуульч сэтгүүл. 2014 оны 12 дугаар сар. № 01 (01)

18. ХБНГУ-ын Өмгөөлөгчийн тухай хуулийн 2 дугаар зүйл.

19.ОХУ-ын өмгөөллийн үйл ажиллагаа, өмгөөллийн байгууллагын тухай хуулийн 1 дүгээр зүйл.

20.Мэргэжлийн хариуцлагын хорооны тайлан, 2014-2019 оны 1 дүгээр улирлын байдлаар.

2. Гадаад эх сурвалж

21.Произведения г-на, Рассуждения о независимости адвоката, 1, стр.3

22. Лоуренс Фридмэн. Введение в Американское право.М.,1993.”Универс”, “Прогресс”.С.203

3. Бусад эх сурвалж

23. www.mglbar.mn

24. www.advocate.mn

---00o---

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ЭРХ ЗҮЙТ ЁС

(Environmental rule of law ойлголтын танилцуулга)



Хуульч R.Мөнхзүл

Эрх зүйн түүхэнд гарсан томоохон ололт амжилт болох Rule of law¹ буюу эрх зүйт ёсны үзэл улам бүр өргөжин тэлж хөгжиж байна. Үүний нэг томоохон жишээ бол Environmental rule of law буюу Хүрээлэн буй орчны эрх зүйт ёс гэсэн ойлголт юм. Энэхүү ойлголт нь үндсэндээ 2013 оноос тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх арга зүйн хүрээнд хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд шинэ тутам хөгжиж байгаа цаашидaa rule of law-с салбарлан боловсруулагдсан суурь шинжтэй хууль зүйн ойлголт болох төлөвтэй байна. Иймд энэхүү танилцуулгаар environmental rule of law ойлголтын үүсэл, агуулга, зорилго, ач холбогдолын талаар мэдээлэл өгөхөөр энэхүү танилцуулгыг боловсрууллаа.

Анхлан 1968 онд Швед Улсаас НҮБ-ын Эдийн засаг Нийгмийн зөвлөлд хандан цаашид хүн төрөлхтөн байгаль орчинд хэрхэн хандах ёстой вэ гэсэн үндсэн асуудлаар НҮБ-ын бага хурал зохион байгуулах саналыг гаргасан. НҮБ-аас энэхүү санаачлагыг дэмжин 1972 оны 6 дугаар сарын 5-16-ны өдрүүдэд хуралдан Хүний хүрээлэн буй орчин хуралдаанаас Тунхаг бичиг батлан гаргасан ба гол үзэл

санаа нь хүний хүрээлэн буй орчныг хадгалж хамгаалах, улам бүр сайжруулахын тулд энэ асуудалд хүн төрөлхтөний анхаарлыг хандуулах, сэдэлжүүлэх үүний тулд нийтлэг зарчим, хэтийн төлөв байдлыг тодорхойлох шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрсөн. Ийнхүү Шведийн Стоколомын тунхагаас хойш улс орнууд дор бүрнээ байгаль орчныг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага байгуулах, хууль тогтоомж батлан гаргах явдал идэвхтэй өрнөсөн.

Судалгаанд дурдсанаар 2017² оны байдлаар дэлхийн 176 улс орон байгаль орчны хууль тогтоомжтой болсон, 187 оронд байгаль орчинд нөлөө үзүүлж болохуйц төсөл, хөтөлбөрт байгаль орчны үнэлгээ хийхэд дагаж мөрдөх эрх зүйн арга хэрэгслийг тогтоож өгсөн, нийт улс орнуудын бараг тал нь байгаль орчны тодорхой асуудлаар мэдээлэл авах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх хууль зүйн баталгааг хангасан, 1970 оноос хойш 88 улс орон эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг Үндсэн хуулиараа баталгаажуулсан, нэмж 62 орон хүрээлэн буй орчны хамгааллын асуудлыг ямар нэг хэлбэрээр Үндсэн хуульдаа оруулж өгсөн, нийтдээ 150 орчим улс орон хүрээлэн буй орчны асуудлаар эрхийн болоод үндсэн суурь нөхцөлийг Үндсэн хуулиараа зохицуулж өгсөн. Мөн түүнчлэн 2017 оны байдлаар 164 улс байгаль орчны асуудал эрхэлсэн салбарын яамдтай, 22 улс салбарын яамгүй ч асуудал эрхэлсэн нэгжтэй, 7 улсын хувьд байгаль орчны асуудлыг бусад асуудлын хамт хавсрага шинжтэй хариуцдаг бүтэцтэй болжээ.

Стоколомын 1972 оны Тунхагаас хойш ийнхүү дэлхийн улс орнууд хүрээлэн буй орчныг хамгаалах, тогтвортой байдлыг хангах, сайжруулахад чиглэсэн хууль

¹ Rule of law ойлголтыг эрх зүйт төр, эрх зүйт ёс, хууль дээдлэх ёс, эрх зүйд захирагдах ёс хэмээн орчуулж байгаа бөгөөд энд эрх зүйт ёс орчуулгыг хэрэглэв.

² UNEnvironment., Environmental rule of law-first global report., 2019 он.

тогтоомж батлан гаргаж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын бүтэц, нэгжийг байгуулсан байна. Гэсэн хэдий боловч хүрээлэн буй орчны шийдвэрлэвэл зохих хэд хэдэн чухал асуудлууд байгаа бөгөөд НҮБ-ын зүгээс гол шийдлийг Хүрээлэн буй орчны эрх зүйт ёс гэж үздэг байна. Эдгээрийг тоймлон дурдвал,

Нэг, дийлэнх улс орнууд байгаль орчны асуудал эрхэлсэн бүтэцтэй, хангалттай хууль тогтоомж баталсан боловч тэдгээрийн хэрэгжилт, биелэлт, үр нөлөөтэй байх, хуулийг нэг мөр ойлгох байдал нэн хангалтгүй байна гэж үздэг. Олон улсын хүрээлэн буй орчны төлөв байдлын 5 дахь илтгэл³ байгаль орчинтой холбоотой хамгийн чухал, нэн тэргүүний гэж үзсэн 90 зорилго, зорилтоос ердөө 4 нь л биелэгдсэн гэж дүгнэсэн. Энэхүү илтгэл нь НҮБ-ын хувьд байгаль орчны асуудлын явц байдлыг үнэлж, хэмжиж байдаг гол чиг шугам, аргачлал нь юм. Батлан гаргасан хууль тогтоомж нь орон нутгийн онцлог, нөхцөл байдалд тохироогүй, үйл ажиллагаа явуулах эрх, зөвшөөрөл олгох үйл явц тодорхой биш, стандартууд ойлгомжгүй, үр дүнг тодорхойлох боломжгүй гэх мэт дутагдууд байна гэж үзсэн.

Хоёр, хөрсний доройтол, агаар усны бохирдол, усны хомсдол, биологийн төрөл зүйлийн алдагдал, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг үзэгдлүүд улам бүр нэмэгдэж байгаа нь байгаль орчин доройтох, амьжиргааны түвшин буурах, баялагийн тэгш бус хуваарилалт улам гаарах, ядуурал, нийгмийн тэгш бус байдал даамжирхад шууд нөлөөлж, эцэстээ хүчирхийллийн шинжтэй болж байна. Тухалбай, 2002-2013 оны хооронд⁴ 35 оронд 908 хүн байгаль орчин, газар, байгалийн нөөцийн маргаанаас болж амь үрэгдсэн ба харамсалтай нь энэ үзэгдэл жил ирэх тусам улам нэмэгдэж байгаа аж. Байгалийн нөөц, хүрээлэн буй орчны гэмт хэрэгтэй холбоотой зөрчил, мөргөлдөөний

гаралт мэдэгдэхүйц нэмэгдсэн⁵ ба сүүлийн 60 жилд гарсан дотоодын зөрчил мөргөлдөөний багадаа 40 хувь нь байгалийн баялагаас үүдэлтэй гэжээ.

Гурав, “Хүрээлэн буй орчны эрх зүйт ёс”-ны хамгийн том сорил бол улс төрийн тоомжиргүй байдал гэж үздэг. “Эрх зүйт ёс”-ны олон улсын судлаач Томас Кароттер⁶ хэлэхдээ “эрх зүйт ёсны гол саад тодгор бол санхүү болоод техникийн асуудал биш ерөөсөө улс төр, хүн юм” гэсэн. Хөгжиж буй ихэнхи улс орны хувьд эдийн засгийн өсөлтдөө анхаарч төсвийн ихэнх хувийг зарцуулдаг, байгаль орчны асуудал эрхэлсэн яамны хувьд эрх мэдэл багатай, ЗГ-ын төсөл хөтөлбөр гэнэт зогсдог. ХБОЭЗЁ-ны байдал хөгжиж байгаа улс оронд нэн хангалтгүй байгаа бол хөгжингүй орнуудын хувьд илүү боловсронгуй өргөн хүрээтэй хууль тогтоомж баталсан ч хэрэгжилт мөн л хангалтгүй байна гэж үзсэн. Европын комиссоос тишүүн орнуудын байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийн дүгнэлтийг хоёр жилд нэг удаа гаргадаг бөгөөд 2017 оны дүгнэлтэд⁷ дурдсанаар хог хаягдлын менежмент, байгалийн болон биологийн төрөл зүйл, агаарын чанар, дуу чимээ, усны чанар гэсэн асуудал болоод эдгээрийн менежментийн хооронд хэрэгжилтийн зөрүү их гарч байна. Ялангуяа гишүүн орнууд орон нутаг, бүс нутаг, төрийн эрх бүхий байгууллагын үр нөлөөгүй хамтын ажиллагаанаас болж хохирол хүлээж байгаа нь төрийн захиргааны чадавхи сүл, санхүүжилт бага, мэдээллийн сан хомс, салбарын мэдлэг дутмаг, зохистой байдлыг хангах баталгаа сүл, бодлогын болоод оролцооны уялдаа холбоо дульмаг байгаатай холбоотой гэжээ. Олон улсын хандив тусламж, санхүүжилт, төсөл хөтөлбөр нь зэрлэг байгалийг хамгаалах,

⁵ https://www.unenvironment.org/explore-topics/environmental-rights-and-governance/what-we-do/promoting-environmental-rule-law_0

⁶ Carothers, Thomas. 1998. “The rule of Law revival.” Foreign Affairs (March/April)

⁷ European Commission 2017. The EU Environment Implementation Review (EIR) Package; Common Challenge and How to Combine Efforts to Deliver Better Results. http://ec.europa.eu/environment/eir/pdf/full_report_en.pdf

³ UNEP 2012 b.GEO5;Global Environment Outlook. Nairobi, Kenya.

⁴ Global Witness 2014. Deadly Environment; The dramatic Rise in Killings of Environmental and Land Defenders. London .

цааг уурын өөрчлөлттэй дасан зохицох гэм мэт асуудалд голчлон анхаараад байгаль орчны асуудал хариуцсан ЗГ-ын бүтцийг сайжруулах, хүний нөөц, шүүгчдийг чадавхижуулах, тэдний мэдлэгийг дээшлүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах зэрэг асуудалд төдийлөн чиглэхгүй байна гэж шүүмжилдэг. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөгөөр байгаль орчны хууль тогтоомж нь нийгмийн суурь шинжтэй шийдэл, хүчин зүйл болж чадахгүйн дээр ерөөс соёл болж төлөвшигүй байна гэж үздэг.

Дөрөв, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарлах, боогдуулах үйл явц улам бүр нэмэгдэж байна. Хүрээлэн буй орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгахад иргэний нийгэм гол үүрэг гүйцэтгэдэг. Гэсэн хэдий боловч сүүлийн 20-иод жилд иргэний нийгмийн оролцоо, санхүүжилтад хууль зүйн хязгаарлалт тавих явдал улам нэмэгдсэн⁸. Тухайлбал, зарим улс оронд иргэний нийгмийн байгууллагуудыг нийтийн эрх ашгийг төлөөлүүлэхгүйээр, зөвхөн төрийн хяналтын дор шийдвэр гаргах ажиллагаанд оролцуулдаг бол зарим улс орны хувьд иргэний нийгмийн байгууллагуудыг гадаад эх үүсвэрээс санхүүжихийг хориглохын дээр гадаадын иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаанд нь хязгаарлалт тогтоодог байна. Сүүлийн жилүүдэд хүрээлэн буй орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудыг хянах, үлажиллагааг нь хязгаарлах, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоох явдал Хятад, Орос, Вьетнам, Камбож зэрэг⁹ улсад нийтлэг байгаагийн дээр өөр бусад улс орнууд ч ийм хандлагатай байна.

Хүрээлэн буй орчны эрх зүйт ёс ойлголтыг хөгжүүлэхэд хамгийн өндөр ач холбогдол өгч, хариуцан зохион байгуулж буй байгууллага бол НҮБ юм. НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөр хариуцсан

байгууллагаас 2013 онд хамгийн анх удаа хүрээлэн буй орчны тогтвортой байдлын хууль, засаглал, зүй ёсны байдлыг сайжруулах тухай 27/9 дугаартай шийдвэр гаргасан бөгөөд энэ шийдвэрээр анх удаа Хүрээлэн буй орчны эрх зүйт ёс гэсэн нэр товьёг олон улсын баримт бичгийн хүрээнд оруулж ирсэн¹⁰. НҮБ-аас ХБОЭЁ-ын ач холбогдлыг авч үзэхдээ, тогтвортой хөгжлийн зорилтуудад амжилттай хүрэх, хүрээлэн буй орчны хууль тогтоомжийг зөрчиж буй байдлыг бууруулахын тулд хүрээлэн буй орчны салбарын асуудалд эрх зүйт ёсны гүйцэтгэх үүрэг нэн их, ерөөсөө ХБОЭЁ-гүйгээр тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх боломжгүй гэж үзсэн. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаас Аюулгүй байдлын зөвлөлд 2004 оны 08 дугаар сарын 23-нд тавьсан илтгэлд “Эрх зүйт ёс бол НҮБ-ын эрхэм зорилгын цөм болно. Энэ нь нийтэд тунхаглан зарлагдсан, бүх нийтээр дагаж мөрддөг, маргааныг бие даасан шүүхээр шийдвэрлэдэг, олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, стандартад нийцсэн хуулийн өмнө бүх иргэн, төр, хувийн хэвшлийн байгууллага, түүний дотор Төр өөрөө хариуцлага хүлээдэг байх засаглалын зарчим”, түүнчлэн эрх зүйт дээдлэх, хуулийн өмнө тэгш байх, хуулиар хариуцлага хүлээлгэх, хуулийг шударга, алагчлалгүй хэрэглэх, эрх мэдэл тусгаарлах, шийдвэр гаргахад оролцох, эрх зүйн тодорхой байдлыг хангах, дур зоргоороо авирлахаас сэргийлэх, үйл ажиллагааны болон эрх зүйн ил тод байдлыг хангах зэрэг зарчмыг мөрдлөг болгоход чиглэсэн арга хэмжээ энд мөн хамаарна” гэсэн. НҮБ-аас үзэхдээ эрх зүйт ёсны дээрх зарчим, агуулгыг хүрээлэн буй орчны асуудалд мөн адил хэрэглэх ба энэ нь хүрээлэн буй орчны засаглалыг сайжруулах гол суурь гэж үзсэн. ХБОЭЁ нь хүний суурь эрх, үүрэгтэй холбогдуулан хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангахад гол анхаарлаа хандуулдаг ба хүрээлэн буй орчны засаглалыг сайжруулах суурь нөхцөл мөн болохыг хүлээн зөвшөөрсэн.

⁸ Wong, Edward. 2016. “Clamdown in China Restricts 7000 Foreign Organizations.” New Yourk Times, Apr.28.

⁹ European Foundation Centre 2017. Why Shrinking Civil society Space Matters in International Development and Humanitarian Action. Belgium; European Foundation Centre.

¹⁰ <https://www.unenvironment.org/explore-topics/environmental-rights-and-governance/what-we-do/promoting-environmental-rule-law-0>

ХБОЭЗЁ нь нийт олны ёс суртахууны үнэт зүйлс, зан төлөвийн ёс зүйн хэм хэмжээнд нөлөөлж хүрээлэн буй орчны эрх, үүргийг хэрэгжүүлэх гол суурийг нөхцөлдүүлдэг. ХБОЭЗЁ-гүйгээр хууль ёсны эрх, үүргийг хэрэгжүүлэхгүйгээр хүрээлэн буй орчны засаглал нь хий хоосон, дур зоргын шинжтэй, тодорхой биш, ажил хэрэг болж хэрэгжих боломжгүй болно гэж үздэг.

ХБОЭЗЁ болон Хүрээлэн буй орчны засаглал нь өөр хоорондоо уялдаа холбоотой боловч зорилт, хүрээний хувьд ялгаатай¹¹. ХБОЭЗЁ нь хүрээлэн буй орчны хууль тогтоомжийг мөрдүүлэх, зохицт байдлыг хангахад чиглэнэ. Хуулийн засаглал нь хүрээлэн буй орчинтой холбоотой шийдвэр гаргалт, бодлого, хэрэгжилттэй холбоотой өргөн хүрээний зорилго, хандлагыг агуулдаг. Нэг ижил асуудалд ч агуулгын хувьд ялгаатай ханддаг. Жишээ нь ХБОЭЗЁ нь иргэдийн оролцоог хуулийн хэрэгжилтийг сайжруулах гэсэн агуулгын хүрээнд тайлбарлаж байхад Хүрээлэн буй орчны засаглал нь шийдвэр гаргалтын чанарыг сайжруулах, олон нийтийн дуу хоолойг хүргэх, иргэдийн дэмжлэгийг бий болгох, түүнчлэн хуулийг мөрдөх, зохицт байдлыг сайжруулах гэх мэт илүү өргөн агуулгаар авч үздэг.

Энэ жишгээр цаашид салбар эрх зүй бүрийн эрх зүйт ёсны тухай үзэл хандлага үүсэх үү, тухайлбал, татварын эрх зүйт ёс гэх мэт. Ийм байхыг үгүйсгэхгүй бөгөөд хүрээлэн буй орчны хувьд НҮБ-аас үзэхдээ хүрээлэн буй орчин бол хүний амьдрал, нийгэм, ерөөсөө дэлхийн ертөнцийг тэтгэж байдаг бөгөөд хүн, байгаль хоёрын хамгийн чухал уялдаа холбоог удирдан чиглүүлдэг учир суурь асуудал гэж үзсэн.

НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн Хүрээлэн буй орчны эрх зүйт ёс санаачлага нь 2013 оноос хойш НҮБ-ын хуулийн асуудал эрхэлсэн газарт харьялагдаж байна.

НҮБ-аас ХБОЭЗЁ-ын үндсэн ^{7¹²} шинжийг авч үзсэн. Үүнд:

Нэг. ХБОЭЗЁ нь хүний амьдралын эх үндэс болсон цэвэр агаар, цэвэр ус, эрүүл орчныг хангахад чиглэсэн хууль тогтоомж, түүгээр зохицуулсан стандарт, процесс, аргуудыг чанд мөрдүүлэх нь чухал болохыг онцлогдог. Түүнчлэн ой, ус, газрыг ашиглах, хүргээмжтэй байлгах, бусад хамгаалагдсан нөөцийг зохицтой ашиглахад үндсэн үүргийг гүйцэтгэх бөгөөд энэ нь эцэстээ амьжиргааг дээшлүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, хүний эрхэмсэг оршихуйг хангах нөхцөл бодлог.

Хоёр. Хамрах хүрээ, агуулга нэн өргөн. Бүхий л хууль тогтоомж, бүх түвшний засаглалын үйл явцад хамаарна. Нэг асуудал хэд хэдэн яамны эрх хэмжээнд хамаарч бодлог. Тухайлбал, уул уурхайн зохицуулалт гэхэд байгаль орчин, ус, уул уурхай, хөдөлмөр, санхүү, нийгмийн хөгжил, хууль зүйн гэх мэт асуудлыг хамаардаг эдгээр түвшин бүрт ХБОЭЗЁ-ыг баримтлахыг шаардана.

Гурав. Хүрээлэн буй орчин нь улс төр, эдийн засаг, нийгмийн гол хөдөлгөгч хүч бөгөөд ХБОЭЗЁ хэр зэрэг төлөвшсөнөөс хамаарч уул уурхайн салбар нь баялагийн хараал хүртэх үү, ард иргэд нь хохирч үлдэх үү гэдэг нь хамаардаг.

Дөрөв. Хүрээлэн буй орчны удирдлага нь хүмүүс байгаль орчин, түүний нөөцийн өмнө үүрэг хариуцлага хүлээх ёс зүйн хийгээд ёс суртахууны үүрэгтэй гэж үздэг. Байгаль эх дэлхий, түүний төрөл зүйлийн хувь заяа ХБОЭЗЁ-ны амжилтас хамааралтай. Зарим улс орнууд гол мөрөн, тусгай хамгаалалттай газар нутаг зэрэг байгалийн нөөц нь өөрөө хууль ёсны эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч эрхийн энэхүү ойлголтыг улам бүр өргөжүүлж байна.

Тав. Байгаль орчин, хүрээлэн буй орчноос хамааралгүй амьдардаг хүн гэж нэгээхэн үгүй тул эдгээртэй холбоотой гарч буй шийдвэр, хууль тогтоомжоос хүний ажил амьдрал шууд хамаардаг. Иймээс мэдээллийн хүргээмж буюу мэдээлэл хайх, олж авах эрхийг аль болох олон нийтэд нээж өгөх нь ХБОЭЗЁ-нд нэн чухал гэж үздэг.

¹¹ UNEEnvironment., Environmental rule of law-first global report., 2019 он.

¹² UNEEnvironment., Environmental rule of law-first global report., 2019 он.

Зургаа. ХБОЭЗЁ нь цаг хугацааны шалгуурыг даван туулах шаардлагатай болдог. Экосистем, байгалийн нөөцтэй холбоотой удирдлагын шийдвэр нь цаашдын алс ирээдүйд шууднөлөө үзүүлдэг. Тиймээс ХБОЭЗЁ нь үе хоорондын залгамж, энэ үеийхэн хийгээд ирээдүй хойч үеийхнийг ижил тэгш боломжоор хангах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй болдог. Түүнчлэн байгаль орчинд нөлөөлөх техник, технологи, хүний зан байдал байнга өөрчлөгддөг, хувьсамтгай шинжтэй учраас байгаль орчны хууль тогтоомж, түүнийг хариуцсан байгууллагууд мөн дасан зохицох, хувьсал өөрчлөлтөнд байх нь чухал болж байна.

Долоо. ХБОЭЗЁ нь тодорхойгүй нөхцөл байдал дахь шийдвэр гаргалтуудаас ихээхэн хамаарч байна. Одоогийн шинжлэх ухааны хувьд бүрэн дүүрэн хариулт өгч чадахгүй байгаа байгаль орчны асуудлууд бүр л нэмэгдэж байна. Нано технологи, эсхүл бусад шинэ технологийн нийтийн эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбарт үзүүлэх урт хугацааны нөлөөлөл нь ямар байх вэ, 2100 он гэхэд далайн түвшин хэр зэрэг нэмэгдсэн байх вэ, зарим төрөл зүйл устахад энэ нь урт хугацаандaa экосистемд яаж нөлөөлөх вэ гэх мэтчилэн. Иймээс ХБОЭЗЁ бол цогц, урт хугацааны мэдлэг шаардсан, шинжлэх ухаан, технологийн ололт амжилтанд сууриссан, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн асуудал, ерөөсөө хүн хийгээд байгаль дэлхийн сайн сайхан байдлын үндэс болоод байна.

Сүүлийн жилүүдэд ХБОЭЗЁ-ны ойлголт, үзэл баримтлал дэлхий нийтэд хүчтэй дэлгэрч хандлага болон хөгжиж байна. Тухайлбал, 1948 онд байгуулгасан Байгаль хамгааллын олон улсын холбоосайн дурын байгууллагаас 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр ХБОЭЗЁ-ны Тунхаг¹³ гаргасан бөгөөд үүгээр ХБОЭЗЁ бол хүн байгалийн оршин байх гол үндэс болохыг хүлээн зөвшөөрч, ХБОЭЗЁ нь хүрээлэн буй орчны зүй ёсны байдлын эрх зүйн суурь нь гэж үзсэн. ХБОЭЗЁ-ыг цогцлооход шүүгч, шүүхийн байгууллагын үүрэг оролцоо

нэн чухал болохыг онцолжсон. Тунхаг нь 4 үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд ХБОЭЗЁ-ын 13 зарчмыг баталсан. Үүнд, байгаль орчны хамгаалах зарчим, байгаль орчинд амьдрах эрх ба байгаль орчны эрх, хүрээлэн буй орчинд амьдрах эрх, экологийн тогтвортой уян хатан байх, In Dubio Pro Natura буюу эргэлзэж байвал байгаль орчинд ээлтэй талыг нь сонгох, өмч дэх экологийн чиг үүрэг, үе хоорондын тэгш байдлыг хангах, жендерийн тэгш байдлыг хангах, эмзэг бүлэг болон цөөнхийн оролцоог хангах, уугуул иргэд хийгээд овгийн эрхийг хангах, зогсолтгүй байх, үргэлж урагш тэмүүлэх зэрэг зарчмууд болно.

ХБОЭЗЁ-ын талаар судалгаа, тайлангаас дурдвал, НҮБ-аас 2019 онд Хүрээлэн буй орчны эрх зүйт ёсны илтгэлийг бэлтгэн гаргасан бөгөөд энэ нь олон улсыг хамарсан ХБОЭЗЁ-ны хамгийн анхны илтгэл юм. Агуулгын хувьд ХБОЭЗЁ-ны үзэл баримтлал, хууль зүйн агуулга, ХБОЭЗЁ-ыг хангахад хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий байгууллага, иргэдийн оролцоо, хүний болоод байгаль орчны эрхийг хэрхэн хангах, шударга ёс, шүүхийн нөлөө, шүүх эрх мэдлийн үүрэг оролцоо, ирээдүйн чиг хандлага гэсэн агуулгыг багтаасан. Түүнчлэн ХБОЭЗЁ ба Америкийн /хойд, өмнөд Америк/ нэртэй эмхэтгэлийг 2015 онд гаргасан бөгөөд Америк тив дэх улс улсаас ирүүлсэн ХБОЭЗЁ-той холбоотой шилдэг 100 баримтад өгүүллийг түүвэрлэн эмхэтгэсэн бөгөөд оролцогчдын хувьд шүүгч, прокурор, өмгөөлөгч, судлаач, гүйцэтгэх, хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын мэргэжилтнүүд, судлаач гэх мэт өргөн хүрээг хамарсан байdag. Агуулгын хувьд усны нөөцийн менежментийн эрх зүйн хүрээ, зохицуулалт, худалдаа, хөрөнгө оруулалт ба хүрээлэн буй орчин, хуваарилагдсан байгалийн нөөцийн менежмент, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, хүрээлэн буй орчны хууль тогтоомжийн хэрэгжилт, эрх, үүргийн хэрэгжилт: мэдээлэл, шударга ёс, шүүхийн процессын хүргээмжтэй байдлын талаарх тухайн улс орны хийгээд олон

¹³ <https://www.iucn.org/about>

улсын хэмжээн дэх нөхцөл байдал, практик зэргийг багтаасан.

Манай улсын хувьд Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай тогтоолыг баталсан. НҮБ-аас ХБОЭЗЁ-оос хамаарч тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх эсэх нь хамаарна гэж үзэж байгаа нөхцөлд бид ХБОЭЗЁ-ыг суурь үзэл баримтлаа болгох нь зүйн хэрэг юм. Гэхдээ ХБОЭЗЁ-ны ойлголт, агуулгыг сайтар судлан ойлгох, энэ төрлийн судалгааны ажлыг өргөнөөр хийх, их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулах, Монгол Улс дахь ХБОЭЗЁ ямар түвшинд байгааг хэмжих гэх мэт ажлыг эхлүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

НОМ ЗҮЙ:

1. UNEEnvironment., Environmental rule of law-first global report., 2019.
2. www.unenvironment.org
3. UNEP 2012 b.GEO5;Global Environment Outlook. Nairobi, Kenya.
4. Global Witness 2014. Deadly

Environment; The dramatic Rise in Killings of Environmental and Land Defenders. London .

5. <https://www.unenvironment.org/explore-topics/environmental-rights-and-governance/what-we-do/promoting-environmental-rule-law-0>

6. Carothers, Thomas. 1998. "The rule of Law revival." Foreign Affairs (March/April)

7. European Commission 2017. The EU Environment Implementation Review (EIR) Packege; Common Challenge and How to Combine Efforts to Deliver Better Results. http://ec.europa.eu/environment/eir/pdf/full_report_en.pdf

8. Wong, Edward. 2016. "Clamdown in China Restricts 7000 Foreign Organizations." New Yourk Times, Apr.28.

9. European Foundation Centre 2017. Why Shrinking Civil society Space Matters in International Development and Humanitarian Action. Belgium; European Foundation Centre.

10. <https://www.iucn.org/about>

---00---

ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан
Б.Ариунжаргал

ТҮЛХҮҮР ҮГС:

Хулгайлах гэмт хэрэг, эрх зүйн хийдэл, хүндрүүлэх бүрэлдэхүүн, үндсэн бүрэлдэхүүн, аутентик тайлбар, хохирол, хорих ял.

ТОВЧЛОЛ:

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаarahгүй” гэж зааснаас үүдэн практикт энэхүү зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлэхэд өнөөдрийг хүртэл маргаантай хэвээр байна.

Дээрх тайлбараас шалтгаалан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг буюу хулгайлах гэмт хэрэг нь үндсэн бүрэлдэхүүндээ бага хэмжээнээс дээш хохирол шаардаж байгаа хэрнээ хүндрүүлэх бүрэлдэхүүндээ хохирол шаардахгүй байгаа нь гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн тайлбарыг дордуулж, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийг зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал үүсээд байна.

Иймд энэхүү өгүүллийнхээ хүрээнд хулгайлах гэмт хэргийн эрх зүйн

зохицуулалтыг судлан, тулгамдаж бүй асуудлыг тодорхойлохыг зорьсон болно.

I. УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж¹ улмаар Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинчилсэн найруулгыг 2015 онд баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлснээс хоёр жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэхэд хүндрэлтэй, эрх зүйн хийдэлтэй зохицуулалт нэлээдгүй байгааг салбарын эрдэмтэн, судлаач, шүүгч, прокурор, өмгөөлөгчид судлан үзэж өөрийн байр суурийг илрэхийлсээр байна.

Тухайлбал, судлаач Г.Ганбаатар “Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ” нийтлэл, судлаач Д.Нямбатын Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “Хулгайлах” гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулах онол (detertenve theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ гэх мэт.

Энэхүү маргаан бүхий зохицуулалтын нэг нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар юм. Учир нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаarahгүй” гэж заасан нь практикт хэд хэдэн асуудлыг бий болгож байна.

Дээрх тайлбартай холбоотойгоор Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд бага хэмжээний хохирлоос

¹ Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, 2013 он.

дээш хэмжээний хохирол учруулсан байхыг шаардахгүй байгаа юм. Уг асуудалд салбарын эрдэмтэн, судлаач, өмгөөлөгч, прокурор, шүүгчид өөр өөр байр суурийг илэрхийлж байна. Тухайлбал, зарим судлаачид² хуулийн дээрх зохицуулалт нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг буюу үндсэн бүрэлдэхүүндээ бага хэмжээнээс дээш хохирол шаардаж байгаа хэрнээ хүндрүүлэх бүрэлдэхүүндээ хохирол шаардахгүй байгаа нь гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулж, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийг зөрчиж байна хэмээн үзэж байна.

II. ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ

Эрүүгийн хууль нь хүний амьдрах эрх, аюулгүй байдал, амин эрх ашиг, үнэт зүйлсийн үндсэн бөгөөд онцгой хамгаалалт учир Эрүүгийн хуулийн шинэчлэлийн бодлого, зохицуулалт нь орчин цагийн эрх зүйн хөгжлийн түгээмэл хандлага, нийгмийн бодит амьдрал ахуйд нийцсэн, зөв оновчтой, гэмт хэргийн гаралтыг ихэсгэхгүй харин бууруулах буюу тодорхой түвшинд тогтоон барихад чиглэгдсэн, энэрэнгүй, эрх зүйн хийдэлгүй байх зэрэг “олон талт” шалгуур, шаардлагыг хангасан байх ёстой.³

Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулахдаа анх Гэмт хэргийн тухай хуулийн төсөл нэртэйгээр боловсруулж, уг төсөлд өөрчлөлт орж явсаар Эрүүгийн хуулийн төсөл боловсруулагдсан бөгөөд уг төсөлд хорих ялын доод хэмжээг 7 хоног, хулгайлах гэмт хэргийн хохирлын хэмжээг хуульчилж өгөөгүй зэрэг одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулиас нэлээд ялгаатай зохицуулалтууд байсан. Тухайлбал, 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Эрүүгийн хуулинд хулгайлах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнийг “Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар,

хууль бусаар авсан...” гэж хуульчилсан заалтад хууль тогтоогч 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Дээрх өөрчлөлтийн талаар судлаач Г.Ганбаатар: “Хожуу боловч энэхүү өөрчлөлтөөр Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалтын ноцтой сөрөг үр дагаврыг анхаарч, саармагжуулахад чиглэсэн нэг алхам нь энэхүү зүйлд хийсэн хууль тогтоогийн тайлбар юм. Гэвч тухайн тайлбарт “...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэсэн бичвэрийг нэмж хуульчилсан нь “нуухыг нь авах гээд нүдийг нь сохолсон”, “Нэг алхам урагшилж, хоёр алхам хойшилсон” утга агуулгын бодит илрэл болсон буюу ялимгүй алдсан иргэдийн ирээдүйг широнд бууллах бодлого дүр эсгэн хэвээр үлдсэн байна”⁴ хэмээн тодорхойлсон байна.

2002 оны Эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэргийн улмаас бусдад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага хохирол учруулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага шууд хүлээлгэх үндэслэл бүхий зохицуулалт байхгүй байсан юм. Хулгайлах гэмт хэргийн тухайд 2002 болон 2015 оны Эрүүгийн хуулийн зохицуулалтыг харьцуулан үзвэл:

Хүснэгт 1. “Хулгайлах” гэмт хэргийн зохицуулалт, түүний харьцуулалт

№	2002 ОНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	2015 ОНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
	<p>145 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хулгайлах 145.1.Бусдын эд хөрөнгийг хулгайланы улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрнийн хөлсний доод хэмжээг тавас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тогтоофер поргох, нэг зурагт хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p>	<p>17.1 дүгээр зүйл. Хулгайлах 1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйэр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун доочин цагас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тусган ажил хийгэх, эсхүл зурагтан сараас таван жил хүртэл хугацаагаар зорих эхийн хязгаарлах, эсхүл зурагтан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэн. 2. Энэ гэмт хөргийг: 2.1.хүн байнаамьдрах, уйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад извтрэх;</p>

² Энэ талаар судлаач Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган “Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг” нийтлэлээ, судлаач Г.Ганбаатар “Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ”, нийтлэлээ, судлаач Б.Ганболд “Хулгайлах гэмт хэргээ (Хуулийн амин сүнсний хулгай)“ нийтлэлдээ тус тус дурдаж өгсөн байна.

³ Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг. Нийтлэл, 2017.04.12, <http://court26.kho.gov.mn/news/209--.html>. (Сүүлд үзсэн: 2019.02.20)

⁴ Г.Ганбаатар, “Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ”, Шүүх эрх мэдэл сэргүүл №2 2018 он, 79-80 дахь тал.

1	<p>145.2. Энэ гэмт хэргийг давтан бүлэглэж буюу урьдчилсан үгсэж тохиолцсон бүлэг, машин механизм, тусгайлан бэлтгэсэн бараж хэрэгслэх буюу орон байр, агуулласаванд иштэрч үйлдсэн, энэ хэргийн улмаас үзүүлж хэмжээний хохирол учирсан, олон тооны мал хуглайлсан бол дахь хөрөнгийн хураах буюу хураахгүй зэрэг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин ишгэж хөөр зуун тавь дахин ишмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тогтолцоог тогтох, гурваас дээш зурагаар сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хөөрөс таван жил хүргэн хугацаагаар хорих ял шийтгэн.</p> <p>145.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хохирогчийн амьдралын эх үүсвэрээс нь салгасан буюу их хэмжээний хохирол учирсан, түүнчлэн гамшигийн далиндуулж үйлдсэн бол эд хөрөнгийн хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хөөр зуун тавин ишгэж таван зуу дахин ишмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тогтолцоог тогтох, эсхүл таваас дээш арван жил хүргэн хугацаагаар хорих ял шийтгэн.</p> <p>145.4. Энэ хэргийг булаах, дээрэмдэх, уулгалан довтлох гэмт хэргэгт шийтгүүлсэн этгээд түүчинлийн онц аюултой гэмт хэргэгэн, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол дахь хөрөнгийн хурааж, арваас дээш арван таван жил хүргэн хугацаагаар хорих ял шийтгэн.</p>
	<p>2.2. түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийн чухал авч холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлийн хулагайлж;</p> <p>2.3. ноцойн хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийн хулагайлж;</p> <p>2.4. учрах саадыг арилгах зорилгоор зөвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвстийн чанартай зүйлийн хулагайлж, машин механизмын ашиглалт үйлдсэн бол хөөр жилээс нийман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэн.</p> <p>3. Энэ гэмт хэргийт:</p> <p>3.1. байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;</p> <p>3.2. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хөөр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэн.</p> <p>Тайлбар: Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэргэг үйлдлийн тооочижүүлж.</p> <p>Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаараахгүй.</p>

1. 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хөдөлмөрийн харилцаанд хэрэглэдэг «хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ» гэдэг ойлголтыг Эрүүгийн хуульд тусгасан байсныг халж гэмт хэргийн ангилалт, учирсан хохирлын хэмжээг бодитой тогтоох, тorgуулийн ял хэмжээг тогтвортой байлгах үүднээс Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар “нэгж” гэсэн хэмжигдэхүүнийг шинээр оруулж ирсэн. Учир нь 2002 оны Эрүүгийн хуулиар хөдөлмөр, нийгмийн зөвшүүллийн гурван талт Үндэсний хорооны шийдвэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдхөхөд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байсан зарим хэргүүд гэмт хэргийн шинжгүй болж, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болж шийдвэрлэх тохиолдол цөөнгүй байсан.

2. 2015 оны Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан

хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хулагайлах гэмт хэрэг үйлдсэн хүнд оногуулах эрүүгийн хариуцлагын төрөл нь дан ганц хорих ял байгаа бол 2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.1, 145.2, 145.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хүнд оногуулах ял нь сонгох санкцтai, 145.4 дэх хэсэгт заасан онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт сонгох санкцгүйгээр хорих ял нь оногуулахаар хуульчилсан байжээ.

3. 2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг хулагайлах” гэмт хэрэг нь үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүндээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтгэй тэнцэхүүц буюу түүнээс дээш хэмжээний хохирол учруулсан тохиолдолд хулагайлах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооочон ял оногуулдаг байсан бол 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолд 300.000 төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан, харин хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр дээрх гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд хохирол шаардахгүй байдлаар хуульчилснаараа өмнөх хуулиас нэлээд ялгаатай зохицуулалт болсон байна.

III. ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ, ЯЛЫН БОДЛОГО

Ийнхүү шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Шинэ хууль хэрэгжиж эхэлсэн өдрөөс 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн хооронд улсын хэмжээнд хулагайлах төрлийн нийт 35397 гомдол, мэдээлэл хүлээн авч, 8390 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Энэхүү тоо баримтаас харвал 2002 оны Эрүүгийн хууль үйлчилж байх үед хулагайлах гэмт хэргийн гаралт жил ирэх бүр өсч байсан ба 2015 оны Эрүүгийн хуулийн хэрэгжих цаг хугацаанд мөн л өссөөр байгааг харуулж байна.⁵

Улсын хэмжээнд 2017 оны 7 дугаар

⁵ Д.Нямбат, “Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан Хулагайлах гэмт хэрэгт оногуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулсан онол (detentione theory)-ын үзүүлэлтэй хийсэн дун шинжилгээ”, Хууль дээдлэх ёс сэргүүл №1 2019 он, 47-48 дахь тал.

сарын 1-нээс 2018 оны 6 дугаар сарын 30-ны хооронд нийт 1650 хүн хулгайллах гэмт хэрэгт холбогдон шалгагдсанаас 137 буюу 8.3 хувь нь эмэгтэй, 1513 буюу 91.7 хувь нь эрэгтэй, 199 буюу 12.1 хувь нь хүүхэд байна.⁶

Практикт өсвөр насны дөрвөн хүүхэд дэлгүүрээс талх, боорцог, чихэр зэрэг 110.000 төгрөгийн хүнсний зүйл хулгайлсан үйлдэлдээ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогdon хорих ялаар шийтгүүлсэн бөгөөд дээрх асуудлаас үүдэн УИХ-ын гишүүн О.Батнасан “Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийг санаачлан боловсруулж, Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн зарим хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан юм.

Гэсэн хэдий ч дээрх өөрчлөлтөөр зөвхөн өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарим зохицуулалтад өөрчлөлт оруулснаас бусдаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн маргаан бүхий зохицуулалтуудад өнөөдрийг хүргэлт нэмэлт, өөрчлөлт оруулаагүй хүчин төгөлдөр үйлчилээр байна.

Маргаан бүхий Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн аутентик тайлбарыг судлаачид өөр өөрийн узэл бодлоор тайлбарлаж байна. Тухайлбал, судлаач Г.Ганбаатар “Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ” нийтлэлдээ “...Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн аутентик тайлбар нь “Зорилго чиглэл, утга агуулга”-ын хувьд гагчхүү Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шууд хамааралтайгаар хуульчлагдсан, тухайн хамаарах хэсгийн хэм хэмжээний хамт хүчин чадалтай байх хэдий боловч тухайн тайлбар дахь “...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэсэн бичвэрийг “тайлбар” гэж үзэх боломжгүй, харин эсрэгээр тайлбарт хамаарахгүй өөр зохицуулалтыг тусгасан нь хуулийн тухайн зүйлийн хэсгүүд хооронд зөрчилдөөн үүсгэж, улмаар иргэдийг хуучин Эрүүгийн хуулиас илүүтэй шоронжуулахад чиглэсэн

узэл санааг агуулсан нь илэрхий байна” хэмээн үзжээ.

Эрх зүйн хэм хэмжээний албан ёсны тайлбар нь кейсийн тайлбар болон хэм хэмжээний тайлбар гэсэн хоёр төрлтэй байна. Эрх зүйн хэм хэмжээний буюу норматив тайлбар нь аутентик тайлбар ба хууль зүйн тайлбар /Улсын Дээд шүүхийн абстракт тайлбар/ хуваагдана. Тэрээр Аутентик тайлбарыг тодорхойлоодо эрх зүйн хэм, хэмжээг батлан гаргасан байгууллагаас тайлбарласан тайлбар. Эрх зүйн хэм хэмжээний утга санааг шууд тайлбарлахад чиглэгдэх хийгээд тэдгээрийг хэрэглэж байгаа бүхэнд заавал биелүүлэх шинжийг агуулдаг.⁷

Дээрхээс үзвэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүргэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүргэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүргэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” хэмээн заасан байх бөгөөд дээрх зүйлийн тайлбар хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж зааж өгсөн нь ямар нэгэн салаа утгагүйгээр хохирлын хэмжээнээс үл хамааран 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн бол 2 жилээс 12 жил хүргэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойш Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2018 онд нийт 17734 хүн, 4 хуулийн этгээдэд холбогдох 14207 эрүүгийн хэрэг хүлээн авч 12551 хэрэг шийдвэрлэсэн бөгөөд анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 42.0 хувиар өссөн байна.⁸

⁶ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, 648 дахь тал, Уб., 2007 он.

⁷ Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн шүүх таслах ажиллагааны 2018 оны тайлан, 2019.01.13, <http://www.judcouncil.mn/main/8465--2018-.html>, (Цүүлд үзсэн: 2019.03.28)

Харин 2002 оны Эрүүгийн хууль хэрэгжиж байх үед хулгайлах гэмт хэргийг шүүхээс шийдвэрлэж байсан тоон мэдээг харвал 2011 онд 1282, 2012 онд 1281, 2013 онд 1283, 2014 онд 1336, 2015 онд 1418⁹, 2016 онд 2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд зааснаар 995 хэрэг, 2015 оны Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд зааснаар буюу 421 хэрэг нийт 1416 хэрэг шийдвэрлэсэн байна.¹⁰

*Хүснэгт 2. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн хулгайлалыг гэмт хэргийн тоон мэдээ /2018 он/*¹¹

Эрүүгийн хууль /2015 он/ 17.1 дүгээр зүйл				
Хянан шийдвэрлэсэн	Нийт	17.1 дүгээр зүйлийн 1 дахь хэсэг	17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг
Хэрэг	1553	778	775	20
Холбогдолг	2049	958	1061	30

Дээрх графикаас узвэл, 2018 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 12551 хэрэг хянан шийдвэрлэсэнээс Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан 1553 хэрэг хянан шийдвэрлэгдсэн нь нийт анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн 12.4 хувийт эзэлж байна.

Харин давж заалдах шатны шүүх 2018 онд эрүүгийн 2166 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 9.9 хувиар өссөн. Хяналтын шатны шүүх 2018 онд эрүүгийн 851 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 92.6 хувиар тус тус өссөн байна.¹²

Өнгөрсөн онтой харьцуулбал, шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 42 хувиар, ял шийтгүүлэгчдийн тоо мөн 37.1 хувиар тус тус өссөн. Энэ нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж гэмт хэрэг тус бүрт ял оногдуулж, шийдвэрлэдэг болсонтой холбоотой бөгөөд 2018 онд эдгээр хууль бүтэн жилийн хугацаанд хэрэгжиж эхэлсэн анхны жил болсонтой холбоотойгоор хянан

⁹ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2016 он, 152 дахь тал, УБ., 2017 он.

¹⁰ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2017 он, 82 дахь тал, УБ., 2018 он.

¹¹ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн тоон мэдээ.

¹² Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан, 2019.01.13, <http://www.judcouncil.mn/main/8465--2018-.html>. (Сүүлд үзсэн: 2019.03.28)

шийдвэрлэсэн хэрэг, ял шийтгүүлсэн хүний тоо өсөлттэй гарахад нөлөөлсөн байна.¹³ Өөрөөр хэлбэл, шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээр гэмт хэргийн гаралт, ял шийтгүүлж буй хүний тоо өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс хулгайлалыг гэмт хэргийн тухайд дэлгэрүүлэн судлан үзэхд анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт хэргээс хулгайлалыг гэмт хэрэг 137 хэргээр буюу 9.7 хувиар өссөн бөгөөд ял шийтгүүлэгчдийн байдлаар нь авч үзвэл хулгайлалыг гэмт хэргэйт ял шийтгүүлэгчдийн тоо 18.6 хувиар өсжээ.¹⁴

Ийнхүү хулгайлалыг гэмт хэргийн гаралт, ял шийтгүүлж буй хүний тоо өсж буй нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбартай хамаарал бүхий байж болох юм.

Учир нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд хулгайлалыг гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн нь бусдын “хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар...” авсан үйлдэл байх бөгөөд энэхүү үйлдлийн улмаас бага хэмжээнээс¹⁵ дээш буюу 300.000 төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан бол энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулахаар хуульчилжээ.

Гэтэл энэ зүйлийн тайлбар хэсэгт “Энэ зүйлийн 1 дахь хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж заасан байна. Дээрх тайлбараас үүдэн хулгайлалыг гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бага хэмжээний хохирол учруулж үйлдсэн тохиолдолд ч эрүүгийн хариуцлага хүлээхээр болж байгаа юм.

¹³ Мөн тэнд.

¹⁴ Мөн тэнд.

¹⁵ Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.3-т “бага хэмжээний хохирол гэж түүнээс доosh хэмжээг”, мөн хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан ба “...нэг нэг нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна. Өөрөөр хэлбэл, бага хэмжээний хохирол нь 300.000 төгрөг бөгөөд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэх нэг үндэслэл нь 300.000 төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан байхыг шаардаж байгаа юм.

Түүнчлэн, шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбараас хамааран Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан хүнд оногдуулах хорих ял нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд “...тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэж заасан шударга ёсны зарчимтай нийцэхгүй байгаа нь харагдаж байна. Үүнийг жишээгээр авч үзвэл:

Тохиолдол 1.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 110 дугаар тогтоолтой иргэн Л.Б-д холбогдох эрүүгийн хэргийн талаар:¹⁶

Шүүгдэгч Л.Б нь 2018 оны 06 дугаар сарын 08-ны шөnө 23 цаг 30 минутын орчим Замын-Үүд сум 2 дугаар багт оршин суух иргэн Д.Э-н байнга амьдрах орон байранд нэвтрэч 1 ширхэг цайны халуун сав, 7.5 литр сарлагийн сүү, 5 кг үхрийн мах зэргийг хулгайлж 51.250 төгрөгийн бага хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт холбогдсон бөгөөд шүүхээс Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.3-т заасныг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад зааснаар шүүгдэгч Л.Б-д 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан байна.

Тохиолдол 2.

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 09 дүгээр тогтоолтой иргэн Ш.С-д холбогдох эрүүгийн хэргийн талаар:¹⁷

Шүүгдэгч Ш.С нь 2018 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Өмнөговь аймгийн Цогцэций сумын төвд үйл ажиллагаа явуулдаг Цэцгэн бууз цайны газраас иргэн М.Л-ийн гар цүнхийг хулгайлж бусдад 1.660.000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

Шүүхээс Ш.С-г хулгайллах гэмт хэрэг үйлдээн гэм буруутайд тооцон, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Ш.С-д хорих ял оногдуулахгүйгээр 1 /нэг/ жил 6 /зургаа/-н сарын хугацаагаар тэнссэн байна.

Дээрх 2 тохиолдолд шүүхээс ялгамжтай байдлаар ял оногдуулсан байх бөгөөд эхний тохиолдолд Л.Б нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайллах” гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй буюу хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтрэч үйлдэн, 51.250 төгрөгийн хохирол учруулж улмаар 1 жил хорих ялаар шийтгүүлсэн бол хоёр дахь тохиолдолд цайны газраас Ш.С нь иргэн М.Л-ийн гар цүнхийг хулгайлж, 1.660.000 төгрөгийн хохирол учруулсан гэх хэрэгт шүүхээс хорих ял оногдуулахгүйгээр нэг жил зургаан сарын хугацаагаар тэнссэн байна.

Өөрөөр хэлбэл, учруулсан хохирлын хэмжээний хувьд хорих ял шийтгүүлсэн Л.Б нь 51.250 төгрөг буюу бага хэмжээний хохирол, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэгдсэн Ш.С нь 1.660.000 төгрөгийн хохирлыг бусдад учруулсан байна.

Товчхондоо хохирлын хэмжээ их байх тусмаа тухайн хүнд оногдуулах ялын хэмжээ нэмэгдэх нь зүйн хэрэг. Гэтэл бусдад 51.250 төгрөгийн хохирол учруулсныхаа төлөө 1 жил чөлөөгөө хасуулан эрүүгийн хариуцлагын хамгийн хүнд төрөл болох хорих ялаар шийтгүүлж байгаа нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан “Шударга ёсны зарчим”-д нийцэж буй эсэх нь эргэлзээтэй юм. Түүнчлэн, дээрх хоёр тохиолдол нь гэмт хэргийн ангиллын хувьд ч эрс ялгаатай байна.

Гэмт хэрэг бүрт нийгэмд аюултай байдлын шинж чанар, хэр хэмжээ оногдуулж болох ялын хүнд, хөнгөн зэрэг

¹⁶ Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, Дугаар 110, 2018.10.23, <http://new.shuukh.mn/eruuhanhan/28027/view> (Сүүлд үзсэн: 2019.03.30)

¹⁷ Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, Дугаар 09, 2019.01.21, <http://new.shuukh.mn/eruuhanhan/25274/view> (Сүүлд үзсэн: 2019.03.30)

шалгуурыг харгалзан нийт гэмт хэргүүдийг тодорхой төрөлд хуваахыг ангилал гэнэ.¹⁸

Гэмт хэргийн ангилал нь гэмт хэргийг нийгмийн хор аюул, шинж чанараар нь ангилахын зэрэгцээ хууль зүйн үр дагаврыг ангиллаас нь хамааран ялгамжтайгаар тогоох, эрүүгийн хариуцлагыг оновчтой тодорхойлоход ач холбогдолтой төдийгүй хууль зүйн техникийн хувьд ерөнхий ангид заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, тэнсэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэхэд чухал ач холбогдолтой тул гэмт хэргийг хөнгөн, хунд гэсэн хоёр ангилалтай байхаар тусгасан.¹⁹

Дээрх тохиолдолд 51.250 төгрөгийн хохирол бусдад учруулсан хүний үйлдсэн хулгайллах гэмт хэрэг нь гэмт хэргийн ангиллын хувьд хүнд гэмт хэрэгт хамаарна. Харин 1.660.000 төгрөгийн хохирол учруулсан хүний үйлдсэн хулгайллах гэмт хэрэг нь хөнгөн гэмт хэрэгт хамаарч байна.

Нөгөөтээгүүр, хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт хулгайллах гэмт хэргийн хүндүүлэх бүрэлдэхүүнийг хуульчлан өгсөн. Тухайлбал, дээрх 2 тохиолдолд Л.Б нь хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтрэч эд зүйл хулгайлсан учир хүндүүлэн авч үзэж буй нь зүйн хэрэг боловч хохирлын хэмжээ нь 51.250 төгрөг байгаа нь хулгайллах гэмт хэргийнхээ үндсэн бүрэлдэхүүнийг хангаагүй (17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй) байхад хүндүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хулгайллах гэмт хэрэг үйлдсэн учраас бага хэмжээний хохирол учруулсан ч хүндүүлэн зүйлчилж байгаа нь өрөөгөл юм.

Учир нь эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг үндсэн, хүндүүлэх, онц хүндүүлэх зэрэгэр тайлбарлан хэрэглэж ирсэн байдаг ба үндсэн бүрэлдэхүүний шинжгүй нөхцөлд дараах хүндүүлэх болон онц хүндүүлэх бүрэлдэхүүний шинж бий болохгүй гэсэн

¹⁸ С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол I боть, ХЗҮХ, УБ, 2009 он. 206 дахь тал.

¹⁹ Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулга, ХЭДХЯ.

үзэл хэвшин тогтсон ойлголт.²⁰

Гэтэл шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайллах” гэмт хэргийн тайлбар нь дээрх ойлголтой зөрчилдэх байна.

Хуулийн энэхүү зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалахад чиглэж буй хэдий ч Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хүндүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бага хэмжээний хохирол учруулж хулгайллах гэмт хэрэг үйлдсэн хүнд ялгамжтай байдлаар хандаж, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, учруулсан хохирлыг үл харгалзаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зохицуулалтад нийцсэн эсэх нь эргэлзээ төрүүлэхүйц байна.

Эрүүгийн хууль нь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, улс үндэстний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг сахин хангах чиг үүрэг бүхий суурь хууль болохын хувьд эрх зүйн шинэтгэл, олон нийтийн анхаарлын төвд байнга байдаг.

Эрүүгийн хууль тогтвортой удаан хугацаанд мөрдөгдэж байх явдал чухал боловч уг хуулийн хэрэгжилт, үр нөлөө, нийгмийн эрэлт шаардлагад нийцэж байгаа эсэхд тогтмол хяналт шинжилгээ хийж, хэрэв нийцэхгүй зүйл байвал түүнийг шинэчлэх, өөрчлөх арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж байх нь зүйтэй.

Маргаан бүхий энэхүү асуудлын талаар практикт ажиллаж буй прокурор, шүүгчдийн саналыг авснаар судалгааны үр дүн илүү бодитой гарна гэж үзсэний үндсэн дээр 78 прокурор, 158 шүүгч, нийт 236 хүнээс анкетын аргаар судалгаа авч үр дүнг боловсруулсан болно.

Практикт дээрх төрлийн гэмт хэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалгасан

²⁰ Б.Ганболд, Хулгайллах гэмт хэрэг (Хуулийн амин сүнсний хулгай), Шүүх эрх мэдэл сэтгүүл №2 УБ., 2018 он, 61 дэх тал.

эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасныг үндэслэн шийдвэрлэж буй тохиолдол цөөнгүй байна.

Үүнийг жишигээр авч үзвэл:

Тохиолдолд 3.

Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 35 дугаар шийтгэх тогтоол²¹, Увс аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 14 дүгээр магадлал²², Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүхийн 299 дүгээр тогтоолтой Т.О, Б.Х нарт холбогдох эрүүгийн хэргийн талаар:²³

Т.О, Б.Х нар нь 2017 оны 12 дугаар сарын 8-ны шөнө Увс аймгийн Улаангом сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрээс тоёота аллион загварын саарал өнгийн 06-83 УВХ улсын дугаартай автомашин ашиглаж хохирогч Ц.А-гийн эзэмшлийн ногооны талбайн 20 метр урттай төмөр тор хулгайлж нийт 90.000 төгрөгийн хохирол учруулсан бөгөөд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн бөгөөд анхан шатны шүүхээс Б.Х, Т.О нарт тус бүрт нь нэг жилийн хорих ял оногдуулсан.

Давж заалдах шатны шүүхээс энэхүү хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан.

Харин давж заалдах шатны шүүх уг хэргийг хянан хэлэлцээд “шүүгдэгч Т.О, Б.Х нарын ногооны талбайн 20 метр урттай төмөр тор хулгайлж учирсан 90.000 төгрөгийн хохирлыг нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодитой хохирол учирсан гэж дүгнэхээргүй байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцох үндэслэлгүй гэсэн прокурорын дүгнэлтийг

²¹ Увс аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, №35, 2018.02.21, <http://new.shuukh.mn/eruuhanhan/18434/view> (Сүүлд үзсэн: 2019.03.14)

²² Увс аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, №14, 2018.04.19, <http://new.shuukh.mn/eruuuhavah/5384/view> (Сүүлд үзсэн: 2019.03.14)

²³ Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүхийн тогтоол, №299, 2018.06.25, <http://new.shuukh.mn/eruuhyanal/962/view> (Сүүлд үзсэн: 2019.03.14)

хүлээн авахаар тогтов” гэжээ. Ийнхүү хяналтын шатны шүүхээс ЭХХШТХ-ийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгож, цагаатгасан байна.

Дээрх тохиолдолд анхан шатны шүүхээс машин механизм нь ашиглаж хулгайлах гэмт хэрэг үйлдэж бусдад 90.000 төгрөгийн хохирол учруулсан Т.О, Б.Х нарын үйлдэл нэг жилийн хорих ял оногдуулсан бөгөөд 90.000 төгрөгийн хохирол учруулж, хохирлоо нөхөн төлсөн ч эрх чөлөөгөө нэг жилийн хугацаагаар хязгаарлуулж байгаа нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнд эрүүгийн хариуцлага тохиорсон эсэх нь эргэлзээтэй.

Хорих ял гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдвол шүүх Эрүүгийн хуульд заасан хугацаанд эрх чөлөөг нь хязгаарлаж, олон нийтээс тусгаарлаж, тусгай дэглэм бүхий хорих анги, гяндан албадан байлгадаг төрийн албадлагын хатуу цээрлэл агуулсан арга хэмжээ²⁴ гэтэл 90.000 төгрөгийн хохирол бусдад учруулж, хорих ял эдэлнэ гэдэг нь хохирол болон нийгмийн аюулын хэр хэмжээндээ тохиорх эсэх нь эргэлзээтэй байна.

Энэ байдлыг хяналтын шатны шүүхээс харгалзан үзэж Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “...Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасныг журамлан Т.О, Б.Х нарт холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж шийдвэрлэсэн байна.

Тэгвэл, Т.О, Б.Х нарын үйлдсэн хулгайлах гэмт хэргийг адил төсөөтэй хэргүүдийг практикт Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг журамлан хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байгаа эсэхийг судлах зорилгоор анкетын судалгаагаар Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан тохиолдолд

²⁴ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, Монгол Улсын Дээд Шүүх, Уб., 2013 он, 206 дахь тал.

тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохируулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой юу? гэсэн асуулт тавихад:

“Тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой” гэж судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын 37.3 хувь нь хариулсан бол “Боломжгүй. Учир нь хууль тогтоогч 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт энэхүү гэмт хэрэгт хохирол шаардахгүй байхаар тодорхой байдлаар тусгасан” гэж 62.7 хувь нь хариулсан байна.

Мөн Та Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол бусдад учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн гэмт хэрэгт тооцохгүй байдлаар хэрэг шийдвэрлэсэн тохиолдол байгаа юу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын 13.1 хувь нь тийм гэж, 86.9 хувь нь үгүй гэж тус тус хариулсан байна.

Гэсэн хэдий ч дээрх асуултад хариулсан шүүгч, прокуроруудын хариулт нэлээд ялгамжтай байсан бөгөөд тухайлбал, прокуроруудын 32.1 хувь, шүүгчдийн 3.8 хувь нь дээрх асуултад тийм гэж хариулсан байна. Дээрхээс дүгнэвэл, практикт прокурорын хяналтын шатанд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол бусдад учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн гэмт хэрэгт тооцохгүй байдлаар хэрэг шийдвэрлэж буй тохиолдолд шүүхээс илүү байна.

Анкетын судалгааны үр дүнг бататгах зорилгоор Монгол Улсын шүүхийн шийдвэрийн shuukh.mn цахим сангаас 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад зааснаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэгдэж, тус санд байршуулсан нийт 724²⁵ хэргээс санамсаргүй түүврийн

аргаар 200 хэрэг сонгон судалж, түүнээс Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бусдад бага хэмжээний хохирол учруулж шүүхээс шийдвэрлэгдсэн хэргийг түүвэрлэн судалсан болно.

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 200 хэрэгээс 30 хүнд холбогдох 27 хэрэг нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бусдад бага хэмжээний хохирол учруулж хулгайлах гэмт хэрэг үйлдсэн тохиолдол байв.

Энэхүү 30 хүнд холбогдох 27 эрүүгийн хэрэгт шүүхээс оногдуулсан ялыг судлан узэхэд 1 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ, үлдсэн хүмүүст хорих ял оногдуулсан байна. Хорих ял шийтгүүлсэн 29 хүнд хамгийн багадаа 1 жилийн хорих ял, ихдээ 2 жил 1 сарын хорих ял оногдуулсан байна. Үүнийг дунджилж үзвэл ойролцоогоор 1 жил 3 сарын хорих ял оногдуулсан байна.

Дээрх 27 хэргийн хохирлын хэмжээг харвал, хамгийн бага нь 20.000 төгрөгийн, хамгийн их нь 300.000 төгрөгийн хохирол бусдад учруулсан байх бөгөөд хохирлын хэмжээ нь дунджаар 178.993 төгрөг байна. Гэмт хэрэг үйлдсэн хүний насны байдлын хувьд дээрх 30 хүнээс 9 хүний насны байдлыг шүүхийн шийдвэрт тусгалгүй орхигдуулсан байна. Үлдсэн 21 хүнээс хамгийн бага нь 18 настай, хамгийн өндөр нь 51 настай хүн байх бөгөөд гэмт хэрэг үйлдсэн хүний дундаж нас 34 байна.

Хулгайлах үйлдэл нь мөн чанартаа нэг үйлдэл бөгөөд үүнийг том, жижиг гэж хоёр хуваах нь шударга ёсны зарчимд харшилдаг. Шударга ёсны зарчмын хүрээнд авч үзвэл Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн хүндрүүлэх шинж болох «корон байранд нэвтэрсэн» хулгайлах үйлдэлд хохирол шаардахгүй атлаа, «нэвтрээгүй» үйлдэлд 300.000 төгрөгнөөс дээш хохирол шаардаж байгаа нь учир дутагдалтай юм.²⁶

Практикт маргаан үүсгээд буй асуудлыг ерөнхийд нь авч үзвэл Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбарт “... Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэсэн бичвэрийг хуульчилсан

²⁵ Б.Өнөрмаа, Г.Оюунболд, “Эрүүгийн хуулийн хэрэгжилт” Нийтлэл, *prokutor.mn*, (Сүүлд үзсэн: 2019.02.21)

²⁶ <http://new.shuukh.mn>, (Сүүлд үзсэн: 2019.03.04)

яvdal юм.

Нэгөөтээгүүр, энэхүү тайлбарыг утгачилан ойлговол Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн “энэ гэмт хэргийг...” гэдэг нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинж бүрэн хангагдсан тухайн гэмт хэргийг л ойлгодог. Тийм ч учраас гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний дараа харин хүндруүлэх бүрэлдэхүүний өмнө нь “энэ гэмт хэргийг...” гэж Эрүүгийн хуулийн тухайн зүйлийн 2, 3 дахь (хэдэн хэсэгтэй ч байж болно) хэсэг болгон тусгайлан хуульчлан заадаг ба тус хэсгийн заалт болгож тус гэмт хэргийн хүндруүлэх бүрэлдэхүүнийг нарийвчилсан, дэс дараалсан байдлаар зохицуулдаг.²⁷

Дээрхээс дүгнэвэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгийн “энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж заасныг практикт хэрэгжүүлэхд сөрөг нөлөө үүсгэж, хүндруүлэх бүрэлдэхүүнтэйгээр бусдад бага хэмжээний хохирол учруулж хулгайлах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 2-12 жилийн хорих ял оногдуулахаар хуульчилсан нь хорих ял эдлэх хүний тоог нэмэгдүүлэхээр байна гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөнөөс хойш жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд эрх зүйн хийдэлтэй зохицуулалт болон маргаан дагуулж буй заалтуудыг хэрхэн засаж, сайжруулах талаар олон талын сургалт, хэлэлцүүлэг²⁸, судалгаанууд хийгдсээр байгаа билээ. Энэ хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар буюу 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн хэргэжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, дараах дүгнэлтэд хүрч байна.

1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр

зүйлийн тайлбарт “...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж заасныг практикт хэрэгжүүлэхд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Тухайлбал, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан “... хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрсэн”, мөн зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан “учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизмыг ашиглах үйлдсэн” хэргүүдэд хохирлын хэмжээ нь 300.000 төгрөг хүрээгүй байсан ч шүүхээс эдгээр хэрэгт хуульд заасан үндэслэл журмын дагуу хорих ял оногдуулан шийдвэрлэж байна.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хулгайлах гэмт хэргийг хүндруүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдэж бусдад 1-300.000 төгрөгийн хохирол учруулсан үйлдэлдээ гэмт хэрэг үйлдсэн хүн 2-12 жилийн хорих ял шийтгүүлэхээр хуульчилжээ.

Энэ нь гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулахын зэрэгцээ Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан “Шударга ёсны зарчим”-тай зөрчилдэж байна хэмээн дүгнэж болох юм.

2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт дан ганц хорих ял оногдуулахаар хуульчилсан нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, учруулсан хохирол зэрэг олон шалтгаан нөхцөлийг шүүх тал бүрээс нь бүрэн бодитой хянан шийдвэрлэж, гэмт хэрэг үйлдсэн хүнд тохиорох ял шийтгэлийг оногдуулахад хязгаарлагдмал байдлыг бий болгож байна хэмээн үзэж болох юм.

Судалгааны явцад шүүгч, прокуроруудаас анкетын аргаар судалгаа авахад энэ гэмт хэрэгт оногдуулах ялын төрлийг нэмж, сонголттой болгосноор тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан тохиорох ялыг гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах

²⁷ Мен тэнд.

²⁸ Тухайлбал, УИХ-ын ХЗБХ, ХЗДХЯ-тай хамтран “Эрүүгийн хууль тогтоомжийн хэргэжилтийн талаарх хэлэлцүүлэг”, “Шүүхийн шийдвэр түүний хэрэглээ ач холбогдол” сэдэвт хэлэлцүүлэг, “Эрүүгийн хуулийн шинэтгэлийн үйл явц” сэдэвт хэлэлцүүлэг, “Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа - онол практикийн асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурал гэх мэт.

боломжтой гэж нийт оролцогчдын 39.8 хувь нь хариулсан нь энэ гэмт хэрэгт оногдуулах ялын төрлийг нэмж хуульчлах боломжийг судлан узэх шаардлагатай болохыг илэрхийлж байна.

САНАЛ

Судалгааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд дараах нэмэлт, өөрчлөлт оруулах саналтай байна.

1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгээс "...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэсэн хэсгийг хасах;

2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ялын төрлийг нэмэх. Тухайлбал, арван мянган нэгжээс дочин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ялыг нэмэх.²⁹

НОМ ЗҮЙ

I. Монгол хэл дээрх эх сурвалж Ганбаатар Г. "Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дун шинжилгээ". Шүүх эрх мэдэл сэтгүүл №2 (2018)

Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онон I боть. УБ: ХЗҮХ, 2009.

²⁹ Практикт тутгээмэл үйлдэгдэг гэмт хэргийн нэг болох Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд зассан "Залилах" гэмт хэргийг хүндэрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн тохиолдолд энэ хуулийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...арван мянган нэгжээс дочин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилийн найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнз" гэж заасныг харгалзан узэж дээрх саналыг гаргасан болно.

Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2016 он. УБ: Мөнхийн үсэг, 2017.

Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2017 он.. УБ: Мөнхийн үсэг, 2018.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Монгол Улсын Дээд Шүүх. УБ: ХЗҮХ, 2013.

Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. Айхны хэвлэл. УБ: Адмон хэвлэл, 2007.

Өнөрмаа Б. Оюунболд Г. Эрүүгийн хуулийн хэрэгжилт нийтлэл.

Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан.

Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал. Хууль зүйн яам. 2013 он.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулга, ХЗДХЯ.

II. Хууль тогтоомж

Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №5;

Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №7;

III. Цахим эх сурвалж

<http://new.shuukh.mn>,

<http://www.prokuror.mn/>

<http://www.judcouncil.mn/main/8465--2018-.html>

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 69.1 ДЭХ ЗААЛТЫН ЗОРИЛГО, ХЭРЭГЛЭЭНИЙ ОНЦЛОГИЙГ ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ ТОГТОЛЦООНЫ ХАНДЛАГААР АВЧ ҮЗЭХ НЬ



*Шихихутуг их сургуулийн
багш, докторант Ы.Болормаа*

АГУУЛГА:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 69.1 дэх заалтын практик хэрэглээний талаар
2. Хөдөлмөрийн тухай хуулийн 69.1 дэх заалтын онолын хэрэглээний талаар

ТОВЧЛОЛ:

Хөдөлмөрлөх эрх, эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор¹ ажилгүй байсан хугацааны олговор, учруулсан хохирлыг арилгуулах эрх зүйн зохицуулалтын практик хэрэглээг, харилцааны тогтолцоо, хууль тогтоомжийн системчлэлд тулгуурлан онолын хэрэглээний үүднээс авч үзэхэд оршино.

УДИРТГАЛ

Тухайн хууль тогтоомжийг хэрхэн зөв хэрэглэх асуудал нь онолын болон практикийн чухал ач холбогдолтой. Энэ

талаар эрдэмтэн, судлаачид² ийнхүү авч үзжээ.

Хэдийгээр хуулиудыг парламент баталдагч тэдгээрийг шүүгчид хэрэглэдэг байна. Эхлээд хараад шүүгчид хуулийн заалтуудыг удирдлага болгон зөвхөн шийдвэр гаргах л үлддэг юм шиг харагддаг. Гэтэл үнэн хэрэг дээрээ бол бүх зүйл тийм ч хялбар биш. Хууль тогтоогч хуулиудын бичвэрт үг нэг бүрийг маш нарийн, нягт нямбай боловсруулдаг боловч шүүхийн хувьд олон тохиолдолд хуулийг тодорхой хэрэгт яж хэрэглэх нь тодорхойгүй байдаг. Ийм тодорхойгүй байдал нь янз

² О.Амархүү, “Эрх зүйн онол”, Уб., 2018 он 249 дэх тал. / эрх зүйг хэрэглэх нь хэн нэгний дур зоргоор хийгдэг ажил биш, хууль эрх зүйн бусад актаар тодорхойлогдсон дэг журам, хэлбэрийн дагуу явагддаг нарийн төвтэйгээ ажиллагаа юм./, /Д.Баярсхайхан, “Эрх зүйн онол”, Уб., 2010 он 246 дахь тал. /Хуулиар эрх олгосон эрх бүхий субъектээс шүүгч, албан тушаалтан/ эрх зүйн хэм хэмжээний заалт, зарчмыг ойлгомжтойгоор тодорхойлж тогтооход чиглэгдэсэн эрх зүйн уйл яви/ /Д.Лүндээжанцан, “Хууль бүтээх уйл ажиллагаа ба хууль зүйн техник”, Уб., 2016 он 148 дахь тал. /Эрх зүйг хэрэглэх нь эрх зүйн онолын тулхүүр асуудлын нэг байдаг. Эрх зүйг хэрэгжүүлэн билэглүүхэд уйл явины бие даасан онцлог хэлбрэ нь эрх зүйт хэрэглэх тухай асуудал юм. Энэ нь хууль зүйн факт буюу эрх зүйн харилцааг үсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэсэн ямарваа нэгэн үйл баримтыг бий болгосноор түүнийн үзэлж шинжилж шийдвэрлэх, эрх зүйн хэм хэмжээг сонгон авч улмаар эрх зүйт хэрэглэсэн акт гаргах замаар шийдвэрлэх үйл юм./

С.Нарангэрэл, “Эрх зүйн эх толь бичиг”, Уб., 2008 он, 534 дэх тал /Мэн “Хууль хэрэглэх практик гэгдгийг эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах буюу тэдгээрийн хийдэл ба тодорхой бус байдлыг арилгах талаар бүрэлдэн тогтсон шүүх буюу бусад хууль хэрэгжилтийн нийтээр хүлээн зөвхөөрөгдсөн хууль зүйн учир холбогдол бүхий зан үйл”, /П.Баянбаатар, Б.Ганпүрэв, “Хууль хэрэглэх үйл ажиллагааны онолын үндэс, хууль зүйн позитивизмын хоногддог”, /Хууль хэрэглэх гээд нь хуулиар эрх олгосон эрх зүйн хэм хэмжээний заалт, зарчмыг удирдлага болгон хууль зүйт тодорхой асуудлыг шийдвэрлэхийн тулд эрх зүйт шийдэл гаргахад чиглэгдсэн ажиллагаа юм. зэрэгээр эрдэмтэн, судлаачид тодорхойлжээ./, А.К.Романов. “Их Британийн эрх зүй болон эрх зүйт тогтолцоо”, Орчуулсан Ч.Даваадаш, Уб., 252-254 дэх тал Оросын эрх зүй судлалд хууль эрх зүйт хэрэглэх гээд нь хуулийг тайлбарлах гэсэн үг юм. Их Британийн эрх зүйн тогтолцоонд “хууль эрх зүйт хэрэглэх” гэдэг нэр томъёог хууль хэрэглэх үйл ажиллагааны субъектээс хамааралттайгаар тайлбарладаг байна.

¹ Мильтон Фридман Рэуз Фридман, “Хувь заяагаа сонгох нь”, Уб., 2007 он, 196 дахь тал. “Чөлөөт зах зээлийн нэг шинж нь өрсөлдөөний гүйцэтгэх үүргэ мөн”, Хүрээд очижход нь ажилд авах өөр бусад ажил олгогч байдал учраас л ажилчин өөрийн ажил олгогчоо хамгаалагдсан байна. Ажил олгогчид цаана нь авч ажиллуулах өөр бусад ажилчид байгаа учраас ажилчдын зүтгэс дарамтанд орохос хамгаалагдсан байдал. Үйлчилж буй худалдагчаас гадна өөр бусад худалдагчид цаана нь байгаа учраас л хэрэглэгч хамгаалагдсан байдал юм гэжээ.

бүрийн шалтгаанаас болдог...³ Шүүх бол хууль хэрэглэх засаглах хэлбэрийн субъект ба харин зохион байгуулах хэлбэрийн субъектэд тодорхой нэг бүрчилсэн акт гаргаж буй албан тушаалтан байх боломжтой.⁴

Зарим судлаачид “Хуулийг зөвхөн шүүх хэрэглэдэггүй, төрийн бусад байгууллага, албан тушаалтан, иргэн бусад этгээд шийдвэр шийдэл гаргахдаа хэрэглэдэг” гэж тайлбарласан байна.⁵ Гэтэл “Эрх зүйн хэм хэмжээг ашиглах нь эрх зүйн харилцаанд оролцогчид субъектив эрхээ хэрэгжүүлж байгаа хэрэг юм. Хууль тогтоомжоор өөрт нь ногдуулсан үүргүүдийг биелүүлэх нь эрх зүйн хэм хэмжээг биелүүлж, гүйцэтгэж буй хэрэг. Харин хууль тогтоомжоор хориглосон зүйлийг зөрчихгүй байх нь эрх зүйг сахин биелүүлж буй явдал юм.⁶ хэмээн хууль хэрэглэх субъектийн талаар мөн тодорхойлжээ.

Хууль хэрэглэхтэй холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн⁷ хэрэглээ нь холимог эрх зүйд⁸ хууль хэрэглэх арга зүйтэй холбоотой. Холимог⁹ эрх зүй нь харьцангуй бие даасан шинжтэй буюу хувийн болон нийтийн эрх зүйн шинжийг өөртөө агуулдаг.

³ Д.Лүндээжанцан, “Хууль бүтээх үйл ажиллагаа ба хууль зүйн техник”, Уб., 2016 он 151 дэх тал.

⁴ А.К.Романов, “Их Британий эрх зүй болон эрх зүйн тогтолцоо”. Орчуулсан Ч.Даваадаш. Уб., 252-254 дэх тал.

⁵ Монгол улсын дээд шүүх. Шүүхээс хууль тайлбарлах, хэрэглэх, онол практикийн тулгамдсан асуудал. Уб., 2008 он, 224 дах тал.

⁶ Д.Лүндээжанцан, “Хууль бүтээх үйл ажиллагаа ба хууль зүйн техник”, Уб., 2016 он, 148 дах тал.

⁷ Хөдөлмөрийн харилцаа эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. 2012 он, 5 дахь хувцас /70 орчим хуульчилсан акт хөдөлмөрийн харилцаанд нийтлэг байдлаар үйлчлэхээр УИХ, ЗГ, Сайр эрх хэмжээнийнхээ хүрээнд дүрзм, журам, жагсаалт, зааврын хэлбэрээр батлан гаргаж хүчин төглөдөр хэвээр үйлчилж байна. Үүнээс гадна ажил олгогчоос хууль, хуульчилсан актад нийцүүлэн харилцааны онцлогтоо тохируулан, дотооддоо үйлчлэх дүрзм, журам, жагсаалтыг батлан гаргаж мөрдүүлж эрх нь хуулиар олгогдсон.

⁸ Кристофер Осакве, “Харьцуулсан эрх зүй судал”, Уб., 2005 он, 41 дэх тал.

⁹ Эрх зүйн онолын үүднээс бие даасан салбар эрх зүйд байх зарим шинж нь ХЭЭЗ-д үргүсгэгдэг. Тухайлбал, XTX-д салбарын зарчим нь томъёллогодогт. Энэ нь маргааныг шийдвэрлэхэд зарчмыг үнэлэх асуудал нь хууль хэрэглээний хувьд үнэтэй зүйл юм.

Босоо¹⁰ болон хэвтээ тогтолцоон дахь хөдөлмөрийн маргааныг, харилцаа үүссэн үндэслэлийг нь харгалзан иргэний ба захирагааны хэргийн шүүхээр харьялан шийдвэрлэгддэг. Нийтийн болон хувийн эрх зүйн хүрээнд¹¹ ажил олгогч, ажилтан талуудын хооронд үүссэн хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг шийдвэрлэхэд хууль тогтоомжийн хэрэглээний байршил нь,

Хөдөлмөрийн тухай хууль
Төрийн албаны тухай хууль
Хөдөлмөрийн тухай хууль+Иргэний хууль

Төрийн албаны тухай хууль+
Хөдөлмөрийн тухай хууль+Иргэний хууль...

Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан нь аль шүүхээр шийдвэрлэгдсэн эсэхээс үл хамааран Хөдөлмөрийн тухай хуулийн 69.1-ийн хэрэглээ нь онолын үүднээс практикт нэг мөр ойлгогдох нь чухал.

Монгол Улсын хэмжээнд ажиллах хүч буюу 15 түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам 1.4 сая 743.0/53.9% /мянга нь эрэгтэй, 635.8/46.1% /мянга эмэгтэйчүүд байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 848.8 /61.5% /мянга нь хот, суурин газарт, 530.4 /38.5% /мянга нь хөдөө орон нутагт амьдарч байна.¹² Эндээс ажиллах хүчийг тойм байдлаар харж болно.

Мөн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн маргааныг авч үзвэл,¹³

¹⁰ Хөдөлмөрийн тухай хуулийн, Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой энэ хуулиар зохицуулагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай болон бусад хуулиар зохицуулна. Мөн Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

¹¹ Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа практикт /хэвтээ тогтолцоо/ үүссэн бий байдлын хэлбэрэй хүчин төглөдөр үйлийг буй ХТХ-ийн хүрээнд тойм байдлаар авч үзвэл,

1. Дангваар /ХТХ 24.1, ИХ 369.1/
2. Холимог /ИХ 369.1, 359.1, 343.1/

3. Хийсвэрлэх байдлаар /ИХ 39.1, 8.1.1, 189.1, 1.2/

4. Түр зуурин /ХТХ 23¹, ИХ 359.1/

5. Тохиролцсон харилцаа /ХТХ 4.2, ИХ 13.1/

6. Итгэлцилээр үүссэн харилцаа /ХТХ 21.1, 21.3, УДШ тогтоол 2-т, ИХ 9.1 .../

¹² Монгол Улсын үндэсний статистикийн хороо, Монгол улсын нийтийн, эдийн засгийн байдал, 2018/7

¹³ “Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дун мэдээ”, шүүхийн ерөнхий зөвлөл, Уб., 2010-2017 он.

Хүснэгт №1

Он дараалал	Ажлаас үндэслэлгүй халагдсан	Өөр ажил буруу шилжүүлсэн	Цалин хөлслүүний маргзан	Бусад маргзан	Нийт маргзан
2010	568	17	272	121	978
2011	534	18	247	98	897
2012	459	18	196	69	742
2013	725	36	206	113	1 080
2014	742	28	475	132	1 377
2015	910	18	415	144	1 487
2016	1 213	59	653	295	2 220
2017	1 306	53	565	290	2 214

Эндээс шүүхээр шийдвэрлэгдсэн маргааны тоо өмнөх жилүүдээс өссөн үзүүлэлттэй байхаас гадна ажлаас үндэслэлгүй халагдсан маргааны тоо дийлэнх хувийг эзэлж байна. Ажлаас үндэслэлгүй халагдсантай холбоотойгоор шүүхээр хэрэг хянан шийдвэрлэгдэж буй хугацаа¹⁴-аар ажилгүй байсан хугацааны олговрыг ажилтан авах үр дагавар үүсдэг. Мөн бусад шалтгаанаар ажилтны олговор авах хугацаа нь нэмэгддэг. Тухайлбал, ажлаас халсан тушаал гаргаж өгөхгүй байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, дараагийн шатны шүүхэд гомдол гаргаснаар маргааныг тухай шатны шүүхээр хэлэлцэх, ажилтны дундаж цалин хөлс өсөх зэрэгтэй холбоотойгоор ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтны авах олговрын хэмжээ нь өсөх магадлалтай.¹⁵

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Хөдөлмөрийн тухай хуулиар ямар нэгэн хязгаарлалт байхгүй байгаа бөгөөд 1973 оны БНМАУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн 98-р зүйлд ...ажилгүй байсан бүх хугацааны цалинг....авах эрхтэй боловч 3 сарынхаас хэтэрч болохгүй гэсэн хязгаарлалт байсан байна.

Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр ажилтныг өмнөх ажилд нь XTX-ийн 36.1.2-оор эгүүлэн тогтоосны дагуу тус хуулийн 69.1 дэх заалтаар ажилгүй байсан бүх хугацаанд нь олговор олгох хуулийн зохицуулалттай.

¹⁴ ИХХШХТХ-ийн 71 дугаар зүйл /Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсэсэн өдрөөс хойш 60 хоног, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол шүүгч хэргийг хүлээж авсанас хойш 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ. Энэ хуулийн 71.1-д заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөө нэг удаа 30 хүртэл хоногор сунгаж болно.

¹⁵ Э.Золзаяа, Д.Дэлгэрцэцэг, “Ажилгүй байсан хугацааны олговрын эрх зүйн мөн чанар, эдийн засгийн үр дагавар”, Иргэний эрх зүйн онол, практик /ильтгэл, магадлалын эмхэтгэл/ Уб., 2017 он, 65 дахь тал.

Ажлаа олгогч из

Ажлаа нь эгүүлж авах /шүүхийн шийдвэрлэгж биелүүлж/ Ажлаа нь эгүүлж авахгүй байх /шүүхийн шийдвэрлэгж биелүүлж/

ИХ-9.4.3 Нийгүүр харилцаа

Дараалсан шаардлага

Хөөрдүүлэв тарилал XTX 69.1?

ИХ 9.4.3?

Сане №1 Иргэний хөргийн ансан шатны шүүхийн шийдвэр, 2018.12.11. Дугаар 2570

Л Шаардлага: Хөөрдүүлэв №1

Сане №2 Иргэний хөргийн ансан шатны шүүхийн шийдвэр, 2019.03.21. Дугаар 684

Л Шаардлага: дараалсан шаардлага: Хөөрдүүлэв №2

Шүүхээс тухайн нэхэмжлэлийг /дараалсан шаардлага/ авч хэлэлцээд дахин шийдвэр гаргаж ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой хууль ёсны ашиг сонирхлыг хангахдаа XTX-ийн 69.1 дэхь заалтыг баримтлан шийдвэрлэж байгаа нь хууль хэрэглээний хувьд 2 өөр харилцааг хуулийн нэг заалтаар шийдвэрлэж байгаа хэрэг юм. Энэ нь харилцааны тогтолцоо, хуулийн системчлэлийн хувьд боломжгүй.

I харилцаа Гэрээний үүргийн харилцаа /хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гарсан/

II харилцаа Гэм хор учруулсанас үүсэх үүргийн харилцаа /Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг эс биелүүлснээс үүссэн гэрээний бус үүргийн харилцаа байна.

Гэтэл Хөдөлмөрийн тухай хуулийн зохицуулалт нь, ХТХ 69 дүгээр зүйл. Буруу халсан буюу шилжүүлсэн үеийн олговор

69.1.Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу ажилтныг ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоосон бол түүнд ажилгүй байсан бүх хугацаанд нь урьд авч байсан дундаж цалин хөлстэй тэнцэх олговор, хэрэв бага цалинтай ажил хийж байсан бол зөрүүтэй тэнцэх олговрыг олгоно.

36.1.2.ажлаас үндэслэлгүй халагдсан¹⁶ ажилтныг өмнө нь эрхэлж байсан ажил, албан тушаалд эгүүлэн тогтоох тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

¹⁶ ХТХ 40 дүгээр зүйл.Хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачилгаар цүлхүүд үндэслэлгүй хуульчлагдсан.

Эндээс ажил олгогч ажилтан талуудын хооронд үүссэн цалин хэлс, олговортой холбоотой маргаан учраас л 69.1 дэх заалтыг 2 өөр харилцаан дээр нэг ижил хэрэглээд байгаа практик тогтсон байна. Иргэнлэг эрх зүйн системд эрх зүйн уян хатан байдал /flexibility/ хангах нь шүүхээс эрх зүйн хэм хэмжээг бүтээх гэдгээр бус харин хуулийн үзэл санаа, зорилгод нийцүүлэн хэм хэмжээг сонгох, төсөөтэй хэрэглэх, иргэний эрх зүйн суурь зарчим, түүнийг баталгаажуулсан ерөнхий хэм хэмжээг хэрэглэх зэрэг байдлаар иргэний эрх зүйн маргааныг шийдвэрлэх байдлаар илрэн гардаг байна. Учир нь хуульд захирагдах гэсэн үзэл санааг буруугаар, хэт явцууруулан ойлгож, хуулийн заалтыг тайлбарлалгүйгээр механикаар авч хэрэглэнээр тухайн нийгмийн болит зүй тогтол, нийгмийн гишүүдийн зүй ёсны тухай хүлээлтээс гажсан шийдвэр гарах нь эргээд эрх зүйн тодорхой байдлыг алдагдуулах үр дагаврыг бий болгодог байна.¹⁷

Нэгдүгээр харилцааны хувьд ХТХ-ийн 36.1.2-оор урьд эрхэлж байсан ажил, албан тушаанд нь эгүүлэн авснаар 69.1 дэхь заалт нь бүрэн хэрэгжиж, хүлээсэн үүргийг гүйцэтгүүлдэг.

Хоёрдугаар асуудлын хүрээнд:

Хууль хэрэглэх ажиллагааны явцад эрх зүйн хэм хэмжээний агуулга, зорилго улам бүр тодорхой болдог.¹⁸ Бусдад гэм хор учруулсан этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэхийн тулд уг этгээдийн гэм буруу, учирсан хохирлын хооронд шалтгаант холбоотой байх тухай зарчим дэлхийн улс орнуудад нийтлэг хэрэгжиж байна.¹⁹ Хуулийн тогтолцоо нь нэг түвшинд орших харилцан зохицсон хэм хэмжээнүүдээс бүрдэггүй. Харин ч эсрэгээр эрх зүйн цэвэр онолын үүднээс судалж үзвэл харилцан холбоотой, шаталсан хэм хэмжээнүүдийн

¹⁷ Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүйн онолын асуудал, Уб., 2018 он, 218 дахь тал.

¹⁸ Монгол Улсын Дээд шүүх. Шүүхээс хууль тайлбарлах, хэрэглэх, онол практикийн тулгамдсан асуудал. Уб., 2008 он, 223 дахь тал

¹⁹ Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, Уб., 2013 он, 96 дахь тал.

бүтэц л байdag.²⁰ Үндэсний эрх зүйн тогтолцоо, салбар эрх зүй, институт, бүлэг, зүйл, заалт бүгд уялдаа холбоотой, гинжин хэлхээтэй. Р.Дворкиний онолоор хууль тогтоомж хоорондоо цуврал роман шиг холбоотой, цул, бүхэллэгчанартай аж. Тийм учраас энэ тогтолцоо, гинжин холбоонд нь аливаа эрх зүйн хэм хэмжээг авч үзэж, бүрхэг угтыг нь тодруулж, хөдөлгөөнгүй нэгдмэл угтыг батлах ажиллагаа юм. Хэрэв тухайн хэм хэмжээний уялдаа холбоо тодорхойгүй, бүрхэг байсан ч шүүгч уг хэм хэмжээний тогтолцооны мөн чанар, агуулгад тулгуурлан тайлбарладаг.²¹

Нэг этгээдэд нөгөө этгээд хохирол учруулсан бол хохирогч нь шаардах эрхтэй тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй. Энэ шаардах эрх нь гэрээнд эсвэл хуульд зааснаар үүсч болно. Гэрээний шаардах эрхийг хэрэгжүүлэхийн тулд эхлээд гэрээ байгуулагдсан байх ба гэрээг зөрчсөн /гэрээний үүргээ зөрчсөн/ байх шаардлагатай. Харин хуульд зааснаар үүсэх шаардах эрхийн тухайд гэрээний харилцааг үндэслэл болголгүй хуульд заасан хэргийн бүрэлдэхүүн хангагдсан нөхцөлд хэрэгжих шинжтэй байдаг. Хохирлыг нөхөн төлүүлэх шаардах эрхээс үүсэх үр дагаврыг үүргийн нийтлэг эрх зүйд зохицуулсан байдаг.²²

Хууль тогтоогч ИХ-ийн 497.1-д “Бусдын эрх” хэмээх нэр томъёог оруулснаар гэм хорын эрх зүйн хамгаалах зүйлийг маш өргөн утгатай ойлгох боломжийг нээж байна. Энэ нь эрх чөлөө нөгөө талаас эрх зүйн тогтолцоонд хүлээн зөвшөөрөгдсөн бүхий л эрхийг хамарна.²³

²⁰ Х.Кельзен, Тайлбарын онолын тухай, Шүүх эрх мэдэл сэргүүл, 2015 он №2 Уб., 7 дахь тал. Орос хэлнээс проф. Н.Лүндэндорж хөрвүүлэв.

²¹ Н.Лүндэндорж, Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй / зөрчлийн улмаас үүсэх үүргэг буюу гэм хорын эрх зүй, Уб., 2017 он, 3 дахь тал.

²² Шварц Вандт, Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй / зөрчлийн улмаас үүсэх үүргэг буюу гэм хорын эрх зүй, Уб., 2017 он, 3 дахь тал.

²³ Б.Буянишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, Уб., 2010 он, 340 дэх тал.

Монгол Улсын Үндсэн хуулинд²⁴ хөдөлмөрлөхтэй холбоотой суурь баталгаа нь бий. Иргэний хуулийн 497.1-д бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөнд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах ҮҮРЭГТЭЙ.

Бусдын эрх гэдэгт хөдөлмөрлөх эрх ч бас зүй ёсоор орох юм.

Хөдөлмөрийн хууль тогтоомжийг хуулийн зорилтод²⁵, бүтцэд тулгуурлан хэрэглэхийн хувьд хэсэг, дэд хэсэг, бүлэг, дэд бүлэг, зүйл, заалт гэсэн бүтэцтэй. Мөн ИХ-ийн 369.3-д Хуульд өөрөөр заагаагүй бол хөдөлмөрийн гэрээнд энэ хуулийн ерөнхий үндэслэлийг хэрэглэнэ гэсэн заалттай. Өргөн хүрээтэй зарим томоохон хууль ангид хуваарилагдаагүй боловч хэсэг, дэд хэсэгтэй байдаг. Тэр нь бүлэг, зүйлүүдээс бүрдэнэ. Хэсэг, дэд хэсэгт ангилдгийн учир нь нийгмийн нийтлэг болон ижил төсөөтэй харилцаануудыг төрөлжүүлэх, төрөл тус бүрийг дотоодод нь улам нарийвчлан зохицуулж, хамгаалах арга ажиллагаанд суралцах, түүнийг танин мэдэх, улмаар зохих чадвар эзэмшиж хэрэгжүүлэх, эрх зүйн асуудал шинжлэх ухаанч, соёлтой, зөв хандах үзэл бодлыг төлөвшүүлэхэд ач тус үзүүлнэ. Хэсэг, дэд хэсэгт ангилагдсан томоохон хуулийн жишигэнд Иргэний хуулийг нэрлэж болно.²⁶

Иргэний эрх зүйн харилцааны тогтолцоо

I Өмчийн эрх зүй

II Үргийн эрх зүй

III Зөрчлийн улмаас үүсэх үүргийн эрх зүй

IV Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй эдгээр нь тус тусдаа хууль хэрэглээний асуудал яригддаг. Өөрөөр хэлбэл хууль хэрэглээний хувьд хэзээ ч хооронд хольж,

сольж, орлож болохгүй.


Иргэний хуулийн системчлэл

Хэсэг	I Е/ унасалт	II Үргэг үнээслэл	III Гэрээ үнээслэл	IV Г/бус заснаар	V Өвөлж хувь	VI ОУИЭЭ /ТБЭЗ/ маргзан
ИЭЗ-и сроний ангид хамаарал тай хэсэг	Үүргийн нийтгэг үнээслэл	Үүргийн эрх зүй	БӨХШХГҮ... БЗАХШХГҮ... АГТУХҮ 369.1 359.1 343.1	Зорилтой эрх зүй /гэр хөр/ ИХ-97	Хуульд заснаар үүсэх үүргийн эрх зүй	Холимог эрх зүй /ТБЭЗ/ маргзан
Өмчийн эрх зүй						
Дэл хэсэг		1				
Бүлэг	X	14 15 16 17 18 г/хөр арилгах	+	-	+ /ИХ 228.1- 230/	
		19 20 21	+	-	+	
Даа булаг					системчлэл	
Зүйл						
Заалт					Хууль хэрэглээ нь заалтын хэрэглэг байдаг.	

Эндээс хоёрдугаар харилцаа буюу дараалсан шаардлагын хувьд хууль хэрэглээ нь нэгдүгээр харилцаатай ижил байх боломжгүй юм. Хэдийгээр ажилтан, ажил олгогчийн хооронд хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан үүссэн боловч талуудын хооронд үүссэн харилцаа нь,

I харилцаа –Үүргийн эрх зүйн тогтолцоо-II

II харилцаа- Зөрчлийн улмаас үүсэх үүргийн эрх зүй-III буюу тогтолцоо, харилцаа, хууль хэрэглээний хоёр өөр асуудал байгаа болно.



Учруулсан хохирлыг арилгуулж
ИХ 497.1 /Бусдын эрх.../
Иргэний эрх зүйн хамгаалалтын арга/
ИХ 9.4.4

Эрхийн хэрэглээ 497.1-498.1-497.1-228-230

²⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн 16.4-т 4/ ажил мэргэжлийн чөлөөтэй сонгх, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхээс эрхтэй. Хөнгийн ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй, 17.2-т хөдөлмөрлөх нь иргэний бүрний журамт үүргээ мөн гэж хуульчлагдсан ...

²⁵ Зөвхөн нэг гэрээгээр хязгаарласан шинжтэй.

²⁶ О.Амархүү. “Эрх зүйн онол”, Уб., 2018 он, 203 дахь тал.

Иргэний хуулийн 228.1-д зааснаар гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно.

I харилцааны хувьд ажил олгогч нь хүчин төгөлдөр анхан шатны шүүхийн шийдвэр гарснаар ажилтныг ажилд нь эгүүлэн тогтоох буюу ИХ-ийн 9.4.3-аар хүлээсэн үүргийг гүйцэтгүүлэх /ХТХ-69.1/

II харилцаа нь I харилцааг ажил олгогч нь үйлдэл, эс үйлдэхүйн улмаас биелүүлээгүйгээс үүссэн ИХ-ийн 9.4.4-өөр учруулсан хохирлыг арилгуулах /ИХ-497.1/

Талуудын хооронд үүссэн хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг шийдвэрлэхдээ холимог эрх зүйн шинж, харилцааны тогтолцоо, хууль тогтоомжийн системчлэлд тулгуурлах нь зүйн хэрэг.

ДҮГНЭЛТ

Тус судалгааны ажлын хүрээнд Хөдөлмөрийн тухай хуулийн 69.1 дэх заалтын зорилго, хэрэглээний онцлогийг иргэний эрх зүйн харилцааны тогтолцооны хандлагаар авч үзэхэд тус заалт нь хоёр өөр тогтолцоо, хоёр өөр харилцаанд, хоёр өөр хууль хэрэглээний асуудал дээр нэг зорилгоор хэрэглэгдэж байгаа практик байна.

Иргэний эрх зүйн харилцааны тогтолцоо, Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хуулийн системчлэлийн үүднээс 69.1 дэх заалтын зорилго нь нь ажил олгогч, ажилтан талуудын хооронд үүссэн маргаануудын хувьд,

1. Ажлаас үндэслэлгүй халагдсантай холбоотой маргаан

2. Ажилд нь эгүүлэн тогтоосон шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэнтэй холбоотой маргаан байна. Өөрөөр хэлбэл, Иргэний эрх зүйн харилцааны тогтолцооны үүднээс авч үзвэл,

1. Гэрээний үүргийн маргаан

2. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн маргаан бүхий хоёр өөр харилцаа байна.

Хоёр өөр харилцааг ХТХ-ийн 69.1-ээр шийдвэрлэж байгаа нь буруу практик тогтсон гэж үзэж болохоор байгаа юм. Учир нь Иргэний эрх зүйн харилцааны тогтолцоо, тогтолцоог дагасан хуулийн системчлэлийн хувьд боломжгүй.

Боломжгүй гэдгийг илтгэлийн холбогдох хэсгүүдээс харах боломжтой.

Иргэний эрх зүйн харилцааны тогтолцоог зөв тодорхойлсноор хууль хэрэглээний хувьд хуулийн системчлэлээ дагаад зүйл, заалтын хэрэглээ зөв байх нь тодорхойлгдоно.

Тиймээс практикт үүссэн энэ төрлийн маргаан болон бусад хөдөлмөрийн маргааны хувьд ч тогтолцоог дагасан системчлэлийг анхаарч байх нь зүйтэй болов уу.

---00---

ҮР ХӨНДӨЛТИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ



Хуульч A.Tuvshintogs

ТОВЧЛОЛ:

Үр хөндөлт нь хараахан төрөөгүй хүүхдийн (unborn child) амьд явах эрх болон жирэмсэн эмэгтэйн жирэмслэлтийг таслан зогсоох эрхийн (right to terminate) огтолцол дээр үүсэн бий болдог маргаантай асуудал юм. Үр хөндүүлэх эрх нь эмэгтэйчүүдийн хувийн эрхэд хамаардаг боловч эрх бүхэн хуульд заасан үндэслэлээр хязгаарлагдана гэсэн зарчмын үндсэн дээр хязгаарлалтуудыг хууль болон журмаар зохицуулж ирсэн. Монгол Улсын хувьд эмэгтэйчүүдийн үр хөндөлтийг хуулиар хориглоогүй, хэрэв эмэгтэй хүн өөрөө хүсч зориулалтын газар эмнэлгийн нөхцөлд үр хөндүүлсэн тохиолдолд уг үйлдлийг эрүүгийн гэмт хэргийн шинжгүй бөгөөд Эрүүгийн хариуцлага хүлээлгэдэггүй. Сүүлийн жилүүдэд эрх зүйн өндөр хөгжилтэй улс орнуудад жирэмслэлтийн гуравдах үе шатанд үр хөндсэн тохиолдолд ургийн эрх зөрчигдөг тул хамгаалагдах эрхэд ургийн эрхийг хамааруулан Эрүүгийн хуулиндаа тусган зохицуулж байна. Ингэж зохицуулах үндэслэл нь анагаахын шинжлэх ухаанд ураг сүүлийн гурван сард амьдрах бүрэн чадвартай болдог бөгөөд зүрх, тархи бүрэн хөгжсөн байдаг гэж үздэгтэй холбоотой юм. Харин Монгол Улсын хувьд үр хөндөлттэй

холбоотой асуудалд анагаахын шинжлэх ухааны үүднээс бус эрх зүйн шинжлэх ухааны үүднээс авч үздэг хүн төрснөөр эрх зүйн чадвартай болдог гэсэн уламжлалт үзэл баримтлалыг баримталсаар байгаа нь ургийн амьд явах эрх зөрчигдөх, эхийн хувийн эрхийн хүслээр үр хөндөлт хийлгэх зэрэг асуудал үүсгэж байна. Дээрх асуудлыг энэхүү өгүүллээр онол, практикийн үндсэн дээр хөндөж, судалгааны дүгнэлт санал гаргахыг зорьсон болно.

1.1 НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Үр хөндөлт хэмээх нэр томьёог дотоодын болон гадаадын тайлбар тольд хэрхэн авч үзснийг толилуулья. Үр хөндөлт хэмээх нэр томьёо нь латин хэлний *Aboriri* гэсэн үгнээс гаралтай¹ бөгөөд англи хэлэнд abortion, герман хэлэнд *Abtreibung* гэж бичигддэг. Үр хөндөлт гэдгийг “Ураг хөндөх-анагаахын шинжлэх ухааны үүднээс дутуу хөнгөжих, байгалийн бус жамаар эхийн умайд байх ургийг гадагшуулах”², “Үр хөндөлт-үр хөврөлийг санаатайгаар устгах”³, “Үр хөндөлт-хугацаанаас өмнө жирэмслэлтийг таслах”⁴, “Үр хөндөлт-байгалийн бус аргаар ураг эсхүл үр хөврөлийг устгах”⁵, “Үр хөндөлт-биологийн үүднээс тайлбарлавал ураг, үр хөврөлийн хөгжлийг зогсоох”⁶, “Үр хөндөх гэдэг нь зориулалтын бус байр, газарт буюу эмнэлгийн бус нөхцөлд эмч болон мэргэжлийн бус хүн эхийн хэвлийд байгаа

¹ Mukesh Yadav, Alok Kumar. medical termination of pregnancy (amendment) act, 2002 an answer to mother's health & 'female foeticide'. 2005 он, 47 дах тал http://medind.nic.in/jal/105/1/jal_105i1p46.pdf.

² Эрхлэн гаргасан Б.Баярсайхан. Монгол хэлний тайлбар толь. Уб. 2011 он, 1271 дэх тал. Монсудар хэвлэлийн газар

³ Oran,Daniel. Oran's dictionary of the law. United States. 1983 он. 4 дэх тал.

⁴ Gifts,Steven.H. Dictionary of Legal terms: a simplified guide to the language of law. United States. 1998 он, 2 дах тал.

⁵ Henry Campbell Black. *Black's law dictionary*. 1990 он, 6 дахь хэвлэлт. 7 дах тал.

⁶ <https://en.oxforddictionaries.com/definition/abortion>

амьд ургийг зулбуулсныг хэлнэ⁷”, “Үр хөндөлт-ургийн амьдрах чадвартай тухайн цаг хугацаанаас өмнө жирэмслэлтийг таслах⁸” гэж тайлбарлажээ.

Үр хөндөлт гэдгийг олонх хэл зүйн тайлбар толь бичигт байгалийн бус жамаар ургийг гадагшлуулах, устгах хэмээн тайлбарлаж байгаа бөгөөд үр хөндөлтийг биологийн үүднээс ургийн хөгжлийг зогсоох, анагаахын шинжлэх ухаанд ургийн амьдрах чадвартай тухайн цаг хугацаанаас өмнө жирэмслэлтийг зогсоох, хууль зүйн шинжлэх ухаанд зориулалтын бус байр, эмнэлгийн бус нөхцөлд эмч болон мэргэжлийн бус хүн эхийн хэвлэйд байгаа амьд ургийн хөгжлийг зогсоохыг хэлнэ хэмээн тайлбарлаж байна. Үр хөндөлт хэмээх ойлголт нь хууль зүйн шинжлэх ухааны ойлголт бус анагаахын шинжлэх ухаанд илүүтэйгээр судлагдсан ойлголт юм.

Хууль зүйн шинжлэх ухаанд хууль бус үр хөндөлтийг эрүүгийн хариуцлагад тооцох, ямар тохиолдолд эрүүгийн хариуцлагад тооцохгүй байх зэргийг Эрүүгийн хууль болон тусгайлсан хууль, хэм хэмжээ тогтоосон актын хүрээнд тодорхойлж байна.

1.2 ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Үр хөндөлт нь хараахан төрөөгүй хүүхдийн (*unborn child*) амьд явах эрх болон жирэмсэн эмэгтэйн жирэмслэлтийг таслан зогсоох эрхийн (right to terminate) отголцол дээр үүсэн бий болдог маргаантай асуудал юм. Амьд явах эрх бол бүхий л эрхийн суурь эрх мөн. Харин үр хөврөл, ургийн хөгжлийг таслан зогсоох эрх нь хүн бүрт олгогдох эрх бус эмэгтэйчүүдийн эрх буюу хувийн эрх гэж үздэг хандлага байна. Үр хөндүүлэх эрхийг эмэгтэйчүүдийн хувийн эрхүүдэд (right to privacy) хамааруулан үздэг. Америкийн Нэгдсэн Улсад шүүхийн

⁷ Нэгтгэн хянаас: Ж.Бямбаа. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Уб., 2010 он, 339 дах тал. Эмхэтгэн хэвлүүлсэн Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, Эрх зүйн боловсрол академи, Герман Улсын Ханс-зайделийн сан.

⁸ Mukesh Yadav, Alok Kumar. medical termination of pregnancy (amendment) act, 2002 an answer to mother's health & 'female foeticide'. 2005 он, 47 дах тал. <http://medind.nic.in/jal/t05/i1/jal05i1p46.pdf>

прецедентийн үндсэн дээр Эмэгтэйчүүдийн хувийн эрхэд үр хөндүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх эрхийг хамааруулснаас гадна эмэгтэйчүүдийн хувийн эрхийн хязгаарлалтыг бий болгосон байдаг. Үр хөндүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх эмэгтэйчүүдийн хувийн эрх нь үр хөндөлтийн нэгдүгээр үе шатнаас хойш хугацаанд хязгаарлагддаг гэж үздэг. Энэ талаар олон онолын үзэл баримтлал байдаг бөгөөд олон ургалч үзлийн үндсэн дээр онолын тайлбарыг танилцуулъя.

Ургийн эрхийг хамгаалан үр хөндөлтийн эхний үе шат буюу гурван сараас хойш хугацаанд эхийн болон ургийн амь насанд аюул учрах нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд үр хөндөхийг хориглодог нь олон учир шалтгаантай. Энэхүү шалтгааныг хууль зүйн шинжлэх ухааны үүднээс бус анагаахын шинжлэх ухааны үүднээс илүүтэй тайлбарладаг.

▪ Биологийн эсийн үүслийн үүднээс тайлбарлан үзвэл:

Биогенетикийн хууль: Олонх амьд биес үр тогтсон өндгөн эсээс хөгждөг. Загас, гүрвэл, молтогчин, хүний хөгжлийн дараалсан үе шатыг харьцуулахад биесийн хэлбэр сүүл, мөчдийн үүсвэр, залгиурын хажуу дахь загалмайн сүвээрээ хажуудаа хоорондоо ихээхэн төстэй байдаг. Анхандаа бүгдээрээ адилхан хөвч, мөгөөрсөн нугалам, ганц эргэлт бүхий цус гүйх тогтолцоо, адилхан бүтэц бүхий бөөр гэх мэт бүх бүтцээрээ төсөөтэй байна. Харин цааш хөгжих тусам дээрх төсөө яванаадаа аажим багасаж тус тусын ангийн төрх шинж удам тодрон илэрнэ гэж үздэг⁹. Хүний нэг сартай хөврөлийн уураг тархи загасныхтай адил цуварсан таван тусгай хэсгээс тогтдог. Аажимдаа буюу гурван сар гаруй хугацааны дараагаас их тархи бусдынхаа дээгүүр бүрхэн атираа нугалаажих гадарга нь ихсэн хүний тархины төрх бүрддэг¹⁰. Беогенетикийн хуулийн үүднээс бүх хөхтөн амьтны эсийн үр хөврөл төсөөтэй хэлбэрээр хөгждөг ч тодорхой цаг хугацаа өнгөрөх тусам ангийн

⁹ Ц.Жамсран нар. Ерөнхий биологи. Уб., 1999 он, 73 дахь тал.

¹⁰ Мөн тэнд., 87 дахь тал

төрхөө давтан хөгждөг гэж үздэг хууль юм. Хүн хэмээх бодгаль нь арван хоёр долоо хоногоос хорин дөрвөн долоо хоногийн хугацаанд өөрийн төрхөө олж авдаг бөгөөд тархи, зүрх нь хөгжиж эхэлдэг байна. Тиймээс ургийг хүний нэгэн хэсэг, амьдрах чадвартай хэмээн тайлбарладаг.

■ Ураг хөгжих эрхтэй гэх үзэл баримтлалын үүднээс тайлбарлавал:

Үр хөврөл тасралтгүй хөгжлийн үр дүнд хүний төрхийг олдог. Эр эм бэлгийн эсүүд нийлэх үзэгдлийг үр тогтолт гэнэ¹¹. Үр тогтохын тулд өндгөн эсийн бүрхүүл дээрх бяцхан сүвээр сперматозоидын бөөм нэвтрэн орж ингэснээр сперматозоид өндгөн эс хоёрын бөөм нийлдэг. Сперматозоид бөөмтэй нийлж үр тогтсон өндгөн эсийг үр хөврөл (зигот) гэж нэрлэдэг. Бодгаль биеийн хөгжлийн бүх л үеийг онтогенец гэж нэрлэдэг бөгөөд үр тогтож зигот үүссэнээр шинэ бодгалийн хөгжил эхэлнэ. Ямар ч амьд биеийн хөгжлийг хөврөлийн шатны, хөврөлийн дараах шатны гэж хуваан үздэг. Хөврөлийн шатны хөгжил үр тогтсоноор үүсч эхийн хэвлэлийгээс гарч гадаад орчинтой шууд харьсан хөгжих шатандаа шилжктэл хөврөлийн хөгжлийн үе үргэлжилдэг байна. Хөврөлийн дараах үе шатыг шууд ба шууд бус гэж ангилдаг бөгөөд эхийн хэвлэлийгээс гарсан ураг биеийн гадаад, дотоод бүтэц, хэлбэр төрх нь бие гүйцсэн бодгальтай ижил төсөөтэй байх тул дорвitoй өөрчлөлтөд оролгүйгээр бойжих бие гүйцнэ үүнийг шууд хөгжил гэж нэрлэдэг байна. Хүн гэдэг үр хөврөлөөс эхлээд үр хөврөлийн дараах шат хүртэл хоёр мянга найман зуун цагийг эхийн хэвлэлийд өнгөрүүлдэг гэж үздэг нь хөгжлийн үе шатны хугацааг илэрхийлдэг. Хөгжих эрхийн талаар Англи-Америкийн эрдэмтэд өөрсдийн байр суурийг илэрхийлдэг¹² бөгөөд ургийн хөгжлийг тодорхой хугацаанаас хойш таслахыг хориглох байр суурьтай байдаг байна. Учир нь үр хөврөл тасралтгүй хөгжлийн

¹¹ Ц.Жамсран нар. Ерөнхий биологи.Уб., 1999 он, 138 дахь тал.

¹² Report by the Working Party on the Protection of the Human Embryo and Fetus. Steering committee on bioethics. The protection of the human embryo in vitro. Strasbourg, 19 June 2003. 5-6 дахь тал

үр дүнд хүний төрхийг олдог гэж үздэгтэй холбон тайлбарлаж болно.

• Анагаахын шинжлэх ухааны үүднээс тайлбарлавал:

Амьдрах чадвар хэмээх ойлголт нь хууль зүйн бус анагаахын шинжлэх ухааны ойлголт гэж үздэг¹³. Роналд Дворкин ургийг жирэмслэлтийн турав дахь үеэс өмнө хүн биш учир нь түүнээс өмнө ураг зовж тарчлах мэдрэмжийг мэдэрч чадахгүй гэж үзсэн байдаг¹⁴. Шинжлэх ухааны үүднээс судлаачид “Ойролцоогоор хорин зургаан долоо хоногоос Ургийн тархи хангалттай хэмжээнд зовж тарчлах мэдрэмжийг мэдэрч чадах хэмжээнд хөгжсөн байдаг”¹⁵ гэсэн тайлбарыг өгсөн байдаг. Канадын эрүүл мэндийн холбооноос “Өнөөгийн анагаахын шинжлэх ухааны хүрээнд амьдрах чадвар гэдгийг эхийн хэвлэлийд тээх хугацаа, хөгжлийн зэрэг, ургийн жин дэх бие даасан байдлыг харгалзан тогтоодог бөгөөд эхийн хэвлэлийд тээх хугацаа хорин долоо хоног өнгөрсөн, ургийн жин таван зуун граммаас илүү байх тохиолдолд ургийг амьдрах чадвартай¹⁶” хэмээн дүгнэснээс гадна Анагаахын шинжлэх ухаанд ураг хэмээх ойлголтыг “Ураг тогтсоноос хойш найман долоо хоногтойгоос төрөх хүргэл хөгжиж, өсөж буй хүний хөгжил”¹⁷ хэмээн тайлбарласан байдаг. Орчин үед эрүүл мэндийн шинжлэх ухаанд ураг эхийн хэвлэлийд бүрэлдэж ургийн хөгжил явагдаж эхэлсэн нь хүний бие организм мэдэгдэхүйц хэмжээнд амьдарч байгаа гэж үзэх болсон байна¹⁸.

• Ураг амьд явах эрхтэй гэсэн үзэл баримтлалын үүднээс тайлбарлавал:

¹³ Mollie Dunsmuir. abortion:constitutional and legal developments. Law and Government Division Reviewed 18 August 1998, 6 дахь тал.

¹⁴ Sai Abhipsa Gochhayat. Understanding of right to abortion under Indian constitutional. 2 дахь тал.

¹⁵ Clifford Grobstein. Science and the unborn: choosing human futures (Basic books, 1988), 13 дахь тал.

¹⁶ Mollie Dunsmuir. abortion:constitutional and legal developments. Law and Government Division Reviewed 18 August 1998, 6 дахь тал, Mukesh Yadav, Alok Kumar. medical termination of pregnancy (amendment) act, 2002 an answer to mother's health & 'female foeticide'. 2005 он, 47 дахь тал. <http://medind.nic.in/jal/105/i1/jal05i1p46.pdf>

¹⁷ Ц.Лхагвасүрэн нар. Монголын Анагаах ухааны үндэсний нэвтрэхий толь. III боть.Уб., 2012 он, 1368 дахь тал.

¹⁸ Мөн тэнд, 7 дахь тал.

Хүүхдийн эрхийн конвенцод¹⁹ “Хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж хамгаалалт, түүний дотор эрх зүйн хамгаалалт шаардлагатай” анхааралдаа авахыг улс бүрт үүрэг болгосон байна. Манай Улсад Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “Төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалулах нийгмийн амьдралд тэгш оролцох эрхийг тэгш хангах”²⁰ зарчмыг тусгажээ. Үнээс харахад Монгол Улсын хувьд хүүхдийн эрхийн конвенцоор үүрэг болгосны дагуу хүүхдийг төрөхөөс өмнө болон төрсний дараа хүүхдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хамгаалах учиртай. “Хүний суурь эрхүүд” – “Хүний эрхэм чанарын хооронд харилцан нөлөөлөл байх (mutual influence) ба хүний суурь эрх зөрчигдсөн тохиолдолд хүний эрхэм чанарыг ч мөн зөрчигдсөн гэж үзэж хамгаалдаг. Энэхүү ойлголтыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад “Schranken-Schranke” гэж дууддаг²¹. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн гаргасан тайлбарын дагуу Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт нь экийн хэвлэлий дэх ураг болон эрх зүйн чадвартай этгээдийг адилхан хамгаалдаг байна.²²

Онолын үзэл баримтлалын үүднээс үр хөндөлтийг ургийн хөгжлийн тодорхой цаг хугацаагаар хязгаарлах хандлагыг баримталж байна. Учир нь эмэгтэйчүүдийн амьд явах, эрүүл амьдрах эрхийг зөрчихгүй

¹⁹ Хүүхдийн эрхийн конвенц. 1989-11-20 өдөр баталж, 1990-09-02 өдөр хучин төгөлдөр болсон. Эрхлэн эмхэтгэсэн: Д.Баярсхан, Т.Золбоо. “Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл (Эрүүгийн эрх зүй. Эрүүгийн байсан шийтгэх эрх зүй)”. Уб., 2012 он, 44 дэх тал, Rights of the Pregnant child vs. rights of the unborn under the convention on the rights of the child. Boston University International law journal (Vol. 22:163), 2004 он, 165 дахь тал, Patrick J. Flood. Does International Law Protect the Unborn Child?. 9 дэх тал.

²⁰ Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль. 2016-02-05 он. Төрийн мэдээлэл, Дугаар 09 <http://www.legalinfo.mn/>

²¹ Reginald M.J.Oduor, Rainer Ebert. “The Concept of Human Dignity in German and Kenyan Constitutional Law”. A Journal of the Philosophical Association of Kenya. New Series, Vol.4 No.1, June 2012 он, 48 дахь тал.

²² Э.Байгал. “Иргэний эрх зүйн ерөнхий анги”. Уб.. 2009 он. 34 дэх тал.

байх, Үндсэн хуулиар олгогдсон эрхийг нь хязгаарлахгүй байх гэсэн үзэл баримтлалтай холбоотой. Нөгөөтэйгээр ургийн эрхийн суурь нь үр хөндөлттэй холбогдон үссэн бөгөөд ураг амьд явах эрхтэй, ургийн эрхэм чанарыг хүндэтгэх нь төрийн үүрэг гэх үзэл баримтлалын үүднээс ургийн эрхийг хамгаалж байна. Энэхүү хоёр эрхийн отголцол дээр үр хөндөлтийн эрх зүйн зохицуулалтын мөн чанар бий болдог.

ХОЁР. ҮР ХӨНДӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1 ҮНДСЭН АСУУДАЛ

Монгол Улсын хувьд эмэгтэйчүүдийн үр хөндөлтийг хуулиар хориглоогүй, хэрэв эмэгтэй хүн өөрөө хүсч зориулаалтын газар эмнэлгийн нөхцөлд үр хөндүүлсэн тохиолдолд уг үйлдлийг эрүүгийн гэмт хэргийн шинжгүй бөгөөд Эрүүгийн хариуцлага хүлээлгэдэггүй. Монгол Улс үр хөндөлтийн харилцааг Эрүүгийн хуулиар болон Эрүүл мэндийн тухай хууль, Үр хөндөлтийг зохицуулах журмаар тус тус зохицуулж байна²³. Монгол Улсын Эрүүгийн хуулиар (2002) эмэгтэй хүнийг тулган шаардаж үр хөндүүлэх, эмнэлгийн бус нөхцөлд болон мэргэжлийн бус хүн үр хөндсөн тохиолдолд үр хөндөх үйлдлийг гэмт үйлдэлд тооцон, тогтоохоор зохицуулсан. Эмэгтэй хүнийг тулган шаардаж үр хөндүүлэх, Эмнэлгийн бус нөхцөлд үр хөндөх гэмт хэргийн хамгаалгасан эрх буюу объект нь жирэмсэн эхийн амь нас, эрүүл мэнд байна гэж олонх эрдэмтэн нэгдмэл саналтайгаар тайлбарладаг²⁴. Сүүлийн жилүүдэд эрх зүйн өндөр хөгжилтэй улс орууладж шишигэлжүүлж гуравдах үе шатанд үр хөндсөн тохиолдолд ургийн эрх зөрчигдэг тул хамгаалагдах эрхэд ургийн эрхийг

²³ Монгол Улсын Эрүүгийн хууль (2002-01-03), Эрүүл мэндийн тухай хууль (2011-05-05, Төрийн мэдээлэл эмхтгэл дугаар 21), Үр хөндөлтийг зохицуулах журам (Эрүүл мэндийн сайдын 148 тоот тушаалын хавсралт, 2014-05-05)

²⁴ Нэгтгэн хянасан: Ж.Бямбаа. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Уб., 2010 он, 338-239 дэх тал, С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй:Тусгай анги.Уб., 1998 он, 79-81 дэх тал.

хамааруулан Эрүүгийн хуулиндаа тусган зохицуулж байна. Ингэж зохицуулах үндэслэл нь анагаахын шинжлэх ухаанд ураг сүүлийн гурван сард амьдрах бүрэн чадвартай болдог бөгөөд зүрх, тархи бүрэн хөгжсөн байдаг гэж үздэгтэй холбоотой юм. Харин Монгол Улсын хувьд үр хөндөлттэй холбоотой асуудалд анагаахын шинжлэх ухааны үүднээс бус эрх зүйн шинжлэх ухаанд авч үздэг хүн тэрснөөр эрх зүйн чадвартай болдог гэсэн уламжлалт үзэл баримтлалыг баримталсаар байна.

Үр хөндөлтийг зохицуулах журмаар үр хөндөлтийг эрт үеийн болон хожуу үеийн хэмээн хуваан авч үзсэн. Эрт үеийн үр хөндөлт гэдэгт жирэмсний эхний арван хоёр долоо хоног дотор үр хөврөлийг авах ажилбарыг хэлнэ, хожуу үеийн үр хөндөлт гэдэгт жирэмсний арван гурав долоо хоногоос хорин хоёр долоо хоногийн дотор жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслах ажилбарыг хэлнэ хэмээн зохицуулжээ. Эрт үеийн үр хөндөлтийг нэгдүгээрт, эмэгтэйн өөрийнх нь хүсэлтээр төлбөртэйгээр, хоёрдуугаарт, эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр төлбөргүйгээр гүйцэтгэхээр харин хожуу үеийн үр хөндөлтийг эмэгтэйн зөвшөөрлөөс гадна мэргэжлийн эмч нарын дүгнэлт, зөвлөгөөний шийдвэрээр гүйцэтгэхээр журмаар хуульчилжээ. Хожуу үеийн үр хөндөлтийг гүйцэтгэх онцгой хэд хэдэн шалтгаан бий. Тэдгээр шалтгаанаас бусад тохиолдолд үр хөндөхийг журмаар хориглосон нь ихээхэн ач холбогдолтой юм. Гэхдээ хожуу үеийн хугацаанд үр хөндөлтийг эмч, эмнэлгийн стандартын нөхцлийг ханган гүйцэтгэсэн нөхцөлд хэнд, хэрхэн хариуцлага тооцох тухай зохицуулалт тусгагдаагүй байна.

Эрүүгийн хууль болон Үр хөндөлтийг зохицуулах журмын уялдаа холбоог хууль зүйн үүднээс системчлэн тайлбарлавал Эрүүгийн хуулиар Эмэгтэй хүнийг тулган шаардаж үр хөндүүлэх, Эмнэлгийн бус нөхцөлд үр хөндөх буюу хууль бусаар үр хөндөх²⁵ гэмт үйлдлийг хуульчлан зохицуулсан, Үр хөндөлтийг зохицуулах

журмаар журамд заасан тохиолдлоос бусад зорилгоор хожуу үеийн хугацаанд үр хөндөхийг хориглоно хэмээн зохицуулжээ. Хожуу үеийн хугацаанд үр хөндсөн буюу ургийн хөгжлийг зогсоосон тохиолдолд 2002 оны Эрүүгийн хуулийн аль зохицуулалтад хамаарч зохицуулагдах эсэх асуудлыг тодруулан тайлбарлай. Эмэгтэй хүнийг тулган шаардаж үр хөндүүлэх гэмт хэргийн “тулган шаардаж” хэмээх ойлголтыг Эрүүгийн хуулийн тайлбарт “тулган шаардаж” гэдэг нь жирэмсэн эмэгтэйн ургийг хорин найман долоо долоо хоног болохоос өмнө үр хөндүүлэхээс өөр аргагүй байдалд хүргэж жирэмслэлтийг таслан зогсоосон гэм бурууний шууд санаатай, шунахайн болон хувийн сэдэлтгэй идэвхтэй үйлдлээр илэрн²⁶ хэмээн тайлбарласан. Хожуу үеийн хугацаанд болон эрт үеийн хугацаанд “Тулган шаардаж” үр хөндүүлсэн тохиолдол бүхэн энэхүү гэмт хэрэгт хамаарах хэдий ч тулган шаардаагүй тохиолдолд энэхүү гэмт хэргийн зүйлчлэлээр гэм буруутай этгээдийг буруутгах боломжгүй юм. Эмнэлгийн бус нөхцөлд үр хөндөх зохицуулалтаар нэгдүгээрт, эмч, эмнэлгийн бус нөхцөлд үр хөндсөн байх, хоёрдуугаарт, мэргэжлийн бус хүн үр хөндсөн байх урьдчилсан нөхцөлийг тогтоосон байна. Мэргэжлийн бус хүн гэдэгт үр хөндөх эрхгүй эмч, сувилагч, асрагч болон эмнэлгийн мэргэжилгүй хүн буюу субъект²⁷, эмнэлгийн бус нөхцөл гэдэгт эрүүл мэндийн байгууллагаас бусад газарт мэс ажилбарыг гүйцэтгэснийг²⁸ ойлгоно гэх тайлбараас үзвэл хожуу үеийн хугацаанд мэргэжлийн эмч, стандарт хангасан багаж хэрэгслээр, эмнэлгийн нөхцөлд үр хөндсөн тохиолдолд Эмнэлгийн бус нөхцөлд үр хөндөх зохицуулалтаар зүйлчлэх боломжгүй юм.

Эрүүгийн хуулийн (2015) 15.5.1-т “Эмнэлгийн нөхцөлд жирэмсэн эмэгтэйн

²⁵ Нэгтгэн хянасан: Ж.Бямбаа. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Уб., 2010 он, 338 дахь тал. Эмхэтгэн хэвлүүлсэн Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, Эрх зүйн боловсрол академи, Герман Улсын Ханс-зайделийн сан.

²⁷ Мөн тэнд. Уб., 2010 он, 339 дахь тал.

²⁸ Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол (2009-06-24, №.22)

амь бие, эрүүл мэндийг хамгаалах зайлшгүй шаардлагыг үндэслэн жирэмслэлтийг зогсоохоос бусад тохиолдолд хохирогчийн хүсэл зоригийн эсрэг жирэмслэлтийг хүчээр таслан зогсоосон бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж шинэчлэн найруулсан.

Дээрх зохицуулалтаар 2002 оны Эрүүгийн хуулиар зохицуулаагүй байсан эхийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зайлшгүй шаардлагыг үндэслэн жирэмслэлтийг зогсоохоос бусад тохиолдолд хохирогчийн хүсэл зоригийн эсрэг жирэмслэлтийг хүчээр зогсоосон тохиолдолд хариуцлага тооцохоор тусгасан нь ач холбогдолтой байна. Эрүүгийн хуулийн (2015) дээрх зохицуулалтаас үзэхэд эмнэлгийн нөхцөлд жирэмсэн эмэгтэйн амь бие эрүүл мэндийг хамгаалах зайлшгүй шаардлагыг үндэслэн жирэмслэлтийг зогсоохоос бусад тохиолдолд жирэмсэн эмэгтэй өөрөө хүсч жирэмслэлтийг зогсоолгосон тохиолдолд гэмт хэрэгт тооцохгүй байхаар харагдаж байна. Үр хөндөлтийг зохицуулах журамд зааснаар хожуу үеийн жирэмслэлтийг б тохиолдолд таслан зогсоохоор заасан. Үүнд:

а. Тухайн жирэмлэлт нь эх, ургийн амь нас, эрүүл мэндэд аюултай болох нь тогтоогдсон,

б. 18 хүртэлх насын охид өөрөө хүсвэл, эцэг эх асран хамгаалагчийн зөвшөөрлөөр,

в. 40-өөс дээш насын эмэгтэй өөрөө хүсвэл,

г. Сэтгэцийн эмгэгтэй,

д. Цусан төрөл ойртсон нь нотлогдсон,

е. Бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэлсэн.

Дээр зааснаас бусад тохиолдолд хожуу үеийн жирэмслэлтийг таслан зогсоонгүй байхыг журмаар хуульчлан зохицуулсан. Хориглосон хэм хэмжээ нь эрх зүйн онолын хувьд императив хэм хэмжээ байна. Гэтэл шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар журамд заасан хожуу үеийн жирэмслэлтийг тодорхой үндэслэлээс бусад тохиолдлоор, эхийн зөвшөөрснөөр таслан зогсоох

тохиолдолд хэрхэн хариуцлага тооцох эсэх нь тодорхойгүй байсаар байна. Энэхүү хариуцлагын механизмыг бий болгоогүй үр дагавар нь эрүүл бойжиж буй ургийг таслан зогсоох, ургийн амьд явах эрхийг зөрчих, хүн амын тоог цөөрүүлэх, эхийн эрүүл мэндэд аюул учрах зэрэг эрсдэлийг бий болгож байна.

2.2 ТҮҮХЭН СУДАЛГАА

Эрүүгийн хуульд (2002, 2015) үр хөндөлтийг зохицуулах журмаар зохицуулсан хориг хэм хэмжээг зөрчих тохиолдолд хэрхэн хариуцлага тооцох эсэх механизмыг байхгүй байх тул Монгол Улсын Эрүүгийн хууль (2002, 2015)-иас өмнөх хуулиудад эхийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл байдал бий болохоос бусад тохиолдолд жирэмслэлтийн авран хоёр долоо хоногоос хойш хугацаанд үр хөндөхийг хориглож, хууль бус гэж үзэн зохицуулж байсан эсхийг тодрууляя.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн (1961) 80 дугаар зүйлийн 80а-д Умай дах хүүхдийг хууль бусаар устгах явдлыг их эмч хүн үйлдвэл хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эмчлэх эрхийг нь хасна²⁹ хэмээх зохицуулалт байсан. Энэхүү зохицуулалтын шинжлэх ухааны тайлбарт “Хууль бусаар үр хөндөх гэдэг нь эхийн хэвлийд байгаа үрийг төрөх хугацаанаас нь өмнө эмнэлгийн эрх бүхий комиссын шийдвэрлгүйгээр устгахыг хэлнэ³⁰”, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн эрх (тусгай анги) бүтээлд: “Эхийн хэвлийд бойжиж яваа хүүхдийг устгах явдлыг хүн амины хэрэг гэж үздэггүй, үр хөндсөн хэрэг гэж тусгай зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Эхийн хэвлийд байгаа хүүхдийг хууль бусаар устгах явдал нь шууд объектын хувьд эхчүүдийн эрүүл мэндийн эсрэг чиглэсэн байдаг тул бусдын эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүдийн

²⁹ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн хууль (1961-01-31)

³⁰ Г.Совд нар. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 1982 он, 178 дах тал.

системд багтан ордог. Энэхүү гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинж нь үр хөндөлт хууль бусаар хийгдсэн байх явдал мөн. Хууль бусаар үр хөндөлт гэдэг нь заавал үр хөндөх шаардлагагүй байсан үед бусдын үрийг хөндөхийг хэлнэ³¹.” хэмээн тайлбарлажээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн хууль (1986³²)-ийн 103 дугаар зүйлийн 103.1-т “Их эмч хууль бусаар үр хөндсөн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсвэл гурван жил хүртэл хугацаагаар эмчлэх эрхийг хасах ял шийтгэнэ” хэмээн зохицуулж байсан байdag. Энэхүү хуулийн зохицуулалтыг хууль бус хэмээх ойлголтыг “үр хөндөхийг хэдийгээр хохирогчийн зөвшөөрөлтэй байсан ч эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон журмыг зөрчиж, жирэмслэлтийг зориуд тасалдуулсныг, энэхүү мэс заслыг хийж гүйцэтгэхийг хохирогч зөвшөөрсөн байdag нь энэ гэмт хэргийн заавал байх шинж байна. Объектив тал нь хууль бусаар үр хөндөх өөрөөр хэлбэл тогтоосон журмыг зөрчиж, жирэмслэлтийг зориуд зогсооход чиглэсэн идэвхтэй үйлдэл байна.³³” хэмээн тайлбарлажээ.

Монгол Улсын хувьд үр хөндөлттэй холбоотой харилцааг Эрүүгийн хуулиар зохицуулж байсан түүхэн уламжлалтай. Монгол Улсын Эрүүгийн хуулиудад (1961, 1982) хууль бусаар үр хөндсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байх бөгөөд хууль бусаар үр хөндөх гэдгийг нэгдгүээрт эхийн зөвшөөрлөөр байсан ч шаардлагатай бус тохиолдолд үр хөндсөн байх, хоёрдугаарт, эрх бүхий эмнэлгийн шийдвэргүйгээр үр хөндсөн тохиолдлыг хамруулахаар

хуульчилсан байжээ. Харин 2002 оны Эрүүгийн хуулиар хууль бусаар үр хөндөх хэмээх зохицуулалтыг өөрчлөн найруулсан байна. Түүхэн судалгаанаас үзэхэд Эрүүгийн хуучин хуулиудаар ургийн эрхийг хамгаалан зохицуулж чадаагүй ч эхийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд үр хөндөх, бусад тохиолдолд үр хөндөх тохиолдолд ял оногдуулахаар хуульчилсан байсан нь ач холбогдолтой байгааг дурдах нь зүйтэй байна.

ГУРАВ. ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА

3.1 ХУВИЙН ЭРХИЙН ХЯЗГААРЛАЛТ БА УРГИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ

Үр хөндөлтийн эрх зүйн зохицуулалт зүй зохистой ажиллах механизмыг хорьдугаар зууны сүүлээр гарсан шүүхийн нэр хүнд бүхий шийдвэрүүд бий болгосон гэж хэлж болно. Америкийн Нэгдсэн Улс болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын шүүхийн шийдвэрүүд нь үр хөндөлттэй холбоотой олон асуудлыг эмхлэн цэгцлэх, олон улсын чиг хандлагыг тодорхойлох үндэслэлийг гаргаж тавьсан бөгөөд энэхүү шийдвэрүүд гарсны дараагаар европын ихэнх улс орнууд үр хөндөлттэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс хууль тогтоомждоо өөрчлөлт, шинэчлэлт хийсэн байdag байна.

Үр хөндөлттэй холбогдуулан Америкийн Нэгдсэн Улсын Дээд шүүх хорьдугаар зууны сүүлээр Вэдийн эсрэг Роеийн хэргийг³⁴ хянан шийдвэрлэхдээ Нэгдгүээрт, Эхийн хэвлэйд ураг эхний гурван сар бойжих хүртэл хугацаанд буюу үр хөндөлтийн эхний шатанд Мужийн (state) зүгээс хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрөхгүй. Хоёрдугаарт, дараагийн гурван сар буюу үр хөндөлтийн хоёрдугаар шатанд эхийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс үр хөндөлтийн процедурын аюулгүй, баталгаатай байдлыг хангах үүднээс Мужийн зүгээс оролцох

³¹ Г.Совд. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын эрүүгийн эрх (Тусгай анги). Уб., 1965 он. 107-108 дах тал, Редактор Ж.Авшиа. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн эрх (Тусгай анги). Уб., 1979 он. 153-154 дах тал.

³² Баярсхайхан, С.Жанцан нар. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). Уб., 2011 он, 505 дах тал. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг батгах тухай, Ардын их хурлын тэргүүлэгчдийн зарлиг (1986-12-05, №.217)

³³ С.Нарангэрэл. Монгол Улсын эрүүгийн эрх зүй (Тусгай анги). Уб., 79 дэх тал.

³⁴ Roe v.Wade, 410 U.S. 113 (1973); Doe v.Bolton, 410 U.S. 179 (1973)

боломжтой, Гуравдугаарт, Үр хөндөлтийн хоёрдугаар шат дуусгавар болсны дараа Мужийн зүгээс ургийн амьд явах эрхийг хамгаалах ёстой. Ургийн хангалттай амьдрах чадвартай болсон тэр үеэс Муж хамгаалалт тогтоож үр хөндөлтийг хориглох шийдвэрийг гаргаж болно. Гэхдээ эхийн эрүүл мэнд, амь насанд эрсдэлтэй гэж эмч үзсэн тохиолдолд хэрэгжүүлж чадахгүй гэж тайлбарлан дутгэсэн байдаг. Мөн Америкийн Нэгдсэн Улсын Дээд шүүх Хүний хувийн эрхэд эх хэвлийд бойжиж буй ургийг төрүүлэх эсэх асуудалд шийдвэр гаргах эрх хамаарна, эхийн амьд явах эрхэд аюултай нөхцөл үүссэн тохиолдолд л үр хөндөх боломжтой гэж зохицуулсан нь үндсэн хуульд заасан хувийн эрхийг зөрчсөн байна хэмээн тайлбарлажээ³⁵. Америкийн Нэгдсэн Улсад хувийн эрхэд эх хэвлийд бойжиж буй ургийг төрүүлэх эсэх асуудалд шийдвэр гаргах эрхийг хамааруулан үздэг. Ураг үр хөндөлтийн гуравдах шатаас хойш амьдрах чадвартай гэж дүгнэн энэхүү цаг хугацаанаас хойш Улсын хувьд ургийн амьд явах эрхийг хамгаалах ашиг сонирхол нээлттэй болно гэсэн үзлийг баримталдаг байна.

Америкийн Нэгдсэн Улсын Georgia мужид үр хөндөлтийг хэрэгжүүлэх эмнэлгийн байгууллага нь үр хөндөлтийн хороогоор баталгаажсан, эрх олгогдсон эмнэлэг байх эсхүлмэргэжлийн хоёр эмчтэй хамтран хэрэгжүүлэх гэсэн шаардлагыг тавьсан байжээ. Энэхүү хэм хэмжээг Хорьдугаар зууны сүүлээр Doe эсрэг Bolton-ний хэргийг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль зөрчсөн зохицуулалт хэмээн Дээд шүүх дүгнэсэн байдаг. Учир нь үр хөндүүлэхийг хүссэн эмэгтэйн шаардлагыг хориглосон гэж үзсэн³⁶.

Баруун Германы шүүх жирэмсэн эмэгтэй арван хоёр долоо хоногийн дотор үр хөндөлт хийлгэх нь гэмт хэрэгт биш хэмээн шийдвэр гаргасан бөгөөд үүнээс хойш хугацаанд үр хөндөлт хийлгэх

³⁵ Philip Francis. Legal status of women, Second edition, United states., 1978. 7 дахь тал.

³⁶ Philip Francis. Legal status of women, Second edition, United states., 1978. 7 дахь тал.

нь эхийн хэвлийд бойжиж буй ургийн амьд явах эрхийг зөрчине гэж үзсэн. Үндэслэлдээ Германы Үндсэн хуульд зааснаар хүний амьд явах эрх, хүний эрхэм чанар хамгаалагдах бөгөөд эхийн хэвлийд бойжиж буй ургийн амьдрал бол үндсэн хуулиар хамгаалагдах үнэ цэнэтэй эрхэм чанар гэжээ³⁷.

3.2 ГАДААД ОРНУУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Бүгд Найрамдах Солонгос Улсын хувьд Эрүүгийн хуулиндаа³⁸ (1953) үр хөндөлтийг хориглосон зохицуулалттай байсан бөгөөд гэмт хэргийн субъектэд жирэмсэн эх болон эмч аль алиныг хамааруулж байжээ. Эх болон хүүхдийн эрүүл мэндийн актад³⁹ (1973) онцгой тохиолдлын систем буюу хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд үр хөндөлт гүйцэтгэхийг гэмт хэрэгт тооцоohoор хуульчилсан. Эх болон хүүхдийн эрүүл мэндийн актад онцгой тохиолдлын улмаас хохирсон эмэгтэйн ургийг тээх хугацаа хорин дөрвөн долоо хоногоос хэтрээгүй бол мэргэжлийн эмчийн зөвшөөрлөөр үр хөндөлтийг гүйцэтгэнэ хэмээн зохицуулсан. Ургийг тээх хугацаа хорин дөрвөн долоо хоногоос хэтэрсэн тохиолдолд бүх нөхцөл байдалд үр хөндөлт гүйцэтгэхийг хориглосон байдаг. Солонгос Улсын хувьд хувийн эрх буюу жирэмсэн эх өөрийн үр хөврөлийг үгүй хийх эсэх шийдвэрийг гаргахад нийтийн байгууллага хөндлөнгөөс оролцох эрхгүй гэж үздэг байна⁴⁰.

Энэтхэг Улсын Эрүүгийн хуульд амьдрах, амьд байх хэмээх ойлголтыг тодорхойлохдоо эхийн хэвлийд бойжиж буй ураг болон эхийн хэвлийгээс амьд терсөн хүүхдийг⁴¹ хамааруулжээ. Энэтхэг Улсын Эрүүгийн хуулиар (Penal code)

³⁷ Reva b.Siegel. the constitutionalization of abortion. 2012 он., 1067 дахь тал.

³⁸ korean criminal code, art. 269(1), 270(1)

³⁹ Mother-Child Health Act

⁴⁰ Andrew Wolman. Abortion in korea: a human rights perspective on the current debate over enforcement of the laws prohibiting abortion. 2010 он, 170 дахь тал.

⁴¹ Энэтхэг Улсын Эрүүгийн хууль (Penal code [1860]), 45 дугаар зүйлийн 45.1

эхийн амьд явах эрхийг хамгаалахын тулд жирэмслэлтийг таслан зогсоохыг хүлээн зөвшөөрдөг⁴². Эхийн амьд явах эрхийг хамгаалах зорилгоос бусад тохиолдолд ургийн хөгжлийг таслан зогсоохыг хориглодог байна. Эхийн амьд явах эрхэд аюултай гэдгийг эмнэлгийн байгууллагын магадлаагаар зөвхөн тогтооно гэж үздэг. Жирэмсэн эмэгтэйн амьд явах эрх эрсдэх боломжтой тохиолдлыг жагсаалтын тоочин заах зарчмын хүрээнд тогтоосон бөгөөд энэхүү тохиолдолд жирэмсэн эмэгтэйн бие болон мэдрэлд ноцтой эрсдэл бий болохоор бол, хүчиндэх гэмт хэргийн улмаас жирэмсэн болсон зэрэг тохиолдлыг хамааруулжээ. Эхийн амьд явах эрхийг хамгаалнаас гадна ургийн амьд явах эрхийг хамгаалах зохицуулалтыг тусгайлан зохицуулсан. Энэтхэг Улсад ураг эхийн хэвлийд хорин долоо хоногоос дээш хугацаанд тээгдэж буй тохиолдолд ургийн хөгжлийг зогсоохыг зөвшөөрдөггүй байна⁴³.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуулийн 218 дугаар зүйлийн 218.2-т Гэм буруутай этгээд жирэмсэн эмэгтэйн хүсэл зоригийн эсрэг үйлдэл хийсэн, эрүүл мэндэл хүнд гэмтэл учруулсан эсхүламь насандааултай үйлдэл болгоомжгүйгээр үйлдсэн үйлдлийг тус тус аюултай үйлдэлд хамааруулах бөгөөд уг үйлдэлд ял оногдуулна⁴⁴ гэжээ. Герман Улсад үр хөндөлтийн үйл ажиллагаа ямар тохиолдолд гэмт хэрэгт тооцогдохгүй талаар хэд хэдэн тохиолдлыг зохицуулсан байна. Герман Улсын Эрүүгийн хуулийн 219 дүгээр зүйлд “Жирэмсэн эмэгтэйн зөвшөөрлөөр мэргэжлийн эмчээр гүйцэтгэгдсэн, үр хөврөл эхийн хэвлийд арван хоёр долоо хоногоос дээшгүй хугацаанд бойжсон, жирэмсэн эмэгтэйн хувьд онцгой зовлон шаналал байсан бөгөөд эмчийн зүгээс зөвлөсний дараа түүний зөвшөөрөл олгогдсон зэрэг

тохиолдолд үр хөндсөн бол гэмт хэрэгт тооцогдохгүй⁴⁵. Гэж зохицуулжээ. Герман Улсын Эрүүгийн хуулиар ургийн хөгжил арван хоёр долоо хоногоос дээш хугацаа өнгөрснөөс хойш үр хөндөлт гүйцэтгэх тохиолдолд ял оногдуулахаар хуульчилсан. Үр хөндөлтийн гуравдахь үе шатнаас ургийн хөгжлийг зогсоохыг эсэргүүцдэг улсууд болох Грек, Норвеги, Австри зэрэг улсуудын хувьд эхийн эрүүл мэнд, амь насанд аюул учирснаас бусад тохиолдолд үр хөндөлтийн эхний үе шат буюу эхний гурван сараас хойш жирэмслэлтийг таслахыг хориглоно гэж үздэг байна. Швед Улсын хувьд найман долоо хоногоос хойш үр хөндөхийг зөвшөөрдөггүй⁴⁶. Австри Улсад үр хөндөлтийн эхний үе шат буюу эхний гурван сарын хугацаанд жирэмсэн эмэгтэйн хүсэлтээр үр хөндөхийг хүлээн зөвшөөрдөг.

Бельги Улсын хувьд үр хөврөл бүрэлдэн тогтсоноос эхлэн эхний үе шат буюу арван хоёр долоо хоногийн дотор үр хөндөхийг хүлээн зөвшөөрдөг. Бельги Улсын Эрүүгийн хуулиар хууль ёсны дагуу үр хөндөх тохиолдолд эмч нарын нэгдүгээр зөвлөгөөний дараа зургаан өдөр хүлээхийг жирэмсэн эмэгтэйгээс шаардлаг байна⁴⁷. Үр хөврөл бүрэлдэн тогтсоноос хойш эхний үе шат буюу арван хоёр долоо хоногийн хугацаа өнгөрснөөс хойш онцгой тохиолдолд үр хөндөхийг хууль ёсны гэж үздэг. Финланд Улс үр хөндөлтэй холбоотой эрх зүйн харилцааг Үр хөндөлтийн актаар зохицуулдаг. Үр хөндөлтийн актаар үр хөврөл бүрэлдэн тогтсоноос хойшарван хоёр долоо хоногийн дотор үр хөндөхийг хүлээн зөвшөөрч, гэмт хэрэгт тооцогхгүй байхаар зохицуулсан байдаг. Үр хөндөх зөвшөөрлийг жирэмсэн эмэгтэй өөрөө гаргах бөгөөд түүнд эхний шатанд зөвлөгөө өгөх ёстой гэж үздэг байна⁴⁸.

⁴² The Medical Termination of Pregnancy Act, (1971), Suchitra C Dalvie. Second trimester Abortion in India. 2008 он, 39 дахь тал.

⁴³ Sai Abhipsa Gochhayat. Understanding of right to abortion under Indian constitutional. 5 дахь тал.

⁴⁴ Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуулийн 13 November 1998, <http://germanlawarchive.iuscomp.org/?p=752#225>

⁴⁵ Mary Ann Clendon. Abortion and Divorce in Western law. United states. 1987. 22 дахь тал.

⁴⁶ Бельги Улсын Эрүүгийн хуулийн 350(1°), 350(2°) дугаар зүйл

⁴⁷ Финланд Улсын Үр хөндөлтийн актын (1970) 4 дүгээр зүйл

Франц Улсын хувьд үр хөндөлтийн эрх зүйн харилцаа жирэмслэхийг сайн дураар таслах журмаар зохицуулагддаг байна. Жирэмслэлтийн арван хоёр долоо хоногийн хугацаа дуусгавар болох хүртэл сайн дурын үндсэн дээр үр хөндөлтийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд арван хоёр долоо хоногийн хугацаа өнгөрсөн бол онцгой тохиолдолд үр хөндөж болно гэж үздэг. Энэхүү онцгой тохиолдол гэдэгт жирэмслэлт нь ургийн болон эхийн амь нас эрүүл мэндэд аюултай болох нь тогтоогдсон зэргийг хамааруулдаг⁴⁹. Онцгой тохиолдолд жирэмслэлтийг зогсоохыг мэргэжлийн эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр мэргэжлийн эмч нар хамтран гүйцэтгэх ёстой байдаг. Үр хөндөлт хийлгэхээр ирсэн жирэмсэн эмэгтэй болон түүний гэр бүлд гэр бүлийн төлөвлөлт, үр хөндөлтийн сөрөг үр дагаврын талаар зөвлөгөө өгч, зөвлөгөө авахыг санал болгодог байна.

Их Британи Улсын хувьд үр хөндөлтийн эрх зүйн харилцаа үр хөндөлтийн актаар зохицуулагддаг. Ургийн хөгжлийн үе шатнаас хамааруулан Үр хөндөх эсэхийг хүлээн зөвшөөрнө гэж үздэг. Арван дөрвөн долоо хоногийн дотор үр хөндөхийг хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрдөг⁵⁰. Үр хөндөлтийг гүйцэтгэх газар нь эмнэлгийн газар байх бөгөөд эмнэлгийн бус газрыг үндэсний аюулгүй байдлын алба тогтооно хэмээн зохицуулсан байна. Арван дөрвөн долоо хоногоос хойш хугацаанд эсхүл хууль бусаар үр хөндсөн тохиолдолд гэмт хэрэг хэмээн үздэг байна⁵¹.

Итали Улсын хувьд үр хөндөлтийн эрх зүйн харилцааг жирэмслэлтийг сайн дураар таслах болон эхийн эрүүл мэндийг хамгаалах актаар⁵² зохицуулагддаг байна. Үр хөндөлт гүйцэтгэх эсэхийг зөвхөн эхийн зөвшөөрлөөр гүйцэтгэдэг бөгөөд

⁴⁹ Франц Улсын жирэмслэлтийг сайн дураар таслах актын L2212-1, L2213-1

⁵⁰ Англи Улсын Үр хөндөлтийн акт (1967)-ын 87.1 дүгээр зүйл.

⁵¹ Хувь хүний эсрэг зөрчлүүдийн акт (Offences Against the Person Act)-(1861)-ын 58 дугаар зүйл.

⁵² Итали Улсын жирэмслэлтийг сайн дураар таслах болон эхийн эрүүл мэндийг хамгаалах акт [the Social Protection of Maternity and the Voluntary Interruption of Pregnancy (1978)]

эцгийн зөвшөөрлийг шаардлагүү байна. Үр хөврөл бүрэлдэн тогтоосоноос хойш арван есөн өдрөөс хойш хугацаанд Нэгдүгээрт, жирэмслэлт нь эхийн эрүүл мэнд, амь насанд аюултай нь тогтоогдсон, Хоёрдугаарт, ураг эмгэгтэй гэдэг нь тогтоогдсон тохиолдолд үр хөндөхийг хүлээн зөвшөөрдөг. Сэтгэцийн эмгэгийн улмаас эрх зүйн чадваргүй болсон жирэмсэн эмэгтэй үр хөндүүлэх тохиолдолд зөвшөөрлийг асран хамгаалагч, эсхүл түүний нөхрөөс авч болно гэхдээ жирэмсэн эмэгтэй өөрөө гаргах ёстой гэж үздэг байна⁵³.

Нидерланд Улсын хувьд үр хөндөлтийн эрх зүйн харилцааг Үр хөндөлтийн хуулиар зохицуулдаг бөгөөд үр хөндөлтийг тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн эмч нар, эмнэлгийн байгууллагад гүйцэтгэнэ хэмээн хуульчилсан. Үр хөндөлтийн хүлээн зөвшөөрөгдсөн хугацааны хязгаарлалтыг хуулиар тогтоогоогүй хэдий ч Нидерланд Улсад ургийн амьдрах чадварт тулгуурлан хорин дөрвөн долоо хоногийн дотор үр хөндөхийг хүлээн зөвшөөрдөг байна. Эмч нар үр хөндөлтийн ажилбарыг гүйцэтгэхээс өмнө зөвлөгөөнөөр хэлэлцүүлэх бөгөөд үр хөндүүлэхээр хүсэлт гаргасан эмэгтэйд зөвлөгөө өгснөөс хойш зургаан өдрийн дотор үр хөндөлтийг гүйцэтгэнэ⁵⁴ гэж зохицуулсан байдаг. Үр хөндөлтийн хүлээн зөвшөөрөгдсөн хугацаа өнгөрснөөс хойш нэгдүгээрт, ураг эмчлэгдэх боломжгүй өвчин туссан, хоёрдугаарт ураг эмчлэгдэх магадлал багатай өвчин туссан нь тогтоогдсон тохиолдолд үр хөндөх ажилбарыг гүйцэтгэж болно гэж үздэг байна⁵⁵.

Польш Улсын хувьд үр хөндөлтийн эрх зүйн харилцааг үр хөндөх журам, ургийн хамгаалалт, гэр булийн төлөвлөлтийн тухай актаар зохицуулж байна. Үр хөндөх ажилбарыг мэргэжлийн эмч нар гүйцэтгэх бөгөөд эхний арван хоёр долоо хоногийн дотор үр хөндөхийн хуулиар хүлээн зөвшөөрдөг. Эхний арван хоёр долоо

⁵³ Мөн тэнд, 13 дугаар зүйл.

⁵⁴ Нидерланд Улсын Үр хөндөлтийн хууль [Termination of Pregnancy law]-ийн 3.1 дэх зүйл

⁵⁵ Мөн тэнд, 4.1-4.3 дугаар зүйл.

хоног өнгөрснөөс хойш зөвхөн тухайн жирэмслэлт эхийн болон ургийн эрүүл мэнд, амь насанд аюултай, жирэмслэлт нь хууль бус үйл ажиллагааны үр дүнд бий болсон буюу бэлгийн хүчирхийллийн улмаас жирэмсэн болсон тохиолдолд⁵⁶ үр хөндөхийг хүлээн зөвшөөрсөн байна. Бусад тохиолдолд үр хөндөхийг хуулиар хориглож, гүйцэтгэсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцооор хуульчилжээ.

Олонх улс орнууд өөрсдийн улс орны онцлог, түүхэн уламжлал, хүн ардын аж төрөн суух ахуй зэргээс хамааруулан хууль тогтоомжоо харилцан адилгүй тогтоодог. Монгол Улсын хувьд үр хөндөлттэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг бусад улс орнуудынтай харьцуулахад нэгдгүйгээрт, Монгол Улсын хувьд ургийн эрхийн хамгаалалтыг хэдий чеэс хамгаалах шаардлагатай эсэхийг тодорхойлсон практик болон онолын судалгаа дутмаг байна, хоёрдугаарт хожуу хугацааны үр хөндөлтийг олон улсын жишигт нийцүүлэн тогтоосон хэдий ч хариуцлага тооцох механизмыг Эрүүгийн хуулиар болон журмаар тодорхойлж өгөөгүй, гуравдугаарт, үр хөндөлтийн өмнө жирэмсэн эмэгтэйд зөвлөгөө өгөх, үр хөндөхийн өмнө хугацаа тогтоох зэрэг процедурын зохицуулалт дутмаг байна. Үр хөндөлтийг гүйцэтгэх механизм үйл ажиллагаа нь анагаахын шинжлэх ухааны үүднээс илүүтэй тайлбарлагдаж, хэрэглэгддэг бол хариуцлага тооцох, эрхийн зөрчлийн асуудал нь хууль зүйн шинжлэх ухааны үүднээс тайлбарлан хэрэглэгддэг байна. Нийтлэг байдлаар олонх улсуудад жирэмслэлтийг арван хоёр долоо хоногоос хойш хугацаанд таслахыг хориглож хууль бус хэмээн үзэж байгаа бөгөөд энэ нь ураг амьд явах эрхтэй, ургийн эрхэм чанарыг хүндэтгэх нь төрийн үүрэг гэх үзэл баримтлалын үндэслэл болохоос гадна хожуу үед үр хөндөх нь эхийн амь нас эрүүл мэндэд хүнд аюул учруулна гэж үздэгтэй холбоотой байна.

Тиймээс манай улсын хувьд ургийн амьд явах эрхийг хамгаалах, эрхэм чанарыг хүндэтгэх, эхийн амь нас, эрүүл мэндийг эрсдэхээс урьдчилан сэргийлэх үүднээс хориг хэм хэмжээг Эрүүгийн хуулиар тусган зохицуулах хэрэгцээ шаардлага байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Онолын үзэл баримтлалын үүднээс үр хөндөлтийг ургийн хөгжлийн тодорхой цаг хугацаагаар хязгаарлах хандлагыг баримталж байна. Учир нь эмэгтэйчүүдийн амьд явах, эрүүл амьдрах эрхийг зөрчихгүй байх, үндсэн хуулиар олгогдсон эрхийг нь хязгаарлахгүй байх гэсэн үзэл баримтлалтай холбоотой. Нөгөөтэйгүүр ургийн эрхийн суурь нь үр хөндөлттэй холбогдон үүссэн бөгөөд ураг амьд явах эрхтэй, ургийн эрхэм чанарыг хүндэтгэх нь төрийн үүрэг гэх үзэл баримтлалын үүднээс ургийн эрхийг хамгаалж байна. Энэхүү хоёр эрхийн огтолцол дээр үр хөндөлтийн эрх зүйн зохицуулалтын мөн чанар бий болдог.

Монгол Улсын хувьд үр хөндөлттэй холбоотой харилцааг Эрүүгийн хуулиар зохицуулж байсан түүхэн уламжлалтай. Монгол Улсын Эрүүгийн хуулиудад (1961, 1982) хууль бусаар үр хөндсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байх бөгөөд хууль бусаар үр хөндөх гэдгийг нэгдгүйгээр эхийн зөвшөөрлөөр байсан ч шаардлагатай бус тохиолдолд үр хөндсөн байх, хоёрдугаарт, эрх бүхий эмнэлгийн шийдвэрлэгжээр үр хөндсөн тохиолдлыг хамруулахаар хуульчилсан байжээ. Харин 2002 оны Эрүүгийн хуулиар хууль бусаар үр хөндөх хэмээх зохицуулалтыг өөрчлөн найруулсан байна. Түүхэн судалгаанаас үзээд Эрүүгийн хуучин хуулиудаар ургийн эрхийг хамгаалан зохицуулж чадаагүй ч эхийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд үр хөндөх, бусад тохиолдолд үр хөндөх тохиолдолд ял оногдуулахаар хуульчилсан байсан нь ач холбогдолтой байгааг дурдах нь зүйтэй байна.

⁵⁶ Польш Улсын үр хөндөх журам, ургийн хамлаалалт, гэр бүлийн төлөвлөлтийн тухай акт [Act on Family Planning, Protection of the Human Fetus, and Conditions for Pregnancy Termination (1993)-ын 78 дугаар зүйл.

Олонх улс орнууд өөрсдийн улс орны онцлог, түүхэн уламжлал, хүн ардын аж төрөн суух ахуй зэргээс хамааруулан хууль тогтоомжкоо харилцан адилгүй тогтоодог. Монгол Улсын хувьд үр хөндөлттэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг бусад улс орнуудынхтай харьцуулахад нэгдүгээрт, Монгол Улсын хувьд ургийн эрхийн хамгаалалтыг хэдий үеэс хамгаалах шаардлагатай эсэхийг тодорхойлсон практик болон онолын судалгаа дутмаг байна, хоёрдугаарт хожуу хугацааны үр хөндөлтийг олон улсын жишигт нийцүүлэн тогтоосон хэдий ч хариуцлага тооцох механизмыг эрүүгийн хуулиар болон журмаар тодорхойлж өгөөгүй, гуравдугаарт үр хөндөлтийн өмнө жирэмсэн эмэгтэйд зөвлөгөө өгөх, үр хөндөхийн өмнө хугацаа тогтоох зэрэг процедурын зохицуулалт дутмаг байна. Үр хөндөлтийг гүйцэтгэх механизм үйл ажиллагаа нь анагаахын шинжлэх ухааны үүднээс илүүтэй тайлбарлагдаж,

хэрэглэгддэг бол хариуцлага тооцох, эрхийн зөрчлийн асуудал нь хууль зүйн шинжлэх ухааны үүднээс тайлбарлан хэрэглэгддэг байна. Нийтлэг байдлаар олонх улсуудад жирэмслэлтийг арван хоёр долоо хоногоос хойш хугацаанд таслахыг хориглож хууль бус хэмээн үзэж байгаа бөгөөд энэ нь ураг амьд явах эрхтэй, ургийн эрхэм чанарыг хүндэтгэх нь төрийн үүрэг гэх үзэл баримтлалын үндэслэл болохоос гадна хожуу үед үр хөндөх нь эхийн амь нас эрүүл мэндэд хүнд аюул учруулна гэж үздэгтэй холбоотой байна.

Иймд Монгол Улсын хувьд ургийн амьд явах эрхийг хамгаалах, эрхэм чанарыг хүндэтгэх, эхийн амь нас, эрүүл мэндийг эрсдэхээс урьдчилан сэргийлэх үүднээс хожуу үеийн жирэмслэлтийг Үр хөндөлтийг зохицуулах журамд зааснаас бусад үндэслэлээр таслан зогсоосон тохиолдолд хариуцлага тооцох хэм хэмжээг Эрүүгийн хуулиар тусган зохицуулах хэрэгцээ шаардлага байна.

---000---

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХЭСЭГЧЛЭН ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль
зүйн судалгааны төв¹*

ТҮЛХҮҮР ҮГС:

ЗТХ, зөрчил, шийтгэл оногдуулах үндэслэл, шударга ёс, хариуцлага.

ТОВЧЛОЛ:

Энэхүү судалгааны ажилд Зөрчлийн тухай хуулийн Нэгдүгээр бүлгийн 1.3-т шударга ёсны зарчим; Гуравдугаар бүлгийн 3.1-т шийтгэл оногдуулах үндэслэл; Тавдугаар бүлгийн 5.2-т танхайрах; Зургадугаар бүлгийн 6.21-т гүтгэх зэрэг зүйл, заалтыг сонгон авч түүний хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийж, тодорхой саналыг дэвшүүллээ. Судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтооолын б дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэсэн болно.

ҮНДСЭН ХЭСЭГ:

Зөрчлийн тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч зэрэг үнэт зүйлс, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх хариуцлагыг ялгамжтай оногдуулах, хууль зүйн хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор² баталжээ.

Зөрчлийн тухай хууль нь нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулж буй 230 гаруй хуулиар тогтоосон зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон хэм хэмжээг төрөлжүүлэн нэгтгэсэн³ анхны

хууль болсон.

Зөрчлийн тухай хууль нь зөрчлийг төрөлжүүлэн нэгтгэхдээ зарим төрлийн зөрчлийг тусгаагүй орхигдуулсан, хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангах, хамарвал зохих харилцааг орхигдуулсан, эрүүгийн гэмт хэрэг, эрүүгийн зөрчил, захиргааны зөрчил гэсэн нэр томъёог онолын түвшинд судлах, мөн хуулийг практикт нэг мөр ойлгон хэрэгжүүлэх зэрэг асуудлууд тулгамдаж байна.

Иймд үнэлгээний хүрээг тогтоохдоо хуулийн зорилго, хэрэгжилт, үнэлгээний шалгуурт нөлөөлөхүйц байдлыг харгалzan үзэж Зөрчлийн тухай хуулийн Нэгдүгээр бүлгийн 1.31 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Зөрчил үйлдсэн хүн хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна”, 3.1 дүгээр зүйлд заасан шийтгэл оногдуулах үндэслэл, 5.2 дугаар зүйлд заасан танхайрах, 6.21 дүгээр зүйлд заасан гүтгэх зэрэг зүйл, заалтыг сонгон авч зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд судаллаа.

Нэг. “Зорилгод хүрсэн түвшин”

1. Зөрчлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Зөрчил үйлдсэн хүн хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна” зохицуулалт зорилгодоо хэр нийцэж байгаа талаар:

“Зөрчил” гэсэн ойлголтыг онол болон практик талаас нь судалсан. Зөрчлийг бусад эрх зүйн зөрчлөөс ялган зүйлчилж чадсанаар түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн үндэслэл оновчтой болно. Зөрчлийн тухай хуулийн

¹ Судалгааг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор П.Амаржаргал ууидрах, Эрдэм шинжилгээний ажилтан Ц.Номиндарь, У.Эрдэнэзаяа нар гүйцэтгэв 2018 он.

² “Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”, <http://forum.parliament.mn/projects/75> сүүлд үзсэн 2018.10.02..

³ Мөн тэнд.

2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлэсгүй бол зөрчил үйлдсэнд тооцно.” гэснийг зөрчил гэж заасан байна. Онолын талаас нь судалж үзвэл “Зөрчил” гэх ойлголтыг доктор, дэд профессор Ч.Нямсүрэн “Эрх зүйн зөрчил гэж эрх зүйн хэм хэмжээний шаардлагыг зөрчсөн буюу түүний эсрэг чиглэсэн, нийгэмд хор аюултай, хуульд зааснаар хүлээх тусгай хариуцлага хүлээх эрх зүйн чадамжтай этгээдийн зан үйл” хэмээн бүтээлдээ⁴ тэмдэглэжээ. Мөн эрх зүйн зөрчлийг гэмт хэрэг, захиргааны эрх зүйн зөрчил, иргэний эрх зүйн зөрчил, сахилгын зөрчил, олон улсын эрх зүйн зөрчил гэсэн төрлүүдтэй хэмээн үзжээ.⁵

Тиймээс захиргааны зөрчил нь захиргааны журам зөрчсөнөөс үүдэн гардаг.⁶ Нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон зан үйлийн горим, эрх зүйн хэм хэмжээг захиргааны журам гэнэ.⁷ Захиргааны хариуцлага хүлээлгэх бодит үндэслэл нь захиргааны зөрчил гаргасан явдал юм. Иймд захиргааны зөрчилд эрх зүйн чухам ямар зөрчил орох, түүний бүрэлдэхүүн, үндсэн шинж, харьяллын тухай асуудлыг авч үзэх нь зүйтэй юм.

Зөрчлийн тухай хууль дагаж мөрдгэснөөс хойш хэрэгжилтийн явцад 1.3 дугаар зүйлд заасан тус хуулийн шударга ёсыг тогтоох зорилгод нийцээгүй зарим зүйл, заалт тусгагдсан нь илрэн гарч байна. Уг нехцөл байдлыг тодруулахын тулд тодорхой жишээг дурдья. Иргэн Г нь б нэрийн барааны дэлгүүр ажиллуулдаг, нэг өдрийн орлого нь 600.000-780.000 төгрөг байдаг. Мэргэжлийн хяналтын эрүүл ахуйн

байцаагчдын хяналт шалгалтын үр дүнгээр Зөрчлийн тухай хуулийн 10.15 дугаар зүйлийн 1.2-т “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүлахуйн стандарт, дүрэм, журам, хангаж ажиллаагүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасан нь эрүүл ахуйн стандарт хангаж ажиллаагүй гэсэн үндэслэлээр 3.000.000 сая төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан байна. Г нь уг торгуулийг төлөх мөнгө байхгүй бөгөөд торгуулиа төлөөд цаана нь дэлгүүрээ үргэлжлүүлэн ажиллуулах эргэлтийн хөрөнгөгүй болох нөхцөл байдал бий болж байна. Өмнөх эрх зүйн зохицуулалтын хүрээнд Эрүүл мэндийн стандарт хангаж ажиллаагүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага⁸ нь бага байсан бөгөөд нэг удаад сануулах эрх зүйн зохицуулалттай байсан.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд Зөрчлийн тухай хуулийн зорилго, 1.3 дугаар зүйлийн Шударга ёсны зарчим болон оногдуулах шийтгэлийн хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж хэр хэмжээнд тохирсон байна гэсэнтэй нийцэхгүй байгаа нь харагдаж байна. Уг зүйл, заалт нь Зөрчлийн тухай хуулийн зорилтыг хангаж шударга ёсыг тогтоох үндсэн зохицуулалт юм. Гэтэл “Зөрчил” гэх ойлголтыг уг хуульд онолын үүднээс нарийвчлан аль төрлийн зөрчил болохыг тусгайлан зохицуулаагүй нь хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсгэж байна.

2.Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд заасан “гүтгэх” зохицуулалт хуулийн зорилгодоо хэр нийцэж байгаа талаар:

Ардчилсан нийгмийн нэг чухал элемент нь хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж буй байдал буюу үзэл бодлын эрх чөлөө нь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой байдаг.

Монгол Улс хүний эрх, эрх чөлөөг дээдэлж 1992 онд баталсан Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсэгт “итгэл үнэмшилтэй байх, үзэл

⁴ Ч.Нямсүрэн, “Эрх зүйн онол” ерөнхий анги, Уб., 2016 он, 385 дахь тал.

⁵ Мөн тэнд.

⁶ Ж.Сүхбаатар, “Захиргааны эрх зүй”, Уб., 2005 он, 35 дахь тал.

⁷ Мөн тэнд.

⁸ Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №21, Уб., 2011 он.

бодлоо чөлөөтэй илэрхийлэх, уг хэлэх, хэвлэн нийтлэх” эрхийг хүний эрх, эрх чөлөөний гол цөм нь гэж үзэж болох бөгөөд итгэл үнэмшилтэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн арга нь уг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөө юм⁹, мөн хуулийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;”¹⁰ хэмээн заасан.

Түүнчлэн Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 19 дүгээр зүйлд хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж болно хэмээн заасан ба уг пактын үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлахдаа 19.3-т заасан шаардлагуудыг хангаж заавал хуулиар тогтоогдсон байх ёстой.

Ийнхүү хүний эрх, нэр төр, алдар хүндийг хамгаалах, иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрх чөлөөг баталгаажуулсан ба үүний зэрэгцээ мөн үүрэг, хариуцлага хамтдаа хэрэгжих бөгөөд Иргэний хууль¹¹, Зөрчлийн тухай хуульд зааснаар хариуцлага хүлээхээр зохицуулсан.

Зөрчлийн тухай хуулиар хариуцлага оногдуулахдаа хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлтэйгээр зохицуулсан байна. Ийнхүү иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг эдэлснийхээ төлөө их хэмжээний төгрөгөөр торгох санкцтaiй байхаар хариуцлагыг тодорхойлсон нь улмаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг боомилох, мэдээлэл хайх, хүлээн авах эрх

хязгаарлагдах эрсдэлтэй байж болзошгүй юм.

2.“Практикт нийцэж байгаа байдал”

1.Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасан “шийтгэл оногдуулах үндэслэл”¹² практикт хэр нийцэж байгаа талаар:

Уг хуулийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шийтгэлийн зорилго нь хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино гэж заасан байна.

Зөрчлийн тухай хууль 2017 онд мөрдөдөж эхлэхээс өмнө зөрчилтэй холбоотой асуудлыг 1992 онд батлагдсан Захиргааны хариуцлагын тухай хууль¹³-иар зохицуулж ирсэн. Зөрчлийн тухай хуульд нийт 1600 гаруй үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцоо зохицуулсан бөгөөд зөрчил үйлдсэн тохиолдолд торгох, баривчлах, эрх хасах гэсэн шийтгэл оногдуулахаар зохицуулсан байна. Үүнээс 931 торгох, 8 баривчлах, 16 эрх хасах, мөн торгох, баривчлах үндсэн шийтгэл дээр нэмэгдүүлэн эрх хасах шийтгэлийг оногдуулахаар заажээ. Зөрчлийн тухай хуулийн шийтгэлийн дийлэнх хувь нь торгох шийтгэлтэй.

Дээрх сонгосон зүйл, заалтад зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр заасан боловч үйлдэгдсэн зөрчилд хүлээлгэх эрх зүйн үндэслэлийг тусгайлан зохицуулаагүй орхигдуулсан байна. Тухайлбал, Хог хаягдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь хог хаягдаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх,...” гэж заасан байdag. Хуулийн зорилгын хүрээнд иргэн аж ахуйн нэгж, байгууллагууд нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хог

⁹ “Үндсэн хуулийн тайлбар”, Ханис-Зайдел сан. Эрх зүйн боловсролын академи, Уб., 2009 он, 98 дахь тал.

¹⁰ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №1, 1992 он.

¹¹ Иргэний хуулийн 21, 27, 497, 511 дүгээр зүйл.

¹²

Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйл бүтцийн хувьд 5 хэсэгтэй бөгөөд 1-3 хүртэлх хэсэг тус бүрт нь дүн шинжилгээ хийсэн болно.

¹³ Захиргааны хариуцлагын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 он, №4-5.

хаягдал, цас, мөсийг цэвэрлэх үүрэгтэй бөгөөд биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг дээрх хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3-т заасан. Гэвч Зөрчлийн тухай хуульд уг зохицуулалтыг тусгаагүй байна.

Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шинжийг харгалzan хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулна гэж заасан байна. Зөрчил нь дараах хууль зүйн шинжийг агуулдаг. Үүнд:

1. Эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн байх;

2. Нийгэмд хор уршигтай байх;

3. Гэм буруутай үйл ажиллагаа байх;

4. Хууль тогтоомжид заасан шийтгэл хүлээх үйлдэл, эс үйлдэл гэсэн шинжүүдтэй байна.¹⁴

Уг хуульд зөрчлийн шинжийг үл харгалzan тусгасан эрх зүйн зохицуулалт байна. Тухайлбал, Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Хууль тогтоомжийн дагуу хувь хүн, хуулийн этгээдийн орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг албан татвар гэнэ.” гэж заасан. Гэвч Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 6 дахь “татвар төлөгч хүн, хуулийн этгээд:”, 11.19 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6.1-д “хууль тогтоомжид заасан тайланг хуулиар тогтоосон хугацаанд татварын албанад гаргаж өгөөгүй” гэсэн нь ашиг, орлого, татвар ногдох зүйл байгаа эсэхээс үл хамааран хариуцлага хүлээлгэж байна. Энэхүү эрх зүйн зохицуулалтын үр дунд иргэн аж ахуйн нэгж байгуулсан боловч үйл ажиллагаа эрхлээгүй байх хугацаандаа татварын тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй хэмээн 5 сая төгрөгийн торгууль ногдуулж байна.

Зөрчлийн тухай хуулийн дээрх зохицуулалт нь зөрчлийн шинжийг бүрэн зохицуулаагүй боловч шинжийг нь үл

¹⁴ С.Долгорсүрэн, “Захиргааны хариуслага”, Уб., 2005 он, 47 дахь тал.

харгалзан шийтгэл оногдуулж байна. Хүн, хуулийн этгээд нь зөрчил үйлдээгүй байхад Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулж байгаа мэт зохицуулалтууд байна.

Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг үүргээ биелүүлээгүйтэй нь холбогдуулж шийтгэл оногдуулсан нь уг үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасан байна. Мөн Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцсоныг мэдээгүй нь тухайн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг шийтгэл, албадлагын арга хэмжээ хэрэглэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.” хэмээн заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 38.2.1 дэх хэсэгт “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах;” гэж заасан. Засгийн газраас хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулах бөгөөд хуулийг иргээдэд таниулах сурталчлах үйл ажиллагааг хариуцна.

Иргэдийн эрх зүйн чадавхын талаар 2016 онд Нээлттэй нийгэм форум нь иргээдэд тулгамдаж буй хууль зүйн үр дагавар бүхий бэрхшээл, түүнийг шийдвэрлэж буй арга хэрэгсэл, хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ авах хэрэгцээ, боломжийг тодорхойлох судалгааг¹⁵ үндэсний хэмжээнд хийсэн байна. Судалгаагаар иргээдэд өдөр тутамд тулгарч буй бэрхшээл, түүнийгээ шийдвэрлэж байгаа зан төлвийг сүүлийн 3 жилд тулгарсан бодит байдалд үндэслэн судлахад иргэдийн 54.8 хувьд нь хууль зүйн үр дагавар бүхий ямар нэг бэрхшээл тохиолдсон байна. Бэрхшээл тохиолдсон гэж хариулсан иргэдийн 50.5 хувь нь түүнийг шийдвэрлэх ямар нэг оролдлого хийх буюу мэдээлэл туслалцаа хайх, байгууллага албан тушаалтанд хандаагүй байна. Түүнчлэн иргэд юу ч хийгээд нээмзргүй гэж 36.8 хувь, юу хийхээ мэдэхгүй байсан гэж 25.5 хувь, тийм ноцтой асуудал биш гэж 17.3 хувь, харин 15.7 хувь нь надад ямар эрх байгааг сайн мэдээгүй гэх зэрэг

¹⁵ “Иргэдийн эрх зүйн чадавхийн өнөөгийн байдал” судалгаа, Нээлттэй нийгэм форум, 2016 он.

шалтгааны улмаас хууль зүйн үйлчилгээ аваагүй байна. Харин зөвлөгөө, үйлчилгээ авсан иргэдийн хувьд найз нөхөд, гэр бүл, танил талдаа хандсан гэж 40.8 хувь, холбогдох төрийн байгууллагад гэж 14.5 хувь, 15.6 хувь нь цагдаад хандсан бол 14.5 хувь нь хуульч, өмгөөлөгчид хандсан байна. Ийнхүү Монгол Улсын иргэд хууль зүйн туслалцаа хаанаас хэрхэн эрж хайхаа мэдэхгүй, хуулиар олгогдсон боломжийг ашиглаж, ашиг сонирхлоо хамгаалах, эрхээ хэрэгжүүлж чадахгүй буюу эрх зүйн чадавх сүл байгааг судалгааны дүн харуулж байна.

Энэ тухайд “...иргэд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, аюулгүй байдлаа хамгаалах байдал хангалтгүй байгаа нь иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсрол дутмаг, өөрт тулгарсан асуудлаа хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд шийдвэрлэх чадавх сүл байгаатай холбоотой байна”¹⁶ гэжээ.

Иргэдийн эрх зүйн боловсрол, чадавх хангалттай бус, эрх, ашиг сонирхол нь зөрчигдвэл хуулийн дагуу эрхээ хамгаалах чадвар сүл байгаа нь Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 3.1.3 дахь хэсэгт заасан зохицуулалт хэрэгжихэд хүндрэл учирахаар байна.

2. Зөрчлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйл. Танхайрах зохицуулалт практикт хэр нийцэж байгаа талаар:

Зөрчлийн тухай хуулийн тавдугаар бүлэгт нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил буюу нийтийн хэв журмын зөрчилд танхайрах зөрчлийг уг ангилалд багтаасан. Зөрчлийн тухай хуульд “олон нийтийн газарт биеэ зүй бусаар авч явах, танхайрах” гэсэн хоёр терлөөр танхайрах зөрчлийг тус тусад нь ялгаж зохицуулсан.

Олон нийтийн газарт биеэ зүй бусаар авч явах байдлыг энэхүү хуулийн 5.1 дүгээр зүйлд зааснаар “олон нийтийн газар, авто зам, орон сууцны орчим, гудамж талбайд бие зассан, эсхүл нус, цэр, тамхины иш хаясан” бол олон нийтийн газарт биеэ зүй бусаар авч явах гэж үзэх юм.

Харин танхайрах зөрчилд Зөрчлийн тухай хуульд зааснаар дараах зүйлсийг хамааруулан ойлгоно.

Олон нийтийн газарт:

1.1.хэрүүл маргаан үүсгэж;

1.2.бусдыг өдөөн хатгаж;

1.3.бусдын амгалан тайван байдал алдагдуулж;

1.4.олон нийтийг үл хүндэтгэж;

1.5.үйлчилгээний болон дарааллын журам зөрчиж биеэ авч явах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн, эсхүл аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан.

Эндээс олон нийтийн газарт хэмээн нарийвчлан зааснаар хязгаарлалт үүсгэж буй нь практикт танхайрах зөрчлийг шалган шийдвэрлэхэд зарим нэг бэрхшээл учирч байна.

Тухайлбал, тус зөрчлийн 1 дэх хэсэгт “олон нийтийн газарт” үйлдэгдсэн байх шинжийг тусгасан. Гэтэл өөрийн оршин суух хашаа байшин болон монгол гэртээ архидан согтуурсан, хэрүүл маргаан үүсгэсэн, бусдыг өдөөн хатгасан, амгалан тайван байдал алдагдуулсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх боломжгүй байна. Учир нь ахуйн хүрээнд архи ууж, гэр бүлийнхэндээ агсам тавьж танхайрдаг, зүй бусаар бусдыг доромжилдог зэрэг байдлууд ихэнхдээ тохиолддог бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт заасан “нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах” гэсэнд хамааруулах боломжгүй болж байна.

Дээр дурдагдсан зөрчлүүд гэр хороололд, монгол гэр, хашаа байшинд үйлдэгдэхэд танхайрах зөрчилд хамааруулж болохгүй нөхцөл байдал бий болж байгааг анхааран үзэх шаардлагатай болж байна.

Зөрчлийн тухай хуулиар танхайрах зөрчилд тортог шийтгэлийг оногдуулж байгаа тохиолдолд эрх бүхий албан тушаалтан заавал шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлэх эсэх нь тодорхойгүй ба нэгжүүдэд өөр өөр практик тогтох хандлагатай байна.

¹⁶ С.Энхцэцэг, “Эрх зүйн боловсролгүйгээс иргэд эрхээ эзэлж чадахгүй байна” /яришилага/, 2018.11.14, www.legalinstitute.mn (сүүлд үзсэн 2018.11.18.).

Хуулийг практикт нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл үүсэх, хууль зүйн техник, утга найруулгын алдаатай, байгаагаас шинэчлэлийн үр дүн зарим талаар хүссэн үр дүндээ хүрээгүйг харуулж байна.

Иймд танхайрах зөрчлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

3.Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйл.Гүтгэх зохицуулалт практикт хэрнийцэж байгаа талаар:

Гүтгэхтэй холбоотой асуудлыг 2002 оны Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлүүдэд хүний нэр төр хамгаалах талаар зохицуулж байсан ба 2015 онд шинчилсэн найруулсан Эрүүгийн хуулиас гүтгэх, доромжлох гэсэн заалтыг хасч Зөрчлийн тухай хуульд нэгтгэж зохицуулсан. Гэхдээ энэхүү “гүтгэх” гэсэн зохицуулалтыг практикт хэрэглэхэд зарим зүйлийг тодруулах шаардлага ажиглагдаж байна. Тухайлбал, Говь-Алтай аймгийн прокурорын газраас бусдыг доромжилсон гэх зүйл хэсэг байхгүй байна. Тиймээс “хүний нэр төр алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон, эсхүл худал мэдээллийг нийтэд дэлгэж гүтгэсэн, мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол ... гэж өөрчлөх”.

Түүнчлэн Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн цагдаагийн албан хаагч Зөрчлийн тухай хуулиар тухайн иргэнийг доромжилсон тохиолдолд гомдлыг зөрчлийн шинжгүй гээд татгалзаж байгаа. Учир нь Зөрчлийн тухай хуулиар энэ төрлийн гомдлыг зөрчлийн шинжгүй гээд гомдол хүлээн авахаас татгалзаж байна.¹⁷

Дээрх тохиолдоос харахад доромжлохтой холбоотой асуудлыг практикт зөрчлийн шинжгүй гэж үзэж, гомдол хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэж байна.

Зөрчлийн тухай хуулийн гүтгэх гэсэн зохицуулалтын агуулгыг харахад

¹⁷ Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хүрээнд хийсэн ганцаарчилсан ярилшагын үр дүнгээс, Уб., 2018 он.

гүтгэх, доромжлох асуудлыг нэгтгэж, хамрах хүрээг өргөжүүлж зохицуулсан байхаар ойлгогдож байна. Ийнхүү гүтгэх, доромжлох асуудлыг зохицуулахдаа өгүүлбэрийн гишүүдийг тусгаарлаж, өгүүлбэрийн утга санааг тодруулаагүйгээс хоёрдмог утга, ойлголтын зөрүү үүсэх нөхцөл болсон байж болох юм.

Шийтгэл оногдуулж буй байдал:

Зөрчлийн тухай хуулиар “хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тортогох”-оор заасан нь практикт төдийлон нийцтэй бус байна.

Энэ талаар “...их хэмжээний торгууль төлөх нь үзэл бодлоо илэрхийлэх болон хэвлэн нийтлэх эрх чөлөөг эдлэхэд айdas төрүүлдэг. Их хэмжээний торгууль төлөх айdas нь нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлыг хэвлэх мэдээлэхээс хэвлэлийнхэн татгалзахад хүргэдэг”¹⁸ хэмээн үзжээ.

Мөн иргэд, сэтгүүлчид үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө Зөрчлийн тухай хуулиар өндөр хэмжээний торгууль төлөх хариуцлага оногдуулж байгаа нь санхүүгийн дарамт болж амьдралд төдийлон нийцэгүй хууль хэрэгжиж эхэлсэн гэж эсэргүүцэл илэрхийлэх болсон. Тухайлбал, энэхүү зохицуулалт нь аливаа нэгэн шүүмжлэлт илэрхийлэл нь нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон үйлдэл болж, зарим тохиолдолд тухайн хувь хүн, байгууллагыг оршин тогтонох боломжгүй болгох хүргэл нөлөөлж болохуйц, ялангуяа улс төрчид, өндөр албан тушаалтны сэтгүүлчдийг айлган дарамтлах хэрэгсэл болгон ашиглаж болох нийгэмд халтай үр дагавар хэвээр үлдээж байна гэж үзэж байна.

Шинэ хууль нь олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой ч хамрах

¹⁸ О.Мөнхсайхан, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүзэн түтгэлгийг зохицуулах нь”, Эрх зүйл сэтгүүл, №2 Уб., 2017 он.

хүрээ, нэр томьёо, хариуцлага тооцох этгээдийг нарийвчлан тодорхойлоогүйгээс “гутаан доромжилсон” гэдгийг хэн нэгэн эрх бүхий албан тушаалтан тодорхойлох болж байгаа нь хуулийн заалтыг хэтрүүлэн хэрэглэхэд хүргэж болзошгүй тул энэ чиглэлээр Дээд шүүхийн тайлбарыг гаргахыг шаардаж байна гээд Хэвлэл мэдээллийн байгууллага хэвлэн нийтэлсэн зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээн гэж Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулинд заасан байdag бөгөөд Зөрчлийн тухай хуулиар хувь хүн, байгууллагыг торгоно гэж байгаа нь сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн байгууллагад хариуцлагыг давхардуулан хүлээлгэх эрсдэлийг дагуулж, сэтгүүлчдийг айdas хүйдэст автуулан байдлыг бодитоор мэдээлэхээс түдгэлзэхэд хүргэж, хэвлэл мэдээлээр дамжуулан эрх мэдлийг хянах иргэний эрх хохирох аюулыг бий болгоно¹⁹ хэмээн узжээ.

Зөрчлийн тухай хууль нь иргэний маргаанаар шийдвэгдэх асуудал /гүтгэх, доромжлох/-д төрийг татан оролцуулж торгуулиар далайлгах, улмаар хууль сахиулах байгууллагад хэрэгцээгүй илүү эрх мэдлийг төвлөрүүлэх, хохирогчийн хохирол барагдах боломжгүй болгож байна. Үүний оронд Иргэний хуулиа задлан чамбайруулах, гэм хорын хууль эрх зүйн орчноо шинэчлэхийн оронд бүгдийг нь хаман заавал шүүхээр шийтгүүлэх / ял шийтгэлийн гэмт хэрэг/ болгож хууль сахиулах зардлыг үлэмж нэмэгдүүлсэн хууль болсон.²⁰

Сүүлийн жилүүдэд гүтгэх, доромжлох асуудлыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиар бус Иргэний хуулийн зохицуулалтыг узэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн зохицуулах²¹ ёстой гэсэн байр суурь, узэл санаанууд эрдэмтэн, судлаачид, иргэдээс нэлээд хөндөгдөх болсон.

¹⁹ Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл Глоб интернэйшилтэв, 2017-07-02, <http://eagle.mn/r/31932> (сүүлд үзсэн 2018.09.10).

²⁰ “Гүтгэх” эрх, http://batengineer.blogspot.com/2017/04/blog-post_29.html?m=1@batengineer'sblog (сүүлд үзсэн 2018.09.17).

²¹ О.Мөнхсайхан, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь”, Эрх зүй сэтгүүл №2, Уб., 2017 он.

Гэтэл 2018 оны 5 дугаар сарын 28-ны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн 13.14 дүгээр зүйлээр гүтгэх²²-ийг буцааж Эрүүгийн хуульд тусгахаар болсон нь дахин няяталж зохицуулах шаардлагатайг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах дүгнэлтийг хийж, зөвлөмж боловсрууллаа.

а.Зорилгод хүрсэн байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1.Зөрчлийн тухай хуулийг боловсруулахдаа зөрчил гэх ойлголтыг онолын талаас нь нарийвчлан тодорхойлоогүй байна. Тиймээс зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтэд сөрөг үр дагавар үүсгэхээр байна. Шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэхийн тулд зөрчил гэх ойлголтыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна. Эрх зүйн хариуцлага нь эрх зүйн зөрчилд үндэслэгдэж, нарийн зааг ялгааг гаргасны үндсэн оногддог бөгөөд зөрчил буруу тодорхойлогдсоноор оногдуулах шийтгэл тохиromжтой бус байна. Энэ нь Зөрчлийн хуулийн хэрэгжилтийг гажуудуулах үндэс нь болдог байна.

Зөрчлийн тухай хууль нь Монгол Улсын нийт 230 гаруй хуулийг нэгтгэж 1250 орчим зөрчлийг тусгаж өгсөн боловч зарим зөрчлийн шинжийг бүрэн тодорхойлж зааж өгөөгүй, зөрчлийн шинжийг нарийн тодорхойлоогүй тул түүнд хүлээлгэх хариуцлага оновчтой бус болсон байна.

2.Зөрчлийн тухай хуулийн зорилго, 1.3 дугаар зүйлийн шударга ёсны зарчим болон оногдуулах шийтгэлийн хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж хэр хэмжээнд тохирсон байна гэсэнтэй нийцэхгүй байгаа нь харагдаж байна. Уг зүйл, заалт нь Зөрчлийн тухай хуулийн зорилгыг хангаж шударга ёсыг тогтоох үндсэн зохицуулалт юм. Гэтэл “Зөрчил” гэх ойлголтыг уг хуульд онолын үүднээс нарийвчлан аль төрлийн зөрчил болохыг тусгайлан зохицуулаагүй нь хуулийг хэрэгжүүлэхэд хундрэл бэрхшээл үүсгэж байна.

²² <http://mojha.gov.mn/images/files/huuliintusul/2018/eruu-bagsi> (сүүлд үзсэн 2018.10.23).

3.Үг хуулиар иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд их хэмжээний төгрөгөөр торгох санкцтийн байхаар хариуцлагыг тодорхойлсон нь улмаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг боомилох, мэдээлэл хайх, хүлээн авах эрх хязгаарлагдах эрдэлтэй байж болзошгүй.

6.Практикт хэрэгжиж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1.Зөрчлийн тухай хуулиар бусдыг доромжилсон гэсэн зүйл, хэсэг байхгүй учир уг асуудлыг зөрчлийн шинжгүй гэж үзэж, гомдол хүлээн авахаас татгалзаж байгаа тул доромжлох гэсэн зүйлийг нэмж оруулж өгөх шаардлага гарч байна. Нөгөөтэйгүүр Зөрчлийн тухай хуулийн гүтгэх гэсэн зохицуулалтын агуулгыг харахад гүтгэх, доромжлох асуудлыг нэгтгэж, хамрах хүрээг өргөжүүлж зохицуулсан байхаар ойлгогдож байна. Ийнхүү гүтгэх, доромжлох асуудлыг зохицуулахдаа өгүүлбэрийн гишүүдийг тусгаарлаж, өгүүлбэрийн утга санааг тодруулаагүйгээс хоёрдмолов утга, ойлголтын зөрүү үүсэх нөхцөл бий болж байна. Энэ нь хуулийг практикт нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл үүсэх, хууль зүйн техник, утга найруулгын алдаатай байгаа нь харагдаж байна.

2.Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг зөрчлийн шинжийг бүрэн зохицуулаагүй боловч шинжийг нь үл харгалzan шийтгэл оногдуулж байна.

3.Иргэдийн эрх зүйн боловсрол, чадавх хангалттай бус, эрх, ашиг сонирхол нь зөрчигдвэл хуулийн дагуу эрхээ хамгаалах чадвар сул байгаа нь Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 3, 3.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зохицуулалт хэрэгжижэд хүндрэл учирахаар байна.

4.Танхайрах зүйлийн зохицуулалтыг “олон нийтийн газарт” хэмээн нарийвчлан зааснаар хязгаарлалт үүсгэж буй нь практикт танхайрах зөрчлийг шалган шийдвэрлэхэд зарим нэг бэрхшээл учирч

байна. Танхайрах зүйлийн 1 дахь хэсэгт “олон нийтийн газарт” үйлдэгдсэн байх шинжийт тусгаснаар өөрийн оршин суух хашаа байшин, монгол гэртээ архидан согтуурсан, хэрүүл маргаан үүсгэсэн, бусдыг өдөөн хатгасан, амгалан тайван байдал алдагдуулсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх боломжгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж дээрх дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна.

- Зөрчил гэсэн ойлголтыг онолын талаас нь эрх зүйн зөрчлийн аль төрлийн зөрчил болохыг нарийвчлан тодорхойлох. Аливаа зөрчилд оногдуулах шийтгэл нь хууль хэрэгжүүлэгчийн субъектив хандлагаас хамааралгүй, зөрчлийн шинж болон бүрдэл хэсгийг тодорхойлсон, нэг мөр, хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, бусад ижил төрлийн хуулиар ялгамжтай болгож хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна.

- Эрүүгийн гэмт хэрэг, эрүүгийн зөрчил, захиргааны зөрчил гэсэн нэр томьёог онолын түвшинд судалж, нарийн зааг ялгааг гаргаж зохицуулах.

- Танхайрах зүйлийн 1 дахь хэсэгт “олон нийтийн газарт” үйлдэгдсэн байх шинжийт тусгаснаар өөрийн оршин суух хашаа байшин, монгол гэрт архидан согтуурсан, хэрүүл маргаан үүсгэсэн, бусдыг өдөөн хатгасан, амгалан тайван байдал алдагдуулсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх боломжгүй байгааг анхаарч үзэх.

Гүтгэх, доромжлохтой холбоотой асуудлыг тус бүрт нь зохицуулах эсхүл өгүүлбэрийн гишүүдийг тусгаарлаж, өгүүлбэрийн утга санааг тодруулах.

- Зөрчлийн тухай хуулийг практикт зөв хэрэглэх, ур чадвар, дадал, хандлага төлөвшүүлэх ажлыг хийх шаардлагатай байна.

“ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭТГЭЛ ГЭМТ ХЭРГИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТАД НӨЛӨӨЛСӨН НЬ” СУДАЛГААНЫ ТАЙЛАН

*ҮЕПГ-ын Сургалтын төвийн судлаач,
хяналтын прокурор Г.Оюунболд,*

*МУИС-ийн ХЗС-ийн магистрант
Б.Ариунтуяа*

1. Судалгааны үндэслэл, шаардлага: Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлийн дараагаар Монгол Улсын хэмжээнд 2017 онд 32259 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5092 хэргээр буюу 18.7 хувиар өссөн бөгөөд зарим төрлийн гэмт хэрэг буюу өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 4,840 (36.3%), Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 842 (9.7%), Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 189 буюу 49.2 хувиар, 2018 оны эхний улирлын байдааар 56 хувиар тус тус өссөн статистик тоон үзүүлэлттэй гарч байв. Гэмт хэрэг өсөхөд шинээр батлагдсан Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт болон бусад ямар шалтгаан, нөхцөл нөлөөлснийг бодитоор тогтоох, үнэлэх шаардлагын үүднээс энэхүү судалгааг явуулав.

2. Судалгааны зорилго, зорилт: Монгол Улсын хэмжээнд үйлдэгдэн гарсан гэмт хэргийн өсөлт бууралт, шийдвэрлэлтийн үндэслэл, шалтгааныг судлах зорилгоор дараах зорилт дэвшүүлэв. Үүнд:

1. Гэмт хэргийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийх;

2. Цагдаагийн байгууллагын болон прокурорын тоон мэдээг дүгнэх үзүүлэлт; түүнийг боловсруулах журам, эрх зүйн орчны байдалд үнэлэлт дүгнэлт өгөх;

3. Гэмт хэрэг өссөн, гэмт хэргийн илрүүлэлт буурсан шалтгааныг судлах;

¹ Гэмт хэргийн цагаан ном-2017 судалгааны тайлан. 2018 он. Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Монголын Криминологичийн холбоо хамтран гаргасан. Тайллангийн үндсэн бүлэг

3. Судалгааны хамрах хүрээ: Гэмт хэргийн өсөлт бууралт, шийдвэрлэлтийг судлах зорилгоор 2016, 2017 он бүтэн жилээр, 2016 оны сүүлийн хагасаас 2017 оны сүүлийн хагас, 2017 оны I улирлаас 2018 оны I улирлыг харьцуулан тус тус судалгааг явуулаа. Судалгаа явуулахдаа цагдаа, прокурор, шүүхийн хэмжээнд 2016, 2017, 2018 оны гаргасан тайлан, мэдээг нэгтгэж дүгнэсэн болно.

4. Судалгааны арга зүй, аргачлал: Судалгааны хүрээнд гаргасан удирдамж, төлөвлөгөөний дагуу математик, статистик, бичиг баримтыг судлах арга, шинжээчийн дүгнэлтийг үнэлэх, ярилцлага хийх зэрэг аруудыг ашигласан болно.

5. Судалгааны боловсруулалт: Гэмт хэргийн тоон мэдээлэл, өсөлт, бууралтыг харьцуулан үзэж ярилцлагаар тодруулсаны үндсэн дээр гэмт хэргийн өсөлт, бууралтыг дүгнэх аргачилал, эрх зүйн орчноос шалтгаалсан нөхцөлийг тодорхойлж бусад эх сурвалжид дүгнэлт өгөв.

1.7. Судалгааны үр дүн: Судалгааны үр дүнд үндэслэн гэмт хэргийн өсөлт бууралтад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийн талаар дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулаа.

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ
БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ²

Цагдаагийн байгууллага 2017 онд иргэд, хуулийн этгээдээс 192618 гомдол, мэдээлэл хүлээн авсанаас 78722 буюу 40.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 113896 буюу 59.1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг шалгажээ.

Харин прокурорын байгууллага нь 36574 хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 6419

² Цагдаа, авлигатай тэмцэх, шүүхийн шинжилгээ, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйшэтгэх байгууллагын статистикийн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийв.

хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, хяналт тавьж ажилласан бол Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 10390 хэргийг хүлээн авч, 9019 хүнд ял шийтгэл хүлээлгэсэн байна.

I. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Монгол Улсын хэмжээнд 2017 онд 32259 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5092 хэргээр буюу 18.7 хувиар өссөн бөгөөд зарим төрлийн гэмт хэрэг буюу өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 4,840 (36.3%), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 842 (9.7%), хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 189 буюу 49.2% хувиар тус тус өссөн статистик тоон үзүүлэлттэй байна. Гэмт хэрэг өсөхөд шинээр батлагдсан Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт болон бусад ямар шалтгаан, нөхцөл нөлөөлснийг бодитоор тогтоох, үнэлэх шаардлагын үүднээс энэхүү судалгааг хийлээ³.

Гэмт хэргийн өсөлт бууралт, шийдвэрлэлтийг судлах зорилгоор 2016, 2017 он бүтэн жилээр, 2016 оны сүүлийн хагасаас 2017 оны сүүлийн хагас, 2017 оны I улирлаас 2018 оны I улирлыг харьцуулан тус тус харьцуулан судаллаа. Судалгаа явуулахдаа цагдаа, прокурор, шүүхийн хэмжээнд 2016, 2017, 2018 оны гаргасан тайлан, мэдээг нэгтгэж дүгнэсэн юм.

Гэмт хэргийн тархалт

2017 онд улсын хэмжээнд 32259 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 21947 буюу 68 хувь нь Улаанбаатар хотод, 10273 буюу 31.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Toо	27167	32259	17909	21947	9222	10273
Өсөлт, бууралт	18.7хувь		22.5хувь		11.4хувь	

2017 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргээс хараход дээрэмдэх гэмт хэрэг

2.6⁴ дахин, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 2.3 дахин, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 2.0 дахин өссөн байна.

№	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэргэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэргэг эзлэх хувь
		2016	2017		
1	Хүний алах	174	189	8.6	0.6
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	8248	8812	6.8	27.3
3	Хүчиндэх	290	376	29.7	1.2
4	Хулгайлал	9065	12222	34.8	37.9
5	Дээрэмдэх	474	1233	2.6 дахин	3.8
6	Залилах	2165	2996	38.4	9.3
7	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	1449	727	-49.8	2.3
8	ХАБ, ТХАЖ-ын эсрэг гэмт хэргэг	1783	1525	-14.5	4.7
9	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргэг	165	330	2.0 дахин	1.0
10	Бусдыг амиа хорлоход хүргэх	206	470	2.3 дахин	1.5
11	Бусад	2826	3010	-6.5	9.3

Хэдийгээр гэмт хэргэг өссөн үзүүлэлттэй байгаа боловч гэмт хэргийн статистик үзүүлэлт, цагдаагийн байгууллагын танилцуулгаас үзвэл гэмт хэргийн шинжтэй тохиолдол бүрийг бүртгэж, шинээр гэмт хэрэгт тооцогдсон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хулгайлах, гэмтэл учруулах гэмт хэргийн шинжийг тодорхой болгож, нуугдмал гэмт үйлдлээ ил гаргаж тэмцэж эхэлсэнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл, хуулийн шинэчлэлээс хамаарч нуугдмал гэмт хэргийн гаралтыг бодитоор үнэлж, түүнтэй үр дүнтэй тэмцэх болдлого үнэн зөв тодорхойлох боломжийг олгож байгаа нь сайн тал юм.

Эрүүгийн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш гэмт хэргийн гаралт нэмэгдсэн харагдаж байгаа нь хэрг бүртгэлтийн хэргийн тоо нэмэгдсэн болон нуугдмал гэмт явдлыг гэмт хэрэг, зөрчилд тооцсонтой холбоотой байна.

³ Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

⁴ 2015 онд батлагдсан Эрүүгийн хуульд 2002 оны Эрүүгийн хуульд байсан “Булаах” гэмт хэргийг “Дээрэмдэх” гэмт хэрэгт хамтаган хуульчилсантай холбоотойгоор 2017 онд бүртгэгдсэн дээрэмдэх гэмт хэргийн тоо ийнхүү өсөлттэй гарахад тодорхой хэмжээнд нөлөөлсөн.

Гэмт хэрэгт холбогдгчдын нас, хүйс, нийгмийн байдал

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэгт 18131 хүн холбогдон шалгагдсан бөгөөд өмнөх оныхтой харьцуулахад 23.8 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүний тоон үзүүлэлт, зарим онцлогийг харуулах статистикийг үзүүлбэл:

№	Үзүүлэлт	2016	2017	Өсөлт, бууралт
1	Нийт шалгагдсан хүн	23805	18131	-23.8 хувь
2	Эрэгтэй	20213	15599	-29.5 хувь
3	Эмэгтэй	3592	2532	-22.8 хувь
4	Хүүхэд	1165	1066	-8.5 хувь

2017 онд нийт шалгагдсан 18131 хүний 15599 буюу 86 хувийг эрэгтэй, 2532 буюу 14 хувийг эмэгтэй, 1066 буюу 5.9 хувийг хүүхэд тус тус эзэлж байна. Ийнхүү 32000 орчим гэмт хэрэг бүртгэгдсэн атлаа 18131 хүн холбогдон шалгагдсан нь шинэчлэн батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн яллагдагчтай холбоотой зохицуулалтаас болсон байна. Өөрөөр хэлбэл, “сэжигтэн” хэмээх хууль зүйн ойлголт өөрчлөгдөж, хүнийг яллагдагчаар татахын өмнөхөн хийгдэг богино хугацааны ажиллагаа болсонтой холбоотой юм.

Гэмт хэргийн хохирогч, хохирол

Улсын хэмжээнд 37173 иргэн, 86 хуулийн этгээд хохирсон байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирол түүнд хамаарах статистикийг харуулбал:

Хохирогч бүтэц	Иргэн Нас барсав	Үүнээс				Хуулийн этгээд	Учирсан хохирол бүтгэг (саа.төг)	Нохон төлүүлсэн (саа.төг)	Утга	2016	2016	2017	2017	2017 I улирал	2018 I улирал
		Гэмтсэн							III-IV улирал	III-IV улирал	III-IV улирал	III-IV улирал	III-IV улирал	III-IV улирал	III-IV улирал
2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017	2016	Нийт гэмт хэрэг	27167	32259	13609	30032	6869	10753
37773	37459	27689	37173	880	1179	11257	10313	34	Өсөлт, бууралт	+5092 гэмт хэрэг буюу 18.7%-иар өссөн	+6423 гэмт хэрэг буюу 47.2%-иар өссөн	+3884 гэмт хэрэг буюу 56.5%-иар өссөн			

Прокурорын байгууллагын мэдээнээс үзвэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2017 онд **198.1 тэрбум төгрөг**, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ **74.5 тэрбум төгрөг** болж, өмнөх оноос учирсан хохирол 35.2 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирол 30.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Согтууруулах ундааны зүйл хэргэлжлэж саатуулагдсан хүн, Үүнээс:	87357	86497	-0.9
Эмэгтэй	4925	5521	12.1
Хүүхэд	279	271	-2.8
Сайн дурын эмчилгээнд хамрагдсан хүн	755	2668	3.5

Бүртгэгдсэн гэмт хэргийн өсөлт, бууралт

Судалгааг Монгол Улсын хэмжээнд сүүлийн 2 жилд гарсан гэмт хэргийн статистик, тоон мэдээлэлд үндэслэв. Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дун шинжилгээ, шуурхай удирдлагын албаны гэмт хэргийн статистик мэдээллээс үзвэл Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш үйлдэгдэн гарсан хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн болон эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан гэмт хэрэг 2016 оныг 2017 онтой харьцуулахад 18.7 хувиар, 2017 оны эхний улирлыг 2018 оны мөн улирлын байдлаар харьцуулахад 56.5 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Харин гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн тоон үзүүлэлт өмнөх 3 жилийн дундаж хэмжээнээс нэмэгдээгүй байна. Тухайлбал:

Утга	2016	2016	2017	2017	2017 I улирал		2018 I улирал
					III-IV улирал	III-IV улирал	
Нийт гэмт хэрэг	27167	32259	13609	30032	6869	10753	
Өсөлт, бууралт	+5092 гэмт хэрэг буюу 18.7%-иар өссөн	+6423 гэмт хэрэг буюу 47.2%-иар өссөн	+3884 гэмт хэрэг буюу 56.5%-иар өссөн				

Дээрх хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг өссөн байх бөгөөд Цагдаагийн байгууллага 2017 оны гэмт хэргийн статистик мэдээг шинээр хэрэгжиж эхэлсэн 2015 оны Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002 оны Эрүүгийн хууль гэсэн хоёр байдлаар гаргажээ.

Эрүүгийн хууль 2017 оноос (шинэчилсэн найруулга) үйлчилж эхэлснээс өмнө ба хойших хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн үзүүлэлтийг жил, улирал тус бүрээр харьцуулж үзвэл хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 518-aac 731 гэмт хэрэгээр буюу 21.2-30 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 62-97 гэмт хэрэгээр буюу 69 хувиас 2 дахин, хулгайлах гэмт хэрэг 1697-3990 гэмт хэрэгээр буюу 2 дахин, дээрэмдэх гэмт хэрэг 365-691 гэмт хэрэгээр буюу 3.2-4 дахин, Залилах гэмт хэрэг 804-941 гэмт хэрэгээр буюу 86.4

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн статистик мэдээнээс үзвэл амь хохирсон хүний тоо өмнөх оноос 63 хүнээр буюу 11.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн улмаас 663 хүн хүнд гэмтэл, 904 хүн хүндэвтэр гэмтэл, 3105 хүн хөнгөн гэмтсэн бөгөөд өнгөрсөн онтой харьцуулбал хөнгөн гэмтэл авсан хүний тоо 2.5 дахин өсчээ.

Улсын хэмжээнд 2017 онд шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нийт хэмжээ **84.8** тэрбум төгрөг байна. Үүнээс улсад учирсан хохирол **3.8** тэрбум төгрөг, аж ахуйн нэгжид учирсан хохирол **11** тэрбум **955.5** сая төгрөг, иргэнд учирсан хохирол **69.3** тэрбум төгрөг байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нийт хэмжээг өнгөрсөн онтой харьцуулбал **69.5** тэрбум төгрөгөөр буюу **5.6** дахин өссөн дүнтэй гарсан байна.

Эрүүгийн хуулийн гол үзэл санаа болох хохирогчийн эрхийг хангах, хохирол хор уршигийг арилгах талаар зохицуулсан Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйл гэмт хэргийн хохирол, хор уршиг, Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйл болох Гэм буруугаа хүлээсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын талаархи зүйл, хэсэг заалтууд нь бодитоор хэрэгжих эхэлсэний зерэг үр дагавар гэж дүгнэж болохоор байна.

Цагдаагийн байгууллагад 2017 онд 1327017 зөрчил бүртгэгдэж, 1289466⁵ иргэн, 44 албан тушаалтан, 823 хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан байна⁶.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зөрчил, түүнийг шалган шийдвэрлэх ажиллагааг хүснэгтээр харуулбал:

Улсын хэмжээнд	2016	2017	Өсөлт, бууралт, %
Бүртгэгдсан зөрчил, Үүнээс:	1038050	1327017	27.8
Иргэн	1001379	1289466	28.7
Албан тушаалтан	107	44	-2.4
Хуулийн этгээд	1167	823	-29.4
Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан	1031467	1314831	27.4
Шүүгч шийтгэл оногдуулсан, Үүнээс:	6583	12186	85.1
Тортог (тэрбум төгрөг)	30.6	40.3	31.6
Баривчах	5380	11345	2.1
Тортог, эрх хасах	30017	25339	-15.5

⁵ Давхардан тоогоор буюу нэг хүн хэдэн хэдэн удаа зөрчил гаргасныг изгитгэж дүгнэсэн тоон мэдээ болно.

⁶ Цаашид зөрчлийн статистикиг цагаан номонд дэлгэрэнгүй оруулж байх нь зүйтэй гэсэн саналтай байна.

хувиас 2.4 дахин, авлига албан тушаалын гэмт хэрэг болон хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 2-3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Үүнээс үзвэл голчлон үйлдэгдэн гардаг 5 төрлийн гэмт хэргийн өсөлт 2017 болон 2018 оны гэмт хэргийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, бусдын биед гэмтэл учруулах, хулгайлах, дээрэмдэх, хүчиндэх гэмт хэргүүд тухайн онд өссөн нийт гэмт хэргийн дийлэнхи хувийг эзлжээ.

Мөн дараах 9 төрлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн болон эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан гэмт хэргэнийт хэргийн өсөлтөд шууд нөлөөлсөн эсэхийг Прокурорын байгууллагын гэмт хэргийн цахим бүртгэлийн мэдээлэлтэй тулган үзвэл прокурорын бүртгэл мэдээлэл, цахим системд 2018 онд өөрчлөлт орсон, түүнчлэн тоон мэдээ өсөн нэмэгдэх дүнгээр гардаг учир цагдаагийн гэмт хэргийн мэдээтэй харьцуулах, нарийвчилан судлах боломжгүй байв.

Зүйлчлэл	2016 III-IV улирал	2017 III-IV улирал	Өсөлт, бууралт	2017 I улирал	2018 I улирал	Өсөлт, бууралт
11.6.Хүний эрүүл мэндэл хөнгөн хохирол учруулах	3554	4185	21.2%	1763	2281	29.4%
11.7.Гэр бүлийн хүчинхийнгэл үүдэл		223			106	
12.1.Хүчиндэх	143	240	67.8%	63	125	98.4%
17.1.Хулгайллах	3938	7928	2 дахин	2175	3999	2 дахин
17.2.Дээрэмдэх	316	1007	3.2 дахин	123	488	4 дахин
17.3.Залилах	1089	2030	86.4%	563	1367	2.4 дахин
17.5.Андуулсан илгээмж, алдаатай гүйлгээ, гээгдэл эд зүйл завших		+432			+383	
22 дугаар бүлэг: Авлынгын гэмт хэрэг	52	106	2 дахин	27	8	
24 дүгээр бүлэг: Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	79	240	3 дахин	48	67	39.6%

Цагдаа, прокурор, шүүхийн гэмт хэргийн статистик болон шийдвэрлэлтийн хувь хэмжээг тооцож аргачлал тус бүртгээ өөр, тухайн онд гарсан гэмт хэргийн нөхцлийг цагдаагийн байгууллагын мэдээнд тулгуурлан дүгнэхээр байлаа. Иймд дээрхи Цагдаагийн байгууллагын

статистик тоо, мэдээ үнэн бодит эсэхийг прокурор болон шүүхээс гаргасан статистик тоо мэдээллийн боломжит үзүүлэлтүүдтэй харьцуулан тулгаж судлахыг эрмэлзлээ.

ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

Цагдаагийн байгууллага нь 2014-2017 онд жилд дунджаар 94990 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 65 хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах шийдвэр гаргуулахаар прокурорт шилжүүлсэн тоон үзүүлэлттэй байв.

Гэмт хэргийн статистикийг бүртгэлийн эхний үе шатнаас буюу цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтээс үзвэл эдийн засаг, нийгэм, хувь хүн болон бусад хүчин зүйлээс гэмт хэрэг бодитоор өссөн байж болох шалтгаан, нөхцөл ажиглагдаагүй бөгөөд зарим гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн тоо буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн статистик мэдээлээс үзвэл 2014-2017 онд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан гомдол, мэдээллийн дотор бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл нийт мэдээллийн 28 орчим хувийг эзэлж байжээ.

Үзүүлэлт	2014	2015	2016	2017
Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл	93984	96661	94324	78050
Үүнээс: Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан гомдол, мэдээллийн тоо	63245	65885	65709	44393
Эзлэх хувь	67%	68%	70%	57%
Хулгайлалын гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл	20662	23716	27070	28991
Эзлэх хувь	22%	24,5%	28,6%	37%

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхлэнсээс хойш гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг шалгах ажиллагааг хэрэг бүртгэлтэд тооцсон бөгөөд цагдаагийн байгууллага гэмт хэргийн статистик үзүүлэлт гаргахдаа хэрэг бүртгэлтийн хэргийн тоог бүртгэгдсэн гэмт хэргийн тоо гэж үзжээ. Гэтэл хэрэг бүртгэлтийн хэрэг нээгээд шалгах явцад тухайн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй байх, эсхүл зөрчил байх боломжтой тул бүхэлд гэмт хэрэг гэж зүгнэх нь учиртай дутагдалтай юм.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл		ЭХҮ-ээс татгалзсан	
2002 оны ЭБШХ-иар хуулиар шийдвэрлэсэн			
2016 I-VI улирал	2017 I-VI улирал	2016 I-VI улирал	2017 I-VI улирал
99455	45177	65669	28710
			65%
2017 оны ЭБШХ-иар хуулиар шийдвэрлэсэн		Хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан	Хэрэг бүртгэлийн хэргийн хаасан
2017 III-IV улирал	2017 I-5 сар хүртэл		
40104	34588	15179+10848	7406+6956
		34.5%	19%

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтаар “мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авснаас эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах хүртэл явуулж байгаа энэ хуульд заасан ажиллагааг хэрэг бүртгэлт” гэж томъёолсон боловч гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хуульд заасан 5 хоногт шалгаад үргэлжүүлэн “хэрэг бүртгэлтийн хэрэг нээж” шалгасныг “гэмт хэрэг гарсан” гэж үзэн гэмт хэргийн статистикт бүртгэж, үзүүлэлтийг гаргажээ. Өнөөгийн байдлаар прокурорын байгууллагын хэмжээнд хэрэг бүртгэлтийн хэргийг гэмт хэрэг гарсан гэж шууд үзэх бус харин гэмт гарсан эсэхийг шалгаж тогтоох ажиллагаа гэж ойлгож, хяналт тавьж байгаа болно.

Энэ нь дээр дурдсан хулгайлал, дээрэмдэх болон хүний биед хөнгөн хохирол учруулах хэргүүд өссөн үзүүлэлтэй гарах нэг шалтгаан болсон гэж үзэж болох юм.

Судалгааны дагуу Эрүүгийн хууль тогтоомж хэрэгжиж эхлэхээс өмнө болон хэрэгжиж эхлэнсээс хойш хагас жилийн байдлыг сар, улирал байдлаар тус тус харьцуулж үзвэл гэмт хэргийн талаарх гомдлын тоо харьцангуй тогтвортой буюу 500-1000 гомдол, мэдээллээр өссөн дунтэй, харин хагас жил, шинэ хууль хэрэгжиж эхлэхээс хойшихи 10 сарын байдлаар

⁷ 6 ЭХХШТХ-ийн 30.1 дүгээр зүйл. Хэрэг бүртгэлт

харьцуулж⁸ үзвэл цагдаагийн байгууллагад иргэд, байгууллагаас гаргасан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн тоо буурсан байна.

Хуучин хуулиар	Гомдол, мэдээлэл	ЭХҮ-ээс татгалзсан	Эрүүгийн хэрэг үүсгэсэн	Ажиллаганд байгаа	Яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлж сэн
2016	99455	65669	29607	4425	5985
		66%	30%	10.7%	14.4%
2017 I-VI	45177	28710	14272	4225	4420
Эзлэх хувь		63.6%	31.5%	19%	20%
Шинэ хуулиар	Гомдол, мэдээлэл	ХБ-ийн хэрэг изэхээс татгалзсан	Хэрэг бүртгэлтийн хэрэг хаасан	ЭХҮ-гэж мөрдөн байцаалт явуулсан	Хэрэг бүртгэлтийн ажиллаганд байгаа
2016 III-IV улирал	40104	15179	7406	1095	1674
		38%	18.4%		
2018 V сар	34588	10848	6956	639	1891
Эзлэх хувь		31.3%	20%		

ЦЕГ-ЫН Мэдээлэл, дун шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас шинээр батлагдсан Эрүүгийн хууль, тогтоомж мөрдөгдөж эхэлсэн тохиолдолд МУ-д бүртгэгдэх гэмт хэрэг жилд дунджаар 10000 орчмоор өсөх магадлал, тооцооллыг гаргаж, ХЗДХЯ-нд танилцуулж байжээ. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл шалгах ажиллагаа “хэрэг бүртгэл” гэдэг ойлголтод тооцогдсон, мөн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай ойлголт шинэ хуулиар өөрчлөгдж, хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэхээс татгалзах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах гэсэн 2 өөр шийдвэр гаргах болсонтой холбоотойгоор гэмт хэргийн статистик үзүүлэлт өсөхөд нөлөөлөхөөр байсан.⁹

өмнөх ба дараах үеийг 2016.07.01-нээс 2017.05.31 хүртэл, 2017.07.01-2018.05.31 хүртэх байдлаар харьцуулан үзвэл гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн тоо 94731-ээс 67087 болж 70 гаруй хувиар буурсан байна.

Дээрхи хугацаанд 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зохицуулалтын дагуу хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тоотой нэгтгэн харьцуулж үзвэл, 65.2 хувиас 53.6 хүртэл хувиар буурсан байна.

2017 оны 07 дугаар сарын 01-нээс хойш 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд 67087 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн 38947-д буюу 58 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 26561-ийг буюу 38 орчим хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтайгаар прокурорт шилжүүлж, 2689 тохиолдолд буюу4 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, үлдэх 2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэжээ.

Судалгааны явцад хийсэн бүлгийн ярилцлагаас¹⁰ үзвэл гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах 5 хоногт бүрэн гүйцэт ажиллагаа хийх боломжгүй, зөвхөн үйл баримтыг үнэлэх, үндэслэл бүхий сэжиг байгаа эсэхийг тогтоож гэмт хэргийн шинжтэй л бол тохиолдол бүрт хэрэг бүртгэлтийн хэрэг нээн, шалгаж



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш

⁸ Энэ судалгааг хийх үеийн тоон мэдээллийг ашигласан болно.

⁹ “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага” судалгааны тайлангаас, ХСИС.2012 он

байгаагаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн болон эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан гэмт хэрэг 20-30 хувиар өссөн

¹⁰ Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн мөрдөн байцаагч нартай сургалтын явцад хийсэн ярилцлагаас.

дүн мэдээ гарч байгаа бөгөөд цаашид “гэмт хэрэг үйлдэгдэн гарсан болохыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн үес биш эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, мөрдөн байцаалт явуулсан тоогоор тооцдог болох нь зүйтэй” гэсэн санал дэвшүүлж байв.

Өөрөөр хэлбэл, шинээр хэрэгжиж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах ажиллагааг хэрэг бүртгэлтэд хамааруулахаар заасан

Зарим судлаачид гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлийн хэрэг нээж шалгаж байгаа ба улмаар эрүүгийн хэрэг үүсгэсэн тохиолдолд энэ үзүүлэлтийг хэрхэн хасч тооцох нь тодорхойгүй учраас хуучин аргачлалаар гэмт хэргийн статистик мэдээг гаргаж байна. Мөн гэмт хэргийн шинжтэй үйлдэл тус бурт хэрэг бүртгэлтийн дугаар авч байгаа ба шалгах зайлшгүй шаардлагатай гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл байхад нөгөө талаас, гэмт хэргийн шинжтэй эсэх нь тодорхойгүй цаашид шалгах шаардлагатай үйл баримтууд байна. Цаашид яг ямар үзүүлэлтээр гэмт хэрэг гарсан гэж үзэн статистик гаргах нь бэрхшээлтэй.

Гэмт хэргийн өсөлтөнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас шалтгаалсан зарим хүчин зүйл

2014-2017 оны байдлаар Монгол Улсад “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” гэмт хэрэг жилд дунджаар 10000 орчим бүртгэгдэж, нийт хэргийн 32.4 хувийг эзэлж байжээ.

Үзүүлэлт	2014	2015	2016	2017
Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг	27318	27757	27167	32259
Бусдын эд хөрөнгийг хулгайлалын	8424	9169	9065	11771
Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	30.8%	33.0%	33.4%	36.4%
Бусдын эд хөрөнгийг булаах	245	216	176	56
Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	0.9%	0.8%	0.6%	0.1%
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг	1076	1356	1449	1294
Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	3.9%	4.9%	5.3%	4.7%

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн хөтлөх журам”-ын код 701-ийн 701.7.1-д Эрүүгийн хэргийн дугаар авах гэсэн хэсэгт:/ЦЕГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын 24-ний А/301 дугаар тушаалаар шинэчилгэдсэн батлагдсан/

- “үйлдэл бүр дээр эрүүгийн хэргийн дугаарыг шинээр авна”... гэж заасан заалтыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, хэрэг бүртгэлтийн дугаар авахдаа хамааруулан тооцож байгаагаас шалтгаалан олон үйлдэлтэй хулгайлах, дээрэмдэх зэрэг хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн болон эрүүгийн хэрэг үүсгэсэн хэргийн тоо өссөэ.

- Мөн уг журмын “Хэрэгсэхгүй болгох саналтайгаар прокурорт шилжүүлсэн хэргийн бүртгэл” маягтыг хөтөлнө. гэж заасан боловч хэрэг бүртгэлтийн хэрэг нээснээс хаасан, хэрэгсэхгүй болгосон, мөн түүнээс эрүүгийн хэрэг үүсгэж мөрдөн байцаалт явуулсан гэж ялгах боломжгүй учраас гэмт хэргийн статистик үзүүлэлт мөн өсөхөд нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

Үзүүлэлт	2016 III-IV улирал	2017 III-IV улирал
Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг	13609	20032
Бусдын эд хөрөнгийг хулгайлалын	3938	7928
Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	29.1%	39.5%
Бусдын эд хөрөнгийг булаах (дээрэмдэх)	316	1007
Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	2.3%	5%
Гэр бүлийн хүчирхийллийн үйлдэл гэмт хэрэг		223
Нийт гэмт хэрэгт эзлэх хувь		1%

2016 оны 7 дугаар сараас 12 сар, 2017 оны 7 дугаар сараас 12 сар буюу хагас жилийн байдлаар авч үзвэл хулгайлалын гэмт хэрэг 2 дахин, дээрэмдэх гэмт хэрэг (булаах гэмт хэргийг дээрэмдэх гэмт хэрэгт тооцсон) 3 дахин, гэр бүлийн хүчирхийлэл 1 хувиар нэмэгдсэн өсөлт нь тухайн хэргүүдийн үйлдэл тус бурт хэрэг бүртгэлтийн дугаар авч байгаа болон дээр дурдсаны дагуу гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, шалгах тохиолдолд өссөн байна.

Түүнчлэн, хэрэг бүртгэлтэнд байгаа хэд хэдэн хэргийн үйлдлийн арга, хэлбэр ижил, тэдгээрийг нэг хүн үйлдэсэн байж болохыг тогтоосон тохиолдлууд байгаа боловч түүнийг Эрүүгийн хэрэг хянан

шалгах тухай хуулиар нэгтгэн шалгах боломжгүй учраас үйлдэл тус бүр дээр дугаар авч шалгаж байна. Энэ нь статистикийн тоон үзүүлэлт өсөх хүчин зүйл болжээ.

Эрүүгийн хуульд шинээр гэмт хэрэгт тооцсон, үйлдлийн шинжийг нэгтгэсэн гэмт хэргийн талаар:

2015 онд шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуульд 26 төрлийн гэмт хэргийн шинжийг шинээр томьёолж, нийт гэмт хэргийн 70 гэмт хэргийн шинжийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар тусгажээ. Үүнд:

Эрүүгийн хуулийн 11.7-д заасан Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 223, 17.5-д заасан Андуурсан илгээмж, алдаатай гүйлгээ, гээгдэл эд зүйл завших гэмт хэрэг 432, Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэгт заасан Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 240 тус тус бүртгэгдсэн нь “тухайн жилд дунджаар 1000 орчим хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэсэн хэрэг нэмэгдсэнийг” харуулж байна.

Мөн Эрүүгийн хуульд зарим гэмт хэргийн шинжийг нэгтгэн шинээр томьёолсонтой холбоотой өссөн дүнтэй гарсан гэж үзэхээр байна. Тухайлбал: 2002 оны Эрүүгийн хуулиар тодорхойлж байсан “булаах гэмт хэрэг” болон “дээрэмдэх” гэмт хэргийн шинжийг 2015 оны Эрүүгийн хуулиар “Дээрэмдэх” гэсэн нэг гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх шинж болгож тодорхойлсон учир тухайн гэмт хэрэг 2017 онд 3-4 дахин өссөн үзүүлэлттэй гарчээ.

Танхайрах үйлдлийг гэмт хэргээс хасч зөвхөн Зөрчлийн тухай хуулиар зөрчилд тооцсоноос хамааран гэмт хэргийн тоо 500-600 гэмт хэргээр багассан боловч түүнтэй үйлдлийн хувьд ижилгэр бүл, ахуйн хүрээнд үйлдэгддэг зарим гэмт хэрэг өсчээ. Тухайлбал, Улсын хэмжээнд 2014 оноос 2016 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчил 4497 бүртгэгдэж (жилд дунджаар 1499) нийт зөрчлийн 0.1 хувийг эзэлж байв. Энэ үйлдлүүдийн дийлэнх нь Зөрчлийн тухай хуулийн 5.4

дүгээр зүйлийн 4 дэх хэсэг болон Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт болж бүртгэгдэж эхэлсэн байна.

Үзүүлэлт	2014	2015	2016	Нийт	3 жилийн дундаж
Бүртгэгдэсэн захирагааны зөрчил	681222	1423088	1038050	3142360	1047453
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчил	1178	1453	1866	4497	1499
Эзэх хувь	0.2	0.1	0.2	0.1	0.1

Үүнээс гадна 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш хагас жилийн байдлаар нийт 500 мянган зөрчил бүртгэгдээд байгаа нь урьд бүртгэж байсан зөрчлийн тооноос даруй 10 дахин нэмэгдсэн үзүүлэлтэй байгаа бөгөөд энэ нь цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа зөрчлийн тоог бодитой хянаж эхэлсэн, бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтаас явуулах зөрчлийн хэрэг бүтгэлтэд хяналт тавьж, бүртгэж эхэлсэнтэй холбоотой юм.

2018 оны 04 дүгээр сараас эхлэн Цагдаагийн байгууллагын бүтцэд “Хэрэг бүртгэх алба”-ыг шинээр байгуулсан ба энэ алба цагдаагийн газар, хэлтсүүдэд байгуулгаснаас хойш 2015 оны Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг буюу “Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”-ийг харьялан шалгаж эхэлсэн. Уг албыг байгуулснаас хойш тухайн төрлийн гэмт хэргийн бүртгэл нэмэгдэж, илрүүлэлт өссөн дун мэдээ 2018 оны эхний улирлын байдлаар ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн өсөлт бууралттай холбоотой мэдээ нь цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанаас хамаарч байгаа дүр зураг ажиглагдаж байна.

Авлига, албан тушаалын гэмт хэргийн бүлгийг 2015 оны Эрүүгийн хуульд шинээр томьёолж хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар тусгажээ. 2002 оны Эрүүгийн хуульд байсан гэмт хэргийн шинж дээр нэмж б хэргийг тусгасан ба шинэ хуулийн үйлчлэлээс хойш Авлигатай тэмцэх газраас шалгасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн тоо 2 дахин өсчээ.

Авлигатай тэмцэх газар 2017 онд гэмт хэргийн шинжтэй 658 гомдол, мэдээллийг хүлээн авсан бөгөөд төрлөөр

нь авч үзвэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан 337, хахууль авсан 63, хахууль өгсөн 76, албан тушаалтан өмч хөрөнгө завшсан 82, хөрөнгө нуусан буюу үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн 51, худалдан авах ажиллагааны журам зөрчсөн 48, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан 50, бусад 6 байна. Гэмт хөргийн шинжтэй гомдол, мэдээллийн 174 буюу 26.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээх / эрүүгийн хэрэг үүсгэх/, 375 буюу 58 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах /эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах/, 93 буюу 14.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай харьяа прокурор шилжүүлэн шийдвэрлэж одоо 16 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй байна. Хуульд заасан харьяаллын 1301 үйлдэлтэй, 654 холбогдгчтой, 427 эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна¹¹. Гэтэл хамтран ажиллах журмын дагуу АТГ нь цагдаагийн байгууллагын мэдээллийн санд гэмт хөргийн талаарх холбогдох мэдээллийг оруулж, статистикийн мэдээлэлд тусгуулдаг бөгөөд ЦЕГ-аас эрхлэн гаргасан улсын хэмжээний гэмт хөргийн статистикийн мэдээлэлд АТГ нь 2017 онд гэмт хэрэгт холбогдсон 14 хүн, бүртгэсэн 184 гэмт хэрэг байгаа статистик үзүүлэлтээс¹² харахад АТГ-ын статистикийн мэдээлэл улсын хэмжээний гэмт хөргийн нэгдсэн статистикийн мэдээнд бүрэн тусаагүй байгааг цаашид анхаарах нь зүйтэй.

II. ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу прокурорын байгууллагын бүртгэл, статистикийн үзүүлэлт, түүнийг дүгнэх аргачлалууд хэд, хэдэн удаа өөрчлөгджэх цагдаагийн байгууллагын гэмт хөргийн статистик мэдээтэй тулгаж үзэхэд зарим үзүүлэлт зөрөх байдал ажиглагдаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар эрүүгийн хэрэг түдгэлзүүлэх тухай зохицуулалт өөрчлөгдсөнөөс

шалтгаалж түдгэлзүүлсэн хөргийн үзүүлэлт эрс багасаж, 2016 онд 5503 хөргийг түдгэлзүүлж байсан бол 2017 онд 77 хөргийг түдгэлзүүлжээ. Хуулийн зохицуулалтаар хөргийг түдгэлзүүлэхгүйгээр гэмт хөргийг хөөн хэлэлцэх хугацаанд нь хэрэг бүртгэлтээр шалгадаг болжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 оны 07 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлнээс хойш хэрэг бүртгэлтийн хэрэг татгалзаж хаах (хуучин хуулиар эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж хаах) тохиолдол 30 хүртэл хувиар буурч, үүнтэй урвуу хамаарлаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээх шалгасан үзүүлэлт 30 хувиар өссөн байна. хууль хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн хөргийн тоо 10 хүртэл хувиар буюу 1092 хөргээр нэмэгджээ.

2002 оноос хойш хэрэгжиж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хохирогчтой эвлэрснээр эрүүгийн хөргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг байсан зохицуулалт өөрчлөгдсөнөөр шүүхэд шилжүүлсэн хөргийн тоо нэмэгдсэн байна. Тухайлбал, 2016 онд прокуророос 21712 эрүүгийн хөргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байсан бол 2017 онд 612 хөргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

2017 онд цагдаагийн байгууллагын гэмт хөргийн илрүүлэлтийн талаар тоон мэдээнээс харвал илрэсэн гэмт хэрэг 8856, прокурорын цахим бүртгэлээр мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хөргийн тоо 8864 буюу 8 хэрэгээр зөрүүтэй байгаа статистик үзүүлэлтэй байна.

2017 онд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчар татсан хэрэг	ЭХХШТХ-н 30.15-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар	5395
	ЭХХШТХ-н 30.17-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар	1278
Мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг		8864

Прокурорын байгууллагын хянасан, бүртгэсэн гэмт хөргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн гэмт хөргийн тоон мэдээ нь Цагдаагийн байгууллагын бүртгэсэн гэмт хөргийн тоон мэдээтэй зөрүүтэй гарч байгаа нь прокурорын байгууллагын гэмт хөргийн талаарх гаргаж байгаа тоон мэдээ,

¹¹ АТГ. Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, Авлигын ерөнхий нөхцөл байдал-2017. Танилцуулгаас авав.

¹² ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны статистикийн мэдээлэл

статистик үзүүлэлтийг бүртгэх аргачлал нь өөр, өсөн нэмэгдэх үзүүлэлтээр тус тусын үндсэн ажлын үзүүлэлтээр болон шийдвэр гаргалтын байдал, шийдвэрээр бүртгэдэг, зарим үйлдлийг, өргөдлийг нэгтгэж шалгах мөн тайлан мэдээ гаргах хугацаа зөрдөгөөс шалтгаалсан гэж үзэхээр байна.

Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу прокурорын байгууллагын бүртгэл, статистикийн үзүүлэлт, түүнийг дүгнэх аргачлалууд хэд, хэдэн удаа өөрчлөгджэг цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистик мэдээгэй тулгаж үзэхэд хүндрэл бэрхшээлтэй байв.

Тухайлбал: прокурорын байгууллагын гэмт хэргийн тоо бүртгэлээс 2016 онд хэрэг бүртгэлт явуулсан хэрэг, мөрдөн байцаалт явуулсан нийт хэргийн тоог үзвэл 41130 байх ба энэ өмнөх оны үлдэгдэл болон тухайн онд шалгагдан, хянаж байгаа нийт эрүүгийн хэргийн нийт тоог хамарчээ.

Үзүүлэлт	Цагдаагийн байгууллага	Авлагатай тэмцэх газар	ТЕГ-ын МБА
Өмнөх оны тайлангийн үлдэгдэл хэрэг	2010	70	19
Үрьд оны хэргийг сэргээж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэг, Үүнээс:			
Түргэлзүүлснээс	5858	11	11
Хэрэгсэхгүй болгосноос	240	6	
Өмнөх онд шүүхэд шилжүүлсэн хэргээс прокурорт буцаах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэг	367	8	
Тайлангийн хугацаанд эрүүгийн хэрэг үзсгэсэн хэрэг	29654	104	54
Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг	41130	84	84

2016 оны цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн талаарх гомдолын тоо 94324 гэж гарсан бол прокурорын байгууллагын тоон мэдээгээр 94213, үүнээс ЭХҮ-гээс татгалзсан тохиолдол цагдаагийн байгууллагын мэдээгээр 65709, прокурорын байгууллагын тоон мэдээгээр 65293 зэрэг зөрүүтэй гарсан байна. Энэ нь гэмт хэргийн үйлдлийн тоо, эсхүл хэдэн өргөдөл гомдолыг нэгтгэж шалгасан байдал, мөн мөрдөгчөөс ЭХҮ-гэж татгалзах

саналтай ирүүлснийг үндэслэлгүй гэж үзэж буцаасан зэргээс хамаараад прокурорын шийдвэр гаргасан статистик үзүүлэлтээс шалтгаалж зөрүүтэй гарч, өөрчлөгдхөд хүргэдэг байна.

Үзүүлэлт	2016	Эзлэх хувь	2017 I-II улирал	
ГХ-ийн талаарх гомдол мэдээллийн тоо	99455		45177	63.6%
ГХТГМ-ийн шийдвэрлэлт, Үүнээс:				
Эрүүгийн хэрэг үзсгэхээс татгалзах шийдвэрлэсэн	65669	66%	28710	31.5%
Эрүүгийн хэрэг үзсгэсэн	29607	30%	14272	
Харьяаллын лагуу шилжүүлсэн	1001		617	
Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт, Үүнээс:				
Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан	41413		22468	
ХБ, МБ-ыг түргэлзүүлсэн	5503	13.2%	3218	14.3%
Хэрэгсэхгүй болгосон	21712	52.4%	8841	39.3%
Яллах дүгнэгүй үйлдэж шүүхэд шилжүүлсэн	5985	14.4%	4420	20%
Ажиллагаанд байгаа	4425	10.7%	4225	19%

Үзүүлэлт	2017 III-IV улирал	2018 I-V сар
ГХ-ийн талаарх гомдол мэдээллийн тоо	40104	34588
ГХТГМ-ийн шийдвэрлэлт, Үүнээс:		
Хэрэг бүртгэлтийн хэрэг изэхээс татгалзсан	15179	38%
Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	21979	
Хэрэг бүртгэлтийн хэрэг хасан	7406	18.4%
ЭХҮ-гэж мөрдөн байцаалт явуулсан	1095	
Хэрэг бүртгэлтийн ажиллагаанд байгаа	45252	
ЭХҮ-гэж мөрдөн байцаалт явуулснаас		
Ял сонсгож яллагдагчаар татсан	10364	
Мөрдөн байцаалтыг түргэлзүүлсэн	77	
Ажиллагаанд шалгаж байгаа	1674	
Яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн	5715	
		5764

Прокурорын байгууллагын хянасан, бүртгэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн гэмт хэргийн тоон мэдээ нь цагдаагийн байгууллагын бүртгэсэн гэмт хэргийн тоон мэдээтэй зөрүүтэй гарч байгаа нь:¹³

- Цагдаагийн, Прокурорын байгууллагын гэмт хэргийн талаар гаргаж байгаа тоон мэдээ, статистик үзүүлэлтийг бүртгэх аргачлал өөр өөр байдагтай холбоотой. Тухайлбал, цагдаагийн байгууллагаас анх бүртгэсэн хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад нэгтгэсэн, тусгаарласан, хэрэг бүртгэлтийн хэрэг гэмт хэргийн шинжгүй гэж үзэж хаасан зэргийг мэдээнд тусгадаггүйгээс өөр хоорондоо зөрдөг байна.

- Тус тусын үндсэн ажил дүгнэх үзүүлэлт болон гаргасан шийдвэрээр бүртгэдэг. Тухайлбал, Цагдаагийн байгууллага гэмт хэргийн шинжгүй гэж үзэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан тохиолдлыг гэмт хэргийн шинжгүй гэж хааж нийт гэмт хэргээс хасч бүртгэдэг байхад дээрхи тоо мэдээ нь прокурорын хяналтын явцад гаргасан шийдвэрээс хамаарч өөрчлөгддэг. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага нь мөрдөгч, хэрэг бүртгэгчийн гаргадаг шийдвэрийн хэлбэрээс хамаарч бүртгэлээ хийдэг.

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад зарим үйлдлийг, эсхүл гэмт хэргийн шинжтэй өргөдлийг нэгтгэж шалгасан тохиолдлийг прокурорын байгууллагын тоо мэдээнд тусгадаг. Мөн тайлан мэдээ гаргах хугацаа зөрдөгөөс тоон үзүүлэлт зөрөхөд хүргэдэг. Тухайлбал; цагдаагийн байгууллага сар болгоны 25-нд гаргадаг бол прокурорын байгууллага тухайн сарын 1-нд багтаж тоо, мэдээгээ гаргадаг.

- Прокурорын байгууллага нь цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хэргийг нэг бүрчлэн тулгаж Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр мэдээ гаргадаггүй бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэсэн, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн хаасан, яллах дүгнэлт үйлдсэн зэргээр прокурорын

шийдвэр гаргалтын хэлбэрээр мэдээг гаргадаг.

- Мөн 2002 оноос өмнө хэрэгжих ЭБШХ-д хохирогчтой эвлэрснээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг байсан заалтыг өөрчилж, нотлогдсон гэмт хэргийг заавал шүүхээр шийдвэрлэж гэм буруу, хохирлын асуудлыг эцслэн шийдвэрлэж байна. Тухайлбал, 2016 онд прокуророос 21712 эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байсан бол 2017 онд 612 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэн, 2017 оны 7 дугаар сарын 1-нээс хойш бүх эрүүгийн хэргийг шүүхээр эцслэн шийдвэрлэж байна. Иймээс Эрүүгийн шүүхийн ачаалал З дахин нэмэгдсэн тоон мэдээ гарч байна гэж дүгнэж болох юм.

III. ШҮҮХИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Анхан шатны шүүх 2017 онд эрүүгийн 8839 хэрэг шийдвэрлэж, 12675 зөрчил, зөрчлийн хэрэгт шийтгэл оногдуулжээ. Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оны мөн үеэс 53.4%-иар өссөн дунтэй гарсан гэмт хэргийн статистик үзүүлэлтэй хамааралгүй байх бөгөөд 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зохицуулж байсан хөнгөн гэмт хэргийн хохирогчтой эвлэрснээр хэрэгсэхгүй болгохтой холбоотой зохицуулалт өөрчлөгдж, нотлогдсон бүх эрүүгийн хэрэг шүүхээр шийдвэрлэгддэг болсонтой холбоотой байна. Тухайлбал:

2017 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр ял шийтгүүлэгчдийн тоо 37.4 хувиар өссөн байна.

Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт эрүүгийн хэргээс дараах төрлийн гэмт хэрэг өссөн байна. Тодруулбал, залилах, хүнийг алах, хулгайлал, дээрэмдэх гэмт хэрэг их хэмжээгээр өссөн дунтэй байна.

- хүнийг алах гэмт хэрэг 44 хэргээр буюу 28.9 хувиар,

- хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах гэмт хэрэг 23 хэргээр буюу 7.3 хувиар,

- хулгайлал гэмт хэрэг 261 хэргээр буюу 22.6 хувиар,

¹³ Монгол Улс дах гэмт хэргийн статистикийн үйлажиллагын өнөөгийн байдал: SWOT шинжилгээ” судалгааны тайлан 2017 он. 10 дах тал. ХСИС, ЭШХХүрээлэн. Судлаачдын баг

- дээрэмдэх гэмт хэрэг 32 хэргээр буюу 20.9 хувиар,

- улсын хилээр барааг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 33 хэргээр буюу 2.4 дахин,

- авто тээврийн хэрэгслийн хөдлөгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 97 хэргээр буюу 15.3 хувиар,

- залиах гэмт хэрэг 130 хэргээр буюу 90.9 хувиар,

- мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 11 хэргээр буюу 4.9 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүн шүүхээр ял шийтгүүлж буй нөхцөл байдлыг судлан үзвэл хорих ял оногдуулах, түүнийг биечлэн эдлүүлэх үзүүлэлт 3 дахин багассан ба энэ нь хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх, ял оногдуулахгүйгээр тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх зэрэг Эрүүгийн хуулийн 6.7, 7.1 дүгээр зүйлүүдэд заасан ялын уян хатан зохицуулалт, хоригоос өөр төрлийн ялыг хэрэглэж эхэлсэнтэй холбоотой байна. Тодруулж үзвэл, 2016 онд анхан шатны шүүхээр 4267 хүнд хорих ял оногдуууж шийдвэрлэж байсан бол 2017 онд анхан шатны 1314 хэрэгт хорих ял оногдуууж, хорих ял оногдуулахгүйгээр 639 хүнийг тэнсэж, ял оногдуулахгүйгээр 370 хүнийг тэнсэж, албадлагын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргажээ. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15 хувь буюу нийт 30 гэмт хэрэгт хоригоос өөр төрлийн ял оногдуулахаар заасан ба нийт оногдуууж буй ялын 1/3-ийг тэнсэж, 1/3-т хоригоос өөр төрлийн ял оногдуулж шийдвэрлэжээ.

Харин олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах гэмт хэрэг 162 хэргээр буюу 29.9 хувиар, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг 1 хэргээр буюу 50 хувиар тус тус буурсан байна. Шүүхийн энэхүү статистик үзүүлэлт нь өссөн зарим гэмт хэргийн өсөлтийн бодит илрэл байж болох талтай байна.

ДҮГНЭЛТ

Гэмт хэргийн өсөлт, бууралтын шалтгаан нөхцөл болон эрүүгийн хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн судалгаагаар дараах дүгнэлтийг хийж болохоор байна:

- Монгол Улсад 2017 онд 32259 хэргэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татсан гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 5092 хэргээр буюу 18.7 хувиар өссөн дүнтэй гарсан байна.

- Судалгаагаар Эрүүгийн хуульд шинэчлэн томъёолон тусгагдсан 26 гэмт хэрэг нь нийт өссөн гэмт хэргийн 20 хувийг, мөрдөн байцаалт явуулсан нийт хэргийн 2.8 хувийг эзэлж байна.

Шүүхийн статистик, мэдээгээр олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг гэмт хэрэг, эдийн засгийн эсрэг гэмт хэрэг тус тус өссөн нь бодит үзүүлэлт байж болохоор байна. Энэ нь нийт өссөн гэмт хэргийн 2 орчим хувийг эзэлж байна.

Нийт өссөн 5092 хэргэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татсан гэмт хэргийн 1000 орчим нь буюу 20% нь шинэ Эрүүгийн хууль тогтоомжоос, 2500 буюу 40% нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгаж, шийдвэрлэх талаарх зохицуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор, 1500 орчим буюу 35 хувь нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, гэмт хэргээс зөрчил рүү харьяллын дагуу шилжүүлэн шалгах болсонтой холбоотой байна.

Өөрөөр хэлбэл, дээр дурдсаны дагуу буурсан эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэдэг байсан 30% гаруй хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгаж байгаагаас гэмт хэргийн тоон үзүүлэлт өссөн дун гарахад шууд нөлөөлсөн байна гэж үзэх үндэслэлтэй юм.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн тоо өссөн дүнгүй, зарим улирлын байдлаар тогтмол, харин хагас жил, сүүлийн 10 сарын байдлаар харьцуулж үзвэл буурчээ.

- Бүртгэгдсэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар

татсан гэмт хэрэг өссөн нь тухайн болсон үйл баримт, хүлээн авсан гомдол, мэдээллийг шалгаж, хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгадаг болсонтой холбоотой байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтаас хамаарч хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, зөрчил гэж үзэн харьяаллын дагуу шилжүүлэх болсон тул өмнө байсан гэмт хэргээс өссөн гэж дүгнэхтэй холбон үзвэл зүйтэй.

Жишээлбэл: Нийт гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн дийглэнх хувь буюу 36-аас 40 хувийг хулгайлах хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татсан гэмт хэрэг эзэлж байсан ба 300.000 төгрөгийн хохирол учирсан тохиолдолд (хуучин хуулиар 240.000 төгрөг байсан) гэмт хэргийн шинжийг хангахаар заасан.

Хулгайлах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хуульд заасан 5 хоногийн дотор үнэлгээ хийлгэх, тодорхой ажиллагаа явуулж шалгах хугацаа хязгаарлагдмал байгаа тул хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгаад хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, зөрчил гэж үзэн зөрчлийн хэрэг бүртгэлт рүү шилжүүлэх шийдвэр гаргасан гэж үзэхээр байна. Учир нь 2017 онд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татсан гэмт хэрэг өссөн гол шалтгааны нэг нь гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл шалгах хугацаа өөрчлөгдсөнөөс хамаарчээ. Зөрчлийн тухай хуулиар гэмт хэргээс зөрчилд, зөрчлөөс гэмт хэрэгт тооцон бүртгэгдэж байгаа тоон үзүүлэлтийг гаргах, хянаж харьцуулан судлах бололцоогүй байна.

- Мөн зарим гэмт хэргийн шинжийг нэгтгэснээс тухайлбал булаах, дээрэмдэх гэмт хэргийн үйлдлийн шинжийг нэг гэмт хэргийн зүйлчлэлд оруулан дүгнэж эхэлсэн тул уг гэмт хэрэг 3 дахин өссөн дүнтэй гарч, алдаатай гүйлгээ андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, мал завших гэсэн гэмт хэргүүд шинээр Эрүүгийн хуульд нэмэгджээ.

- Прокурорын байгууллагын гэмт хэргийн бүртгэл мэдээллийн систем нь өсөн нэмэгдэх дүнгээр гардаг, бүртгэх аргачлал өөр, өмнөх оны үлдэгдэл хэрэг зэрэг прокурорын хяналтын ажлын төрлөөр гаргадаг учир цагдаагийн байгууллагын тоон мэдээтэй тулгах, түүнийг хянах бололцоогүй байв. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн талаарх гомдлын тоо, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, хэрэг бүртгэлтийн хэрэг хаасан, хэрэг бүртгэлтийн хэрэг хэрэгсэхгүй болгосон гэх шийдвэрүүдийн тулгахад зөрүүтэй мэдээ гарч байна.

Энэ нь Прокурорын байгууллагаас хяналт тавьж шийдвэр гаргасан, хянасан, бүртгэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн гэмт хэргийн тоон мэдээ нь Цагдаагийн байгууллагын бүртгэсэн гэмт хэргийн тоон мэдээтэй зөрүүтэй гарч байгаа нь прокурорын байгууллагын гэмт хэргийн талаарх гаргаж байгаа тоон мэдээ, статистик үзүүлэлтийг бүртгэх аргачлал нь өөр, өсөн нэмэгдэх үзүүлэлтээр тус тусын үндсэн ажлын үзүүлэлтээр болон шийдвэр гаргалтын байдал, шийдвэрээр бүртгэдэг, зарим үйлдлийг, өргөдлийг нэгтгэж шалгах мөн тайлан мэдээ гаргах хугацаа зөрдөгөөс шалтгаалсан гэж үзэхээр байна.

Цаашид хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн систем боловсронгуй болгон хөгжүүлснээр цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын статистикийн мэдээллийн үзүүлэлтийг харьцуулан ашиглах, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх боломж бүрдэх юм. Эдгээр тоон мэдээллийн үндсэн дээр гэмт хэрэгтэй тэмцэх, зөрчлийг шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд дун шинжилгээ хийх замаар тэдгээрээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөх, хэрэгжүүлэх боломжтой болно хэмээн дүгнэж байна.

ХУУЛЬ ЗҮЙН НЭР ТОМЬЁО

Ж.Амарсанаа

д/д	Буруу	Зөв	Тайлбар
1	Сумын Засаг даргын Тамын газар	Сумын Захиргаа (Үг нь Сумын Засгийн газар)	Сумын (аймаг, нийслэл, дүүргийн) Тамгын газар гэдэг нь нэг л доодогт нэгж нь юм. Ингэж буруу бичиж, ярж хэвшсэний засах.
2	Төрийн гурван өндөрлөг	Төрийн эрх мэдлийн хуваарилалт. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэсэн нэгэн цогц төрийн З салаа мечир.	Төрийн гурван өндөрлөг гэж Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд гэсэн 3 хүнийг нэрлэх болжээ. Энэ бол хүн биш, субъект, институт, байгууллага. Энэ бол төрийн дээд эрх мэдлийн хөдөлмөрлийн хуваарь юм.
3	Хууль, эрх зүй; Хууль эрх зүй; Хууль эрх	Хууль, эсвэл эрх, эсвэл эрх зүй гэх.	Хууль, эрх, эрх зүй бол 3 өөр фойлголт. Ийм газар, хэлтэс УИХ, ЗГ, СЗХ, АТГ зэрэг олон газар байна. Зүй нь хууль зүйн эсвэл эрх зүйн газар, хэлтэс гэх.
4	Хуулийн байгууллага	Хууль сахиулах байгууллага, Шүүх эрх мэдлийн байгууллага.	Хуулийн, дүрмийн, тогтоолын байгууллага гэж байхгүй. Хуулийн бол бие даасан эрх зүйн баримт бичиг.
5	Хууль хяналтын байгууллага	Хууль сахиулах байгууллага гэж бий.	Ийм байгууллага байхгүй. Хяналтын гэсэн тодотголтой тусгай байгууллага гэвэл прокурорын хяналт, маргажийн хяналтын байгууллагыг хэлж болно. Олон агентлаг хяналтын чиг үүрэгтэй. Оюуны өмчийн газар зэрэг зарим байгууллага ч ийм үүрэгтэй.
6	Төрөө дээдлэх	Хууль дээдлэх (Монгол Улсын Үндсэн хууль, Нэгдүгээр зүйл, Арван долдугаар зүйл)	Төр дээдлэх нь феодалын хийгээд коммунист, фашист узэл юм.
7	Хууль цааз	Хууль эсвэл цааз	Хууль нь УИХ-ын баталсан акт. 1990 он хүртэл нийтлэг хэрэглэж байсан. Одоо ч хэрэглэсээр байгаа, прокурорт хэрэглэж байна, өөрчлөх хэрэгтэй. Дархан цаазтай газар эх зэрэг хууль тогтоомжид хэрэглэж буй, буруу биш байх.
8	Төрийн эрх мэдлийг хуваах	Төрийн эрх мэдэл хуваарилалт	Нэг төрийг дотор нь эрх мэдлээр нь 3 ангилж буй хөдөлмөрийн, нэг ёсоondoо, чиг үүрэг, ажлын хуваарь.
9	Улс орон	Улс, эсвэл орон	Улс орон гэж хоршин хэрэглэж буй нь зөв биш. Тухайн асуудал эсвэл ойлголтоос хамаарч тус тусад нь хэрэглэх нь зүй.
10	Хуулийн сургууль	Хууль зүйн сургууль	Хуулийн, тогтоолын, зарлигийн сургууль гэж байхгүй.
11	Хууль хүчиний байгууллага	Хууль сахиулах байгууллага. Төрийн тусгай алба гэж бий.	Ийм байгууллага байхгүй. Цагдаа, батлан хамгаалах зэрэг байгууллагыг, сурвалжлагч, бас бус хүн ингэж нэрлэдэг.
12	Хуульч профессор	Хуульч тусдаа. Профессор тусдаа. Яг унзэндээ ийм "гажи" ойлголт байхгүй.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь хэсэгт ийм нэг ойлголт бий. Дээд боловсролын хуульд дэд профессор, профессор байх болзول бий.
13	Яамны сайд	Сайд нь Засгийн газрын гишүүн, төрийн улс төрийн албан тушаалтан.	Үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн ёсоор яам нь ердөө л сайдын "ажлын аппарат".
14	Төрийн бус байгууллага	Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэг "... олон нийтийн байгууллага".	УИХ-аас 1997 онд Үндсэн хуулийн заалт зөрчиж Төрийн бус байгууллагын тухай хууль баталсан. Зарим улсын NGO (Non Governmental Organization) буюу Засгийн газрын бус байгууллага гэдгийг орчуулан буулгасан нь тэр).
15	Эрхийн баталгаа	Эрх зүйн баталгаа	Эрхийн, үргийн баталгаа гэж байхгүй. Эрх, эрх зүй нь өөр ойлголт.
16	Нам төвтэй тогтолцооноос төр төвтэй тогтолцоонд шилжих	Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйл, Арван зургадугаар зүйлийн 10, Арван долдугаар зүйлийн 1.1 дахь хэсэгт хууль дээдлэх заалт бий.	Нам төвтэй гэх тогтолцоо гэх ойлголт одоо цагт байхгүй болсон.
17	Иргэн төвтэй төрийн үйлчилгээ	Төр, иргэн хоёр адил төвшинд хуулийн дор ажиллаж амьдарна.	Ямар нэгэн төв "юм" байхгүй. Иргэнд чиглэсэн, иргэнд хандсан үйлчилгээ юм.
18	Сайн засаглал	Чадварлаг буюу үр нэлэөтэй удирдлага	Англи хэлний "Good governance" гэдгийн үгчилсэн орчуулга. Төрийн олон баримт бичигт тусгагдах болсон байна.

- Хууль – Эрх зүйн утгаараа хууль тогтоох байгууллага - Улсын Их Хурлаас онцгой журмын дагуу баталсан бөгөөд нийгмийн гол, чухал харилцааг зохицуулсан, хууль зүйн дээд хүчин чадалтай, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичиг.

- Эрх зүй – Нийгмийн харилцааг зохицуулдаг, голчлон хуулиар дамжин илэрхийлэгддэг, хүмүүсийн эрх чөлөө, шударга ёсны үзэл санаанд суурилсан хэм хэмжээний тогтолцоо.

- Тогтолцоо – Хоорондоо нарийн уялдаа холбоо бүхий бүтэц, бүрэлдэхүүн, нэгж, хэсгийн харилцан хамаарал.

- Жам ёсны эрх зүй – Нийгэмд амьдарч байгаа хүний өөрийн уг чанараас үүдэлтэй, заяамал эрх, эрх чөлөөний эрх зүйн бүрдэл, нийлбэр цогц.

- Оюун санааны эрх зүй – Төрийн эрх бүхий байгууллагаас баталсан хууль болон эрх зүйн бусад баримт бичгээр хэлбэржин илэрхийлэгддэг эрх зүй.

- Иргэн – ашиг сонирхлоо ухамсарласан хүн. Энэхүү ашиг сонирхол нь төртэй харилцаад нэг талаас сонгогч, нөгөө талаас татвар төлөгч болж илэрдэг.

- Эрх зүйт төр – Хуульд үндэслэсэн, хуулиар дамжин үйл ажиллагаа нь хэрэгждэг, тэрхүү үйл ажиллагаа нь хуулиар хязгаарлагддаг төр. Эрх зүйт төрийн үндсэн шинж: хууль дээдлэх; хүний эрх; улс төрийн олон ургальч үзэл; төр, иргэний харилцан хүлээх хариуцлага. Эрх зүйт төрийн үндсэн зарчим: эрх зүйт дээдлэх, ард түмний эрх мэдэл, эрх мэдэл хуваарилах.

- Эрх зүйт төр эрх мэдэлд суурилдаг.

- Иргэний нийгэм – Улс төр, эдийн засаг, соёл, угсаатны, мэргэжлийн, ахуйн зэрэг янз бүрийн зорилгоор нэгдсэн нийгмийн бүлэг (гэр бүл зэрэг), бүтэц (нам, олон нийтийн хөдөлгөөн, хамтлаг, нэгдэл зэрэг). Хувийн болон бүлийн ашиг сонирхол, хэрэгцээг хамгаалах, хэрэгжүүлэх зорилготой, эрх зүйн болон нийгмийн бусад хэм хэмжээнд үндэслэсэн төрийн үйл ажиллагаанаас ангид байгаа хүмүүсийн нийтлэг.

- Иргэний нийгмийн үндсэн шинж: чөлөөт (өрсөлдөөнт) зах

зээл; хувь хүний эрх чөлөө; олон нийтийн санаа болод; хувийн өмч. Иргэний нийгэм ёс суртахуунд суурилдаг.

- Хүн – байгалийн төдийгүй нийгмийн “амьтан”. Хүн нийгмийн харилцаанд оролцогч “этгээд” болохын хувьд түүний сэтгэхүй, сэтгэлгээ, зан төлөв, хэл яриа, ажиллах чадвар зэрэг нь зөвхөн нийгэмд төлөвшин хөгждөг. Хүн гэдэг нэр томьёог голчлон олон улсын эрх зүйд хэрэглэдэг. Мөн дотоодын эрх зүй, ялангуяа үндсэн хуулийн эрх зүйд өргөн хэрэглэдэг. Сүүлийн үед зөрчлийн болон бусад хуульд иргэн гэдэг ойлголтыг хүн гэдэг ойлголтоор сольж хууль батлах болсон нь том гажуудал мөн. Энэ бол Үндсэн хуулийг зөрчиж байгаа хэрэг юм.

- Хүний эрх –Хүн өөрийгөө төрөөс хамгаалах, түүнчлэн төрөөр хамгаалуулах заяамал эрх.

- Бие хүн – Нийгмийн харилцаанд оролцогч этгээд. Бие хүн нийгмийн хөгжлийн тодорхой үе шаттай холбоотой. Хүн төрөлхтний хөгжлийн эхний үед шаттай холбогдуулан энэ талаар ярих боломжгүй гэсэн үг. Бие хүн хувийн, төрөлх шинж, онцлог болон түүнд нөлөөлж буй нийгмийн орчин гэсэн хоёр үндсэн хүчин зүйлийн нөлөөн дор төлөвшдөг.

- Төрийн эрх мэдэл хуваарилах – Энэ бол үзэл баримтлал, хэм хэмжээ, зарчим юм. Төрийн эрх мэдэл нь нэгдмэл, нэг байдаг. Энэхүү эрх мэдлийг дотор нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэсэн гурван салаа мөчирт хуваарилсан байдаг. Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг боловсруулах комиссоос бэлтгэсэн төсөлд: “Монгол Улсад төрийн эрх мэдлийг Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл болгон хуваарилж, хоорондын уялдаа, зохицлыг хуулиар баталгаажуулан хангана.” (III бүлэг. Арван есдүгээр зүйл. Монгол улсын төрийн байгуулал.) гэсэн заалт байсныг төсөл хэллэлцэх явцад (1991.IV.5; XI.7) нэгэнт төслийн бусад бүлэгт зааглан, ялгаж тусгасан тул хасах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн байна.

- Үндсэн хуулиар зохицуулах харилцаа – Хүний эрх, төрийн байгууллага, гадаад бодлого.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДСЭНИЙ ХҮРЭЭЛЭН

Үндсэн үйл ажиллагаа:

Хууль зүйн бодлогын судалгаа
Эрх зүйн албан бус болон захиалгат сургалт
Эрх зүйн мэдээлэл, суртасчилгаа
Эрх зүйн актын лавлаггаа, мэдээллийн нэгдсэн сан
Эрдэм шинжилгээний номын сан
Хэвлэх үйлдвэр
“Хууль дээдлэх ёс” сэтгүүл
“Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”
“Хууль зүйн мэдээ” цахим сонин
Бусад ном, товхимол



-ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ-

www. LEGALINFO .mn